

***МАХАБХАРАТА***

## ОРШИЛ

Эрт урьд нэгэн цагт даяанч мэргэд ойн цоорхойд цуглан эрт дээр үеийн үлгэр домог дуулагч Саутид хандан: “Үлгэрч ээ, Бхаратын удмын их домгоо бидэнд ярьж өгөөч, эртний баатар эрсийн эрэлхэг гавьяа хүч их хаадын удам угсаадын дайсагнал, мөхлийн тухай, Куругийн талд болсон цуст тулалдааны тухай ярьж өгнө үү” гэж ээ.

Саути эрхэмсэг өтгөст хүндэтгэлээ илэрхийлэн мэхийснээ газар дээр залран бууж тэдэнтэй зэрэгцэн суугаад үлгэрээ ярьж эхлэв.

### I

“Ариун сахилт хүмүүс ээ, эрт дээр үед улс гэрийн маань ёс шударга үйл сайнтай боловч ан гөрөөнд хэт хорхойтой Парикшит гэдэг хаан ачлан захирч байжээ. Тэр хаан шархдсан хэг гөрөөс мөшгөн мөрдсөөр ойн гүн төгөлд оржээ. Цааш явсаар ойн суугч өвгөн даяанч дээр ороод очжээ. Даяан үхрийн саравчинд үг ч үгүй, хөдөлгөөн ч үгүй сууна. “Хөөе бярман шархтай гөрөөс үзэв үү?” гэж хаан асуудаг. Гэтэл даяанч хариу огт өчсөнгүй. Тэр өвгөн даяанч хэзээ ч дуугарахгүй гэж бурханд андгайлснаасаа хойш цорын ганц ч үг хэлээгүй ажээ. Хариу өчсөнгүйд хаан ихэд хилэгнэн, үхсэн могой газар хэвтэж байхыг харж, нумныхаа үзүүрээр түүнийг өлгөж аваад өвгөний мөрөн дээр давуулан хаяжээ. Гэсэн ч даяанчийн амнаас сайн, муу үг аль нь ч гарсангүй. Парикшит хааны урам хугарч, уухаа бараад хот руу буцжээ. Мэргэн даяанч мөрөн дээрээ могой тохоостой суусан хэвээр үлджээ.

Тэр өвгөн даяанч ер бишийн их шидтэй нэг хүүтэй байжээ. Юм бүхэн түүний хэлсэн үгээр бүтнэ. Эцгээр нь тэгж доог тохуу хийснийг мэдэж хилэгнэсэндээ Парикшит хааныг “Парикшит чамайг долоо хоноод хорт могой Такшака хөнөөж, үхлийн бурхан Ямын оронд тонилог” гээд хараачихсан ажгуу.

Хаан, тийм хараал хийснийг нь сонсоод айхын эрхэнд зөвлөх түшмэдээ цуглуулав гэнэ. Эзэн хаанд нүүрлэсэн энэ цээрлэлээс яаж мултрах ухаан сийлцгээжээ. Парикшит хаан нэн даруй өндөр багана босгон түүн дээр орд барих зарлиг буулгажээ.

Тэр ордыг өдөр шөнөгүй харгалзагч нар нүд цавчилгүй хамгаалан сахижээ. Увидаст эмч, могой хөнөөгч нар хааны дэргэдээс ганц алхам холдолгүй дагажээ.

Парикшит хаан өндөр баганан дээр барьсан ордноосоо долоо хоног цухуйлгүй, зөвлөх түшмэдээрээ хүрээлүүлэн улс орноо захиран суужээ.

Тэгээд долоо хоног дээр нь үл таних бярман хааны зоогонд зориулан ус, үр жимс аваачжээ. Тэр орой Парикшит хаан өөрийн анд нөхөд, зөвлөх түшмэдийхээ хамт амарч байснаа гэнэт тэр авчирсан шинэхэн жимснээс амсмаар санагджээ. Тэгээд өөрөө нэг жимс авч, бусды нь зөвлөх түшмэддээ өгөв. Хааны авсан жимсэн дээр хархан нүдтэй, зэсэн өнгөтэй жижигхэн өт үзэгджээ. Парикшит хаан инээд алдан: “Нар нэгэнт жаргаж байна. Өнөөдөр могойн хорноос айх юмгүй боллоо. Намайг энэ муу өт хазвал ч хазаг даа. Даяанчийн хараал ингэж биелэг л дээ “ гэж хэлээд өнөөх өтийг хүзүүн дээрээ тавив.

Тэгтэл ч өчүүхэн тэр өт юу юу үгүй асар том могой болон хувирч байхыг түшмэд нь хараад таван сүнс нь зайлах дөхжээ.

Тэр бол доод тивд байдаг хамгийн аймшигтай, хорлонтой могой Такшака агаад хяхтнан дуугарч эвхрэлдэн хөдлөөд Парикшит хааныг ороогоод авчээ. Могойн хяхтнах чимээ гарч хаан нь үхлийн саварт орсныг хармагцаа хамаг түшмэд нь орь дуу тавьцгаан тал бүр зугтжээ. Такшака могой тэнгэрт галан зам татуулан талийж байхыг уй гашууд автсан тэд олж харав. Паракшитын ордон ч Такшакын халуун хорын нөлөөгөөр шатаж эхлээд улалзсан дөлөнд нь аянганд ниргүүлсэн юм шиг нурж эхэлжээ.

Паракшитын насан эцэс болсон хойно түүний хүү Жанамежав улсын эзэн болов. Хорон санаат могой хэрхэн хааны ордонд орж ирээд хааны биеийг харсаар байтал шатааж байсныг түшмэд нь хожим хүүд ярьж өгөв. Жанамежая үүнийг сонсоод Такшака болон ер нь могойг бүгдийг нь, ганцыг ч үлдээгүй бурханд зориулан золигт гарга гэж лам нартаа зарлиг болгожээ.

“ Миний эцгийг хорын галаар хэрхэн шатаасны адил би тэр гэмт Такшакаг садан төрлийнх нь хамт бүгдийг шатаахыг хүсч байна! ” гэж Жанамежая хэлжээ.

Бярмангууд тахилын ширээ босгож ариун гал асаан, хав хар хувцас өмсөөд утаанд улайсан нүд гаргацгаан ид шидэт тарни уншиж могойнуудыг түүдэг галынхаа дөл рүү хаяж байлаа.

Том жижиг, хар, хөх, шар, янз бүрийн могой хяхтнан дуугарч эвхэрч ороолдсоор түүдэг рүү орж байхаг хаан Жанамежав зөвлөх түшмэдийхээ хамт тахилгын ширээний дэргэд хараад сууж байна.

Могойг олон өдөр шатаасан бөгөөд хэрэв тэднийг бурхан өрөвдөж хайрлаад Жанамежаяг тахилга хийхийг нь зогсоогоогүй бол бүх могой галд шатаад дуусах байсан юм.

Тэр их тахилгын үеэр алдар цуутай олон бярман, эрт урьдын үлгэр домог мэдэгчид нүүр учирсан ажээ. Тэднийг могой шатааж байсан тахилгын ширээ тойрон хааны хажууд сууцгаахад Жанамежаяд Бхаратын удам төрлийн тухай домог сонсмоор санагджээ.

Тэр домгийг мэргэн Вайшампаяна хаанд яаж ярьж өгсөн яг тэр янзаар нь одоо Саути би та нартаа ярьж өгье” гэжээ.

## II

“Эрт урьд цагт алдар цуу их, баян чинээлэг Хастинапур хотыг Бхаратын дээд овгийн хаан сохор Дхритараштра эзлэн суужээ. Түүний захиран суусан улс гүрэнд амар тайван, өлзий буян үлэмж байсан учраас Шива бурхны соёрхлоор хааны хатан Гандхари зуун сайн хүү төрүүлжээ. Харин хөвгүүдийг эрийн цээнд хүрч, зэр зэвсэгт сургах цаг болоход алдар гавьяа нь дуурссан бөгөөд цэрэг дайны ухааныг нэвтэрхий сайн мэдэх тийм багш нарыг хайж олох сурал болжээ.

Зориг төгөлдөр дайчин энэ улс гүрний дотор олон байвч, хааны хөвгүүдийг сургах хувьтай нь амар олдсонгүй.

Нэг өдөр хааны хөвгүүд хотын том хаалганаы дэргэд модон бөмбөгөөр тоглож байгаад тэрнийгээ худагт унагаачихжээ. Худаг нь гүн байсан учир тэднүүс бөмбөгөө гаргаж авч эс чадав. Тэгтэл нэг үл таних дайчин эр тэдний дэргэд хүрч ирээд инээмсэглэн хэлсэн нь: “Та нар чинь Бхаратын удам гэж байж зэр зэмсгээ эзэмшиж байгаа аль вэ? Худагт бөмбөгөө унагачихаад гаргаж авч чадахгүй юм бол та нар чинь юуны нь баатар эрчүүл байх вэ? Зэвсгээр юу хийж болдгийг та нар харж бай л даа!” гээд өнөөх үл таних хүн хануур жадаа худаг руу хаяж бөмбөгөнд нэвт шаав. Дараачийн жадыг мань эр шидэхдээ түрүүчийнхтэйгээ угсран залгаж шидсээр байгаад нэг их урт юм болгочихжээ. Тэгээд мань овжин ухаан тэр урт юмаа худгаас татаж бөмбөгийг нь татаж гаргаж ирээд мэл гайхаж хоцорсон тэр хэдэн жаалд өгчээ.

Хүүхдүүд юу болсон тухайгаа ордонд очоод ярихад тэдний үеэл ах өвгөн Бхишма тэр хүнээр зэр зэмсгийг хамгийн сайн мэддэг, цэргийн эрдэмд боловсорсон Дрона мөн гэж мэдэв. Тэгээд Бхишма, Дронаг дуудуулж авчраад Дхримараштрагийн хүүхдүүд болон Пандугийнханд багшлуулах болгожээ.

Панду бол Дхритараштрагийн дүү юм. Тэрээр залуудаа бие барж, Юдхиштхира, Бхимасена, Аржуна, ихэр гарсан Накула, Сахадева таван хүү өнчин хоцорчээ. Ихэр нь Пандугийн бага хатан Маднигаас гарчээ. Эр нөхрийгөө оршуулгын түүдэгт шатаалгасны дараа хоёр хүүгээ гурван ахынх нь эх Кунтинд нэрээр дуудах болсон юм.

Тэгээд хүүхдүүдэд Дрона зэвсэг эзэмших сургууль заах болжээ. Тэднийг тэргэн дээрээс, морь, заан дээрээс, явган байлдах, илд ба балтаар байлдах, жад, хануур жад шидэх, нум сум харвахад сургаж байлаа. Дронагийн шавь нарын дотроос ах дүү Дурйодхана болоод Бхимасена хоёр балтаар тулалдахад онцгой шалгарч байхад, ихэр хоёр нь илд эзэмших талаараа бусдыгаа даагуулахгүй байжээ. Юдхиштхира тэргэн дээрээс тулалдахдаа хамгийн сүрхий нь байсан боловч бүгдээс илүү нь Аржуна байлаа.

“ Хөвгүүд чинь цэрэг дайны ухааныг эзэмшлээ. Одоо тэдний уран чадварыг үз ” гэж Дрона хаанд хэлэх нэг өдөр иржээ. Хааны сэтгэлд тааламжтай байсан учир “ Дрона, чи агуу их үйлийг бүтээжээ. Хэзээ, хаана, ямар цаг товлохоо сонгож хэлээд тэмцээн явуулахыг зарлиг болго ” гэжээ.

Зарц нар, Дронагийн заавраар мод, бүт сондуулгүй тэгш тал газар сонгон олж. Тэнд нь хаан болон ордныхонд зориулан дархчуулаар алт, эрдэнийн чулуу, сувдаар чимсэн гайхалтай сайхан байшин бариулж, хоёр жигүүрээр нь баян хүмүүст майхан, хөдөөний хүмүүст урт урт сандал засч өгчээ. Тэмцээн болсон өдөр индрүүд болон тэмцээний талбай тойрон шаасан майхнуудаар үй олон хүн пиг дүүрчээ. Хаан ба түүний бараа бологчдыг суудлаа эзэлсний дараа тавцангийн яг дунд Дрона цав цагаан хувцастай гарч ирэв. Хуяг дуулга өмсч, илд, нум, саадаг дүүрэн сум агссан хүчирхэг дайчид башгийнхаа дохиогоор үзэгчдийн өмнө гарч ирж байлаа. Тэд зэр зэвсгээ аль хэр эзэмшиж чадсанаа насныхаа эрэмбээр гарч ирж дараалан үзүүлж байв. Хөлөг мориныхоо хар хурдаар давхих явдал дунд онох гэсэн зүйлээ алдалгүй онож байна. Дараа нь тэд илдээр яаравчлан тулалдахад үзэгчид тэдний авхаалж самбаа тэвчээрийг өөрсдийн нүдээр харжээ.

Юлдээр тулалдсаны эцэст Дурйодхана, Бхимасена хоёр балтаар халз тулалдав. Хоёул улангассан арслан шиг болж гардан тулалдахдаа бие биен дээрээ хүчтэй цохилт буулгаж байна. Үзэгчдийн зарим нь Пандугийнхны талд орж, зарим нь Каурынхныг зоригжуулах гэж хашгиралдан шуугилдаж эхлэв. Тэр хоёрын

тулалдаан ширүүсч, зон олны үймээн асар их болсон учраас Дрона тэр халз тулааныг зогсоосон юм.

Хамгийн сүүлд Дрона, хамгийнхаа хайртай шавь Аржунаг тавцнаа дуудан гаргав. Морь унах, тэрэг жолоодох жад шидэх, нум сум харвах энэ бүхэнд Аржуна бүгдээс давж Каурынхныг ах дүү нарын алдрыг бууруулав. Ард түмэн энэхүү залуу баатрыг алга ташин баяр хөөр болон сайшааж байхад Дурйодхана дүү нарынхаа хамт дотроосоо адгийн муу атаархан, уур хилэндээ химлэгдэн зогсож байжээ.

Тэмцээн дуусах дөхөж олны үймээн шуугиан намжиж байтал нэг цэрэг эр талбай дээр гарч ирээд Аржунагийн хийсэн бүхнийг яг л тун чадвартай нь аргагүй давтан хийхэд хүмүүс үгүй энэ чинь хэн бэ? Гэлцэн бие биенээсээ гайхан асууцгааж байхад Дурйодхана баярлан түүнтэй нөхөрлөхөө илтгэлээ. Харин Пандугийнхан тэр этгээдийг зэвүүцэн харж байв. Тэд түүнийг таньжээ. Энэ чинь хөтчийн хүү Карна байна. Хааны хүүхдүүдтэй чи сүлбээрхээд дөнгөх үү дээ? гэж хор шар нь буцалсан Пандугийнхан хэлээд зэвүүрхсэндээ талбайг орхин яваад өгчээ.

Ингэж ах дүү Пандугийнхан Каурынхны хооронд дайсагналын харгайгаар улс гүрнийг минь асар их гай гамшиг дайрсан юм.

### III

Тэр тэмцээнээс хойш Пандугийнхны цэргийн их эрдмийн тухай яриа хот даяар түгжээ. Хотынхон бие биенээсээ нуух хаах ч юмгүй “Өвгөн Дхритараштра” мэргэн ч гэсэн сохор юм даа. Цэрэг эрсээ дайнд жолоодож чадахгүй юм. Дүү панду нь амьд байхдаа улс түмнээ түүний нэрийн өмнөөс захирч байсан нь учиртай байжээ. Хаан ширээнд Пандугийнхны ахмадыг нь суулгавал таарна. Юдхитхира нас залуу ч гэлээ ухаан саруул мэргэн хууль ёс мэднэ дордос ядууст элэгтэй шударга хүн. Хаан болчихвол Дхритараштраг ч үр хүүхдүүдийг гомдоохгүй гэж дээ ч гэлцэх болжээ.

Атаархал, хилэнд хилмэгдэж яваа Дурйодхана ийм яриа гарч байгааг мэдэж аваад хаанд бараалхан ирж хэлсэн нь: “Хаан аав минь дээ хотын хүмүүс өөдгүй муу юм үйлдхээр санаа сэджээ. Тэд Пандугийнхныг хаан болгохын хүсэж байна. Чиний хэдэн хүү эрх мэдэлгүй болж бусдын гараас өглөг горьдон амь зуух болж байна. Харцас доодос биднээр элэг доог хийх болно. Пандугийнханыг хөөж зайлуулахгүй бол бидэнд гарцаагүй гай ирэх нээ” гэв.

Хаан хүүхдүүддээ хайртайн эрхээр тийм шударга биш хэргийг зөвшөөрөх нь тэр. Пандугийнхныг хөөж зайлуулах шалтаг олно гэж Дурйодхана хаандаа

амлажээ.Тэгээд Каурынхан тал засах бэлэг сэлт барих аргаар харьяаныхаа хүмүүсийг өөрсдийн талд татаж эхлэв.Хүний мөсгүй түшмэлүүд нь хааныхаа хатгалтаар Варанавата гэдэг сайхан хотыг Пандугийнханд учиргүй магтах болжээ. “Тэр хотод бол алт эрдэнэсэн чимэгтэй үй олон орд харш бий. Мөн шива бурханы их баяр тэнд болно” гэж ярихдаа Пандугийнхныг тийш нь яаж баяр ёслолд оролцъё гэсэн хорхойг нь хүргэх зорилготой ятгалаг хийжээ.

Дурйохана өөрийн итгэлтэй зарц Пурочанаг сэмхэн дуудаж “Пурочана аа сонсч бай.Намайг төрийн эрхэнд байхад чи юмаар дутахгүй хүндэтгэлээр дүүрэн байна.Чамаас илүү итгэлтэй хүн над өөр алга.

Одоо би чамд нэг юм даалгана.Чи тэр хэрэгт хүчин тусла,ам алдаж болохгүй нууц юм Пандугийнхан шүү. Чи Пандугийнхнаас урьтаж Варанаватад хүрэлцэн очоод тэнд тэдэнд нэг байшин бариул. Тэр байшинг давирхайтай мод, хулс сүрлүүр бариулах хэрэгтэй. Пандугийнхныг тэр байшиндаа орсон цагт хамгийн харанхуй нэг шөнийг сонгож аваад байшинг нь галдагтун.Хүн амьтанл шижиг авхуулж болохгүй шүү. Пандугийнхан санаандгүй байтал гарсан гал түймэрт үрэгдлээ л гэж бодог”гэв.Пурочана “Жаа” гэж хэлээд тэр өдөртөө Варанаватагийн зүг морин тэрэгээр хурдлан довтолгожээ.

Пандугийнхан ямар ч сэжиг авалгүй, баяр ёслолд оролцхо бэлтгэлээ хийцгээж байв.

Тэднийг явах өдөр, төрөл садан хотынхон том хаалга хүртэл үдэж гаргав. Пандугийн хөвгүүдийн өвөг ах өвгөн Видура салахдаа ийн хэлрүүн: “Ухаант хүн учиртай үгийг ойлгоно.Хүн галын аюулаас үхэр зарааны аргаар мултарч гардаг юм шүү. Сэрэмжтэй явж эсэн мэнд үлдээрэй” гэжээ. Юдхиштхира ч Вадурагийн битүү утгыг ухаарч хэрэгтэй цагт санасан ажээ.

Хэд хоног явсан дараа тэд эх Кунтигийнхээ хамт Варанаватад хүрэлцэн очжээ.Тэд бярман хотын эх баригчид, нэр цуутай хүмүүстэй уулзаж бүгдийг нь хүндэтгэн ёсолж үнэт бэлэг сэлт барихдаа халуун дотно эвсэг сайхан үгээ хэлж байжээ.Тэгээд өөрсдөдөө зориулсан барьсан байшинруу явцгаав.Тэднийг Пурочана бараа болон дагажээ.

Юдхиштхира байшинд ороод сайн ажиглаж хараад Бхимасенад “Энд аюул ихтэй юм байна. Бүгдийг нь мод зэгс хоёроор хийж цөмийг нь тос давирхайгаар нэвтэлжээ. Одоо л Видурийн хэлсэн үгийн санааг ухаарлаа. Дурйодханагийн өөдгүй

муу энэ зарц нь биднийг эзнийхээ хүслээр галд шатаах гэж байгаа юм байна” гэхэд “Тэгвэл эндээс зайлъя гэж Бхимасена хэлэв. Гэвч Юдхиштхира зөвшөөрсөнгүй: “Бид энд суувал зохино.Тэгэхгүй бол сэжиг авчихна шүү дээ. Дурйодханагийн мэдэлд бүх улс орон сан хөмрөг цэрэг байна. Гэтэл бид хэдэд байх юм алга.Тэгэхлээр дайсныг хуурч мэхлээд хүмүүсийнх нь нүд чихнээс далд орох хэрэгтэй байна. Яг өнөөдрөөс эхлэн үхэр зараа шиг доошоо шарах нүх ухаад байдаг хэрэг, байшинг шатаж эхэлмэгц л энэ гарцаараа гарч, хотоос дайван зайлж ойд орж нуугдъя” гэжээ.

Панду нарын ийнхүү ямар ч сэжиг аваагүй амгалан байдалтай байгаа Пурочана ажиглаад анх өвөрлөж ирсэн санаагаа биелүүлхээр шийджээ. Харин Юдхиштхира цаг ямагт сонор сэрэмжтэй байжээ. Пурочана алах цаг нэгэнт бэлэн болсныг тэр мэдээд дүү нартаа “нэгэнт цаг болов гэж хэлжээ. Пандугийнхан оргон зайлахаар шийдсэн өдөр Кунти эх нь бярман нарт гэртээ зоог барихаар бэлдсэн ажээ. Бусад гийчдийн хамт нэг гуйлгачин ядуу авгай таван хүүгээ дагуулсаар тэднийд ирсэн байна.Тэр гуйлгачин хэдэн хүүхдүүдийнхээ хамт цадталаа идэж, нанчид согтголоо уугаад харанхуй буланд унтаад өгчээ.

Гийчид тарж явахад тэд тэнд унтаад хоцорсныг хэн ч анзаарсангүй. Шөнө харанхуй болохтой зэрэг Бхимасена муу санаат Пурочана л ганцаараа үлдсэн гэж бодоод байшингаа галджээ. Пандугийнхан эхийнхээ хамт газар доогуурх гарцаараа явж шатаж байгаа байшингаа орхин хотоос тийнхүү сэмхэн зайлав. Өглөө үүр цайхын алдад тэд Варанаватаас бүр холдсон байжээ.

Нөгөө байшин өглөө болоход хуу шатаж дуусаад газар доогуурх нүх нь ч дарагдсан байжээ.Үнсэн товрог болсон газраас хотынхонд гагцхүү Пурочана настай авгай,түүний таван хүүгийн шатсан хүүрийн ор мөр олджээ. Пандугийнхан эхийнхээ хамт галд шатаж үхлээ гэж Варанаватагийнхан боджээ.Тэд харамсахдаа Дхритараштра хаанд эмгэнэлт мэдээ хүргэхээр элч залан явуулжээ.

#### IV

Каурынхан үеэл ах дүү нарынхаа амь үрэгдсэнийг сонсоод уй гашуй болж байгаа дүр үзүүлэн хойтхыг нь уншуулж байхад Пандугийнхан эхийнхээ хамт өлсөж, цанган ядарч зовсоор битүү ой тайга дундуур өмнийг зорьсоор явлаа.Тэд олон хоног явахдаа цулгай газар модны нөмөрт хоноглон, жимс үндсээр хоол хийж ойн гол горхи нуурын уснаас цангаагаа гаргаж байлаа.Тэд, Дурйодханагийн



тагнуулчдаас болгоомжлон танигдахаас айхдаа далдуу модны хальсыг хувцас болгон нөмөрч зээрийн арьс нөмөрч, урт гэзэг унжуулан тэнэмэл даяанчид болж явав.

Ингэж явсаар тэд Экачакра хотын захад хүрч нэг ядуу бярманьд суух болжээ.

Түүнээс хойш төдий л удаагүй байтал нэг өдөр хөвгүүд нь хотын гудамаар явж, өглөг хишиг гуйхаар явахад Кунти авгай гэрт үлджээ.Тэгтэл хананы цаана хүн уйлах чимээ гарав гэнэ. Кунти авгай гэрийн эзэн бярман дээр орж үзвэл түүнийг эхнэр хүүхэд нь уй гашуу болон айн балмагдаад уйлцгааж байна. Өвгөн бярман өөрийн ядуу зүдүү амьдралын тухай Кунтид ярьсан нь:

“Олон жилийн урьд манай хотын ойролцоо Бака хэмээх аймшигтай мангас оршин суугаад дайснуудыг уулгалан довтлохоос хотыг хаацайлан хамгаалж байлаа.Гэвч тэр тэгж байхынхаа хариуд алба татвар авдаг болж өдөр бүр тэрэг цагаан будаа, хоёр өдөс нэг хүнийг авдаг байсан юм,хүн мал амуу будаа тэр мангасын аманд орсоор байна. Бид тэр гамшигт мангасаас ангижирч чадахгүй байгаа юм.Одоо миний ээлж болчихлоо” гэв. Сайн санаат Кунти бярман ба түүний гэрийхэнд ийн хэлрүүн: ”Битгий зов битгий бачимд. Та биднийг орон гэртээ оруулж ачилсан тусыг тань бид бодож та нарыг гай зовлон болоход”орхихгүй гэжээ. Үдэш хэдэн хүүхдүүдээ гуйлга гуйж яваад ирэхэд нь Кунти авгай бяроманд ямар гай зовлон нүүрлээд байгааг тэдэндээ яриад”Маргааш Бхимасена чи,бярманы оронд явж очоод энэ хотыг тэр мангасаас салга” гэхэд хүүхдүүд нь эхтэйгээн санал зөрсөнгүй. Бхимасена үүр цайж байхад алба татварыг авч хотоос гаран ойн захад ойртож очоод “хүүе Бака гэж өндөр дуугаар дууджээ. Тэгмэгц үлэмжийн том мангас, газар доргиулан ургаа, моднуудыг булга булга унагаасаар гарч иржээ. Өөрт нь зориулсан хоолыг Бхимасена идэж байхыг мангас хараад галзууртлаа уурсан Кунтигийн хүү рүү ноцов. Мангас нэг цохиод авчээ. Гэтэл залуу баатар эр хөдөлсөн ч үгүй. Тэгэхээр нь догшин Бака ургаа модыг орвонгоор нь булга татан Бхимасена руу шидэж гэнэ.

Бхимасена инээгээд өнөөх модыг зүүн гараараа шүүрэн барьж аваад өөр рүү нь шидчихжээ. Тийнхүү тэр хоёрын тулалдаан эхэлж,ургаа модыг булга булга татан ойр хавийнхаа ойг салам устгаж байв.Тэгсээр Бака Бхимасена руу дайрч лут хоёр гараараа тэврэн барьж авав. Гэвч тэр хоёрын хав барил удаан үргэлжилсэнгүй. Мангас цуцаж ядраад амьсгаа дээр гарч байхад нь Бхимасена түүнийг тэр дээр өргөж байгаад газар хүчтэй савж унагахад мангас нэгэнт босч чадахаа больжээ.

Тэр хорлонт мангас Бака нэг муухай гэгчийн дуу тавин хашгирснаа Бхимасенагийн хөлд хөглөрөн унаж амь тавив.

Баатар эр мангасын хүүрийг үүрч ирээд хотын хаалганы дэргэд хөсөр хаячаад явахыг хэн ч харсангүй. Өглөө нь хүмүүс босоод харахад хотын ханы дэргэд мангасны цусан нэлий болсон хүүр уул овоо шиг сүглийн байхыг олж үзээд ихэд гайхалдан гайхалдан чухам хэн биднийг аврав гэж таацгаах болжээ. Гэвч өвгөн бярман дуу гарсангүй, Пандугийнхны нууцыг хадгалжээ.

Бака мангас үхсэн мэдээ ойр хавийн газар нутгаар түгэн тархав. Олон тосгодын баяр хөөр болсон хүмүүс хотыхонтой хамтарч тэр аз завшаан гайхамшигт үйл хэргээ ёслон тэмдэглэх гэж Экачакра руу цувжээ. Пандугийнхан хуучин хэвээр өвгөн бярман овоохойд амьдарсаар л байжээ.

## V

Панчал нарын хаан Друпада өөрийн охин Друпадыг хадамд өгөх гэж байна гэсэн мэдээ Экачакрад иржээ. Тэр хааны охин ер бишийн гуа болохыг хорвоогоороо ярилцдаг байжээ. Түүнийг нүд лянхувын дэлбэ шиг, үс хав хар гол шиг бие цогцос нь уран налархай. Тэр охиныг ертөнцөд мэндлэх өдөр нь энэ охиныгоо үзэсгэлэнгээс болж Кшатри нар мөхөх болно гэж үл үзэгдэх хүний дуу гарсан юмсанжээ.

Нум сум харвах тэмцээнд түрүүлсэн хүнд охиноо өгнө гэж Друпада хаан зарлажээ. Тэр тэмцээнд оролцох гэж улс гүрэн бүхнээс нэртэй төртэй хаад баатар дайчид Панчалын нийслэл хотноо иржээ. Панчалын орноос ирсэн мэдээг Пандугийнхан дуулаад тайван сууж чадахаа больжээ. Үзэсгэлэн гуа Драупада тэднийг санаанаас гарахгүй тэмцээнд орохсон гэсэн хүсэл мөрөөдөл дийлэгдэхгүй болжээ. Кунти эх нь хэлсэн нь: “Хүүхдүүд минь, бид энд ирээд уджээ. Эндхийн ой шугуй, уул мөрөнг дахин дахин харсаар байтал одоо бүр уйтгартай болжээ. Панчалчуулын оронд очвол яадаг юм, тэнд мод их баяр ннадам болж гайхалтай сайхан юм гарах юм байна” гэж ээ.

Пандугийн хөвгүүд үлэмж их баярлан алсыг зорих аяндаа төдхөн бэлдэж аваад толгой хоргодуулж байсан өвгөн бярмантайгаа салах ёсыг гүйцэтгэн эхийнхээ хамт Экачакра хотыг орхиж явжээ. Хэд хоног яваад хөл хөдөлгөөн цайз тааралдсан нь Друпадагийн хааны нийслэл мөн байжээ.

Пандугийнхан хотод даяанчид шиг хүрч ирээд хотын хаалганы ойролцоох нэг ваарчныд суужээ.

Нэр цуутай, хүчирхэг олон хаад, ноёд, зарц, түшмэд, цэрэг эрсээ дагуулсаар Панчалын нийслэлд хүрэлцэн иржээ. Бас мадрын дийлэгдэшгүй хаан Шалья ирсэн байна. Хотын захын суваг ба хэрмээр хашсан талбар дээр хаад ноёд нум сум харвах наадам хийх ёстой байжээ. Хэн, аварга том нумын хөвчийг татаж харваад жижигхэн сүвэгчээр оруулан гаргаж байг оносон хүн хааны охиныг авах ажээ.

Тэмцээн хийх өдөр болов. Хаад ноёд тэмцээний талбайд ээлж дараагаараа гарч ирсээр гэвч ер бусын нумыг татаж хүчрэх хүн байсангүй. Тэгтэл эгэл хүмүүсийн сууж байсан байрнаас Аржуна аз хийморио туршиж үзэхээр босч ирэв. Тэмцээнийг харж суусан бярманууд шуугилдан “Хүчирхэг хаад татаж хүчрээгүй нумыг ийм балчир даяанч яаж дийлэх юм бэ? Бярман язгуурын нэр хөөдөхийн л нэмэр” гэлцээд зориглож боссон залууг буцааж суулга гэж хашгиралджээ. Гэтэл Аржуна нуманд хүрч очин өргөөд нүд ирмэхийн зуургүй хөвчийг нь татаж нэг зараар таван сум тавив. Тавтсан сум нь бүгд сүвэгчээр нэвтрэн гарч зохих байгаа бүгд онов.

Гайхаж биширсэн үзэгчид суудлаасаа босч хашгиралдан алга ташиж, дийлсэн тэр залууд баяр хүргэжээ. Наадмын талбайд шуугиан намдахгүй үргэлжилж дууч үлгэрч хуурчид тэр танихгүй сайн эрийг магтан дуулцгаав. Сүйт хүүхний цагаан хувцсыг өмч зүйл зүйлийн цэцгэн чимэглэл гуа үзэсгэлэнтэй бор царайт хөөрхөн Драупади мишээсээр босч өөрийн суух хүн сайн язгуурт Аржунагаа угтан очлоо.

Друпада хаан танихгүй нэг даяанчид охиноо өгч байхыг хаад ноёд хараад уур хилэн нь бадарчээ. “Яалаа гэж энэ муу Друпада, охиноо гуйлгачин даяанчид өгч байгаа юм бэ? Энэ бол бид бүгдийн даажигнаж байгаа хэрэг гэж дуу алдацгааж босч ирээд Друпадаг сэлэмдхээр занаж байна. Друпада хааныг өмчөөр Аржуна Бхимасена хоёр босов. Бхимасена балтаараа хага цохисоор дайрагчдыг зогсоов. Тэгтэл хаадын цөөрсөн эгнээн дундаас Карна, Шалья хоёр гарч ирээд Пандугийн хоёр хүүтэй үзэлцэж алдлаа. Аржунагийн мөндөр мэт буулгасан суманд Карна тэсэлгүй ухрав. Бхимасена, Шальяг бүснээс барьж өргөж газар шидэхэд тэр дахин тулалдах чадахгүй дийлдсэнээ хүлээхээс аргагүйтчээ.

Аржуны өрсөлдөгч дийлдэж урам нь хугараад панчалуудын нутгаас өөр өөрсдийн улс гүрэндээ буцацгаажээ.

Маргааш нь Друпада хаан хүргэн хүү түүний садан төрлийг их найр хуримандаа урьжээ. Друпада хаан, хаадыг дийлдэг тэр эрчүүл ер нь ямар улс

болохыг мэдэж авахыг хүсч,өөрийнхөө ордон доторх найрын ширээнүүдийг тойруулан төрөл бүрийн жимс үнэт арьс хнгийн үс,тариачан хүний хэрэглэдэг багаж зэвсэг янз бүрийн эд бараа, алт эрдэнийн чулууг чимэгтэй буу зэвсэг, хуяг дуулга хоёр талдаа иртэй сэлэм, балт, нум, жад өрөн тавиулжээ.

Яг товолсон цагт нь ханхар дал мөрөн дээрээ гөрөөсний арьс нөмөрсөн баатар эрчүүл арслангийн зоригт алхаагаар ордон дотор нь орж ирээд тансаг баян суудлуудыг ердөө ичих зовох янзгүй эрэмгий зоригтой эзлэн суухыг Друпада хараад зүрх сэтгэл нь баяр хөөрөөр бялхжээ.Найр хуримн дараа Пандугийн хөвгүүд ордон дотуур явсаар шууд дайн байлдааны зэр зэвсэгт хүрч очоод авч үзэн эргүүлж тойруулан сонирхож байхлаар Друпада хаан тэднийг сурвалжит дайчид эрс юм гэж эргэлзээгүй итгэжээ.

Друпада тэдний дэргэд очиж “Та нар ямар улс вэ? Ямар овгийн хэн хэн гэгч баатрууд вэ? үнэнээ хэлж өгөөч” гэхэд Юдхиштхира түүнд хариу өгсөн нь: Хаан минь бүү зов, бид бол Куругийн удам нэрд гарсан кшатри хүмүүс алдар цуут Пандугийн хөвгүүд байна гэлээ. Хаан Пандугийн хөвгүүдийг эхийнхээ хамт давирхайдсан модон байшинд шатаж үхсэн гэж урьд сонссон тул ихэд гайхав. Тэгэхлээр нь Юдхиштхира Дурйоханагийн хорон санаанаас яаж мултарч гараад бярман зүс хувилган тэнүүчилж нуугдаж явсан хэрхэн Драупадын ураг холбох хурим нарын тухай сонсоод Панчалын нутагт ирснээ хаанд нэгд нэггүй ярьж өгөв. Хаан эрэлхэг баатар Пандугийнхантай ураг барилдсандаа баярлаж тэднийг ордондоо суулган улс гүрнээ буцааж авахад Юдхиштхирад хүчин туслана гэж амлаж гэнэ.

## VI

Дурйохана атаархал айтаг хоёрт хэлмэгдсээр панчалын орноос Хастинапурт буцаж иржээ. Эргэж ирсэн тэр өдрөө түүний шамдан шаардсан хаан Дхритараштра ордондоо зөвлөгөө хийлгэжээ. Тэр зөвлөгөөн дээр Бхишма, Дрона, Карна, мэргэн Видура бүгд л иржээ. Пандугийнхан амьд байна. Тэд Друпадатай ураг холбоод манай улс гүрнээс хагасыг нь өвлөн авах ёстой эрхээ шаардаж байна гэж Дурйодхана зарлав. Пандугийн хөвгүүдийг үгүй хийхийн тулд Дурйохана энэ удаа ч нууц, хорон санаат арга зохиогоод хордуулах шууд алах мэт янз бүрийн арга мэх сэдэжээ. Чи Пандугийнхныг нууцаар хөнөөх гээд чадаагүй шүү дээ.Тэгэхлээр тэднийг хүч олж дэвжээгүй байгаа дээр нь шууд дайлан очоод устгачхаач” гэж Карна өчив. Гэтэл Бхишма Дрона Видура гурав түүнтэй санал нийлсэнгүй. Манай улс гүрний тэн хагас

нь Пандугийнханд өвлөж очих ёстой билээ. Тэрнийг л өгч орхи тэгвэл тэд таны нөхөд холбоотон болно. Тэгвэл таныг давирхайтай байшин галдсан гэж түмээрээ жигшихээ болино” гэж тэд хаандаа хэлэв.

Хаан ч Пандугийнхантай байлдахаас зүрхшиж тэднийг нутагтаа буцаж ирээд эзэмшиж захирах хэсгээ ав гэсэн урилгатайгаар Видураг элч болгон зарж явуулав.

Тэгээд Пандугийнхан Панчалын хаантай салах ёс гүйцэтгээд эх Кунти Драупада хоёрыгоо аваад Хастинапурт буцаж ирэв гэнэ. Тэднийг ордонд орж ирэхэд Дхритараштра хаан өгүүлсэн нь: Пандугийн хөвгүүдээ би та нарт улс гүрнийхээ хагасыг нь өгсөн байна. Улс гэрийн дотор аливаа хэрүүл маргаангүй байлгахын тулд та нар минь өөрсдийнхөө өмчлөх нутаг усанд орд харшаа барин оршин сууцгаа гэжээ.

Пандугийнхан алс холын балар ойд шинэ хот барьж эхэлжээ. Тэд мод хөрөөдөж газар ухаж цайзны хана цамхаг босгон эрдэнэсийн чимэгтэй орд харш ард олныг оршин суух байшин сав барьж урт шулуун гудамжуудтай болсон тэр хотоо Индрапрастха гэж нэрлэжээ. Тэр хотруу гар урчууд худалдаачид бярман нар цэргийн хүмүүс дуучин хөгжимчин хүмүүс цувж эхэлжээ.

Шинэ хотын гуа үзэсгэлэн баян чинээлэг Пандугийнхан хүч чадал энэрэгч сэтгэл газар сайгүй магтагдан дуурсах болов.

Асур нарын нэрд их гарсан уран барилгачид Майя Индрапрастхад нэг ирсэн юм байж. Тэр хүн Юдхитхирад бараалхаж хэлсэн нь: Эзэн хаан чи соёрх би чамд аянгын бурхан Индрагийн тэнгэрийн ордон шиг бөгөөд энэ дэлхий дээр урьд хожид байгаагүй тийм орд босгож өгье. Би хойш Гималайн цаст оргил өөд явья. Тэндэх уулын нэг нуурын эрэг дээр би урьд үлэмжийн их үнэт эрдэнийн чулуу хураагаад орхисон юмдаг. Тэнд урьд догшин аваргууд тахилаа өргөдөг байсан юм. Би тэр их үнэт эрдэнийн чулуудаараа ордны чинь ханыг хийнэ. Тэгвэл орд чинь яг од шиг гялалзаж байх болно. Тэр нуурын ёроолд аваргуудын балт бий. Тэр эгэл цэргийн арван түмэн балттай тэмцэнэ. Би түүнийг чиний дүү Бхимасенад авч өгье Аржунад зориулан тэндээс би урьд цагт гол мөрөн нуурын бурхан Варунагийн өмчилж байсан ховор дунгийн ясан бүрээ авчирна. Тэр бүрээний дуугаар дайсан дагжин чичирдэг юм гэжээ. Майя тийнхүү Пандугийнхны зөвшөөрөлтэйгээр тийшээ яваад амалсан бүхнийгээ авчирчээ.

Майя Пандугийнхны нийслэл хотод уртаараа таван мянган тохой багана алт хана нь эрдэнийн чулуун чимэгтэй баримал чимэг бичиг бүхий маш олон цамхаг дааман халбагатай тийм орд барьжээ. Ордны нам гүмийн дотор зөөлөн салхи сэвэлзэнэ. Тэр ордыг асар том агуу хүчтэй улаан зэсийн өнгө шиг нүдтэй, сум шиг хурц чихтэй, дуртай цагтаа шувуу шиг тэнгэрээр дүүлэн нисч чадах тийм найман мянган догшин Ракшас харж хамгаалах болжээ. Уран барилгач, ордны дотор гуа сайхан усан цөөрмийг гантиг чулуугаар хийжээ. Усны дээгүүр гайхмаар сайхан лянхуа цэцэг алт, маргад навчаа дэлгэн хөвж явна. Хажуугаар нь ховор ганган шувууд хөлхөж усан сангийн дотор алтан загас, яст мэлхий хөвнө. Ордны бусад ханын хажуугаар нь далбагар модод хүрээлсэн цөөрөм бас олон ажээ.

Юдхиштхира ордондоо орох цаг болоход их найр хурим болсон бөгөөд түүн дээр олон хаа, бярман, дуус, үлгэрч хөгжимч нар ирж ууж идэхдээ өгөөмөрч Юдхиштхира уран чадварлаг Майя барилгач хоёрыг тэнгэрт тултал магтацгааж байжээ.

Тийнхүү Пандугийнхан эд баялаг алдар хүндийн алинаар нь дуталгүй агуу том ордондоо элбэг дэлбэг амар жимэр амьдран суух болжээ. Гэтэл нэг өдөр Аржуна ахдаа хэлсэн нь: Эзэн ах минь бид юугаар ч дутаагүй бидэнд юм бүгд байна. Ойр хавийн улс гүрнүүдийг эзэлж аваад алба татвар төлүүлбэл яадаг юм гэжээ. Юдхиштхира зөвшөөрч аян дайнд морджээ.

Аржуна хойшоо, Бхимасена зүүнчээ, Сахадева урагшаа Накула баруун зүг тус тус морджээ. Тэд харь улсын хаадыг бут цохиод Юдхиштхирагийн дагаар оруулан Индрапрастдаа цэргийн их олз омогтой эргэж ирлээ. Пандугийнхны эрдэнэсийн сан нь үнэт эрдэнэ алтаар дүүрч зуун жил зараад бархааргүй болжээ.

Юдхиштхирагийн засаг төрийн нүүрэн дээр дэлхий даяараа энх тунх ээлтэй сайхан цагийг эдэлж байжээ. Газар тариалан ба худалдааны ажил цэцэглэн мандаж, хулгай дээрэм үгүй болж хүнд хүчир алба үл амсах, ард нийтээрээ чинээлэг аж төрөх болж эзлэгдсэн улс гүрний дотор ч дургүйцэн босох хүнгүй байжээ. Тэгээд Юдхиштхираг хүн төрөлхтний дотор хамгийн дээд эрхийг оллоо гэдгийг дэлхий даяар зарлан мэдэгдэхийн тулд Паундагийн хөвгүүд асар их тахил өргөхөөр шийджээ.

## VII

Юдхиштхира тэр тахилгадаа хөрш хаад холбоотон болон мэдлийн доорх улсуудын эзэд түүнчлэн Хастинапурт байдаг өөрийн ах дүү саданг ч урьжээ. Пандугийнхны ордыг Дурйохана их л гайхан сонирхож өрөө дамжсаар явахдаа ийм гуа сайхан ийм их үнэт баян юмыг энэ насандаа энэ дэлхий дээр үзсэнгүй нэн нууц гунигт автан бодож байжээ.

Нэг өрөө нь усан болороор хийсэн шалтай байжээ. Дурйохана түүн дээр гишгэхдээ энэ лав ус байна гэж санаад хувцсаа норгохгүй гэж хормойгоо шуужээ. Өөр нэг өрөөнд орвол болор шиг тунгалаг устай усан сан байж. Дурйодхана энэ бас шал байх гэж бодоод шууд алхтал усанд унажээ. Шолбойтол хороод сандарч байгаа Дурйоханаг хүчирхэг Бхимасена олон дагуул зарцынхаа хамт хараад түүний эндүүрснийг шоолон их л чанга чанга инээлдэв гэнэ. Бас Дурйохана усан болрон хаалгыг анзааралгүй онгорхой газар байна гэж явж очоод духаа өвдтөл мөргөчихжээ. Паундагийнхан гийчид боллон зарц нар түүнийг бас шоолжээ. Дурйодхана бүр дотор нь муухайрч элий балай болох шиг болоод хүний нүүр өөд ч харж чадахаа болив. Тэгж яваад онгорхой хаалга руу очихдоо мань хүн бас л үзэгдэггүй усан болор хаалга байна гэж бодоод дахин мөргөчихгүйн тулд хоёр гараа урдаа барин хий түлхчихсэн чинь хүчиндээ ухасхийгээд ойчоод өгчээ. Улсууд улам чанга инээлдэв. Дурйодхана уур хилэн бадарч ордноос сүрдхийн гараад тэр өдөртөө Индрапрастхагаас яваад өгчээ.

Гэртээ харьж ирээд мань эр Пандугийнхан хичнээн аз хийморьтой амьдарч яваа тэдний оронд өөрөө мундраа тарьж улс амьтны элэг доог болж байснаа эгдүүтэйгээ гуниглан бодоод хотын гудамжаар тэнэж явжээ. Дурйодхана атаа жөтөөндөө тарчлан түүний амьдрал хувь заяа нь Пандугийн хөвгүүдийнхнийг бодвол даанч доожоогүй санагдана. Гуниж гутрах атаархаж жөтөөрхөхөөс болоод түүний бие зуны аагим халуунд хатаж байгаа цөөрөм шиг л болж байна. Үхэх юмсан гэсэн бодол түүнийг дийлэх болж иржээ. Тэгээд Дурйодхана өөрийн нагац ах бөгөөд Гандхарын хаан Шакунид очиж өөрийнхөө зовлонг тоочжээ. Шакуни түүний үгийг сонсоод ийн хэлрүүн: “Битгий гутар чи ганцаараа биш Дурйодхана минь. Чамд садан төрөл анд хань холбоотон байна. Чамайг зовлонд учрахад тэд чинь хаяхгүй харин тусална. Харин Пандугийнхныг зэвсгийн хүчээр дийлнэ гэж горилохын хэрэггүй шүү. Тэд дэлхий дахиныг эзэлжээ. Тэдний цэрэг тоогүй олон сан хөмрөг нь хэмжээлшгүй их холбоотон хар нь хүчтэй, зэр зэвсэг нь дийлдэшгүй. Бид тэднийг

гагцхүү ов мэхээр дийлж эрдэнэс баялгийнх нь эзэн болж чадна. Юдхиштхира бол даалуу тоглох хорхойтой боловч муу тоглоомч гэдгийг би мэдэж байна. Нэг тоглоод эхэлвэл тэр чинь болихоо мэддэггүй хүн. Түүнийг нааш нь Хастинапурт уривал зохино. Надтай даалуу тоглог. Даалуу тоглох талаар надтай энэ зэрэгцэх хүн энэ ертөнцөд байхгүй. Би тоглож хожоод юмыг нь чамд авч өгье. Тэгвэл чи аз жаргалыг амсах болно. Дхритараштра хааныг зөвшөөрүүлэх ганцхан арга байна гэж ээ. Тэр хоёр хаандаа бараалхан очоод Дурйодхана нь Пандугийнхны ийм их сүр жавхланг би тэсэж чадахгүйн ээ. Хэрэв эцэг та надад тус хүргэхгүй бол амиа хорлоно гэв. Хаан хүүгийнхээ амь насанд хүрэхээс айхдаа Шакунийн сэлсэн санааг зөвшөөрчээ.

Дхритараштра уран барилгач зураач мужаан, чулуучин нарыг өөр дээрээ илрүүлэх зарлиг буулгаж ирүүлээд богино хугацааны дотор олон зуун хаалга, мянган баганатай сүрлэг гоо үзэсгэлэнтэй орд барихыг зарлиг болгожээ.

Ордоо барьж дуусмагц хаан Индрапрастха руу элч зарж Юдхиштхираг шинэ барьсан ордон үз. Каурыхантай даалуу тоглож нарги гэсэн урилга өгүүлжээ. Юдхиштхира элчийн хэлэх үгийг сонсоод: “даалуу тоглоно гэдэг чинь дэмий ажил байна. Хэрэв би Каурыхантай тоглох юм бол лав хэрүүлгүй салахгүй. Гэсэн ч би тэгж өдөөд байгаан бол очихгүй байж эс чаднам. Пандугийнхан хожигдохоос хулчийгаад байна гэж бодож магадгүй” гээд аян замд бэлдэхээр зарлиг буулгажээ. Пандугийнханыг бэлдсэн суудалд суухад Шакуни босч Юдхиштхирад хандаж хэлэдээ: “Эзэн минь өөрөө дүүрэн хүн байна бүгд таныг хүлээж байсан юм. Одоо суугаад даалуу тоглоцгооё гэж ээ. Юдхиштхира “За яахав харин луйваргүй тоглоно шүү. Би мөрийтэй тоглоомч хүн биш би бол цэрэг эр. Цэрэг эр бол тулалдахдаа ч шударга байх ёстой билээ. Луйвраар олж авсан аз жаргал, эд баялаг, надад хэрэггүй” гэхэд Шакуни “Дайнд ч эрдэм номд ч нэг нь нөгөөгөө дийлж ирсэн хэзээний жамтай. Аль чадвар муутай нь чадвартайдаа дийлдэг юм. Тэмцэл хийхэд аль аль нь дийлэхийг хичээдэг. Хүчтэй нь хүчгүйгээ дийлдэг ийм хуультай. Хэрэв чи хульчийж байвал тоглохоо боливол барав биш үү” гэв.

Юдхиштхира тийм өдлөгөөс татгалзаж чадалгүй тоглож эхэллээ. Шакуни заль мэхэнд мэргэжсэн хүн болохоороо тавьсан мөрийг нь авч эхлэв. Юдхиштхира эхлээд нэг үнэтэй сувдаа алдаж дараа нь сав хайрцганд хадгалаастай алтан зоосуудаа, цагаан торьд хөллөдөг сүйх тэргээ (Агни Бурханы бэлэг ажээ) гоёлын хувцас өмсгөлөн дуулж эрээ, гоёл чимэгтэй дайны мянган заанаа, алтан чимэгтэй зэвсгээ алдав.



Пандугийнханы хамаг эд баялаг луйварчин Шакунигийн гарт тийнхүү шилжиж байгааг Видару үзээд зэвүү нь хүрч Дхритараштрад хэлсэн нь: “Хаан тинь тоглоом зогсохыг зарлиг болгооч, манай удам төрлийн гай болсон Дурйодханаг цаазаар авхуулах зарлиг буулгаач. Шакуныг ирсэн газарлуу нь хөөж явуулаач. Энэ бузар тоглоомын хар гайгаар манай ертөнцийн хүмүүс мөхөн сүйдхэн байна шүү. Пандугийнхантай байлдуулахгүй бай арга хийгээч гэв”

Хаан Видаругийн үгэнд орох гэж байх эмээсэн Дурйодхана өндөр дуугаар “Видару чи чинь хэзээ бидэнд сүй болж байлаа. Чи бол дайсанд маань тусалж биднийг хөнөөхийг зорьж байна. Явж сайн нэрээ бодсон чинь дээр биз. Мэддэг нь чи биш хаан өөрөө байна” гэжээ. Шакуни Юдхиштхирагаас Пандугийнхны бүх мөнгө, эрдэнэт баялаг үхэр хонин сүрэг бүх хүн ам байшин барилга орд харштай нь мөрийд тавиад бас алдчихжээ. Дараа нь өөрийн бүх зарц даамлуудыг хувцас хунартай нь тавьж алдаад хов хоосон болохтой зэрэг хэдэн дүүгээ мөрийд тавин нэг нэгээр нь цувуулан алдав. Ингэхэд нь Шакуни” Хаан гуай, одоо танд мөрийцөх юм үлдэв үү? гэж асуухад Юдхиштхира “Би өөрийгөө тавиагүй байна шүү. Одоо өөрийгөө тавилаа гэжээ. Өөрийгөө ч алдаж орхижээ. Юдхиштхира чамд тавих юм бас үлдсэн үү гэж Шакуни хэлэв. Юдхиштхира, Драупадыг мөрийд тавихад хүн бүхэн балмагдав. Пандугийнхан гуьнж гутарч байгаагаа нууж чадахаа больж, Видура бүр толгойгоо хоёр гараараа барин доороо гишгих газаргүй болсон хүн шиг сууж байнаж. Энэ болсон бүх явдлыг шохоорхсон сохор Дхитараштра ойр дотны хүмүүсээс “За яав, хожигдоо биз тэр гэж асууж байв. Карна Дурйодханагийн дүү Духшасана хоёр Пандугийнхны баларч байгаад баярлахдаа чанга чанга инээлдэж байв.

Юдхиштхира энэ удаан ч бас хожигджээ. Пандугийнханд үлдсэн юм юу ч үгүй “Яагаад Драупад аваад ир гэж баяр Дурйодхана Видаруд тушаав.

Видару хилэн бадруулж мөчөөрхсөн нь”Муу өлзийт чи ийм этгээд үг хэлснээрээ өөрийгөө олсоор хүлснээ мэдэж байна уу? Дурйодхана чи Пандугийнхны өмч гэрт гар бүү хүр, тэднийг бүү боолоо болго. Дайсныгаа дайн тулалдаан биш луйвардаж тоглоод эрхэндээ оруудаг улс шившгээ тарих болтугай” гэжээ. Ёрын муу Видура айгаад хамаг бие нь чичирч байна гэж Пандугийнхнаас айсандаа тушаал биелүүлж чадалгүй хоосон буцжээ. Тэгэхлээр нь Дурйодхана өөрийнхөө хүү Духшасанад “яваад амаар элс бол албаар аваад ир” гэж хэлэв. Духшасана, Драупадигийн өмнө очиж Каурынхан чамайг даалуугаар мөрийцөн хожсон учир чи одоо тэдний боол болсон гэж зарлажээ. Драупади энэ үгийг сонсоод нүүрээ хоёд гараар таглаж ордны

доторх бүсгүйчүүдийн амрах өрөө рүү гүйв гэнэ. Гэтэл Духшасана түүний хойноос гүйцэж очоод үсдээд авчээ. Хөөрхий Драупадигийн өрөвдөлтэй орилон хашгирахыг үл ойшоосон Духшасана түүнийг чирсээр тоглоомын газар авчирчээ. “Боол бүсгүй, боол бүсгүй” гэж Духшасана онгирон инээж хашгирахад түүний ах дүү нар хоолой нийлүүлж байв.

Пандугийнхан гүн гашуудалтайгаар уруу царайлан зогсож байлаа. Драупадыг тийнхүү доромжилж байгааг Бхимасена тэвчиж хэрхэн ч чадсангүй Юдхитхирад хандан “Чи ийм нэр хөөдсөн юм яагаад хийж байгааг юм. Сахадева, гал аваад ир. Юдхитхирагийн гарыг шатаагаад өгье би” гэж хилэн бадруулан хашгирав. Гагцхүү Аржуна л түүнийг хорьж “Уураа тат. Бхимасена Дайсан бүгдээр элэг доог хийхийг харахад чамд хэцүү байгаа л даа, гэхдээ хоорондоо бид химлэлцвэл дайсны бах тав ханах биш үү, тэгж болохгүй гэв.

“Ий хөөрхий би гэж ийм заяагүй амьтан болох гэж. Эцгийн дээ байхад ч, эр нөхрийндөө ирээд ч дээрэлхүүлж, доромжлуулд ор үзээгүй юмсан. Харь элгийн хэн ч болтугай намайг ширүүн харж үзээгүйсэн. Гэтэл энд намайг юу болгоод байна вэ? Би боол гэж үү? Сайн язгуурт эрцүүл минь минь над хэлээд өгөөч би боол уу, биш үү?” гэж Драупади цугалсан олонд хандан цурхиран уйлав. Ингэхэд нь: Тийм ээ, чи боол Драупади боол хүний хүү ч, эхнэр нь ч боол байдаг шүү дээ. Дотор өрөөнд ороод хатдын шивэгчин бол хэрэв хүсвэл өөр хүнтэй суу, тэгвэл чамд ийм хувь тавилан ирэхгүй болно” гэж өчив. Энэ үгийг Дурйодхана чи намайг илэнц хуланц руугаа тонилхын наана энэ хэргээ цусаараа төлөх болно гэж ихэд хилэгнэн хашгирав.

Яг энэ агшинд чив чимээгүй болох завсар цөөвөр чоно аль хэг зүгээс аягүй муухай ульжээ. Ордны хананы цаадах цэцэрлэг дотор жигүүртэн шувууд түгшин шуугилдаж эхэлжээ. Хааны ордонд бас цэрэг эрсийн зүрх түгшин балмагдав. Энэ бол Куру овгийнхны мөхлийн аймшигт муу ёр орлоо гэдгийг бүгд ухаарчээ. Дхритараштра хувь тавилангийнхаа эрхээр хүүдээ ийн хэлрүүн: “Дурйодхана минь чи ичих нүүрээ баржээ. Чи яах гэж Драупадын охиноор элэг доог хийнэ вэ? гээд Драупадид хандаж “Ая хааны охин чи хүслэнгээ хэлж аль. Бурханы тааллаар тэр бүгдийг чинь би биелүүлнэ” гэжээ.

Драупади өөрийгөө болон Пандугийнхныг эрх чөлөөт хүмүүс болгожээ. Хаантан минь түмэн насла. Таны өршөөлт сэтгэлээр Пандугийнхан чөлөөт иргэд болж эд баялгаа дахин өөрсдөө эзэмдэж явах боллоо” гэж Драупади хэллээ. Дхритараштра, Пандугийнханд хэлэхдээ” Сэтгэл амар явж очоод улс гүрнээ

захирцгаа, эд агуурсаа эдлэн жаргацгаа” гэжээ.Тэгээд мөрийд тавьж алдсан бүх юмыг нь эргүүлэн өгөөд тэднийг Индрапрастха руу нь буцаажээ.

### VIII

Хааны талбиун сэтгэлд Дурйодхана урвайжээ. Буцааж өгсөн эрдэнэт хасуурч, бас Пандугийнхантай өстөн болсондоо айж байна. Дахиад эцгийгээ ятгаж эхлэв. “Эцэг минь Пандугийнхан бидэнд ингэж доромжлуулчхаад зүгээр өнгөрөөхгүй. Тэд цэрэг эрс холбоотноо аваад заавал ирнэ. Тэр цагт бид амьд гарахгүй. Одоо л бид Пандугийнхныг буцааж ирүүлэх зарлига буулга. Биднийг тэдэнтэй дахиж даалуугаар мөрийцхийг соёрхооч. Дийлсэн маань балар ойд арван хоёр жилийн хугацаатай сууж арван гуравдах жилээ танигдалгүй өнгөрөөе. Хэрэв танигдчихвал цөллөгөө дахид арван хоёр жилээр сунгая. Шакуни бол авхаалжтай тоглоом ч хүн учир зайлшгүй хожно.Эцэг минь ингэж хэдэн хүүгээ авраач” гэхэд Дхритараштра жаахан тээнэглэзнэж байснаа хүүгийнхээ үгэнд орж, Пандугийнхны хойноос элч илгээжээ. Элч тэднийг замд нь гүйцэж очоод: Буцацгаагаарай та минь Юдхиштхираг даалуугаар дахин тоглуулахаар хаан шийдсэн байна” гэжээ.Энэ бол урилга зарлиг хоёр гэж Юдхиштхира хэлээд “ Бидэнд эмгэнэлтэй явдал болохыг би мэдэж байна, гэвч яана гэхэв. Дхритараштра хааны үгээс гажиж болохгүй гэв. Ингээд өөрийн дүү болсон Драупадаг дагуулан буцаав.

Юдхиштхираг даалуу тоглохоор дахин суухад Шакуни түүнд ингэж хэлжээ: “Өвгөн хаан та харт эд агуурсыг чинь эргүүлж өгсөн. Энэ сайн хэрэг. Харин одоо ингэж тохиролцъё. Хэрэв бид хожигдвол бугын арьс нөмрөөд арван хоёр жилийн хугацаагаар балар ойд цөллөгөнд явъя, арван гуравдах жилд нь нэг газар танигдахгүйгээр аж төрнө хэрэв танигдчихвал цөллөгөндөө дахин явна.Хэрэв бид хожвол та нар яв гэв. “Над мэтийн хаан хүн энэ мэт өдөлтөөс зайлхийх юм гэж Шакуни арай бодоогүй биз? гэж Юпхиштхира хэлэв.Тэр хоёр даалуу тавиад Шакуны аанай л хожчихжээ.

Тэгээд Пандугийнхан цөллөгөнд явах нь тэр. Тэд хааны хувцсаа тайлж бугын арьс нөмөрцгөөв. Духшасана, тэднийг хараад баярласандаа “Өнөөдрөөс эхлэн Дурйодхана бүхний эзэн боллоо.Яв явсаар омог бардам Пандугийнхан үйл тамаа эдлэх болжээ. Өнгө жавхлан сүр сүлдээ алдаж,эдлэх баялаг, эзэмших улс гүрэнгүй гуйлгачид шиг битүү ой тайгаа зүглэж өглөг хишиг горьдон, ойн зэрлэг жимс, ангаар амь зогсоох болжээ. Панчалын хааны хөөрхий гүнж хөөрхий Драупади зэрлэг ой

шугуйд амьдрах түүнд ямар байх бол. Бидний нэгтэй суу тэгвэл чи гай гамшгаас мултарна даа гэж дуу алджээ.

Бхимасена энэ элэг доогтой үгийг сонсоод гималайн арслан цөөвөр чоноруу дайрч байгаа адил урагшаа ухасхийж” өө муу хорон санаат Шакунийг мөрийгөө авав гэж чи одоо баярлаж байгаа вий гэсэн ч чамтай би дайн тулаанаар уулзана даа. Одоо чи миний зүрхийг үмхий үгээрээ сугалж байгаа шиг би чиний зүрхийг гараар суга татна даа” гэж хашгирав. Пандугийнхан ордныг орхиж явахад Бхимасена эргэж хараад инээд алдаж байгаа Дурйодханад хандан: Тэнэг минь Чи удаан баярлахгүй. Би чамайг байлдаж алаад цусаар чинь шороо мялаамз. Миний ах дүү нар чиний булай муу сайн дүү нарыг чинь алаад өгнө гэв.

Пандугийнхан Хастинапураас Вардамын хаалгаар гарч умрыг зүглэжээ. Тэднийг цөлсөн тухай мэдээ хотоор тарахад Хастинапурынхан айж сандран уй гашуу болжээ. Тэд Дурйодханад дургүй байв. Дурйодхана муу санаатай атаач, их зантай, ховдог шунахай хүн. Хотыхонд амар заяа үзэхгүй цаг ирэх нээ гал голомт, гэр бүлийнхээ хувь заяаны төлөө сэтгэл түгшихдээ хотоос гарч цөллөгөнд хөөгдсөн Пандугийнхны хойноос дагаж явахаар санаа шийджээ. “Дурйодхана хаан болсон газар сайнаа үзэхгүй, хамаг юм амарна” гэж хотынхон бодоод хамаг эд хөрөнгө хүн бүлээ авч Пандугийнхны хойноос дайран хөдөлжээ. Биднийг аваад яваач, Дурйодханы мэдэлд бүү орхиоч гэж Юдхиштхирагаас царайчлан гуйжээ. Гэвч Юдхиштхира тэдэнд тус болж чадахгүй байлаа. Тэрүүнд эрх мэдэлд, эд баялаг газар нутаг байхгүй. “Буцацгаа та минь хотод чинь бидний садан төрөл үлдсэн, тэднийгээ харин та нартаа даатгая. Тэднийг минь учрах аливаа гай зовлон халдлагаас хаацайлж байгаарай. Ингэвэл та нар Пандугийн хэдэн хүүд хайртай үнэнч хатан гэдгээ батлах болно гэж Юдхиштхира хэлжээ.

Пандугийнхан Хастинапурынхантай салах ёс гүйцэтгээд морин тэргэнд сууж алсын замдаа гарчээ. Үдэш болж байхад тэд, алс мөрний ариун баньян модонд хүрч усанд нь угаал үйлдээд шөнө нь гагцхүү ус уугаад хоногложээ. Шөнө тэдэн дээр тэнэмэл бярманчууд ирж асаасан түүдэг тойрон суугаад Юдхиштхира болон түүний дүү нар хуучны үлгэр домог ярьсаар үүр цайтал зугаацуулав. Маргааш өглөө Пандугийнхан балар ой шугуйн дотор ороход бярман нар тэдэнд туслах, хэцүү бэрх байдалд орсон тэдний сэтгэлийг тэжээх гэж дагалдан явжээ.

## IX

Пандугийнхан ой тайгад олон жил аж төржээ. Тэд зэрлэг жимс, өвсний үндэс түүн ан араатан, шувуу агнаж, гөрөөсний арьсан хувцас хийдэг байжээ. Ойд тэнэж явахдаа тэд даяанч нарын овоохойд мунгүй олон хүн ноглож, Наль Дамаянт хоёрын хайр сэтгэлийн тухай, үнэнч Савитри хүүхний тухай, Сунду, Упасунду гэдэг эрэлхэг бардам ах дүүсийг хөнөөсөн үзэсгэлэн гуа Тилоттами тухай, Алтан гадас од болж хувилсан Дхривагийн тухай, бурхад, баатар эрс, чөтгөр шулам, гайхамшигт аялал, агуу их алдар гавьяаны тухай эрт урьдын үлгэр домог сонсдог байжээ.

Арван хоёр жилийн цөллөг нь шувтрах дөхөөд байсан нэг өдөр Пандугийн таван хүү ойн цоорхойд гал түлээд сууж байжээ. Тэднийг дагаж явсан өвгөн даяанч өдөр бүр галд барьдаг тахилаа үйлдэхээр завдан байж. Тэгтэл модон дотроос нэг буга цойлон гарч ирээд шууд даяанч руу чиглэн давхиж ирээд түүдгийн дэргэд байсан шилээврийг нь шүүрэн авч модны цаагуур ороод алга болж гэнэ. Өвгөн даяанч бухимдахдаа тэр бугыг барьж шилээврээ авч аль гэж Пандугийнханыг гуйжээ. Тэгээд тэд нум сум жадаа аваад хойноос нь хөөж гарав. Яг гүйцээд очтол өнөөх буга гэнэт алга болжээ. Пандугийнхан түүний тийнхүү гэнэт алга болоход ихэд гайхан зог тусцгаав. Тэд ядарч туйлдаж, ам цангаад өвдөн баньян модны сүүдэрт суухдаа их л хашгиран гайхаж бухимдан байжээ. Юдхиштхира, Накулаг модны орой дээр гарч цангаа гаргах ус цөөрмийн бараа хар гэв.

Накулы модон дээр авирч гараад ийш тийш харвал эргэн дээр нь тогоруу сүргээрээ харагдах нэг сайхан нуур холгүй үзэгдлээ. Накула модноосоо бугаад ус уух, ах дүү нартаа ус авчрах гэж тэр нуур луу явжээ. Накула нуур дээр хүрч очоод уснаас нь уух гэтэл гэнэт дээрээс нэг хүн дуугарчээ. Харвал хүн ердөө ч үзэгдэхгүй байна гэнэ. Гэтлээ: “ хүү минь бүү яар. Энэ сайхан нуур чинь минийх юм шүү. Эхлээд чи миний асуусан асуултанд хариу өг. Тэгсний дараа өөрөө ханатлаа уугаад ах дүү нартаа аваачиж өг” гэх дуу гарчээ. Цангаж туйлдсан Накула тэр үгэнд нь оролгүй нуурын уснаас ханатлаа залгичихаад яг тэндээ үхжээ.

Ах дүү нар нь хүлээж ядав. Тэгээд Юдхиштхира цаадахыгаа бушуул гэж Сахадева хойноос нь явуулав. Сахадева нуурын дэргэд ирвэл дүү нь эргэн дээр нь үхсэн хэвтэж авай. Цангаж үхэх шахсан Сахадева уй гашууд автан ус уух гэж бөхийтөл тэнгэрээс хүний дуу гарч:

“ Хүү минь бүү яар. Энэ бол миний нуур байгаа юм. Эхлээд миний асуусан үгэнд хариу өч. Тэгээд л усаа уу, хэдүйг бол төдийг авч яв гэжээ. Гэсэн ч Сахадева ус уух хүсэл нь дийлдэшгүй байсан тул тэр үгэнд оролгүй цангаагаа гаргасан боловч тэр дороо дүүгийнхээ хажууд амь тавьжээ.

Цаг өнгөрсөөр л, гэтэл ихэр хоёр эргэн ирсэнгүй. Юдхиштхира, хоёр дүү ба усны хойноос Аржунаг явуулжээ. Аржуна нуурын эрэг дээр хүрч харвал хоёр дүү нь үхсэн байв. Уй гашуу уур хилэн болсон тэр нум сумаа зэхэж алан хядагчийг хайж харсан боловч үзэгдэх амьтан ер алга. Тэр ч байтугай ямар ч мөр тэр эрэг дээр байсангүй. Аржуна улам ойртон алхтал гэнэт “Зогс! Чи миний соёрхолгүйгээр ус ууж болохгүй. Эхлээд миний асуусан хариу өч. Тэгээд ханатлаа уу гэсэн үг сонсжээ. Аржуна хариу өчихдөө: “Чи миний өмнө биеэр гарч ирээд надад хориг тавь л даа, гараад ир чи, дахиад чамайг надтай ингэж ярьж чадахгүй болтол чинь би чамайг нум сумаараа хэсэглээд өгье” гээд уснаас балгатал хоёр дүүгийн нь хажууд амь тавин унажээ.

“Дүү нарт минь нэг юм учирсан юм биш байгаа даа” гэж Юдхиштхира бодсоноо яваад наадуулыгаа аваад ир гэж Бхимасенадаа хэлэв. Бхимасена дүү нарынхаа хойноос явж очвол бүгдээр тэр нуурын эрэг дээр үхсэн хэвтэцгээж байхыг олж үзжээ.

Тэрбээр бухимдан цөхрөхдөө алагч гэмтэнг эрж эхлэв. Энэ лав ямар нэг мангас буюу чөтгөрийн гараар үйлдсэн хэрэг, гэж Бхимасена бодсон боловч хавьд юу ч алга байхлаар нь усны зах дээр очоод уух гэтэл “Бүү яар хүү минь энэ чинь миний нуур байгаа юм. Эхлээд миний асуусанд хариу өч. Тэгээд уу” гэх дуу гарчээ. Гэвч Бхимасена хүлээлгүйгээр уснаас уугаад бас л нуурын эрэг дээр нас баран унажээ.

Юдхиштхира, Бхимасенаг бүр хүлээж ядаад өөрөө дүү нараа хайхаар явжээ. Нуурын дэргэд хүрч ирээд тэр нуур түүний орчин тойрон үнэхээр сайхныг гайхан харав. Гэтэл дүү нар нь нэг нь нэгийгээ дэрлэн үхсэн байхашыг үзээд гашуудаж гутсандаа арай л амь тавьчихсангүй. Бүх амьдрал хүсэл найдлагаа хэдэн дүү нартаа бий гэж бодож явдаг ажээ. Яагаад ийм болчихов, хэн ингэж эднийг минь хөнөөв? Хэн эднийг минь дийлдэг билээ? Дурйодхана, яргачдаа нааш нь явуулсан юм биш байгаадаа? Гэвч эргэн тойрон тулалдаж тэмцэл болсон ор мөр огт үгүй, цус нөж ч үзэгдэхгүй, үхэгсдийн нүүр царай дээр хараал зүхлийн шинж тэмдэг байхгүй байв. Гэнэт тэнгэрээс өнөөх нууц дуу гарч: “ би чиний дүү нарыг яма бурханд очих замд

оруулсан юм. Усанд бүү хүр. Наад нуур чинь минийх, эхлээд миний асуусан үгэнд өч, тэгээд хэдийг хүснэ төдийг уу гэв. Сэрдхийн айсан Юдхиштхира чи хэн бэ? бурхан уу, чөтгөр үү? Яах гэж миний дүү нарыг үхүүлэв? Гэж асуув. Энэ үгийг хэлж бараг дуусаагүй байтал өндөр дал мод шиг нуруутай, нар шиг хурц туяарсан царайтай, ширтмэл харцтай аварга биетэн өмнө нь гараад иржээ. “ Дүү нар чинь миний хориглолыг тоолгүй дур мэдэн нуурнаас минь ус авч надад алагдсан юм. Миний асуух гурван зүйлийг хариул тэгвэл чамайг амьд үлдээе гэж хэлэхэд Юдхиштхира “Асуу” гэжээ. Аварга биетэн асуусан нь: “Нарыг хэн захиран мандуулдаг вэ? Тэнгэрт түүнийг хэн дагаж явдаг вэ? Нар юун дээр тогтож байдаг вэ?

Юдхиштхира хариулсан нь “Бярма их бурхан, нарыг захиран газар дээгүүр мандуулдаг, хуулийн бурхан Дхарма түүнийг жаргаадаг. Бурхад түүнийг тэнгэрт байхад нь дагалддаг. Нар бол Чин үнэн дээр тогтож байдаг” гэжээ. Үүнийг аварга биетэн сонсоод:

“ Хаан чи, миний асуусныг зөв хариуллаа. Одоо чи дүү нарынхаа хэнийг нь амьд мэнд байгаасай гэж хүсч байна, ганнцыг л шилж ав” гэв. Юдхиштхира жаахан бодсоноо “Накулаг амьдруулж өг дөө” гэж хэллээ. Аварга биетэн гайхаж “Яагаад Накулаг гэж? Яагаад Бхимасенаг ч юм уу? Аржунагаа хүсэхгүй байдаг билээ? Накула та хоёр чинь хоёр эхээс гарсан улс шүү дээ. Яагаад нэг эцэг эхээс төрсөн дүү нараа илүүд үздэггүй билээ? Гэж асуухад Юдхиштхира “Кунтийн хүүгээс ганц би л амьд үлдлээ. Мадрийн ганц хүү ч болов үлдэг л дээ. Тэгвэл шударга ёсонд нийцнэ гэв.

Юдхиштхирагийн ариун санаа, шударга ёсонд сэтгэл таалсан аварга биетэн санаа шийдэж “дүү нар чинь бүгдээрээ амилаг” гэжээ.

Түүний энэ үг хэлмэгц нөгөө дөрөв үхлийн нойрноос сэржээ. Аварга биетэн хэлэхдээ “Юдхиштхира чи намайг таньж ав, би бол хууль, шударга ёсны бурхан Дхарма байна. Би чиний надад хир үнэнчийг сорих гэж тэр буга болж хувираад чамайг нууран дээр аваачсан юм. Би чамд бэлэг өгч шагнаа, чи юу дуртайгаа сонгож ав” гэлээ. Юдхиштхира “Бүхнийг чадагч Дхарма минь , биднийг цөллөгнөөс үлдэх арван гуравдах жилдээ хаа ч байсан хүнд танигдахгүй болгож өгөөч” гэхэд Дхарма хариу өчсөн нь “Би чиний хүслийг ёсоор биелүүлье. Та нар тэр жилээ Матсын хаан Виратынд өнгөрүүл. Та нарыг хэн ч танихгүй, та нар хүссэн бүхэндээ хувилах

чадалтай болно” гэж хэлээд алга болов. Пандугийнхан юу юу болж өнгөрснийг гайхсаар өөрснийхөө суудаг газар толгой бүтэн тоо бүрэн буцаж очжээ.

## Х

Цөллөгийн арван хоёр жил дуусмагц, Пандугийнхан ой шугуйгаас гарч, урьд найрсаг байсан Вирата хааны хотруу явжээ. Зам зуураа тэд өөрсдөдөө бараа болж явсан бярмангуудтайгаа салах ёсыг гүйцэтгэжээ. Өөрсдийн гэр бүл зарц сүйх тэргүүтнийг панчалуудын хаан Друпасынд явуулжээ. Пандугийнхан Матас нарын нийслэлийн ойролцоо балар битүү ойн дотор газар ухаж зэр зэвсгээ нууж булаад тэр газраа сайн гэгчийн тэмдэглэж аваад хотруу явжээ.

Виратын ордонд Юдхиштхира түрүүлж очив. Бярман хувцас өмсөж гартаа алтан чимэгтэй даалуу барьж эрхэмсэг хааны амрыг айлтгая. Би бол Канка гэдэг бярман даалуунд гарамгай. Намайг албандаа аваач, би таныг завтай цагт тань зугаацуулж байя гэхэд Юдхиштхира өнгө жавхлан дөлгөөн сайхныг биширсэн Вират түүнийг магтаж зөвлөхөө болгон томилжээ. Юдхиштхирагийн дараа Бхимасена гартаа утгуур халбага хоёр барьсаар ордоноо хүрч ирэв. Түүний хүчирхэг бие бялдар, омог бардам шинжийг харсан хэн ч болтугай баатар дайчин эр биш тогооч хүн гэж итгэж үл чадна. Харин Бхимасена өөрийгөө урьд Юдхиштхира хааны тогооч явсан Валлава гэгч байна гэхэд Вират баярлаж, түүний чадварыг шалгаж үзээд хааны ахлах тогооч болгожээ. Энэ мэт Пандугийнхан болон Драупади дандаа эгэл жирийн хүмүүсийн дүрээр Вират хааныд шингэсэн байна. Бриханнала нэртэй болсон Аржуна, хааны охинд хөгжим бүжгийн багш, Накула, Виратын адуучин Сахапева, хааны малчин болжээ. Драупади Виратын хатан Судешанатай уулзаад ордны бүсгүйчүүдийн байранд хатны шивэгчин болсон ажээ.

Виратын алба хаахад өдөр хоног мэдэгдэлгүй өнгөрсөөн байжээ. Харин цөллөгийн арван гурав дахь жил шувтрахын амсар дээр ийм нэг явдал тохиолджээ. Хааны хатан Судешаны дүү хааны жанжин Кичака эгчийнхээ өрөөнд Драупадыг үзсэн цагаас түүний гоо үзэсгэлэнд унаж: Үзэсгэлэнд би унаж гүйцлээ. Чи хайр сэтгэл аз жаргалын бурхан Лагшманатай адил байна. Надад сэтгэлээ өг. Над сэтгэлээ өг, тэгвэл би чамайг алт эрдэнэс, алтан нэхмэл, хувцас хунараар хэмгүй базаана. Миний орд бүх эд агуурс, чиний орд чиний эд агуурс болно. Би цэргийн эрхт жанжин, энэ орны жинхэнэ эзэн нь би, над хайр сэтгэлээ өг. Үзэсгэлэнт хонгор минь



улс гүрэн минь тэр аяараа чиний л төлөө байх болно гэсэн үг хэлжээ. Гэтэл Драупади хариу өчихдөө “Ноёнтон минь, би эр нөхөртэй хүн, түүндээ үнэнч хэвээр үлдэнэ. Хэрэв чи амь насандаа хайртай бол намайг эргүүлдэж ийм хайр сэтгэлийнхээ үгийг хэлэхээ боль гэжээ. Хатны гологдсон хүү зайлсан боловч дотроо гомдон хорсчээ.

Маргааш нь Судешана, Драупадыг даруй авчруулахаар Кичака руу явуулжээ. Цаадах нь бас хайр сэтгэлийнхээ үгийг дэлгэж тэврэхийг оролдоход Драупади мултран сандраад хааны ордонд хамгаалал хайн гүйж ирэн Кичака түүнийг ордны дотор гүйцэж уурандаа өшиглөжээ. Үүнийг Бхимасена харж доромжлогч этгээдийг юу ч үгүй сэглэн хаяхыг завдтал Юдхиштхира дүүгээ барьж “Жил дуусахад хагас сар үлджээ. Жирийн тэвч, өөдгүй амьтанд зохих шанг өгөх болно гайгүй гэв.

Шөнө болсон хойно Драупади доромжлуулж, гашуудсандаа догшин чичирсээр гал тогооны газар Бхимасена дээр ирж өшөөг минь авч аль гэж шалгаажээ. Пандугийнхан хааны охин намайг бүх насаар минь зовох хагацах ийм тавилантай болголоо. Юдхиштхира хөнгөн хийсвэр ашилж, даалуунд хорхойтож нүгэлд унаж улс гүрнээ алдсан гэж гомдол мэдүүлээд, хэрэв Бхимасена, чи Кичакаг амьд үлдээх юм бол би амиа хорлоно гэж Драупади уйлан өгүүлжээ. Бхимасена, түүний гомдол гаргаж буйд сэтгэл хөдлөн маргааш өдөр тэр өөдгүй этгээдийг учрыг нь олно гэж амлажээ.

Дараа өдрийн Бхимасена, ордны нэг өрөөнд хааны хүр дүү Кичакаг отож байгаад галзуу арслан сэт дайран толгойтой үснээс нь шүүрэн барьж өргөөд газар хүчтэй чулуудахад Кичака тэр дороо үхжээ. Бхимасена амь тавьсан Кичакигийн хоёр гар толгойг нь тасчин аваад гал тогоондоо зайлж очжээ.

Өглөө цэргийн жанжны биеийг ордон дотроос олж үл үзэгдэгч алаачийн ер бусын хүчтэйг гайхалдаж байв. Драупадыг сахин хамгаалдаг ямар нэгэн сахиус түүнийг алсан байна гэж хүн бүхэн боджээ. Кичакагийн садан төрлүүд Кичакиг Драупадын балгаар алдлаа гэж зарлаад жанжныг оршуулах түүдгийн галд Драупадыг түүний бэлбэсэн гэргий гэж шатаах нь шударга ёсонд нийцнэ гэлцжээ. Тэд ордны дотор дайран орж ирээд Драупадыг хүчээр хотын хаалгаар чирэн гаргаж оршуулгын гал руу аваачжээ. Драупадын хөөрхийлэлтэй орилон дуу гаргахыг Бхимасена сонсож мөр хөөн асар хол хол үсрэн гүйсээр гүйдэл дундаа нэг мохой булга татан аваад хүүхэн хулгайчид руу хүрч очив. Бхимасена бүгд яах ийхийн

завдалгүй элдэн хөөж, оршуулгын түүдэгт хүрэх зам дагуу амьсгалаа хурааж буй үхдэл хүүрүүд үй олныг бий болгожээ.

Кичакийн удам угсаа сүйдэхээс айсан Вират хаан, Драупадыг улс гүрнээсээ зайлахыг хэлүүлжээ. Гэтэл Драупади, арван гуравхан хоног улс гүрэндээ байхыг соёрхоно уу гэж гуйгаад хэрэв тэгвэл ачийг бодож Матс нартай өөрийнхөө хүчирхэг ивээгч нараар туслуулна гэжээ.

## XI

Дурйодханагийн хүмүүс тэр жилийн турш Пандугийнхныг хайж ядаад бүр цөхрөнгөө баржээ. Цөллөгийн болзоот хугацаанаас хэдхэн хоногийн өмнө тагнуулчид нь Хастинапурт буцаж ирээд Дурйодханад айлдсан нь: „Их хаан минь, бид уул оргил, тал хөндий, ой шугуй, нууц агуй бүгдээрэнгээр явлаа. Бидэнд очоогүй хот тосгон үлдсэнгүй. Гэвч бид Пандугийн хөвгүүдийн мөрийг ч олж чадсангүй. Тэд, зэрлэг ойд үхэж үрэгдсэн нь ямар ч эргэлзээгүй болж гэжээ.

Дурйодхана, тагнуулчдынхаа хүргэж ирсэн мэдээг сонсоод өөрийн анд нөхөд, холбоотнуудтайгаа зөвлөлджээ. Сайхь хаан зарлан мэдэгдэхдээ: Пандугийнхныг хаанаас ч олж чадсангүй. Цөллөгийн арваг гуравдахь жил шувтрах гэж байна гээд тэдний санал зөвлөгөөнийг асуужээ. Пандугийнхныг буцаж ирнэ гэж бодоод тэр эрхийнхээ ёсоор эзэн суух юмыг нь буцааж өгвөл зохино гэж Дрона саналаа хэлэв. Гэтэл Карна, эвлэрэхээс татгалзаж тулалдаанд бэлтгэж зэвсэглэхийг уриалав. Видура, Бхишма хоёр Дронагийн талд орж, Духшасана болон Дурйодханын бусад ах дүү нар Карнаг дэмжив.

Хааны зөвлөлгөөн дээр гарсан маргаан дуусаагүй байтал Кичак болон түүний төрөл садангууд үхэж үрэгдсэн тухай мэдээ матсын орноос иржээ. Дурйодханы ордонд болсон зөвлөлгөөнд суулцсан хаадын дотор тригарт улсын хаан Шашуварман байжээ.

Тэр бол Кичакийн дээрмийн довтолгоонд нэг биш удаа хэлмэгдэж байжээ. Заналт дайсныхаа үхсэн тухай сонсоод баярласан сайхь хаан Матс нарыг дайран довтолж, Вират хааны тоо тоймгүй мал сүргийг булааж авъя гэж Каурынханд санал гаргав. Цаадуулын санаанд Шашуварманы санаа тохирч Каурынхан дайлаар мордоход бэлтгэв.

Шашуварман, шөнийн харанхуйгаар далимдуулан Матсын хаант улсын хил нэвтрэн орж Витарын мал сүрэг хариулж байсан малчдыг дайран хөөж явуулаад зургаан түмэн үнээг нь нутагтаа туулган явуулжээ. Өглөө болоход дайсан довтлон дээрэмдсэн тухай мэдээ Виратын ордонд хүрч иржээ. Хаан нэн даруй цэрэг дайчлах зарлиг буулгав. Байлдааны заан, их цэрэг, явган цэргийг аян, дайнд бэлтгэж эхлэв. Вирата хаан, Канка, Валлава хоёрт хааны сангаас зэр зэвсэг гаргаж өгөх зарлиг гаргав. Зарц нар тэр хоёрт хуяг дуулга, сэлэм, алт мөнгөн чимэгтэй нум авчирч өгөөд бас сайхан хөтөчтэй морин тэргүүд өгчээ. Сайхь хоёр эр, хааны хамт аян дайнд мордов. Нийслэл хотыг хааны эзгүй хойгуур хаан хүү, угсаа залган захирах ёстой учир Утгара захиран үлджээ.

Удаан биш хугацаагаар улайшигтай мөшгөн хөөсний эцэст Витара хаан Шашуварманыг гүйцэн очив. Хоёр этгээдийн цэрэг дайтахаар эсрэгцэн зогсжээ. Хатуу ширүүн тулаан эхлэж Вирата магнайд гарч эрэлхэгээр дайтаж байна. Гэвч тригартын цэрэг маш олон учир тэсвэрлэн байлдсаар байлаа. Төдөлгүй Шашуварман Матс нарыг дийлэн эхэлж, Вирата ч шархдав. Тулалдаанд бүгд холигдож, орь дуу тавих чимээ, тоос шороо, цус нөж нэлий халай болжээ. Тулалдааны талбар дээр энд тэндгүй эвдэрсэн тэрэг, алагдсан шархадсан хүмүүс, морьдоор дүүрчээ. Ийм болоод байхад Юдхиштхира, Бхимасенаг тулалдаанд оруулав. Бхимасена, ургаа мод булгатан авч шийдэм болгож хэрэглэн тулалдая гэтэл Юдхиштхира зөвшөөрсөнгүй. Яагаад гэвэл Бхимасенаг таньчихаж магадгүй. Тэгвэл Пандугийнхан дахиад арван гурван жил цөллөгөнд явахад хүрнэ гэж айжээ. Тэгээд Бхимасена байлдааны тэргэн дээр нум сум, сэлэм, жадаар зэвсэглэн тулалдаанд оржээ. Сайхь эр тулаан дундуур шаргуу үзэлцсээр Шашуварман дээр хүрч очихыг хичээжээ. Бхимасена, хүчирхэг арслан адил тэмүүлж илдээрээ үй олон дайсныг өвс хадаж буй мэт устгасаар замаан цэвэрлэж явна. Тригартчууд сайхь эрийн цохилтонд хяргуулсан өвс шиг сүйдэхдээ санд мэнд зугтааж эхлэв. “Зогс, зогс, Шашуварман! гэж Бхимасена тригартчуудын хаан руу тэмүүлэв. Пандугийн сайхь хүү, хааныг гүйцэж очоод үсдэн авч тэрэгнээс буулгаж газар хүчтэй мөргүүлэв. Цохиулсандаа болоод Шашуварман ухаан алдав. Бхимасена түүнийг морин тэргэн дээр өргөж шидээд Юдхиштхира руу авч давхилаа. Юдхиштхира энэ үе ухаа толгой дээрээс тулалдааныг ажиглан зогсож авай. Тригартчууд хаанаа олзлогдсоныг үзээд тулалдааны талбарыг орхин зугтаав.

Бхимасена, дөнгөж амь голтой айж балмагдан Шашуварманыг авчраад Юдхиштхирагийн хөл дор шиджээ. Олзлогдсон этгээдийг Юдхиштхира хараад: “Бос

хаантан. Чи дуртай зүгтээ явах чөлөөтэй шүү” гэв. Гэтэл тулалдаанд улайрсан Бхимасена Шашуварманд хэлсэн нь: “Яв чи, амьтайгаа үлдье гэвэл, очсон газар болгондоо “би бол Вирата хааны боол, би боол хүн! гэж хашгирч яваарай” гэв. Гэвч Юдхиштхира дүүгээ хорьж: “Чөлөөтэй яваг л даа. Ямар ч гэсэн энэ хүн одооноос эхлэн матс нарт алба төлөх хүн шүү дээ. Харин дахиад тонож дээрэмдэхээ болиг” гэв. Гэтэл энэ үеэр Бхишмагийн удирдсан Каурынхны цэрэг матс нарын нийслэл хотын нөгөө талаас дөхөж байжээ. Каурынхан хотын орчин тойрмыг цөлмөн Виратын олон мянган малыг авч Хастинапур руугаа буцаж явлаа. Энэ болсон явдлын тухай мэдээг хааны малчдын буухиа элч хунтайж Уттарад ирж хэлэв. Сайхь элч, Каурынхны булааж авсан малыг эргүүлж авахад малчин бидэнд туслаач гэж гуйжээ. Утгара тээнэгэлзэж эхэлжээ: хотод цэрэг үлдээгүй, Каурынхантай ганцаараа очиж тулалдана гэдэг хэцүү бөгөөд аюултай., над ядаж хөтөч ч алга. Нэг сайн хөтөч өгөөтөх, тэгтэл би яравчлан явах хэрэгтэй байна гэж буухиад хэлжээ. Аржуна үүнийг сонсоод Драупадыг дуудаж хэлсэн нь: Бриханнала намайг урьд Аржуны хөтөч явсан хүн бөгөөд одоо хунтайжийн тэргийг жолоодоход бэлэн байна” гэж Уттарад хэл гэв. Утгара айвч аргагүйн эрхэнд морин тэргэнд суун Бриханналын хамт аянд морджээ. Чадамгай хөтөчийн гараар жолоодогдсон морин тэрэг салхи мэт хурдалж явсаар төдхөн дайсны бараа харагдаж газар хүрч очвол Каурынханы цэргийн туг хиур намилзан, бөөн тоосны дунд матс нарын мал сүрэг туугдан яваа харагдана. Утгара тэр их цэргийг хараад айдас нь хүрч арай л сүнс нь зайлчихсангүй. “Даанч олуул юм байна. Биднийг алчих байх, Бриханнала минь минь!” гэж хэлээд морин тэрэгнээс үсрэнг буугаад зугтаажээ. Аржуна морио эргүүлж хунтайжийн хойноос очиж түүнийг давхиутаа барьж аваад тэргэндээ чирч оруулав. Намайг гэр лүү минь явуул, Бриханнала, би чамд юу дуртайг чинь өгнө. Гагцхүү намайг энэ үхэл өөд бүү чирээч! Утгара царай алдаж гуйлаа. “Хунтайж чи ичихгүй байна уу? чи чинь эрэлхэг Виратын хүү шүү дээ. Бүү хулчий. Миний оронд суугаад морьдыг жолоод. Би тэргэн дээрээс тулалдая” гэж Аржунын хэлэхэд Утгара гайхаж: “Чи яаж бүхэл бүтэн цэргийн сөрж ганцаар байлдах юм бэ? чи чинь бүжгийн багш болохоос цэргийн хүн биш шүү дээ? гэв. Бриханнала инээд алдан: “би бол түр зуур бүжгийн багш болсноос биш Пандугийн хүү Аржуна шүү дээ. Чи миний хөтөч л бол. Би энэ Каурынханыг ганцаараа үйчээд өгье гэлээ.

Утгара, энэ үгийг сонсоод хийморь нь сэргэж айхаа болиод: Аржуна гэдэг чинь ялагдашгүй дайчин эр. Үүнтэй хамт тулалдахад бүхэд бүтэн анги цэргийг ч

дийлж болно гэж итгэл төрөөд өөрийнхөө зэр зэвсгийг түүнд өгөв. Гэтэл тэр нь Пандугийн хүүд дэндүү хөнгөхөн хэврэг санагдсан тул Аржуна морин тэргээ ойрын ой руу залав. Тэнд Пандугийнхан эдний нийслэлд ирэхийнхээ өмнөхөн өөрсдийн зэр зэвсгийг газар булж нуусан билээ. Сайхь эр, газар ухаж урьд галын бурхны бэлэг болгон өгсөн нум сумаа гаргаж аваад өөрийн хуяг дуулгыг өмсч Уттарын хамтаар морин тэргэндээ суугаад Каурынхны хойноос жийгүүлэв.

Тэр хоёрыг дайсны цэрэгт ойртон очиход Каурынхны олон хүн нь Аржуныг таньж балмагдаж эхэлцгээв. Панпугийн хөвгүүдийн цөллөгийн хугацаа урьд өдөр нь дууссан байлаа. Тэдэнтэй уулзахад Каурав нарын зүрх шимширч авай. Бхишма, нэн даруй Дурйодханыг цэргийн томхон ангитайгаар мал туулган Хастинапур рүү явуулж үлдсэн цэргийг тулалдаанд оруулахаар эргүүлэв.

Аржуна зогсолгүй давхиулсаар Каурав нарын цэргийг гүйцэн очлоо. Өөрийнхөө гайхамшигт нумаар дайсны цэргийн зүг олон мянган сум мөндөр шиг буулгаж эхэлжээ. Гэтэл тэдний дээрэмдсэн мал харагдахгүй байсан тул сайхь эр, Бхишмагийн зохиосон ов мэхийг тааварлан мэдээ цэргээ эргүүлэн Дурйодханагийн хойноос нэхжээ. Аржуна түүнийг гүйцэж очоод аадрын бороо сум буулгав. Дурйодхана тэсвэрлэн байлдаж чадалгүй цэрэг, олзныхоо юмыг орхиод ичгүүртэйгээр зугтан арилав. Гэтэл ялж дийлж байгаа Аржуна Каурынхны гол цэргийн хүчтэй угтан байлдлаа. Аржуна их тэрэгтэйгээ дайсны цэргийн эгнээнд харван ороод нумныхаа сумыг нүүлгэж алдав. Бхишмагийн цэргүүд бамбайгаараа халхавчлаж амжаагүй байтал нь л Аржунагийн сум тэднийг хөнөөж байлаа. Аржуна, дайсны цэргийн дотуур замаа цэвэрлэн тулалдахдаа Уттарыг тэргээ нэг Дрона руу, нэг Карна рүү, нэг Бхишма рүү зал гэж тушаагаад тэдэнтэй ээлж дараалан үзэлцсээр хиар хиар цохиж байв. Өөрсдийн жанжин нарын дийлэгдэж байгааг харсан цэргүүд дайны талбайг орхин зугтаж байна. Ийнхүү Аржуна, Каурынхны хулгайлан дээрэмдсэн мал сүргийг эргүүлэн авч матс нарын нийслэлд буцсан ажээ.

Аржуна, хот руу буцах замдаа Уттарад хэлсэн нь: “Пандугийнхан танайд нууцаар алба хааж байгаа юм байна гэж чи хаанд битгий хэлээрэй. Миний тухай ч гэсэн юу ч битгий дурс. Чи өөрөө Каурынхныг дийлээд мал сүргээ булааж авсан гэж яриарай” Уттара ч зохих цагийг хүртэл дуугүй байя гэж амлав. Аржуна, хөтчийн суудалдаа сууж, өөрийн зэр зэвсэг, туг хиурыг нуув. Тийнхүү энэ хоёр эр, дайсныг ялсан тухай мэдээ хүргүүлэхээр малчдыг урьдчилан явуулаад хотод орж ирсэн ажээ.

Тэр хооронд Вирата, тригартчуудтай тулалдаад хотдоо эргэж ирсэн байжээ. Хүүгээ, Каурынхан нараас мал сүргээ эргүүлж авах гэж бүжгийн багштай хамт явсныг сонсон, хүүгийнхээ эрэлхэг зориг, ухаангүй шийдвэр хоёрт гайхаж, хүч тэнцвэргүй тулалдаанд Уттара үхсэн гэдэгт эргэлзэхгүй байжээ.

Гэтэл Юдхиштхира: “Хаантан минь, сэтгэл бүү зов. Хэрэв хүүгийн чинь хөтчөөр Бриханнала явсан юм бол Уттара түүний ивээлээр ямар ч дайсныг дийлнэ” гэж хааны сэтгэлийг засах санаатай хэлжээ.

Энэ үгээ хэлж дуусаагүй шахам байтал Уттараас ялалтын тухай мэдээ хүрч иржээ. Хаан баярлан бахдаад, дайснаа дарсан эрийг сүрлэгээр угтах зарлиг буулгажээ. Хотынхон гэр байшин гудамжаа туг хиур, өнгө өнгийн цэцгээр чимж, хөгжимчид яруу хэнгэргүүдээ дэлдсээр Уттарыг хотлоороо магтан шагшин угтсан байна.

Сэтгэл нь ихэд баяссан хаан, Юдхиштхирад: “Канка минь, миний эрэлхэг хөвгүүн Каурав нарыг ганцаараа дийлнэ гэдэг чинь ёстой гайхамшиг мөн биз дээ? гэж хэлэхэд Юдхиштхира хариу өчсөн нь: “Хаантан минь бүү гайх. Хунтайжийн хөтөч нь Бриханнала байсан бол гайхах юмгүй шүү”. Хаан ийм үг сонсоод уур нь хүрч: “Чи миний хүүг бүжгийн нэг муу багштай эн зэрэгт аваачна гэж үү. Бярман, чамайг би энэ удаа уучилъя. Хойшид энэ мэт тэнэг үгээр зөрүү үг хүргэвэл сайхан мэдээрэй” гэжээ. Юдхиштхира саяын хэлсэн үгээ давтаж өгүүлээд Бриханнала явалцаагүй бол хунтайж алагдсан байх ёстой гэж хэлэхэд Виратын уур хилэн бадарч Юдхиштхирагийн хацрыг хоёр дахин алгаджээ.

Яг энэ агшинд Уттара ордонд орж иржээ. Сайхь эр, Канка цус нөж болсныг үзээд сэтгэл тэвдэн учрыг лавлавал юу болсон тухай сонсч Канка бярманьг Уттара өмөөрч, тулалдааны тухай чин үнэнийг хаан эцэгтээ айлтгав. Гэхдээ хэлж болохгүй гэж хэлснийг санаж Аржунагийн нэрийг дурьдсангүй. “Бурхны нэг хүү тулалдаанд оролцон дайсны цэргийг хөөж явуулсан. Түүний хүчээр л би ялсан юм” гэж Уттарын хэлэхэд Втрата хаан: “Тэр бурханлаг баатар эр чинь тэгээд хаана байгаа юм? Гэж асуугаад, орж ирэг, би түүнтэй чинь нүүр учрахыг хүсч байна гэжээ. “Бидний нийслэл буцах цагт тэр намайг орхимон, гэвч тэр, нэгмөдөр ирж нэр алдраа хэлэх цаг ирэх юм” гэж хааны хүү хэллээ.

Тулалдаан болж өнгөрсний нөгөөдрийн маргааш нь Пандугийн хөвгүүд цав цагаан хувцас өмсөцгөөн үнэт эдлэлээр гоёж чимээд Вирата хааны ордонд орж хааны ширээний дэргэд залран сууцгаажээ. Гайхаж мэлийсэн хаан:

“Та нар чинь миний зарц байж, хааныхны эзлэх сууринд суух чинь юу вэ? Хэн та нарыг хааны хувцас хунар өмс гэв? гэж асуухад Аржуна инээмсэглэж Юдхиштхира руу заагаад: “Эзэнтэн минь, энэ агуу их эр бол бурхдын хаан Индратай ч суудал зэрэгцүүлэм хувьтай хүн юм шүү. Зоригийн хүч, чин шударга чанар, өрөвч нимгэн сэтгэл, дайчин урлагаараа энэ хүнтэй эн зэрэгцэх тийм эр энэ дэлхий дээр байхгүй. Таны өмнө Пандугийн хүү, алдар цуут Юдхиштхира байгаа нь энэ дээ” гэв.

Вирата хаан хэлшгүй их гайхаж “Алдар гавьяа, амссан зовлонгоороо нэрд гарсан Пандугийн хөвгүүд эд мөн гэж үү? Нээрээ ч тэдний тухай сураг алдагдсаар одоо арван гурван жил болж дээ” гэжээ. Аржуна хэлсэн нь “Хаантан та хараач, танай тогооч тань Кичакаг сөнөөсөн өнөөх хүчирхэг Бхимасена шүү дээ. Таны адуучин тань Накула, малч тань Сахадева, хатны шивэгчин тань Драупади, би бол, хаантан минь, Кунтийн хүү Аржуна байгаа юм”. Хунтайж Утгара хажуунаас хэлсэн нь “Эцэг минь ээ, энэ Аржуна л миний нэрийг шившгээс аварч, Каурынхныг шүү дээ”.

Үүнийг сонсоод баярлаж бахадсан Вирата хаан Пандугийнханд тал өгч та нартайгаа найрамдал холбоотой явъя гэжээ. Сайхь хаан: “Тэд нарт хааны их хүндэтгэл үзүүлэн үнэт их бэлэг сэлэг барьжээ. Бас Пандугийнхантай ураг холбохыг хүсч Аржуны жаалхүү Абхиманьюд өөрийн охиноо гэргий болгон өгөв.

## ХII

Виратын охин, Абхиманью хоёрын хуриманд оролцох гэж Пандугийнхны анд нөхөд, холбоотон, хол ойрын улс гүрний эзэн хаад матс нарын нийслэлд хүрэлцэн иржээ. Маш их хөлтэй болсон хуримын маргааш өдөр нь гийчид нүсэр их гоё чимэгтэй хааны ордонд цуглан ярилцжээ. Хаад, насныхаа эрэмбэ дараагаар алт ба эрдэнэсийн чулуун чимэгтэй суудлаа эзэлсэн хойно Ядов овгийн эзэн Кришна суудлаас босч цугларагсад ийм үгтэй хандав: “Сайн язгуурт эзэд минь! Юдхиштхира болон түүний дүү нар хичнээн их зовлон амссаныг та бүгд андахгүй билээ. Юдхиштхираг даалуугаар яаж хууран мэхэлсэн, яаж Пандугийнхныг улс гүрнээс нь хагацуулж, олон жилийн хугацаагаар зэрлэг битүү ойн шугуйд цөлснийг та бүгд андахгүй мэдэх билээ. Эдүгээ цөллөгийн хугацаа нь нэгэнт дууссан тул бид Юдхиштхира, Дурйодханы аль алинд нь ээлтэй юм бодох цаг болжээ. Хэрэв эрх зүйд

гажуу бол Юдхиштхира тэнгэрийн улс гүрнийг өгсөн ч авахгүй бөгөөд хэрэв шударга гэж үзвэл хөдөөний ганц тосгон өгсөн ч үгүй гэхгүй авах хүн гэдгийг та бид мэдэж байна. Ийм учраас бид урьдаар Каурав нарт нэг ухаалаг, цэцэн цэлмэг үгтэй элчийг илгээж, Юдхиштхирад эзэн суух нутаг газрыг нь найр тавин олгуулахыг хичээе” гэжээ.

Кришнагийн дараа Друпада хаан үг хэлэв. “Кришна та их мэргэн үг хэллээ. Гэвч Дурйодхана өөрийнхөө мэдэлд байгаа юмнаас өчүүхэн төдий хэсгийг ч сайн дураар бусдад өгнө гэдэгт би хэзээ ч итгэхгүй. Дхритараштрад ч найдах юм алга. Тэр бол өөрийнхөө эрх хүүгийн үгэнд орж явдаг хүн шүү дээ. Хастинапур руу элч явуулья л даа. Гэхдээ одоогоос эхлэн дайтахад бэлтгэх хэрэгтэй. Одоо болох тулалдаанд цэргийг нь бэлдүүлэхээр бүхий л эзэн ноёдод элч заръя. Дурйодханаас урьтаж хаадыг өөрийн талд оруулж авахыг яаравчлах хэрэгтэй байна” гэв.

Друпадын хэлсэнтэй бүгдээр санал нийлжээ. Харин Кришна түүнд хандаж “Панчалын эзэн та биднээс нас сүүдэр, мэргэн ухаанаараа давуу хаан билээ. Таныг Дхритараштра хаан ч хүндэлнэ. Та бол Дрона, Видур хоёртой найрсаг, шударга ёсыг баривал олон жил үргэлжилсэн хэрүүл маргаан төгсгөлөө үзнэ. Хэрэв Дхритараштрагийн мулгуу хүү найр эс тавивал биднийг нэн даруй дууд. Бид Пандугийнханд туслахаар очно” гэхэд “чингсүгэй” хэмээн хаад шийдээд Вирататай салах ёсыг гүйцэтгэн нутаг нутагтаа буцжээ.

Пандугийнхан тулалдаанд цаг алдалгүй бэлдэж эхлэв. Вирата хаан, ойр хавийн бүх улсын эзэд, алба төлөгч нартаа элч давхиулж цэрэг дайчлан мамсын нийслэлд хүрч ир гэжээ. Друпада хаан ч бас тэгжээ. Уг урилганд олон улс гүрний эзэд дуртай орж өөрсдийн цэргийг Пандугийнхны тугийн дор нэгтгэв. Дхритараштрын хөвгүүд Пандугийнхны цэрэг дайчлан цуглуулж байгааг сонсоод өөрсдийн найрсаг байдаг холбоотон нарыг Хастинапурт дуудуулжээ. Пандугийнхан Каурынхан хоёрын аль нэгэнд нэгдэх гэсэн цэргүүд улс орны өнцөг булан бүрээс хөдөлжээ. Тэдний нүсэр алхалтын улмаас дэлхий тэр аяараа уул модтойгоо доргих шиг санагдаж байжээ.

Друпади хаан, Юдхиштхиратай зөвлөөд амьдралын хар ухаан ба эрдэм номоор мэргэн болсон өөрийн нэгэн лам бярманыг Хастинапур руу элч болгон явуулжээ. Друпад хаан түүнийг дуудуулж авчраад:



“Бярман чи Дхритараштра ямар хүн гэдгийг мэднэ. Юдхиштхира, даалуугаар тоглож мэхлэгдсэнийг тэр мэдсээр байсныг чи мэднэ. Хууран мэхлэгчид Пандугийнхны эзэмшлийг сайн дураараа эргүүлж өгөхгүй бизээ. Гэвч хэрэв чи Дхритараштрад шударга үг хэлж хандвал түүний дайчин эрсийн сэтгэл зүрхэнд тээнэгэлзлийг төрүүлэх бөгөөд Видура, Дрона, чин шударга Бхишма гурав чамайг дэмжих болно. Хэрэв Дхритараштрын зөвлөх нар Пандугийнхны талд ороод, дайчин нь бас тээнэгэлзэж эхэлбэл тэдний санаа сэтгэлийг засах гэж дайсан цаг алдана. Тэр хооронд нь Пандугийнхан цэрэг эрсийг хялбархан цуглуулж дайны хүнс хэрэглэлийг бэлтгэж амжуулах юм. Айлтгүй яв. Дайсны дотор орж очиход чамд тэдэнд элч гэж очиж байгаа, бас настай хүн, тэгэхлээр хэн ч чамд гар хүрч зүрхлэхгүй” гэжээ.

Явааг хэлэд тэр эхийн уйтгартсан сэтгэлийг засчээ. Гагцхүү гурав хоног дээрээ Кришна, Дхритараштраатай уулзжээ.

Кришна хэлсэн нь: “ Би, ах дүү улсын хоорогд найрамдал тогтоох гэж л наашаа ирлээ. Над өөр бодол санаа байхгүй. Хаантан, миний хэлэх үгийг сайн сонс. Таны хэдэн хүүгийн мулгуу бодол, муу явдлаас болж таны овог сөнөх, дэлхий дахинаа амьд голтой юм үлдэхээргүй болох аюул занал учирч мэдэх нээ. Одоо ертөнцийн хувь заяа та бид хоёрын гарт байгааг та санагтун. Пандугийнханд эрх зүй ёсоор оногдох юмыг нь буцааж өгүүл Дурйодханы шунал эзэрхий занг нь дарж өг. Тэгвэл дэлхий дээр энх тунх амьдрал тогтоно. Хэрэв та үүнийг эс хийвэл таны голомтонд аймшигтай, хайр найргүй дайн ирнэ. Та халуун ам бүлээ алдаад юунд хүрэх юм бэ? гэжээ. Ууган хүүгээ эвлэрэх бодлого тийш эргүүлэх гээд би хүч мөхөстлөө гэж Дхритараштрын хэлэхэд Дурйодхана уурлан хашгирахдаа: “ Би муусайн Пандугийнханд сөөм газар ч зүгээр өгөхгүй! Ганц ч хэлтэрхий алтан зоос, ганц ч боол өгөхгүй. Намайг дайнаар айлгах гэж бүү оролд, би байлдахад бэлэн байна. Энэ ертөнцөд Пандугийнхан бид нэг дор байх газар байхгүй” гээд үг ч сонсолгүйгээр босч дотоод харш руу гарч одов. Түүний хойноос Карна, Духшасана, Шакуни нар дагалдан гарчээ.

Тэр дөрөв нуцц зөвлөлдөөд Кришнаг баривчлан гянданд хорино. Тэгвэл Пандугийнхныг дийлэхэд хялбар болно гэж сэм тохиролцжээ. Гэтэл ордонд болж байсанд тэр яриаг нь элчний нэг зарц санаандгүй явж байгаад дуулчихжээ. Зарц тэр даруй ордон руу гүйн орж Кришнагийн дэргэд хүрч очоод Дурйодханы төлөвлөн буй муу санааг өндөр дуугаар айлтгажээ.

Энэ мэдээг сонсоод тэнд байгсдын айдас нь хүрч асрын дотор нам жим болов. Дхритараштра балмагдаж сандарахдаа хуйвалдагчийг дуудан ирүүлж хүүгийнхээ ухаангүй араншин, итгэл эвдсэн ажиллагааг уур хилэнтэйгээр зэмлэжээ. “тэнэг , хорлогчин чи гэж хаан дуу алдаад Васудевын хүүг газар дээр биелсэн бурхан гэдгийг чи мэдэхгүй юу? Чи чинь нялх хүүхэд аятай сарыг авч малгайдаа хийе гэж байна. Зайлшгүй үхнэ гэдгээ мэдэхгүй дэнгийн эрвээхий шиг галд орох гэж байна. Пандугийнханд өгөх ёстой юмыг нь өг чи эвлэн найрамдаж нөхөрлөе гэсэн ёсоор чи яв” гэв. Гэтэл Дурйодхана гөжсөн хэвээрээ байлаа.

Тэгэхлээр нь Кришна Дурйодханад: “Чи намайг энд ганцаараа анд нөхөдгүй хүний гарын дор яваа амьтан гэж бодоо юу, хар чи” гэж хэлээд гараа үрэхэд нүд ирмэхийн зуургүй түүний хажуу хамаг бурхад, шүтээн, түүний улс гүрний хамаг цэрэг эрс магнайд сүрлэг зэр зэвсгээ барьсан хүчирхэг Пандугийнхан гарч ирсэн байлаа. Кришнагийн ам мэлмийгээс галын дөл бадарч, хүн бүхний дөлийн доорх газар доргин, тэнгэрт аянгын аймшигт дуу нижигнэжээ. Хааны түшмэд, Каурынхны гийчид хань холбоотон нар ухаан алдталаа айж нүүрээ гараараа таглацгаан газар сөхрөн унажээ. Нүд ирмэхийн зуур өнөөх аймшигт үзэгдэл бүгд үгүй болж, гагцхүү тээр алсад Кришнагийн суусан сүйх тэрэгний алтан чимэг нь гялалзаж харагдана.

## XVI

Кришнаг буцсанаас хойш Хастинапурынхны зүрхэнд түгшүүр хоногшжээ. Ах дүүсийн эвлрүүлэх гэсэн хамгийн сүүлчийн найдлага тасарч одоо дайн гарцаагүй болжээ. Хүүхдүүдийнхээ амь насны төлөө айж тарчилсан Кунти эх нар шингэсэн хойно Ганга мөрний ариун эрэг дээр Карна мөргөө хийж байжээ. Хөтчийн хүү ч түүнийг харж дэргэд нь очоод: “ Та юунд уй гашуу болоо вэ? Над зовлонгоо хэл” гэжээ. Кунти түүнд “миний хэдэн хүүгийн амийг авар гэж би бурханд мөргөж байна. Карна чи тэдэнд хар элгийн хүн биш гэдгээ мэдэж ав. Чи анх яаж мэндэлсэн нууцаа мэдэхгүй. Тэрний чинь би хэлж өгье. Чи минь нарны бурхан Сурьяагийн хүү, би чиний эх. Би чамайг эцгийндээ гаргаад нууцаар сагсанд хийгээд усанд хаясан юм. Нарны бурхан чамайг үхүүлэлгүй, усны долгионоор эрэг дээр нь гаргаад ирсэн юм. Тэгээд чи хөтчийн гэрт өссөн юм. Пандугийнхан чинь чиний төрсөн ах дүү шүү дээ. Чи тэдэнтэй хамт, өөрийнхөө ээжийн хүүхдүүдийн талд орох ёстой. Та нар нийлбэл хэнд ч дийлдэхгүй” гэжээ.

Карна: “ Чи яагаад намайг хайрлах сэтгэлгүй хаяж байсан юм? Чи намайг энэ ертөнцөд нохойн гөлөг шиг хаяж байсан байж, одоо болохоор намайг дотно

нөхдөөсөө холд гэж байна. Хэрэв би чиний үгэнд орвол дэндүү хүний тусыг боддоггүй хүн болно шүү дээ. Аржунаг агуу хүчирхэг дайчин эр гэдгийг мэдэхгүй хүн алга. Хэрэв би түүний талд орох юм бол хүмүүс намайг аймхай амьтан түүнээс хулчийжээ гэлцэнэ шүү дээ. Яавч би Дурйодханатай хамт явна. Тэр бол миний анд нөхөр намайг ивгээгч хүн. Харин би чамд нэг зүйлийг л амлая” Аржунагаас бусад чиний хүүхдүүдийг би тулалдаанд хайрлан өршөөнө. Харин Аржунатай тулалдана. Бид хоёрын хэн маань үхсэн ч чиний хүү тав хэвээр л үлдэнэ шүү дээ” гэжээ.

## XVII

Кришна, Упаплавьяд буцаж ирээд явсан хэрэг бүтэмжгүй болсон тухайгаа хэлэхэд Юдхиштхира цэргийн зөвлөгөөн зарлан хуралдуулж: “Каурынхан бидэнтэй найрамдах жанжингууд удирдагтун” гэжээ. Хаан Пандугийнхны бүх цэргийн акшаухини хэмээх долоон зам болгон хуваажээ. Зам бүрт хоёр түм найман зуун далан заан, мөн төчнөөн их тэрэг, зургаан түм зургаан зуун арван морьт цэрэг, арван түм есөн мянга гурван зуун тавин явган цэрэг байна. Долоон зам цэргийн жанжингаар Друпатагийн хоёр хүү Дхриштадьюмнаг бүх цэргийн жанжин гэж зарлажээ.

Бүгд санал нийлсэн учир Юдхиштхира Дхриштадь юмнаг цэргээ Хастинапур руу Курукшетрагийн тал газар руу авч явахыг зарлиг болгожээ.

Пандугийнхны цэрэг үертэй байгаа Ганга мөрний ус адил хязгаар төгсгөлгүй цувсаар авай. Дайчин уриа, дун бүрээний дуу, тэрэгний дугуйнуудын тарчигнах дуун агт морьдын янцгаах нь хавь ойр чих дөжирнө. Бүгдийн манлайд явах морин тэргэн дээр Бхимасена, Накула, Сахадева тэдний ард Юдхиштхира явна. Упаплавьягийн хуаранд Драупадаг шадар хүмүүс болон шивэгчингүүдтэй нь зузаан хамгаалалттай үлдээжээ.

Курукшетрагийн ээрэм талын баруун хязгаарт хүрч очоод цэргээ зогсоов. Юдхиштхира Дхриштадьюмна, Кришна хоёрын хамтаар ээрэм талыг тойрон явж цэргээ хуарагнуулах газрыг сонгов. Пандугийнхны цэргийн жанжингууд, морин цэрэг, их тэргүүд, байлдааны заануудыг хаана хаана байрлуулахыг зааж өгөөд хуарандаа нүх гуу ухаж чухал чухал бэхлэлт босгохыг тушаажээ. Өөрснөө дайсны цэргийн ангиудын хөдөлгөөнийг ажин мэдэх гэж Курукшетрагийн зүүн тал руу явцгаав.

Дурйодхана болон түүний сүлбээтэн нар Курукшетрт арван нэгэн зам цэрэг ирүүлжээ. Тэдний магнайд хүчирхэг дайчин эрчүүл: Каурынхны цэргийг зэвсэгт сургасан Дронагийн дараа орох зэвсгийн их ухаантан Крипа, Дрона, мадрын хаан Шалья, Синдийн хаан Дхритараштрагийн хүргэн Жаятратха, Камбожийн хаан

Судакшина, бхож, андхак нарын эзэн ноён Криставарман, Дронагийн хүү Ашваттхаман, анг нарын хаан Карна, Бхуришравас, Шакуни, Бахлика явна. Дурйодхана явна. Тэр тоо томшгүй их цэргийн жанжнаар Бхишмаг томилжээ.

Дурйодхана байлдахын урьд өдөр цэрэг дайны их мэргэжилтэн Бхишмад хандаж тэргэн дээр байлдахад хамгийн чадамгай хүчирхэг дайчдын тухай ярьж өгөхийг хүсчээ.

Бхишма, Дурйодхана, болон Юдхиштхирагийн цэргийн дотроос хүч чадал, уран чадвартай гэж их л олон баатар эрчүүдийн нэрийг дурдан ярихдаа нарны бурхан Сурьягийн хүү Карнагийн нэрийг хамгийн адагт дурьджээ.

“Чиний шилдэг анд нөхөр, зөвлөх, адгийн муу онгиороо Карна энэ тулааны үеэр байлдааны тэргэнд тэргүүлж чадахгүй. Дийлдэхийг мэддэггүй Аржунатай халз тулаад толгойгоо алдах хүн” гэж өвгөн Бхишма Дурйодханад хэллээ. Цэргийн мэргэн багш Дрона ч Бхишмагийн хэлдэг үг зөв гэв. Өвгөн жанжны хэлсэн үг Карнагийн зүрхэнд хурц өргөс шаах мэт болов.” Бхишма чи намайг доромжилж байна. Гэхдээ би гомдлын хариу өгөхгүй. Догшин тулаан болохын өмнө хэрүүл хийхийг би хүсэхгүй байна. Харин чамд тусална гэж бүү горьд. Чамайг дайны талбар дээр амьсгалаа хурааж унахаас урд би тэргэн дээр хөл тавихгүй. Тэгсний дараа л Пандугийнхны баатрууд бүгдээрээ надтай үзэлцэг. Тэгээд тэрэгтэй тулалдахад хамгийн хүчтэй нь хэн болохыг Бхаратын удам угсаа хараг л дээ” гэж Карна хэлжээ.

Бхишмаг ярьж дууссаны дараа Дурйодхана, Шакунигийн хүү Улукуг дуудуулж авчраад хэлсэн нь “Чи, Пандугийнханд очоод ингэж хэл:

“Тулалдах өдөр ойртлоо. Одоо Юдхиштхира чи буянт хүний царай гаргаж явах хэрэггүй болжээ. Яваа яваандаа чиний эрх дархад дуртай, сувьдаг шунахай чинь хүн бүхэнд ил болж байна. Юдхиштхира чи бол өнөөх ариун явдалт гэлэн царай гаргаж гэнэн итгэлт хулгануудыг амархан барьж идэх гэсэн тэр мууртай адил байна. Ярих чинь нэг өөр хийж байгаа ажил чинь бас нэг ондоо байна. Гэсэн ч одоо тулалдах цаг болжээ. Юдхиштхира чи бүү хулчий, өөр байлдаанд орж өөрийнхөө тогооч дүү Бхимасена, адууё Накула, малчин Сахадева, бүжгийн багш Аржуна дүү нарынхаа хийморийг сэргээхийг бод. Чиний дүү нар чинь хүчтэй гэж сагсуурцгаан намайг ална хядна гэж бишгүй л зандаг байлаа. Тэд чинь одоо л хүч чадал эрэлхэг зориг гэж байдаг юм бол үгээрээ биш үйлээрээ үзүүлэх цаг болж дээ. Байлдаж тулалдана гэдэг чинь хоол хийх юм уу эсхүл эмсийг бүжигт сургахтай адилгүй шүү. Ингэхлээр Пандугийнхан минь, та нар хааны зарц биш жинхэнэ баатар эр гэдгээ харуул л даа”

“Кришнад ингэж хэлээрэй, Улука минь Дурйодхана намайг ч илбээрээ айлгаж

барахгүй, илбэ жилбий чинь Каурав нар ч хийнэ шүү дээ. Бас Дурйодхана тулааны талбар дээр шударгаар халз үзэлцье гэж байна гэж Юдхиштхирад хэлээрэй” гэв. Дурйодхана ингэж хэлээд чангаар инээд алдан, элчээ Пандугийнхны хуаран тийш илгээжээ.

Улука, Дурйодханагийн хэлүүлсэн үгийг Юдхиштхира ба түүний дүү нарт бүгдийг нь яг айх зовох юмгүй нэгд нэггүй хэлж иржээ. Пандугийнхан ч уураа барьж чадсангүй. Кришна ирсэн элчид:

“ Бид чиний хэлж ирсэн үгийг дуулж, үгийн чинь утгыг ухлаа. Маргааш тулалдана. Биднийг зэр зэвсэг маань даана гэж эзэндээ хэл” гэжээ.

### XVIII

Бхарат нарын орны хот, тосгон хүнгүй болжээ. Зэвсэг барьж чадах хүн бүр Курукшетрагийн ээрэм талд очжээ. Гэр зуур зөвхөн бүсгүйчүүл, хүүхэд насандаа дарагдсан өвгөд хөгшид үлджээ. Ирж буй гай гамшгийг дэлхий ёрлон байна. Энд тэндгүй аймшигт ёр шинж үзэгдлээ. Тэнгэрт нар бүдгэрч шөнө нь саргүй болжээ. Сүм дуганы доторх баримал бурхад, дагинасын нүүр царай гэнэт мөргөлчдийн харсаар байтал амь орж инээлдэх буюу чулуун амнаас нь цус олгойдох болов. Хөдөө газар үнээ дудрай гаргаж, гүү тугал гаргажээ. Хоёр толгойтой, дөрвөн нүдтэй, таван хөлтэй, хоёр сүүлтэй араатан бий болжээ. Гол мөрөн ус сөөргө урсч, ус нь цус болон хувирч байжээ. Шөнийн цаг тэнгэрт ганц жигүүртэй, ганц нүдтэй, ганц хөлтэй шувуу нисэх болж муухай хашгирахад түүнийг сонссон хүн цусаар бөөлжүүлж байв. Од мичид мууг ёрложээ.

Курукшетрад болох тулалдааны урд шөнө цусан бороо оржээ. Тэр өдрийн тулаанд эрэлхэг олон дайчид үхэж, дайны талбар дээр үй олон амьтан үүрд нойрсох ажээ. Үүр цаймагц, дайны дохионы бүрээ хэнгэргийн дуу, агт морьдын янцгаалт, тэрэгний түчигнэх дуун, үймж сандарсан заануудын хашгирах, зэр зэвсэг хангинах, жанждын тулалдаанд цэргээ зоригжуулан уриалан дуудах чимээ ээрэм талаар нэг болжээ. Зэр зэвсэг, хуяг дуулга өмсч эгнэн жагссан үй түмэн цэргүүд сая мандсан нарны гэрэлд тал дүүрэн гялалзан харагдана.

Каурынхны цэрэг тулалдаанд бэлтгэж байна. Түүний жагсан зогссон нь нисч буй шувуу мэт харагдана. Байлдааны заанууд жагсаалын их бие, морьтой явган цэргүүд хоёр жигүүр, их тэргүүд дайсны зүг чиглэсэн хүшуу болжээ. Бүхний магнайд Дхритараштрагийн хэдэн хүүгийн их тэргүүд зогсч байна. Буурал үст Бхишма мөнгөлөг хуяг өмсч дээрээ алтан дал мод гялалзсан цагаан туг бүхий их тэргэн дээр

суугаад цэргүүдийн өмнө цагаан үүлэнд халхлагдсан сар шиг гарч ирэв. “Эрэлхэг кшатри нар минь эдүгээ та нарын өмнө тэнгэрийн орны хаалга нээгээд байна” гэж цэргүүдэд хашгирч хэлээд “Дайчин эр хүн гэртээ өвчнөөр үхвэл нүгэл болно. Тулалдаанд үхлийг үзнэ гэдэг бол түүний мөнхийн үүрэг юм” гэлээ. Бхишмаг үг хэлж дуусмагц цэргийн дарга нар тарж, өөр өөрсдийн ангийн манлайд очиж зогсов. Ганц хөтчийн хүү Карна л Бхишмагийн ялалтын төлөө байлдахгүй гэж зэвсгээ хаяжээ.

Дурйодханагийн цэрэг тулалдаанд ороход бэлэн болчихоод байхад Юдхиштхира, Аржунад ингэж хэлж байжээ. “Цөөхөн цэрэг бол тулалдаанд шигүүн бөгөөд зүү шиг хурц эгнээгээр орох ёстой гэж дайн байлдаанд мэргэжсэн их хүмүүс хэлдэг юм”. Аржуна үүнийг сонсоод: “Хаантан минь, тэнгэрийн их хаан Индра цөөхөн цэргээ нягт цагираг шиг эгнээгээд чөтгөр шулмасыг дарсныг санаач. Тийм эгнээгээр бид дайсныг тал бүрээс нь няцааж дуртай ялалтаа хийнэ” гэж өчив.

Тэгээд ч Пандугийнхан цэргээ Аржунагийн хэлсэн ёсоор эгнээн жагсаажээ. Бхисмасена, түүний тэргийн хоёр жигүүрээр Накула, Сахадева хоёр дайсны чанх өмнөөс хараад зогсчээ. Хүчирхэг Бхимасенагийн тэрэгний араас Друпатагийн таван залуу хүү тэдний хойно Дхритадьюмны болон Вирата хааны дайчин эрчүүл жагсчээ. Панчал, матс цэргүүдийн араас Кришнагийн жолоодсон их тэнгэр дээр Аржуна баатар зогсож байв. Аварга том заануудын дунд байгаа цэргүүдийн дунд байгаа цэргүүдийн голд Юдхиштхира хааны хуяг дуулга гялалзана. Сайхь хаан эзний цэргийг ширтэн харахдаа зүрх сэтгэлд нь эргэлзэх түгших бодол төрж байна. Кауравын цэрэг асар олон ажээ. Дурйодханы байлдааны омогт догшин заануудыг тооловч баршгүй, аживч нүдний хараа хүрэмгүй. Нэг зааныг зуун их тэрэг, нэг их тэргийг зуун морьт цэрэг, нэг морьт цэргийг арван нумчин, нэг нумчныг юлдээр зэвсэглэсэн арван явган цэрэг дагажээ.

Юдхиштхира, Аржунад: “Бидний авга ялагдашгүй Бхишмагийн удирдаж яваа энэ тоо тоймгүй их цэргийг бид дийлэх юм гэж үү? Каурынхны цэрэг даанч олон, дарга нар нь гаргууд чадамгай. Би ялна гэдэгтээ эргэлзэж байна” гэхэд Аржуна хариу хэлсэн нь: “Хаантан минь, бид цөөн, гэсэн ч бидний талд үнэн, чин зориг, шударгаёс байна. Бидний хамт Кришна явна. Кришна хаан байна, тэнд ялалт байдаг юм” гэжээ.

Тэгээд Аржуна орчлон сүйдлэгч Шива бурхны гэргий аймшигт дагина дургад залбирахдаа: “агуу их, Мөнхийн, үл ялагдагч дагина чиний өмнө би мөргөн сөхөрье Кришнагийн бүхнийг чадагч дүү шар хэвнэгт дагина минь ээ Чи бол Наран, Саранг жолоодож, гэрэл гэгээг өгдөг билээ.

Үүрийн туяа, Агуу их Эх, өөртөө үнэнч амьтдыг тэтгэгч, ялалтыг бэлэглэгч, өөрөө ялалт билээ чи Нэвт харагч, алт адил мэлмийт дагина минь, би чиний өмнө сөхрөн мөргөө. Агуу их чамайг би гэгээн саруул сүнсээрээ магтая Чиний энэрэнгүй сэтгэл биднийг дагаж, тулалдааны талбар дээр ялалтыг авчирах болтугай” гэв.

Аржунагийн залбирал, догшин дагинад хүрч Дурга төдхөн, гайхаж хоцорсон Пандугийнхан дээр ирээд: “Пандугийн хүү чи хэдэн өдрийн дараа дайснаа дарна. Чи тулалдаанд дийлэхгүй, чамайг Индра өөрөө ч дийлэхгүй” гэж хэлжээ. Ингэж хэлээд л тэр дагина алга болжээ. Юдхиштхира, баярлан сэргэж эргэлзэж эмээхээ болив. Пандугийнхны бүх цэрэг ч ялах итгэл төржээ.

Нар мөд мандаж тулалдаан эхлэх тун ч ойртоод байтал Юдхиштхира тэрэгнээсээ бууж, хуяг дуулгаа тайлж зэр зэвсгээ хаяад, хүүрээ хоёр гарынхаа алгаар дарж дайсны цэргийн зүг чиглэн аяархан явжээ. Түүний араас дүү нар нь болон Кришна дотроо түгшсээр дагалджээ. “Хаантан та яах гэж тэрэгнээсээ буугаад явган, зэвсэггүйгээр дайсныхаа дотор орох нь вэ?” гэж тэднийг асуухад Юдхиштхира хариу дуугарсангүй.

Дандугийн хүүг тийнхүү дайсны хуаранд очиход Каурынхны цэргүүд шоолон инээлдэж угтжээ. “ Их хаан зүрх алдав бололтой. Тэгээд биднээс өршөөл гуйх гэж ирлээ шүү. тулалдааны өмнө сүнс нь зайлтлаа айжээ. Юдхиштхира, Кшартийн овгийн хүн биш дэг ээ. Энүүнийг дайчин эрэлхэг гэж үлгэр домогчид дэмий магтжээ” гэлцэн инээлдэж байлаа. Юдхиштхира, хүмүүсийн хашгиралдан дооглоход хариу өгөлгүй тайван алхаж зай тавин өгч байгаа цэргүүдийн дундуур явсаар Бхишмагийн дэргэд очоод бөхийн ёсолж:

“Ялгуулсан чамд баяр хүргэе. Чамтай тулалдахыг соёрхоно уу. бидэнд ерөөлөө айлтгаж өг” гэхэд Бхишма түүнд: “Газрын хаан чи хэрэв ирээгүй бол би чамайг харааж тэнгэрээс чамд ялагдал, бүтэлгүйдлийг залбиран гуйх байсан юм. Харин одоо, хүү минь би чамайг ерөөе, тулалдаанд зоригтой орж өөртөө ялалтыг олж автугай. Юу дуртайгаа надаас гуй. Гэхдээ би байлдаанд Дхритарашатрын хөвгүүдийн төлөө тулалдах болно. Би бол түүний зарц бөгөөд тангаргаар холбогдсон хүн” гэж хариу өчжээ. Юдхиштхира хэлсэн нь:

“Каурынхны төлөө тулалд л да. Гэвч миний төлөө залбир, надад сайныг ерөөгтүн. Ялгуулсан минь” гэв. Тэгээд Юдхиштхира Дронад ерөөлгөхөөр очив. Дараа нь Крипад очив. Цаад хоёр нь Бхишмагийн хэлсэн шиг үг хэлжээ.

Пандугийн хүү багш нартаа бөхийн ёсолж, салах ёс гүйцэтгээд мадрчуудын хааны дэргэд ирэв. “Шалья минь намайг ерөө, би нүгэлд оролгүйгээр байлдаад

дайснаа даръя” гэхэд Шалья хариу өчсөн нь:” хэрэв чамайг ирээгүй бол би чамайг хараах байлаа. нэгэнт миний эгчийн хүү чи намайг хүндэтгэж байгаа болохоор сэтгэл минь таатай болов. Хүсэл чинь бүтэх болтугай. Дайтаад ялах болтугай. Надаас дуртайгаа гуй, гагцхүү тулалдаан болоход би хэлсэн үгэндээ хүрч Каура нарын холбоотон байх болно гэдгийг мэд” гэв. Юдхиштхира: “Шалья минь, хэрэв тийн бол дайсны талд бай, гэхдээ миний буяныг л битгий мартахыг гуйя” гэхэд Шалья “Хаадын хамгийн шилдэг хаан минь, би чамд юугаараа тус болдог билээ, хэлээч” гэв. Юдхиштхира хариу өчихдөө: “Нагац ах минь тулалдааны үеэр Карны хүчийг султгах талаар бидэнд тус бол доо. Дайны талбар дээр түүний хувь заяа нэг тийш болох цаг ирэхэд түүнийг сэтгэлээр унагаж аль даа” гэлээ. Би хүссэний чинь биелүүлье. Кунтийн хүү тулалдаанд ороод дайсантайгаа үзэлцмэгц би чиний ялалтын төлөө санаагаа тавья” гэж мадр нарын хаан хэлжээ.

Энэ хооронд Кришна, Карнагийн дэргэд очиж мэнд усыг нь лавлаад: “ Карна аа, чамайг Бхишмаад гомдоод гартаа зэвсэг барихгүй гэсэн гэж би сонслоо. Бхишмаг амьд дээр чи бидний талд ороод бидэнтэй бай. Түүнийг хөнөөгдсөн хойно чи дахиад Дурйодханы талд буцаж очсон ч болно шүү дээ дураараа бол” гэхэд Карна: “Дхритараштрын хүүд ээлтэй биш болох юу ч үйлдэхгүй. Би бол Дурйодханад үнэнч бөгөөд миний амь нас түүний мэдлийн вьм гэдгийг мэдэж автугай” гэжээ.

Юдхиштхира, Каурынхны хуаранг орхиж явахдаа дайсны цэрэгт хандан: “Биднийг гэж ирсэн хүнийг бид өөрийн нөхөр, холбоотон гэж авна шүү!” гэж хашгирчээ. Дорд язгуурын эмэгтэйгээс төрсөн бөгөөд Дхритараштрын дагуул хүү Юютсу хариу болгон: “Хэрэв чи намайг эн тэгш үзэх юм бол би тулалдаанд чиний төлөө байлдана” гэв.

“Явъя, явъя бид чамайг бүгдээрээ хүлээж авна, хүчтэн минь. Чамаар алдарт Дхритараштрын овгийг залгуулна. Чи түүнийг дурсах хуриман дээр бас найрлах болно” гэж Юдхиштхира түүнд хэлжээ. Пандугийн хэдэн хүү Кришна, Юютсу хоёрын хамт хурандаа баяр хөөртэй буцаж иржээ.

## XIX

Өглөө болмогц Пандугийнхан Каурынхан хоёр бие биеийг угтан хөдөлж үхлийн их тулалдаанд оржээ. Ээрэм талд гадаад их далайн шуурга адил нижгэнэсэн чимээ гарч чихийг дөжрөөлөө. Энэ аймшигт тулалдаанд бүгд хутгалджээ. Хүү нь эцэгтэйгээ, эцэг нь хүүтэйгээ тулалдан, хамаатан садан бие биендээ сэлэм далайж, анд нь андыгаа дайрч байв.



Цэргүүд бие биенээ өрсөн хөнөөх гэж улайран давшилж байлаа. Байлдааны тэргүүд давхиан дундаа тар няр хэмхэрч нэг нь нөгөөгөө дайран овоорч, өрөөсөн арал, тэнхлэг, дугуйнууд нь бут үсрэн хүн морьдын зам дээр тээглэнэ. Заанууд морьт цэргийн дундуур шумбан орж тэднийг газар савж унагаан, асар том хөлөөрөө их тэрэг, агт морьд, цэргүүдийг дэвсэн дайрч байна. Шархадсан заанууд аягүй муухай орилон унаад амь тавихаар атиралдан тэлчилж байна. Агт морьд янцгаах, шархдагсдын ёолох, амь тавигсдын орилон хашгирахаас тулалдааны талбар чих дөжрөөм ажээ. Дхритараштрын хөвгүүдтэй тулалдаж буй Бхимасена улангассан үхэр мэт хүнгэнэн дуугарна. Дурйодхана болон түүний дүү нарын байлдааны нумууд нь үүлтэй тэнгэрт харагдах нарны цацрар туяа шиг гялалзаж байна. Каурынхны урт урт сумууд нь хальсаа хаясан могойд шиг харагдана. Үүл мэт нүүгэлтэн ирэх сумууд тэнгэр харанхуйлан хүчит Бхимасены зүг нисэн ирж тэр баатар эрийн ширэн хуягийг үерийн бороо адил дэлдэж байлаа. Бхимасенад хүчин туслахаар Драупадын хөвгүүд Накула, Сахадева, Дхриштадьюмна нар ирж байна. Аржуна, Бхишма хоёр халзаар улайран тулалдлаа. Ююдхиштхира Шалья хоёр, Шикхандин, Ашваттхаман хоёр Друпата, синдхийн хаан Жаядратха хоёр хоорондоо нум сум, жад, сэлэм, шийдмээр тулалдаж байх бөгөөд Каурынхан нь Пандугийнхнаас дутахгүй эрэлхэг зоригтой үзэлцэж байлаа.

Үдээс хойш Дхритараштрагийн хөвгүүд Юдхиштхирагийн цэргийг шахан ухраах болжээ.

Ялагдахыг үл мэдэгч, өргөн саруул ухаант Бхишма мөр дээрээ тааралдсан олон зуу мянган эрчүүлийг хиар цохин арчиж байна. Түүний тавьж буй мөндөр адил буух үхлийн суманд, хүн, морь алагдаж дайны тэргүүд эвдрэн зохиж, хүчирхэг заанууд амь тавин тэлчилж байна.

Догшин Абхиманью, Бхишмаг угтан дайлаар хурдан тэргээрээ давхиулав. Сайхь эр Бхишма болон түүний амь хамгаалагчдын дээрээс үүл мэт сум нүүлгэн буулгажээ. Түүний харавсан нэг сум Криставарман, бас нэг нь Шальяг, гуравдах сум нь Бхишмаг шархдуулжээ. Дхритараштрын хүүгийн хөвчийг Абхиманью амьсгаа хураатал нь цохин унагаж, мэргэн нэг харвалтаараа Крипагийн гараас нумыг нь унагажээ. Абхиманью дайны тэргэн дээрээ жалан дугуй шиг эргэлдэн зүг бүр мэргэн харвалтынхаа сумыг цацаж байлаа. Бхишмагийн нум газар унаж, дээрээ алтан дал мод хатгамалдсан байлдааны туг нь хөмрөн онхолдоход Дурйодханагийн цэргүүд гаслан хашгиралдав. Тэд чадамгай жолоодогч Бхишмагаа алдлав гэж боджээ. Вирата ба түүний хүү Утгара, Бхимасена, Дхришьядьюмна нар Абхиманьюд туслахаар дайсны

дундуур нэвт цохисоор ирлээ. Заан унасан Уттара, мадрчуудын хаан шальяг дайрав. Заан, морьдыг тийрэн унагаж, мадрчуудын хааны их тэргийг хөдөлгөөнгүй болгон зогсоов. Шалья ихэд хилэгнэн Уттара тийш төмөр жадыг шидвэл тэр нь түүний хуягийг нэвтлэн шааж Вирата хааны залуу хүүг алжээ. Шалья гартаа юлд барин ухасхийгээд Утгарагийн зааныг ганц цохилтоор унагав.

Виратагийн бас нэг хүү Шветагийн уур хилэн нь тосоор тэтгэгдэн буй гал мэт дүрэлзэн Шалья руу довтлон түүнтэй халз үзэлцэхийг эрэлхийлэв. Уур хилэн, уй гашуу хоёрт автагдаад байхдаа Швета гарцаагүй үхэл авчирч буй мэт Шальяд аймшигтай санагдах байжээ. Гэтэл мадрчуудын сайхь хаанд Бхишма туслахаар амжиж ирсэн байлаа. Швета, Бхишма хоёр эмэгчингээ булаацалдан ноцолдож байгаа хоёр догшин бар мэт бие биеийг дайрч байв. Шветагийн тавьсан сум Бхишмагийн нумыг яйран болгов. Гэвч Каурав нар жанжиндаа хүчин туслан ирж Шветаг сумаар булж, Бхишмад бас нэг бүр ч хүчирхэг нум авчирч өгөв. Каурав нарын өвгөн удирдагч мэргэн цэцэн харвалтаараа матс нарын хунтайжийн тугийг их тэргэн дээрээс цалам цохин унагаж хөтчийг нь алжээ. Тэгэхлээр нь Швета төмөр жад шүүрэн авч Бхишмагийн зүг маш хүчтэй шидэв. Гэтэл Бхишма түүнийг замд нь харван онож салам бутарсан тул тэр жад зорьсон байндаа хүрч чадсангүй. Каурав нар удирдагчийнхаа мэргэн харвалтад баярлан оодорцгоов. Гайхаш нь барагдаж уур хилэн нь бадарсан Швета үзүүртэй нүсэр том бялуу шүүрэн авч эргүүлж дайсан руугаа шидлээ. Тэр асар том бялуу чих дөжрөм шунгинасаар агаарыг зүсэж Бхишмагийн хөтчийг үхтэл дайран морьдыг нь унагав. Швета хурц өргөн юмлд барьсаар Бхишмагийн их тэрэг рүү харайлгасан боловч хүрч очилгүй замдаа гуйвж унаад амь тавив. Түүний Бхишмагийн хүчирхэг сум онож ширэн хуяг, бамбайг нь цоолоод Шветагийн биеэр нэвт гарган газартай хадчихсан байжээ. Ийнхүү Вирата хааны бас нэг хүү алагджээ. Пандугийнхны зүрхэнд уй гашуу харвав. Тэд дайны эхний өдөр олон эрчүүлээ алуулсан учир Юдхиштхира хааны цэрэг хөөрч иржээ. Гэтэл хүчирхэг Бхишма эцэж цуцахыг үл мэдэн цохилт өгч байсан бөгөөд өвгөн жанжны хөлийн дор өнхрөн унасан хүний толгой олон зуу, олон мянгад хүрчээ. Каурынхны зүрх сэтгэл баяраар бялхаж дайснаа шахаж байлаа. Гэвч шөнийн харанхуй болон аюулт тулалдаан завсарласан тулалдаанд халсан дайчид амрахаар одоцгоов.

Шөнө орой болсон хойно уй гашууд дарагдаж гүйцсэн Юдхиштхира хаан Кришнагийн майханд очжээ. “Кришна минь, бидний өвөг ах Бхишма дийлэхгүй хүчтэй хүн юм байнаа. Гал, газрын хуурай өвсийг түймэрдэх шиг, тэр хүн миний цэргийг өөрийн мөр дээрээс арилган устгаж байна. Цэргүүд маань айхдаа тулалдааны

талбарыг орхин түүнээс зугтах байна. Бид Бхишмаг дийлэхгүй юм байна. Тэр хүн тулалдаанд ер дийлдэхгүй Индра бурхан шиг юм байна. Би ой шугуйдаа буцъя. Энэ дэлхийн эрхтэн дархтанд зарцлагдаж байснаас тэнд аж төрөх арай дээр. Бхишма миний бүх цэргийг устгана гэдгийг би мэдэж байна. Бхишмагийн цохилтод миний цэрэг галын дотор орсон эрвээхэй адил сөнөнө. Улс гүрний төлөө дайн хийж байж би хэдэн дүү нараа, анд шадар нөхдөө, өөрийгөө ч хөнөөх нээ. Би амьдралынхаа үлдэж байгаа өдөр хоногийг хатуу харамсал гэмшилд зориулъя.” Гэж хэлэхэд Кришна, Юдхиштхирад хариу өчсөн нь: “Бхаратын эзэнтэн минь бүү гунь! Гуньж цөхөх явдал хаан хүнд зохихгүй. Чиний дүү нар, дайчин эрчүүл чинь хүчирхэг баатар бөгөөд энэ дэлхийд нэр гарсан алдартай билээ. Жанжид, холбоотон нар чинь чин үнэнч, бидний дунд Друпадын хүү Шикхандин байна. Бхишма түүний гарт үхэх болно” гэлээ. Кришнагийн хэлсэн үг ялалтад бүрэн итгэлтэй байсан учир Пандугийнхан сэтгэл зүрх сэргэн баяр баясал төржээ.

Юдхиштхирагийн цэрэг үүр шөнийн завсраар тулалдаанд бэтгэн жагсжээ.

Бүгдийн манлайд Аржуна, түүний хажууд Друпада болон Пандугийнхны бусад холбоотон байр эзэлжээ. Баруун жигүүрийг Бхимасена, зүүнийг Дхриштадьюмна эзэлж, Юдхиштхирагийн их тэрэг нь Пандугийнхны ангиудын зааг дээр байрлажээ. Каурынхны хуаранд сэтгэл санаа өөдрөг амгалан байгаа Дурйодхана тулалдаанд орохын өмнө өөрийн дайчин эрчүүдэд ийм үг хэлжээ. “Та нар бүгдээрээ дийлдэшгүй хүчирхэг баатрууд юм аа. Та нарын хэн нь ч гэсэн Пандугийнхныг холбоотных нь хамтаар өөрснөө бут цохиж чадна. Гэтэл бүгдээрээ хамжиж байгаа болохоор хичнээн их хүчтэй байх вэ! Бхишмагийн удирдаж яваа манай цэрэг тоо тоймлошгүй олон байна. Гэтэл дайсны цэрэг тоогоор цөөхөн байна. Тулалдаанаа дайран орж, дайснаа дарах болтугай!” гэжээ.

Дайны дун бүрээ дуугарч, хэнгэрэг дэлдэхэд дайснууд бие биесийн зүг тэмүүлэн довтолцгоов. Цэргүүд хатуу ширүүн тулалдаж, дайны тэргүүд мөргөлдөн донсолж, морьд цээжээрээ шааж ойчин, энд тэндгүй дарга нарын уриалан дуудах хашгираан, шархадсан хүмүүсийн ёолох, бархиралдах, адгуус малын шуугилдах чимээ гарч байв. Бас л тулалдааны эхний өдрийнх шиг Пандугийнхны давагдашгүй дайралтыг хадан хясаа адил мятардаггүй Бхишма тогтоожээ. Иймд Аржуна Кришнад:

“ Миний их тэргийг өвөг ах Бхишма руу зал. Би түүнийг алаад дайчдаа үхлээс авъя.” Аржуна улангассан заан мэтээр Бхишмаг дайрчээ. Түүний өмнөөс мөндөр мэт сум буулаа. Гэсэн ч Аржуна давхийсэн ч үгүй. Түүний хүчирхэг нум нь дайсныг алдалгүй устгаж, Каурынхны цэргийг цөөрүүлэн сарниаж эхлэв. Бхишмагийн дайчин

эрс нэг нь нэгийгээ дэрлэн унаж мөнхөөр нойрсож байлаа. Дурйодхана өөрийн олон зуун баатар эрчүүдийн алагдаж байхыг хараад орь дуу тавихдаа: “Бхишма чи буруу юм хийж байна” гэж бачимдан хашгирч “ бидэнтэй хамт Карна байхгүй чинь чиний буруугаас болж байна. Карна байсан бол энэ галзуу Пандугийнхныг номхтгоод өгөхсөн. Чи үүнийг сөнөөх ямарваа нэг ухаан сийл. Бхишма!” гэж Дурйодхана Бхишмад хашгиран хэлээд, өөрийн их цэргийг Аржунагийн өөдөөс залав. Тэр хоёрын халз тулаан маш шаргуу байлаа.

Гэвч тэр хоёр хүч чадал, эрэлхэг зоригоор хэн нь ч хэнээсээ дутахгүй байлаа.

Аржунагийн зүүн талд Дхриштавьюмна, хүчирхэг Дронатай ширүүн тулалдаж байна. Тэр хоёр бие биерүүгээ үй олон сум нүүлгэж, сумаар сумыг няцаасаар байлаа.

Дхриштадьюмна алт, танан чимэгтэй жадаа Дрона руу шидлээ. Дрона инээмсэглэж, нэг сумаар Дхриштадьюмнагийн тэр жадыг тэнгэр шт хугалаад, бас нэг сумаар дайсныхаа гар дахь нумыг яйран болгов. Тэгэхлээр нь Друпадагийн хүү бялуу барьж аваад Дрона руу шидэв. Дрона их тэргээ хөдөлгөн бултаад төмөр жад хаяж Дхриштадьюмнагийн үнэт хуягийг нэвтлэн өөрийг нь шархдуулжээ. Энэ байдлаар тэд цус нөжөндөө хутгалдан байлдахад, хуяг дуулгууд нь нарны гэрэлд улайран харагдах нь ой доторх хавар цагийн цэцгэрхүү үзэгдэнэ.

Дрона мэргэн харваж Дхриштадьюмнагийн гараас бамбайг нь алдуулжээ. Друпадагийн хүү балт шүүрэн авч, их тэрэгнээсээ үсрэн буухыг завдтал Дронагийн харвасан сум түүнийг нь бас алдуулав. Дхриштадьюмнагийн аминд Бхимасена орлоо. Сайхь баатар түүнд өөр нэг их тэрэг авчирч өгөөд өөрөө тулалдаанд нэгэнт алжаасан Дронатай халз үзэв. Дронад туслахаар калингийн хаан олон тооны цэрэг болон байлдагч- нишадчууд хүрч иржээ. Тэд чангаар хашгиралдан Бхимасенагийн их тэргийг бүслэн авч эрэлхэг Пандугийнхныг сумаар булж эхлэв. Калингийн хааны хүү Чакрадева мэргэн харваж Бхимасенагийн морьдыг алав. Тэгмэгц уур хилэн нь ихэд бадарсан Бхимасена түүнийг хүнд гэгчийн бялуугаар шидэж, морин тэргэн дэрээс үхэдхийн унагав. Бхимасена заналтай гэгчээр хашгиран их тэрэгнээсээ харайн буугаад калингчууд руу дайрахад, цаадуул нь балмагдан айжээ. Түүний юлдийн цохилтоор дайчин эрчүүл, агт морь, асар том заанууд амь тавин ойчиж байлаа. бхимасена айны талбар дээр галт хуй салхи шиг дүүгэж, хавь ойрын тааралдсан бүхнээ хядаж, дайсны цэргүүдийн сүнсийг зайлтал айлгажээ. Бхимасенагийн шархдуулсан заанууд өвдсөндөө ухаан мууран улангасаад эргэж давхин калинийн цэргүүдийг няц дайрч байна. Калингчууд зэр зэвсгээ хаяад өөрснөө амь зулбан зугтаахад хүчирхэг Пандугийнхан ялсандаа оодрон баярлаж байлаа.

Цусанд будагдсан тулалдааны газар шөнө хав харанхуй болтол шаргуй тулалдаан үргэлжилсэн боловч тэр их байлдааны хоёрдахь өдөр Каурынханд бүтэл муутай өнгөрчээ. Шөнө болж, ээрэм тал харанхуйлахад цуцаж ядарсан дайснууд амарахаар таржээ.

Ийнхүү Пандугийнхан Каурынхан нар өдөр бүр үүр цүүрээр эхлэн хоорондоо үхлийн тулалдаан хийж байсан боловч Пандугийнхан хүссэн ялалтандаа хүрч чадахгүй байжээ. Пандугийнхан эрэлхэг зоригтой шаргуу байлдаж байлаа.

Өвгөн Дхритраштрагийн хөвгүүд ч цөөрсөөр байлаа, гэсэн ч Юдхиштхира болон түүний дүү нарын бүхий л чармайлтыг дийлдэшгүй Бхишма няцаасаар байжээ. Тэгэхлээр нь Кришна түүнийг муу санаагаар дийлж авахыг боджээ.

## XX

Тулалдааны арав дахь өдөр Пандугийнхан Кришнагийн зөвлөсөн ёсоор Друпата хааны хүү Шикхандиныг цэргийн магнайд гаргажээ. Тэгээд бүгдээрээ, нум харван, жад шидэн нүүлгэсээр зам гарган Бхишма руу тэмүүлжээ. Бхимасена болон түүний хүчирхэг цохилтоор Дриодханагийн маш олон цэрэг эрс амь алдаад тэр өглөө Каурынхан Пандугийнхны зогсолтгүй түрэлтийг тогтооё гэвч хүчин мөхөсдөж байжээ. Тэд Бхишма болон түүний амь сахигч нар, Дхритраштрагийн хүүхдүүдийг тал бүрээс нь бүслэн авч өвгөн жанжны зүг тэнэгр харанхуйлсан үй түмэн сум нүүлгэв. Шикхандины харавсан сум Бхишмагийн цээжинд гүнзгий шааж ороход сайхь хүчирхэг жанжны уур хилэн бадарчээ. Гэвч тэрбээр Шикхандинтай тулалдахыг үл хүсэн дооглонгүй инээмсэглэж хэлсэн нь: “Чи надтай тулалдах эсэхээ өөрөө мэд, чиний дурын хэрэг. Харин би чамтай хэзээ ч тулалдахгүй. Чамайг бурхад эм хүн болгож төрүүлсэн бөгөөд би чамайг эр хүн гэж тооцохгүй байна” гэжээ. Бүхнийг мэдэгч Бхишма үнэнийг хэлжээ. Шикхандин уг нь Друпата хааныд охин болж төрсөн боловч бүсгүй хүн байхыг үл хүсчээ. Тэгээд балчир байхдаа өөрийн хүүхэнлэг чанарыг нэг шүтээнд өгөөд хариуд нь эрэлхэг чанар, хүч чадал хоёрыг авсан ажээ.

Бхишмагийн даапаалсан үг Панчалын хааны хүүг дайсны сумнаас ч илүү нэвт шархдуулжээ. Сайхь хүү уурандаа бие нь чичирч, омголтсон уруулаа долоож, Бхишмад хариу өгсөн нь: “Чи агуй их, ялагдашгүй дайчин эр юм. Чиний гавьяа, хүч чадал нь дэлхийд алдаршжээ. Гэвч би чамтай өөөдөр тулалдаад чамайг ална, чин үнэн гээрээ би тангараглая” гэв. Ингэж хэлмэгцээ Шикхандин нумныхаа хөвчийг татан таван сум таьсан нь цөмөөрөө Каурынхны тэрхүү жанжинг шархдуулжээ.

Шикхандиныг ар талаар нь хамгаалж байсан Аржуна түүнд: “Айх эргэлзэх юмгүй тулалаад бай. Бхишмаг зоригтой дайр. Тэр чамд цохилт өгч чадахгүй болжээ. Хэрэв бид Бхишмаг алалгүйгээр хуарандаа буцаж очвол биднийг дэлхий даяар дооглох болно гэдгийг сана” гэв.

Ингээд Пандугийнхан Бхишмаг дахин шинэ хүчээр дайрчээ.

Духшасана, Аржунатай халз тулжээ. Омогт Аржунагийн дайралтыг Духшасана хэлбэрэлтгүй тогтоох нь шуургат их далайгаас газар ухардаггүйтээ адил байлаа. дийлдэж ч яваагүй, өнгө үзэсгэлэнгээрээ наран, саран лугаа төстэй тэр хоёр тулаанд хоёул улайрч, нэг нь нэгийгээ хөнөөхсөн гэж шүлсээ залгиж байна. Духшасанагийн харвасан гурван сум Аржунагийн духанд шаан орж, цусыг нь урсгалаа. Аржуна духандаа сум зоолтгойгоор үзэлцээр төдхөн харавсан сумнуудаараа Духшасанагийн нумыг гараас нь алдуулж их тэргийг нь хэмхчив. Духшасана цус нь нэлий болж тэр цусан далайн доторх сүндэрлэгч хадан хясаа мэт зогсож байсан Бхишмагийн хаацайлалтаар зугтан зайлжээ.

Тулалдааны талбай тэг дунд Юдхиштхирагийн баатар эрчүүлийг довтолгооны хүчирхэг Дрона тогтоосоор байв.

Дрона Пандугийнхны улайрсан довтолгооноос Бхишмаг хамгаалан байлдаж байхдаа өөрийн хүү Ашватахаманд гунигтайхан хэлсэн нь: “ Би харваад харваад ердөө ч дийлэхгүй юм, зэвсэг миний эрхнээс гарч, сэтгэл зүрх нэг л урамгүй болжээ. Шувуунууд ээрэм тал дэгүүр эргэлдэн аймар муухай хашгирах болов. Нар цонхийж, газар доргиж байгаа нь газар ч гэсэн айгаад чанга бахирах шиг санагдах болно.

Муу ёрыг зөгнөсөн цөөвөр чоно улихыг би сонслоо. Муу санаат Аржуна, Шикхандиныг өмнөө оруулчхаад бидний өмөг түшиг Бхишматай уулгалан тулалдаж бай. Үүнийг харахаас зүрх минь шимширч байна. Хүү минь ялж дийлээд алдар нэр олохын төлөө тулалдаанд орогтун, тэнгэртээ залбирч яваарай. Друпата хааны хүү Шикхандинтай тулалдаж үхтэл нь бут цохь Юдхиштхиратай өөрөө тулалдъя” гэжээ.

Дронагийн хэлсэн үг Дурйодханагийн цэргүүдийг зоригжуулсан учир тулалдаан бүр ч хатуу ширүүн болжээ. Харвасан сумууд нь үүл, нарыг халхлан нүүх адил харагдана. Хоорондоо мөргөлдөн гацсан их тэрэгнүүд нэг доор овоорчээ.

Шархадсан мал орилолдож, хүмүүс ёлон хашгиралдана. Газар доргин хүнгэнэнэ. Цус шол мөрөн шиг урсана. Дайчин эрчүүл үмх мах булаалцалдсан шонхрууд шиг үзэлцэнэ. Амь үрэгдсэн дайчдын хүүр тулалдааны талбар дуур зулан хэвтэх бөгөөд цусанд будагдсан ээрэм тал тэр аяара намрын тэнгэрт үзэгддэг улаан

хүрэн үүл мэт харагдана. Нохой чоно, цөөвөр, харцага, хон хэрээ талбайг эргэн зогсоо зайгүй шуналтайяа хашгиралдана.

Пандугийнхан Бхишмаг нягт бүсэлж аваад цохилт өгсөөр байлаа. Түүний хуяганд сумнууд нэвт шаан орж биеийг шархдуулах боловч хүчирхэг Бхишма өвдөхийг үл мэднэ. Түүний нум, юлд нь дайснаа хайр найргүй устгаж, түүний дайран давшла нь сүртэй бөгөөд дийлдэшгүй. Тэр өөрөө орчлон сөнөх цаг болоход бүхнийг шатаан устгагч дөл лүгээ төстэй. Пандугийнхан айн чичирч, сүнс нь зайлах дөхөж байсан бөгөөд гагцхүү Аржуна, сайн язгуурт Бхишмагийн өрөвдөж хайрласан Шикхандын хоёр л өвгөн жанжинд цохилт өгсөөр байлаа. Тэр хоёр Каурынхны удирдагчид улам улам ойртсоор, эцэст нь Аржунагийн харвасан нэг сум Бхишмагийн байлдааны нумыг салам болгов. Өөр нэг нум авсан боловч бас л салам болгуулжээ. Уур хилэн нь бадарсан Бхишма, Аржунагийн их тэрэг рүү жад шидэж эхлэв. Гэвч Пандугийнхны харвасан сумууд түүний жадуудыг газар унагасаар байлаа. Мэргэн харвасан суманд Бхишмагийн хөтөч амь алдаж, морьд нь үхэтхийн унахад мөнгөлөг өнгөөр гялтганагч тэр их тэрэг хөдөлгөөнгүй зогсжээ. Шикхандинын харвасан сумнууд өвгөн жанжины биед шивэн орж тэсэхийн аргагүй өвтгөлөө. “Ингээд миний үхлийн цаг ирлээ” гэж Бхишма жаргаж буй нарыг хамгийн сүүлчийн удаа нэг харж нам дуугаар хэлээд алгуур ойчжээ. Түүний биед шигдээд нэвт цухуйсан сумнууд үхэр зарааны боссон зүүнүүд шиг газар шааж, тийнхүү эрэлхэг Бхишмагийн сүүлчийн нойрссон ор нь нумны сумуудаар бүтсэн байлаа. Амь тавьж буй Бхишмаг үхэтхийн унахад тулалдааны талбар дээр аймшиг, уй гашуу хоёр ноёлжээ. Пандугийнхан ба Дхритараштрагийн хөвгүүд тэр өвгө ахынхаа сүүлчийн ор дэвсгэрийн дэргэд бөөгнөрч хүрээлэн тэргүүнээ гудайлган ганц ч үг хэлэлгүй зогсоцгоожээ.

Бхишма нүдээ нээж, ач ачинцар нарыгаа хараад: “Миний бие суман дээр тогтож байна. Гэтэл толгой минь доош унжаад хүчрэгдэхгүй байна. Аржуна чи миний толгойг сумнуудаараа тулгуур болгож туслаач” гэв. Аржуна аварга том нумныхаа хөвчинд халуун сум хийгээд татаж тавив. Тэр сум Бхишмагийн тэргүүний доорх газар шааж нэг хэсэг доргин салганаж байснаа тэгширч сүүлээрээ Бхишмагийн ар шилд тулгуур болов. Аржуна дахин дахин харвасаар тийнхүү өвгөн жанжинд сумаар сүүлчийнх нь жинтүүг хийж өгчээ.

Догшин сүрт баатар эр амьдралаас харамсалтайяа хагацжээ. “Надад ус өгөөч” гэж Бхишмаг хэлэхэд зарц нар хээ хуар болсон савтай ус авчрахад “энэ уснаас уухгүй” гэв. “Аржуна, чиний харвасан сумнууд миний биед шивж, надад байдаг хамаг

амьтай бүхэн тэдгээрт сэглэгджээ. Миний шарх галаар төөнөх шиг болж байв. Би ингээд амьдралаас хагацлаа. Чи үхэхийн минь өмнө надад ус уулга” гэж ачдаа хэлэв.

“Тэгье” гэж Аржуна хэлээд их тэргэн дээр авиран гарч, нумаа хөвчлөн татаж байгаа Бхишмагийн дэвсгэрийн яг дэргэд сумаа харван шаав.

Сумны харваж орсон яг тэр газар дороос амтлаг цэвэр, зэлмүүн устай гайхам сайхан булаг оргилжээ. Бхишма тэр уснаас цангаага гаргаад Дурйодханад хэлсэн нь: “Уур хилэн ховдог шунал хоёроо дар. Би ингээд үхлээ. Чи миний үхэж байгаа энэ цагт дайсагнахаа болиод Пандугийн хүүхдүүдтэй эвлэр” гэжээ. Өвгөн баатар ингэж хэлсэн бөгөөд энэ нь түүний амьтдаа хэлсэн хамгийн сүүлчийн үг юмаа.

### ХШ

Друпадын элч, Хастинапурт хүрч очоогүй байхад Ганга мөрний эргээс авхуулан алс холын Клакутын оргил хүртэл тоо томшгүй их цэрэг ойр хавийг бүрхсэн харагджээ. Энэ бол тэр орны өнцөг булан бүрээс Хастинапурт хүрч ирсэн Каурынхны болон тэдний холбоотон сүлбээтний цэрэг ажээ.

Дхритараштрын ордноо Каурынхны болон түүний түнш овог аймгийн бүх удирдагч жанжин нар байхыг сайхь элч ордны дотор цугларсан тэдгээр эзэн хаад, жанжин нарт хандан: “Та бүхэн хаан хүмүүсийн эрх үүргийг андахгүй мэднээ. Дхритараштра, Панду хоёр бол нэг эцгийн хоёр хүү билээ. Эцэг өвгөдөөс уламжилсан өвлөх хувь адил байх нь эргэлзээгүй. Дхритараштрагийн хүүхдүүд өөрсдийн хувийг авчхаад байхад Пандугийн хөвгүүдийг хоосон орхих гэдэг шударга хэрэг үү? Тэд их доромжлол, зовлон гамшиг амсчээ. Гэвч тэд муу санаа өвөрлөөгүй байна. Одоо та нар энх тунх амьдрал буюу дайн шударга ёс, муу үйлийн алиныг нь сонгож авахаа шийдэцгээ. Дхритараштрагийн талд дайн, тулалдаанд тэмүүлэн байгаа мянган зоригт эрс байна. Түүний талд дийлэгдэшгүй ах дүү нарынх нь хүч чадал, эрэлхэг зориг, их Кришнагийн мэргэн ухаан байна.

Үйл хэргийг энх тунхаар туйвруулах завшааныг бүү алд! гэсэн ийм үг хэлжээ.

Элчийн үгийг сонсоод Бхишма:

“Бярман чи чин үнэнийг хэллээ. Пандугийнхантай байлдана гэдэг бол тэнэг хэрэг. Тэдэнтэй тулалдаал хэн тэднийг дийлэх юм бэ? “ гэхэд Карна түүний үгийг шууд тасалж, Дурйодхана руу харан хашгиран хэлсэн нь: “Ав адилхан юмын нуршихын



хэрэг юу вэ? бид ийм үг бишгүй дуулсан юм. Юм бүхэн хуулийн эрхээр болсон шүү дээ. Шакуни тоглож хожоод Пандугийнхан ойд явсан. Эсхүл Юдхиштхира тэр гэрээгээ мартчихаа юу яагаав? Тэд буцаж ирээд Дурйодханагийн албат болж амьдрах ёстой шүү дээ. бярман та айлгаж сүрдүүлээд юу ч олж долоохгүй. Дурйодхана сөөм газраа ч зүгээр өгөхгүй. Харин шударга ёсны төлөө бол өөрийн бүх улс гүрнийг дайсан этгээддээ боловч өгөхөөс буцахгүй хүн тэр”. Хөтчийн хүү чиний үг зүйд нийцнэ. Аржуна ганцаараа манай бүх цэргийг ухаарсныг чи санахгүй байна гэж үү? гэж Бхишма мөчөөрхөв.

Дхритараштра маргагчдыг болиулаад “Мэргэн Бхишмагийнх зөв. Би нэн даруй Пандугийнханд элч илгээхээр шийдлээ. Харин лам та өөрийнхөө хаанд очоод намайг таны үгийг сонсоод баярлаж байна гэж хэл” гэв.

Элчийг ормогц хаан өөрийн хөтөч Санжаяг дуудан ирүүлж хэлсэн нь:

" Дхритараштрагийн хуаранд Индра бурхны хүч лүгээ тэнцэх ялагдашгүй их цэрэг хуржээ. Тулалдаанаар тэд миний хэдэн хүүхдийг хүйс тэмтрээд эрхийнхээ дагуу Пандугийнханд оногдох зүйлээ хүчээр авч чадах юм байна. Би тэдэнтэй дайтахаас зүрхшиж байна. Санжая чи Пандугийн хөвгүүд дээр очиж хаан миний хүндэтгэлийг хүргэж та нарын зовлонг амьдрал шувтарсанд баяртай байна, хойшид та нартай гагцхүү найрамдаж энх тунх амьдрахыг хүсч байна гэж намайг хэлж байна гээрэй” гэв.

#### XIV

Санжая тэр даруй Юдхиштхирагийн хуаранд очоод Пандугийн хүүгийн өмнө сөхрөн Манай хаан Пандугийн хүү та нарт баяр хүргэж сайн сайхныг ерөөж байна. Хаан та нарын сүр сүлдийг хүндэтгэж, та нарын сүр таны ганц ч нүгэлт үйлээр бузарлагдахгүй байх гэж итгэж байна. Алдарт Пандугийн хөвгүүдтэй тулалдахад хэн ч Индра бурхан өөрөө ч дийлэхгүй гэдгийг хаан ухаарч байна. Каурынхны хүч чадал, эрэлхэг зоригийг давах хэн ч энэ ертөнцөд байхгүй гэдгийг ухаарч буй. Каурынхан та нарын хооронд энх найрамдлыг тогтоох явдлыг миний хаан болон түүний мэргэн зөвлөх Бхишма хамгийн дээд мөрөөдөл гэж үзэж байна” гэлээ.

Санжая аа, би дайны тухай ганц ч үг дурсаагүй билээ. Дайснаас энх тунх амьдрал дээр. Сэтгэл зүрхнийхээ хүслэнг саадгүй биелүүлэх юм юмтай хүн зэвсэг барьж авахыг яардаггүй чин үнэн. Дхитараштрат энх тунх амьдралын тухай ярих

амархан, тэр бол өөрийнхөө цэвдэг хүүгийнхээ төлөө л санаа тавьдаг хүн шүү дээ. Хаан ариун удамт Видурагийн зөвлөгөөнийг хэрэгсээгүй. Төрсөн дүүгийнхээ хүүхдүүдийг заль мэхийн аргаар үгүйрүүлэхийг тэр тэвчин зөвшөөрсөн хүн. Тэгсэн мөртөө одоо бидэнтэй эвсэг найрсаг бая гэж байна. Тэр хүн гачигдаж дутагдах, өлсөх ундаасах гэдэг зовлонг мэдэхгүй, хээнцэр гоё хувцаснаас өөр юм эдэлж үзээгүй, шилдэг тансаг идээнээс өөр юм амсаж үзээгүй элбэг дэлбэг, эрх жаргалаараа амьдарч яваа хүн. Гэтэл бидэнд байх юм юу ч алга, бид бие шалдан, хөл нүцгэн гуйланч, үгүйрсэн хүмүүс байдаг. Тэгтэл эцгийнхээ олж өгсөн өөрсдийнхөө эрэлхэг эр чадлаараа олж авсан юмнаас хагацсан бидэнтэй одоо болохоор эвтэй найртай байа гэж байна тэр хаан!. Харин бид дэлхий дахинаа энх тунх байлгахыг төлөө Каурав нарын санаат үйлийг уучилна. Ямар л байгаа бол тийм л байг, сайн л биз. Санжая аа би таны зөвлөснөөр энх тунх байх арга замыг хайх болноо, гэвч тэд бидэнд Индрапрасх нийслэлтэй минь эгүүлж өгөг. Дхритараштрад очиж миний үгийг дамжуул Санжая Нэг бол бидэнд нийслэлийг минь эргүүлж өг, эсвэл бидэндтэй нүүрлэн тулалд гэж хэл гэжээ.

Санжая энэ үгийг өөрийн хаанд бүгдийг нь нарийн зөв дамжуулна гэж амиан буцжээ. Сайхь элч шөнө болж байхад Хастинапурт хүрч ирсэн бөгөөд, өглөө нь хаан түүнийг ордондоо дууджээ. Каурынхан түүнээс Пандугийнхны тухай цэрэг зэвсэг холбоотных нь тухай шалгаан асуулаа.

Санжая тэр асуултуудад нь тодорхой хариу өчиж Пандугийнхан тоо томгүй олон цэрэгтэй зэр зэвсэг нь гайхалтай, Юдхитхирагийн хань нөхөд холбоотон нар нь тулалдаанд ороосой гэж тэмүүлж байдаг юм гэж ярьжээ. Үүнийг сонсоод хаан айжээ. Дийлдэшгүй Баимансена бол амьд үхсэн хүн иддэг догшин савдаг, эд адгуурасын бурхдын аянга, мөн ялагдана гэдгийг мэддэггүй Аржуна нь тулалдаанд орохдоо догшин сүртэй байдгаас хаан ер бишийн их айжээ Дхритараштра өөрийн хэдэн хүүгийн амь нас үрэгдхээс айгаад Пандугийхантай тулаан хийж зориглохгүй байжээ. Санжая минь Пандугийнхан миний хэдэн хүүг ганцыг нь үлдээлгүй хядаж орхино доо. Тэр баатар дайчдын цохилтод манай овог үрэгдэж сөнөнө. Тийм учраас би энх тунх байхыг хайж байгаа юм шүү. Юдхитхира бол биднийг гай зовлонд учирлаа гэхэд цэвдэг сэтгэл гаргаад орхих хүн биш, харин би шудрага биш дайны шалтгаан болчихвол намайг тэр зэмлэн залхаана. Яах вэ, Санжая Яаж энэ хэдэн мулгуу шунахай хүүг Пандугийнхантай эвлэрүүлэх вэ, гэж Дхритараштра хаан элчийнхээ үгийг сонсоод өгүүлэхэд Санжая хариу хэлсэн нь: “хаан чиний хэлдэг зөв.

Хэрвээ дайн дэгдвэл чиний овог сөнөнө. Харин чи мэргэн ухаантай хашир хүн байж өөрийнхөө маанаг хүүхдүүдийн үгэнд ороод байдал чинь миний ухаанд нэг л бууж өгөхгүй байна. Одоо тэгж найланхайтаж байдаг цаг биш. Хаан чи Пандугийнхыг ойд цөлөгдөн явж байхад баярлаад инээж байсан шүү дээ. Тэр үед энэ чинь хожмоо юунд хүргэхийг та яаж мэдэв гээч. Эзэмшил чинь хариугүй жаахан байсан, харин эдүгээ та ч нарынхаа гавьяагаар дэлхийг захирч байна. Гэвч одоо мунгинаж суух цаг биш чухамхүү хаан хүн шиг суух хэрэгтэй цаг болоод байна гэхэд “Аав минь энүүний үгэнд бүү ор. Бид ямар ч дайсныг дийлнэ.

Би Пандугийнханд итгэхгүй. Тэд бидэнтэй найрамдахыг хүсэхгүй байна. Ингэж л ярьж байгаа болохоос үнэндээ дайнд өөрснөө бэлтгэж байна. Юдхитхирагийн хуаранд түүний бүхий л анд нөхөд, хань хамсаатан цуглачихаад хаантан минь таны бүх овгийг, хамаг хүүхдүүдийг чинь, ач зээ нарыг тань, толгой тоолон хөнөөх гэж хэл амаа олчхоод байж байгааг би мэдэж байна. Тэд хэнийг ч хайрлахгүй. Пандугийнхантай найрамдлаа ч гэсэн баттай биш. Пандугийнхан Индрапрастхад баттай сууж авмагцаа улс гүрнийг чинь эзлэн авч, таныг өөрийг чинь эрх мэдэлгүй болгоод дараа нь амь насанд хүрэх улс байгаа юм. Тэгэхлээр тэл бидэнтэй тулалдахаас айхын хэрэггүй. Эцэг минь та, Бхимасенагаас айдаг чинь дэмий хэрэг. Би тэрнийг чинь өөрөө тулалдаад шийдмээрээ цохиж аламз. Бурхад ч миний цохилтыг тэсэхгүйгээр шүү дээ. та миний дүү нарыг, замдаа таарсан бүхнийг замдаа таарсан бүхнийг арилгаж сөнөөдөг миний анд нөхөд, холбоотнуудыг мартаад байна. Карна, Бхишма, Дрона нар яагаа вэ? хэн ямар тулалдаан болоход тэдэнтэй эн зэрэгцэх юм бэ? тулалдаахаас шимшрэхийн хэрэггүй эцэг минь. Пандугийнхан жигшүүртэйгээр дарагдах нь гарцаагүй гэж Дурйодхана эцэгтээ хандан хэлжээ.

Гэвч ууган хүүгийнх нь үг хааны сэтгэлийг засч чадсангүй. Дхритараштра ялна гэж итгэж чадахгүй байсан болохоор Дурйодханаг ятгаж элсүүлэхийг оролдохдоо “Хүү минь чи хүнийг юм бол үзэн ядаж дайсагнадаг зангаа тат, би гуйч чамайг. Одоогийн улс гүрний маань хагас нь ч чамд багадахгүй. Сайн язгуурт Пандугийнханд эрхийн ёсоор оногдох юмыг нь эргүүлж өг, тэдний өвлөх хувийг нь өг. эс тэгвэл Пандугийнхантай тулалдаад чиний цэрэг ч, чи өөрөө ч сөнөх үйлээ эдлэнэ. Мулгуу зан шунал хоёр л ухааныг чинь идчхээд байна гэжээ.

“Би Пандугийнхантай энэ дэлхий дээр нэг доор амьдрахгүй. Эсвэл би тэднийг дараад дэлхийн эзэн болно, нэг бол тэд намайг хөнөөгөөд дэлхийг захирна биз. Таны

дур зориг холбоотны чинь хүслээс би зөрж Пандугийнхныг тулалдаанд өдөөд Карнатай хамжиж тэдний ганцыг нь үлдээлгүй устгая” гэж Дурйодхана хариу өчжээ.

Санжаягийн буцсаны дараа Юдхиштхира, Ядав нарын хаан бөгөөд өөрийнхөө хүчирхэг ивгээгч анд нөхөр Кришнад хандан хэлэхдээ: “Яах учраа би олохгүй байна. Каурынханд итгэх юм надад алга. Тэдний эвлэрье гэж байгаа нь цул заль. Дхритараштра, хэдэн хүүгийнхээ үгнээс гарч чадахгүй, цаадуул нь гэдэг чинь ичих нүүр ёс төрөө аль хэдийн алдсан улс. Тэд ов мэх залиар олж авсан газраасаа сөөмийн төдийг ч буцааж өгөхгүй” гэхэд Кришна хариу өчсөн нь: “Чиний сэжиглэдэг чинь яах аргагүй зөв. Дурйодхана бол бузар явдалтай, атаач, сувдаг хүн, тэр ер нь найрамдахыг эрмэлзэх хүн биш ч гэлээ гэсэн би Хастинапурт очиж та нарын хооронд найрамдал тогтоохыг оролдоё. Энх найрамдал найдлага хичнээн бага байгаа ч гэсэн хожим чамайг хэрцгий балмад хүний цус урсгах дуртай гэж зэмлүүлэхийн тулд би Дхритараштра руу чиний элч болж очъё” гэв.

Кришнаг ганцаараанг дайсны хуаранд элчээр явуулах нь Юдхиштхирад аймшигтай байжээ. Гэвч сайхь хаан өөрийн анд нөхрийнхөө мэргэн үгэнд бишрээд эргэж ирэхийг нь тэвчээртэй хүлээж байжээ.

Кришнаг Хастинапурт дөхөж очиход хотын дээгүүр сүртэй юм үүсчээ. Тунгалаг өдрийн тэнгэрт гэнэт гялбаа гялбан тэнгэр асар чимээтэй нижигнэн дуугарчээ. Газар дээр шар тоос хуйлран хөдөлж борооны ус тариалангийн талбай дээр үерлэн буув. Догшин салхи хотыг дайрч ургаа моддыг орвонгоор нь унагаж, оршин суугчдыг нь дагжаан чичрээжээ.

Нийслэл хотод агуу их Кришна ойртон ирж байгааг хотын сахиулууд хаандаа мэдээллэв. Хаан зөвлөх нараа яаравчлан дуудуулаад тэдэнд хэлсэн нь: “Маргааш өглөө Васудевын хүү энд ирнэ. Түүнийг хөлтэйхэн угтах хэрэгтэй байна. Тоос шороо босгохгүйн тулд замыг нь услах, төөнөм халуун нарнаас Кришнаг хаацайлж сэрүүцүүлэхийн тулд хотод орох зам дагуу сэхээвчүүд барих түүнийг угтаж хөгжимчдийг явуулах хотыг туг хиур цэцгээр чимэглэх хэрэгтэй. Түүнд арвин бэлэг болгохын тулд эрдэнийн чулуун бугын арьс, байлдааны заан, цагаан морь хөллөсөн алтадмал тэрэг, царайлаг бол хүүхэн, шивэгчин, бүжигчдийг бэлтгэ гэж зарлиг буулгажээ.

Мэргэн Видура хаантай санал зөрж хэлсэн нь: “Кришнаг хуурах гэж оролдоод дэмий, эзэнтэн минь. тэр чинь Пандугийнхны үнэнч нөхөр, түүнийг эелдэг ааш эд

бэлгээ татаж дийлэхгүй. Кришна таны овыг дор нь мэднэ, нэрд тань муухай. Тэр хүн, таны хүүхдүүдийг Пандугийнхантай найрамдуулах зорилгоор ирж байгаа, өөртөө олз ашиг хайн яавч ирээгүй. Хаантан минь чин үнэнээрээ байсан нь дээр, нэг л бэлэг бэлдүүл, замд явж ирээд хөлөө угаах савтай ус л бэлтгүүл.

Гэтэл Дурйодхана хэлсэн нь: “Бүү зов эцэг минь, Кришнаг ирэхлээр би барьж аваад гянданд хийчихье. Тэгээд Пандугийнхны нэг хүчирхэг холбоотон найз үгүй болно. Дурйодханын үгийг сонсоод хаан түшмэл бүгдээр балмагдав. “Хүү минь ухаан чинь эрүүл биш байна” гэж хаан уурсан зандрав. Кришна бидэн дээр элч болж ирж байхад ч итгэл эвдье гэж байна гэж Бхишма уурандаа нэг ч үг хэлэлгүй зөвлөлгөөнийг хаяад гарчээ. Хаан ч яах учраа ололгүй зөвлөх нарыг тараав.

Өглөө Ядавын хүчирхэг хаан Кришна ордноо залрав гэж Дхритараштрад зар нь айлтгав. Кришна хаан болон түүний хөвгүүд танхимд бугларсан тэдний холбоотон эзэн хаад, тэдний шадар хүмүүс даяанч мэргэдийг хүндэтгэн мэндлэв. Кришна хариу үг сонсч, элч хүнд таарах хүндэтгэлийг үзээд түүнд зориулан гаргасан өрөөнд орлоо.

Кришна маргааш өглөө нь Дурйодханы ордонд орж хааны тэр их хүүд баяр хүргэсэн боловч идээ цайнаас нь татгалзаж хэлэхдээ: “Миний анд нөхдийг үзэн яддаг тийм хүнтэй би зоог хувааж эс чаднам” гэжээ. Кришна, Дурйодханы ордноос гараад Видурынд очиж тэднийд хоол унд зоогложээ. Тэгээд Кришна Кунтийнд очиж түүний хөвгүүдийн эсэн мэнд

Абхиманью түүнтэй халз тулж байгаадаа баярлан Духшасанад хэлэхдээ: “Чи миний цусан төрлийхнийг танаггүй гомдоосон доо. Чи өнөөдөр миний гараас амьд мултрахгүй” гэж байлаа. Абхиманью ингэж хэлээд Духшасана руу нэг хурц үзүүртэй урт гэгчийн сум харавтал тэр нь шоргоолжны үүр лүү шааж буй хорт могой мэтээр тэр Каурын удмийн хүний цээжинд шивэн ороход Духшасана нум бамбайгаа газар алдаж, салгалан гуйвж эхэлснээ сэхээгүй болон тэргэн дотроо ойчив. Аржунайн хүүгийн суманд оногдож амьсгалаа хураан унаж байгаа Духшасаныг харж байсан Каурынханд их л аймшигтай болжээ. Дурйодханагийн цэргүүд айсандаа ам хоолой нь аргаж, үс нь арзасхийн босч, зүрх нь ёгхийн түгшиж дайны талбарыг орхин зугтахыг завдан байтал Дрона, Крипа, Дурйодхана, түүний хүү Лагшмана нар Абхиманьюгийн тал бүрээс дайрчээ. Гэвч Аржунайн хүү тэнгэрийн үүлийг шавхуурдан хөөгч хүчтэй салхи мэтээр дайснуудын өөдөөс зоригтой давшилжээ. “

Ертөнцийг сүүлчийнхээ удаа хар! Гэж сайхь хүү хөөрхөн Лагшманад хашгиран хэлээд хөвчөө татан өргөн хурц үзүүртэй сумыг нүүлгэв. Абхиманьюгийн харавсан сум агаараар исгэрэн нисч очиход ээмгэн чимэгтэй Лагшмана толгой хурц хадуураар хяргуулах адилаар тасран унаад өнхөрч байлаа. Тулалдааны талбар дээгүүр айж балмагдсан олны хашгирах дуу хадаж тулалдаанд хүүгээ алдсан Дурйодханагийн цээжинд дүрэлзсэн уур хилэнг юугаар ч хэмжихийн аргагүй болжээ. Дхритараштрагийн хүүхэд, ач нар дараа дараагаар амь алдацгааж байлаа. Лагшманы дараа Дурйодханагийн дүү Кратха ямын (үхлийн ) оронд тонилов. Тэр ч байтугай ялагдахыг үл мэдэгч Карна ч Абхиманьюгийн түрэлтийг дийлэлгүй ухарч байлаа. Ийм болоход Карна , Дронагаас асуусан нь: “ багш минь явал Аржунайн энэ хүүг дийлэх аргыг хэлж өгөөч” гэв. Дрона түүнд хариу өгсөн нь: Абхиманью нас залуу, хүч их, хуяг нь биеийг найдвартай хамгаалж байна. Тэр гартаа хүчирхэг нумаа барьж, их хурдан тэргэн дээрээ давхиж байгаа цагт тэрнийг дийлнэ гэвэл хэцүү дээ” гэжээ. Карна, Дронагийн хэлсэн үгийг эрэгцүүлэн бодоод Криставарман, Крипа гурвуулаа гурван талаас нь Абхиманьюг дайрахаар шийджээ. Карна хатуу нумаа чихээ хүртэл хөвчлөн татаж хурц сумаа тавихад тэр нь Аржунайн хүүгийн аюулт нумыг мэргэн онож салам бутаргажээ. Карна тийнхүү Абхиманьюгийн нумыг харваж байхад Крипа, Криставарман хоёр, Панду овгийн тэр баатар эрийг дайрч түүний морьд, хөтчийг нь харван устгажээ. Тэхэлээр Аржунайн хүүгийн уур ихэд хүрч юулд, бамбай хоёроо аваад явахаа больсон их тэргэн дээрээсээ хол харайж буув. Гэвч түүнийг газар хөл тавьж амжаагүй байх зуур Карна, Дрона хоёрын харавсан сум түүний гар дахь зэвсгийг алдуулахад Абхиманью маш их нүргээнтэйгээр савж ойчсон ажээ. Каурав нар юлд, жад далайж баярлалдан хашгирч гуугалалдсаар дайран харайлгацгаав. Гэвч Аржунын хүү түргэн гэгчийн босон харайгаад эвдэрсэн тэрэгнийхээ газар унасан нэг дугуйг шүүрэн авч толгой дээрээ хоёр гардан өндөр өргөжээ. Шороо тоосонд булагдаж, хувцас хунар нь цус нөж болж, толгой дээрээ асар том дугуй өргөсөн Абхиманьюыг Каурынхан хараад айдас нь хүрч байжээ. Абхиманью ойд шархадсан арслан мэтээр тэр дугуйгаар Дронаг дайрав. Гэтэл Карнагийн хүчит сумнууд Абхиманьюгийн гараас дугуйг нь ч алдуулжээ. Тэгэхлээр нь Аржунын хүү том гэгчийн бялуу шүүрэн авч уур хилэндээ улаанаар эргэлдсэн нүд гарган Духшасаны хүү рүү дайрч ганц цохилтоор түүний морьд, их тэргийг яйран болгоод бялуугаа далайж өөрий нь цохихоор завдав. Эрэлхэг ах дүү хоёрын халз тулаан маг ширүүн, агаад бие биедээ хайр найргүй хүнд цохилт буулгасаар хоёул газар савц ойчжээ. Духшасаны хүү урьтаж босоод

нөгөөдхийгөө өндийн ирэхэд лут мундаг бялуугаараа дэлсэж дахин унагав. Ийнхүү нуурын дотор ургасан лянхуа цэцгийн шилбийг заан гишгэлэн өнгөрдгийн нэг адилаар дайсны цэргийг няц дайрч зоригт баатар эр Абхиманью нас баржээ. Дайны талбар дээр нас бараад хэвтэж буй Абхиманью анчдын шархдуулсан хүчирхэг заан шиг, ус нь ширгэсэн далай, ой шугуйн түймэрдээд унтарсан түймэр шиг харагдана.

## XXII

Бхишма алагдлаа гээд Пандугийнханд амжилт ирэхгүй байлаа. Өдөр болгон хатуу ширүүн цус урсгасан тулаан болж байлаа. Алдар цуутай олон дайчид үхлийн оронд тонилжээ, Юдхиштра ах дүү нар олон баатар нөхдөө харамсалтайгаар алджээ. Гэтэл Дронагийн удирдсан Каурав нарын цэрэг тэдний урдаас сүрлэгээр тулалдан авай. Байлдааны арван тав дахь өдөр саш ширүүн тулалдаанаар эхэлжээ. Дайсагнагч хоёр их цэрэг бие биеийг омогтой дайран ороход газрыг тоос манангийн өтгөн үүл бүрхэж, тэнгэрийг хүрэн улаан бүрхүүл халхалжээ. Морьтой ба явган цэрэг, заан ба их тэргүүд бүгдээрээ тэр үүл манан мэт тоос шороон дунд хутгалдаж, хэн ч дайсан, нөхрөө ялгаж чадахгүй болжээ. Тэр өглөө давагдашгүй Дрона догшин сүртэй тулалдаж юлд сумаараа хайр найргүй сүйдэлжээ. Түүний цохилтын дор Юдхиштрирын олон мянган дайчин эр үхлийн оронд тонилоход үхэгдсийн дотор Друпата хааны эрэлхэг ач нар, Друпата өөрөө, бас Матс нарын хаан Вирата оржээ. Шадар хүмүүс алагдсаныг мэдээд Юдхиштадьюмнагийн элэг эмтэрч, Друпатын энэ хүү тэр өдөр Каурынхны удирдагч Дронагийн аминд заавал хүрнэ гэж Панчал нартаа тангараглажээ. Панчал нар Дронаг ханаран дайрахад Аржуна тэдний довтолгооныг сумаараа дэмжиж байлаа. Гэтэл Дурйодхана, Шакунай, Карна нар удирдагчдаа туслаар ирж, тэдний харавсан сумууд нь Панчал нарын замыг хааж Юдхиштадьюмнагийн цэргийг Дронад ойтуулахгүй байв. Айхыг үл мэдэгч Бхимасенагийн уур шатаж: “Юдхиштадьюмна чи чинь дайчин эр үү, эм хүн үү? Эсвэл чи эцгийнхээ өшөөг авна гэж тангараглаагүй юм уу? Тэгвэл чи зогсоод харж бай, би чиний тавьсан тангаргийг чинь биелүүлээд өгье” гэж Друпата хаан агсны хүүд харгиран хэлжээ. Тэгээд, улайран шийдсэн Бхимасена, Дхритараштрагийн хүүхдүүдээр хүрээлүүлэн зогсож байгаа уран чадварт хүчирхэг Дронагийн зогсож буй газар өөд их цэргээ залав. Бхимасены хэлсэн үгэнд Дхриштадьюмна болон түүний дайчид Панчал нар ичингүйрч Дронагийн амь сахигчдыг хэирэмгий их хорсголонтойгоор дайрчээ. Тулалдааны талбар дээгүүр цусан мөрөн үхлийн хязгааргүй далай болон урсч байдлаа. Дронагийн шидсэн жад, харавсан сум

алдалгүй намнан байна. Түүний далайж булгах юлдийн дор амь үрэгдэн унах цэрэг, агт морьд, заанууд тоо алджээ. Түүнтэй халзагнаж тулахаар гарсан хүн бүр төдхөн үхлийн оронд тонилж байжээ. Пандугийнхан тэсч тэвчиж чадахгүй болон, сүнс нь зайлтлаа явцгаав. “Энэ ялгуусан Дрона тулалдаанд Индра бурхнаас ч тутахгүй” гэж Юдхиштхирагийн цэргүүд бие биендээ ярих болж, яваандаа дайчин урам зориг нь хугарч байв. Тэр үед Кришна, Аржунад хэлсэн нь: “Дронатай тулалдаад хэн ч түүнийг давахгүй, үхэх тавилантай ганц ч дайчин эр, тэр ч байтугай Индра бурхнаар өөрөөр нь тэргүүлсэн бухад ч түүнийг дийлэхгүй, харин тэр зэр зэвсгээ газар хаяад байлдахаа болих юум бол түүнийг эгэл жирийн ямар ч цэрэг алчихаж чадна. Пандугийн хүүхэд та нар түүнийг дийлье гэвэл ов мэх хэрэглэх хэрэгтэй. Дайтах шударга ёсон дагуу яваад та нарт тус болохгүй. Хэрэв Дронагийн эрэлхэг хүчирхэг хүү Ашваттахаман үхэх юм бол эцэг нь тулалдахдаа болих юм байгаа юм. Дронат рүү хүн явуулаад Ашваттахаман чинь үхлээ гэж хэлүүл” гэжээ. Кришнагийн үгэнд орж цэрэг дайны эртнээс уламжилж ирсэн ёсыг зөрчих гэдэг Пандугийн хөвгүүд их хэцүү санагдана. Тэгэхлээр нь Кришна тэдэнд дахин хэлсэн нь: Юдхиштхира чи өөрийнхөө цэргийн сенеж байгааг хар л даа. Оройхон болохоор бүр сөнөөд дуусна гэж мэд: Өөрийн овгоо, цэргээ аврахын төлөө ов мэх ч өлзий болно шүү” гэв. Хөөрч байгаа цэргээ үзэж аргагүй ов мэх хэрэглэхээр шийджээ. Тэгэхлээр нь Бхимасена, Ашваттахаман гэдэг аварга том зааныг балтаар алаад Ашваттахаман чинь нарт ертөнцөөс халив гэж их Дронад хэлүүлэхээр нэг цэргээ илгээжээ. Гэвч мэргэн ухаант Дрона буухиа элчийн үгэнд үл итгэв. Яагаад гэвэл Ашваттахаман бол цэрэг байлдааны чадвар ухаанаараа эцэгтэйгээ мөр зэрэгцэх сүрлэг дайчин эр байжээ. Пандугийнхан анхандаа тийнхүү мэхэлж чадсангүй. Өвгөн Дрона улам ч аймшигт догшин байлдав. Дайсны хоёр түмэн их цэрэг түүнийг бүслэн очиход минь эр, их тэрэгтэй тэр хоёр түмэн цэргийг бүгдийг нь үхлийн оронд тонилголоо. Цусанд бялдагдсан тулалдааны талбар дээр Дрона биш харин барьсан үхэл өөрөө гялалзаж их тэргэн дээр дүүлж яваа мэт санагдах ажээ. Гэсэн ч эргэлзэх сэтгэл Дронагийн дотроос гарч өгөхгүй сэтгэл зүрхийг нь химэлсээр л байжээ. Тэгээд Юдхиштхирагаас үнэнийг лавлан мэдье гэж санаа шийджээ. Юдхиштхирагийн амнаас насан туршид ганц ч худал үг гарч үзээгүй тул Дрона түүнээс үнэн үг дуулна гэж бат итгэжээ. Дрона Пандугийн ууган хүүгээс: “Шударга хаан чи Ашваттахаманы амьд үхсэнийг хэлж аль” гэжээ. Юдхиштхира, их л уй гашуутайгаар Кришна руу, дүү нар руугаа айж сандран зугтаж яваа цэргүүд рүүгээ нэг харснаа худал хэргийг өөрийн үгээр үнэн гэж нотлов. Агуу их Дронагийн сэтгэл зүрхийг



харуусал дарж зүрхнийх нь уганд цөхрөл шигдсэн учир түрүүчийнхээ адил овжин зоримог үзэлцэж чадахаа больжээ. Друпанын хүү түүнийг улайран дайрлаа. Гэтэл Дрона түүний цохилтын түрүүчийнх шигээ няцааж чадахаа нэгэнт больжээ. Дхриштадьюмнагийн нумыг яйран болгож морьд ба хөтчийг хядахад Друпата хааны хүү Дронагийн мэргэн харвах сумнаас цэрэгнийхээ араар орж нуугдаас өөр аргагүй болжээ. Пандугийнхаа Дронаг хүүг нь үхсэн гэж дахин сануулав. Дронагийн зүрх дахин түгшиж эрэлхэг түүний гараас зэвсэг нь алдран унажээ. Дрона их тэргэн дээрээ захлан суугаад уйтаагаар дуу алдахдаа: “ Хүүе Карна! Хүүе Карна, та хаана байнаа? Миний хайрт хүү минь нас баржээ. Би ч өнөөдөр амь гарахаасаа өнгөрлөө!” гэв. Дхриштадьюман , Дрона руу дайран очиж юлдээ толгой дээр нь далайхад Дрона хөдөлсөн ч үгүй. Друпата хааны хүүгийн мөнгөн сэлэм гялсхийхэд Дронагийн буурал толгой мөрөн дээрээсээ бөмбөрөн унажээ. Сайхь цуут дайчин эр нарт түүнийг тэгж муу санаагаар хуурч мэхлээгүй бол бас төдийчинээ наслахсан. Дронагийн толгой тоост талаар өнхрөхөд Дхритараштра хааны цэргүүд зугтаж эхлэв. Тэднийг хэн ч тогтоож чадахгүй байлаа. Их дайчин эр Карна ч цэргүүдийнхээ хамт тулалдааны талбараас зугтжээ. Куругийн ээрэм талын нөгөө захад зогсож байсан Ашваттахаман өөрийн анд нөхөд, холбоотон нарыгш ухаан зулаггүй айн бачимдаж зугтааж явааг үзээд зүрхэнд нь түгшүүр төрөв. Сайхь эр зугтаж яваа олны дундуур чуу чамай онэвтрэн гарч, Дурйодханагийн дэргэд хүрч очоод асуув. “ Их хаантан минь цэрэгт чинь яагаад аймхай цөөврүүд шиг туладааны талбарыг орхин ум хумгүй зугтана вэ? Нэр алдар нь дуурссан дайчин эр Карна ч хамт зугтаж байх чинь! Эзэнтэн минь манай цэрэгт юу учраа вэ?” Дурйодхана гашуун нулимс асгаруулан мэлмэрээд хариу үг хэлж чадахгүй байлаа. Крипа л Дрона хэрхэн мэхлэгдсэн, Друпатагийн хүү түүнийг хичнээн занаж зүхсэнийг Ашваттахаманд ярьж өгөв. Ашваттахаман түр эмгэнэн дуугүй байснаа ингэж хэлэв: “ Бурхантай мөр зэрэгцэх дайчин эр, зуэг минь алдар нэрээ дуурсгасаар бие баржээ. Одоо тэр бурхдын дотор байраа эзлэх болжээ. Би эцгийнхээ өшөөг авахгүй өнгөрөөхгүй. Пандугийнхан, панчалынхан миний эцгийн амийг амиараа төлөх болно, гэв.

### XXIII

Дрона үхсэн тухай мэдээ Дхритараштрагийн хүүхдүүдийн зүрхэнд зүү шивэх шиг болгожээ. Нүүр нь зэвхий даан цонхийж, уй гашууд дарагдан толгой унжуулж бие биенийхээ нүүрийг харж чадахгүй байлаа. Цусанд бялдсан юлд, жаднууд нь тэдний хүч алдарсан гараас тэнгэрт харван унаж буй од мэт гялсхийн унаж байна.

Каурынхан эгнээ зарсхийн цочиж, цэргүүд нь энд тэндгүй балмагдан ухарч байна. Тулалдааны талбар дээр Дурйодхана ганцаар үлдсэн байлаа. Сайхь эр Пандугийнхны довтогооныг чуутай чаатай хориглон барьж, ухран буй хүмүүсээ зогсоох гэж чанга чанга хашгирсаар авай. Гэвч удирдагчийнхаа дуудлаганд орж буцаж ирсэн хүн цөөхөн ажээ. Дурйодхана тэднээр биеэ тойруулан дайсны цэргийн давшилтыг няцаасаар харанхуй шөнө болголоо. Их тулалдаан ч завсарлалаа. Дурйодхана, Карна, цэргийн бусад жанжин дарга нар тэр шөнийг майхандаа нойргүй өнгөрөөжээ. Үүр цайхын өмнө Дурйодхана бүх хаад, жанжин нараа дуудан цуглуулж “ Ухаан мэргэн, зориг ихт эрчүүд минь! Ирээдүйн тухай юу бодож байгаагаа хүн бүр хэл. Хаад минь өнгөрөгч өдөр болсон явдлын дараа одоо бид яавал таарах вэ? Хэлцгээ” гэхэд зөвлөгөөнд оролцсон баатар эрчүүл бүгдээрээ л тулалдааныг үргэлжлүүлэх зориг шийдэмгий байгааг илэрхийлжээ. Дронагийн хүү Ашваттахаман “ Тулалдаанд найдвар туршлагатай , бурхантай мөр зэрэгцэх хүүчирхэг шадар хүмүүс маань үхжээ. Гэвч бид ялна гэдэгтээ итгэл алдаж болохгүй. Хунтайж минь бидэнд хувь заяа нааштай байх болно. Баатруудын дотроос хамгийн гарамгай Карна манай цэргийг удирдаг. Цэрэг дайны уран чадвар ухаанаараа Карнаг давах хүн ер үгүй. Энэ хүн тулалдаанд үхлийн бурхан , яма шиг үл дийлдэнэ. Түүнтэй хамт явж бид дайснаа дарна” гэлээ. Энэ үгийг дуулаад Дхритараштрагийнхан зориг оржээ.” Оарна минь тулалдаанд Бхишма Дрона хоёр амь үрэгдсэн. Тэр хоёр хоёул үлэмжийн их дайчид байсан авч нас сүүдэртээ дарагдаж агсан хүмүүс билээ. Харин хөтчийн хүү чи бол тэр хоёроос хүч тэнхээ давуу болой! Чи ганцаараа биднийг ялалтад хүргэж чадна. Чи бидэнд ямагт үнэнч нөхөр болж явсан. Одоо Тэнгэрийн дайн байлдааны жолоодогч Скандаа бурхны адил Дхритараштрагийн хөвгүүдийн цэргийн манлайд мандан гарах нарны туяанд шөнийн харанхуй замхарч, Вишну бурхны нүүрийг үзээд хорлонт чөтгөрүүд ул мөргүй алга болдог шиг манай дайснууд чиний дүрийн өмнө замхран устана!” гэжээ. Карна хариу болгож: “Эзэнтэн минь , санаа бүү зов. Би Пандугийн үр сад үнэнч нөхөр Кришнатай нь хамт хүйс тэмтрээд өгнө гэдгээ чамд дахин өчье. Би цэргийг чинь манлайъя. Дайсан маант зайлбаргүй сөнөнө” гэжээ. Дурйодхана бүх хаад, цэргийн жанжин нар суудлаасаа босч Карнад хүдэтгэлээ илэрхийлээд түүнийг бүх цэргийнхээ жанжин болгож тунхаглав. Зохих ёслолыг үйлдэж бярман нар ч зохиж номыг нь уншжээ. Карна торгон эдлэлээр хулдсан амра модон суудал дээр заларч, лам нар ба дуучид түүнийг тойрон дуу дуулахдаа: “Мандах нар , харанхуйг замхраан арилгадаг шиг, Пандугийнхныг холбоотон сүлбээтэнтэй нь сөнөөх болтугай!” гэлцэж байна. карна

шинэ өдрийн үүрээр цэргүүдийг тулалдаанд бэлтгэж жагс гэж зарлиг хүргэн дуугаравч Каурынхны хууранд их шуугиан болов . Жагсаад жагсаад гэлцэн гэнэт чанга чанга хашгиралдав. Тулалдаанд бэлэн болсон их тэрэгнүүдийн нүжигнээн, заануудын нүсэр алхаа, морьдын төвөргөөн, явган хүмүүсийн хөлийн чимээ, зэр зэвсэг хуяг дуулганы харшиж хангиналдах чимээ тэнгэрт тулж байлаа. Нар мэт гялтагнах их тэргэн дээр суусан Карна цэргүүдийн өмнө хүрч иржээ. Түүний гарт алтадмал нум, туг дээр нь байлдааны дүрс харагдана. Хүчирхэг Карнагийн барааг харсан цэргүүдийн сэтгэл баярлан горьдлого төрж зүрх нь догдолж, Бхишма, Дрона болон бусад дайчин баатруудаа алдсанаа маартав. Карна дайны дунгаа үлээж дайтахад бэлдэх дохио өгөөд, цэргээ далайн гахай хэлбэрээр жагсаан тулалдаанд дагуулан оров. Каурынхны байлдааны туг хиур дайны талбар дээр гарч ирэхэд Юдхишхира Аржунад хандаж хэлэхдээ: “Партха минь, цэрэг тулалдаанд ямар шүү жагсаасныг нь хараач! Тэдний цэрэг асар олон байна. Гэвч хамгийн зоригт баатруудгүй болсон болохоор үлдсэн нэг нь бидний өөдөөс хүч мөхөсдөж өвсний шилбэ шиг сүйрнэ. Гагцхүү тэдний дунд бурхан, чөтгөрийн алинд ч дийлдэггүй хүчирхэг дайчин эр, хөтчийн хүү гялалзаж явна даа хэрэв чи түүнийг өнөөдөр алах чи түүнийг алчихвал миний зүрхийг арван хоёр жил тарчлаасан өргөсийг аваад хаях нь тэр! Аржуна минь, цэргээ өөрийнхөө л дураар жагсаа!” гэжээ. Аржунаа энэ үгийг сонсоод өөрийн цэргийг тал сар хэлбэртэйгээр жагсаажээ. Зүүн захад нь Бхимасена, баруун захад нь эрэлхэг зоригт Дхриштадьюмнм зогсчээ. Аржуна өөрөө Юдхиштхирагийн хамтаар жагсаалын тэг дунд байрлажээ. Накула, Сахадева хоёр ар талыг хамгаалах ажээ. Панчалын эрх баригчид болон бусад хаад нь зааж өгсөн байр байрандаа очиж байлдахад бэлтгэжээ. Хоёр талаас дайны дун үлээж, бөмбөр яруу хэнгэрэг дэлдэв. Тулалдаанд орохоор уулгалан байгаа дайчдын хашгиралдах чимээ арслангийн архиралт мэт хүнгэнэж , агт морьдны янцгаах , заануудын хүнгэнэтэл мөөрөх, их тэрэгнүүдийн нижигнэх дуу чимээтэй холилдоно. Хоёр талын цэрэг бүжиг хийх гэж баярлалдах мэтээр бие биедээ дөхөн ирж, хоёр итгээдийн талаас бие бие лүүгээ халз тулахыг тэсч ядан хүлээх баатрууд ялгаран гарч ирлээ. Цэргүүд, талбайн дунд тулгаран тийнхүү тулалдаан эхэлжээ. Хүмүүс, заан, их тэргүүд хатуу ширүүн тулалдаанд мөргөлджээ. Тас хяргуулсан толгойнууд газраар өнхөрнө, цэргүүд бие биеийг сүх, балт жад, сумаар аймшигтай цохино. Дайсанд хөнөөгдсөн баатрууд заан их тэрэг, морин дээрээс тэрий хадан ойчиж байна. их тэргүүд явган хүмүүсийг няц дайрч, заанууд нь их тэргүүдийг дайран онхолдуулж байхад явган цэргүүд морьтонгуудыг мориноос нь унагаж, морин цэрэг нь явганаа сэлэмдэн

хяргаж байлаа. Байлдааны тэргүүд нэг нэгнийгээ мөргөн дайрч байхад улангассан заан, заантайгаа ноцолдож, шийдэм бялуу, хурц юлдэнд хүндээр цохиулан сүйдэж буй явган морьтон цэргүүд тулалдсаар сөнөж байлаа. Тэр өдөр Куругийн ээрэм талд үлэмжийн их цус урсчээ. Мундаг том заан унасан Бхимасена дайсны дотор дайран орохдоо замдаа тааралдсан бүхнийг хиар цохиж байна. Кулут нарын эзэн хаан хүчирхэг Кшемадхурти түүнийг хараад мөн заан унаж угтан тэмүүлэв. Тэр хоёр заан хоёр уул мөргөлдөх адил тулж очсоноо салахад унасан этгээдүүд нь эргүүлж тойруулан залсаар бие бие рүүгээ жад шидэж, нум харваж байна. Кшемадхуртигийн шидсэн жад Бхимасенагийн цээжинд шавжээ. Өвдсөн уурласан хоёртоо мань баатар хашгираад дайса руугаа хүнд гэгчийн шидсэн боловч Кулутын хаан Бхимасенагийн жадыг харваж яйран болгов. Тэгэхлээр Пандугийн сайхь хүү дайсны зүг хөдлөв. Тийнхүү тийнхүү тулалдааны талбар дээр хоёр заан хөөцөлдөх нь шуурганд хөөгдөх аянгын хар үүл мэт ажээ. Гэтэл эрэлхэг Кшемадхурти заанаа тогтоон эргэж хараад мэргэн харвалтаар Бхимасенагийн гар дахь нумыг салам болгов. Тэгээд дайныхаа зааныг жадаар хөнөөхөд Бхимасенагийн заан эзнийхээ хамт хөсөр унаж байна. гэтэл баатар эр заанаа бүр унахаас нь өмнө харайн буугаад босч амжив. Бхимасена шийдмийнхээ аюулт цохилтоор Кшемадхуртигийн зааныг унагав. Д Тийнхүү тийнхүү тулалдааны талбар дээр хоёр заан хөөцөлдөх нь шуурганд хөөгдөх аянгын хар үүл мэт ажээ. Кулут нар удирдагчаа алуулмагц зугтааж эхлэв. Талбарын нөгөө үзүүрт Анувинда, Винда төрсөн ах дүү хоёр эрэлхэг зоригт Сатъякигийн хоёр талаас дайран довтолж байна. тэр ах дүү хоёр бол кайкей нарын эзэд бөгөөд Сатъякигийн зүг олон зуун сум тавьжээ. Гэвч Сатъяки дайралтыг няцаан тэсвэртэй тулалдсаар амой. Дайсны сум түүний нумыг харван алдуулахад Сатъяки өргөн хурц үзүүртэй жад шүүрэн авч мэргэн шидээд Виндагийн дүү Анувиндагийн толгойг аваад хаячихжээ. Ах Винда нь Сатъякийг улам ч галзуу мэтээр дайрав. Түүний харван нүүлгэх суманд тэнгэр харанхуйлж байлаа. Гэтэл Виндагийн суманд эрүүл газаргүй болтлоо шархадсан Сатъяки хариуд нь гагцхүү инээж байжээ. Сатъяки, Виндагийн хөтөч ба морьдыг алахад Винда ч бас Сатъякийн хөтөч ба морьдыг алав. Тэгээд зоригт хоёр эр их тэрэгнүүдээсээ буун ирж юлд, бамбай тар няр хийлгэн үзэлцэхдээ нэг нь нөгөөгөө өрсөж сөнөөхийг хүсэлхийлнэ. Сатъяки, Виндагийн бамбайг юлдээрээ тас чавчихад, Винда Сатъякигийн бамбайг тас чавчлаа. Кайкейн эзэн хаан, дайсныха хажуу бөөрнөөс гэнэт дайрах санаа өвөрлөн түүнийг тойрон отож байлаа. Гэтэл Сатъяки түүнээс урятаж луг том юлдээ далайж Виндагийн биеийг ташуухан

чавчилтаар хоёр хуваав. Кайкей нар ч удирдагчдаа алагдсан дараа ум хумгүй зугтаж эхэлжээ.

#### XXIV

Бусад газрууд ч гэсэн Пандугийнхан, тэдний шадар нөхөд нь бүр тулалдаан эхлэхээс аваад Каурынхныг дийлэн түрсээр байжээ. Бхимасена их тэргэн дээр давхиж, ухаран байгаа дайснуудыг элдэн хөөж байтал өөдөөс нь талийгаач Дронагийн хүү Ашваттахаман тулдаг байна. сайхь хоёр баатрын тулалдахыг харахад аймаар догшин ажээ. Индра бурхан л тэнгэртээ Вритра чөтгөртэй тулалдаж буй мэт санагдах ажээ. Нумаар харвахдаа онц мэргэн Ашваттахаман, Бхимасенаг зуун зуун сумаар харваж баатрын цээж, мөр, толгойг шархдуулав. Гэсэн ч сайхь баатар ер ажрахгүй, шуурах салхин болж байхад давгүй л байдаг уулын оргил мэт байлаа. Бхимасена ч хариуд нь олон зуун сум нүүлгэн буулгахад цаадахь нь бас л амжрахгүй байх нь намрын их үерт хөдлөшгүй хэвээр байдаг хадан хясаа мэт ажээ. Дайсан этгээдүүдийн их тэргүүд нэг тулж, нэг салах боловч тулалдаан нь нүд ирмэхийн төдийд ч үл зогсоно. Харвасан сум, шидсэн жад, зээрэнцэг, янз бүрийн шидэж чулуудах сумууд агаарыг зүсч нүүгэлтэн гялалзаж, тулалдагч хоёрыг халхалж байна. Харвасан сумууд, шидсэн жадууд нисүүт мөргөлдөн тал тал тийш оч бутрахад ертөнцийн төгсгөл болж буй санагджээ. Орчлонгийн одон гаригууд хоорондоо мөргөлдөөд хорвоогийн түймэрт сөнөж байгаа мэт санагдана. Урьд хожид үзэгдээгүй энэ халз тулалдааныг харах гэж бурхад өөрснөө Сиддхи, Чаран нарынхаа хамт тэнгэрээс бууж иржээ. Бхимасенагийн зориг хүч чадал, Ашваттахаманы цэрэг дайны чадварыг үзээд бурхад алгаа ташицгаан: “Дронагийн хүчирхэг хүү чамайг магтъя! Бхима чамайг магтъя! хэмээн дуу алджээ. “үүнтэй эн зэрэгцэх тулалдаан дэлхий дээр хэзээ ч байгаагүй” гэж сиддхи нар хоорондоо ярьж байлаа.

Бхимасена, Ашваттахаман хоёулангийн туг их тэрэгнүүд дээрээс унажээ. Суманд сийчүүлсэн морьд нь үхэж хөтөч нар нь өнгөрчээ. Гэтэл хоёр баатар хэлбэрэлтгүй зогсон сулрашгүй улаймшигтайгаар үзэлцээр бөгөөд хэн нь ч хэнийгээ дийлж чадахгүй байна. Бхимасена өөрийн сумнуудын дотроос хамгийн урт, хамгийн хүндийг шилж аваад хөвчлөн татаж Ашваттахаман руу харвав. Цаадах нь ч бас Бхимасенагийн яг тийм сумаар яг тэр үед нь харвав. Хоёр баатар нэг нэгнийхээ аймшигт суманд зэрэг оногдон их тэрэгнүүд дээрээсээ газар үхэдхийн унажээ. Ашваттахаманы цэргүүд Дронагийн хүүг ухаан алдан унахыг үзмэгцээ түүнийг тулалдааны дундаас гарган авч аюулгүй газар аваачжээ. Пандугийнхны цэргүүд

Бхимасенаг бас тэгжээ. Аржуна , Кришнагийн жолоодсон их тэргэн дээр морилон самшаптак нарын тоогүй олон цэргийг далайн усанд дэгдсэн шуурга мэтээр дайрчээ. Тэрбээр дайсны зүг үүл мэт хүүгэлдсэн үй олон сум нүүлгэж үй түмэн хүнийг сөнөөжээ. Өргөн бөгөөд хурц үзүүртэй сумнууд цэргүүдийн толгойг тас хяргаж гарыг таслан морьтой, явган цэргүүдийг хядаж байлаа. Битүү модон төглийн дотор түлээ огтлогч өөртөө зам гарган явахын адил Аржуна дайсны цэргийн дундуур эрлэг болсон зэвсгийнхээ хүчээр замаа гаргаж явна. Самшаптакууд түүний эсрэг үзэлцэх гэсэн нь талаар өнгөрчээ. Тэд дайчин маягийн дуу хоолойтойгоор түүнийг бөөнөөрөө дайрч жад шидэн, нум харваж байсан боловч Аржуна их тэргээ хаашаа ч зүглүүлсэн дайсны дайралтыг няцаан өөрсдийг нь устгаж байлаа. Аржуна дайсны цэргийг сарниах нь өтгөн үүлийг салхи хөөн нүүлгэх лүгээ адил бөлгөө. Тас чавчигдаж огтлогдсон толгой гарууд газраар нэг болон овоорч, их тэргүүдийг хэсэг бусад болтол нь хэмх цохиж , үхсэн заанууд тэнгэрт ниргүүлсэн уулын орой шиг ундуй сундуй үзэгдэнэ. Хязгааргүй уудам усан санг төөнөм халуун нарны илч хатаан ширгээхийн адил Аржуна самшаптакд уудын цадиггүй олон цэргийг тийнхүү устгажээ. Энэ хооронд Ашваттхаман, Бхиманесад цохиулан унаснаасаа сэгээд дахин тулалдааны талбар дээр гарч иржээ. Сайхь баатар эр шинэ их тэргэн дээр заларч Аржунад дөхөж очоод аянгын дуу мэт том хоолойгоор: “ Баатар эр чи, хэрэв чиний нүдэнд би ийм хувьтай болж байгаа бол намайг чи энэ дайныхаа найр хуриман дээр хүндэт зочин болгож ав!” гэж хашгирав. Баяр ёслолын найр хуриман дээр гэрийн эзэн хүн сурвалжит гийчнийг угтаж авахын тулд язгуур угсаагүй зочдыг орхин явдаг шиг Аржуна, Самшаптак нарыг хүйс тэмтрэхээ болиод их тэргээ Дронагийн хүүгийн зүг залав. Ашваттхаманы харвасан сум нь Аржуна, Кришна хоёр луу үерийн бороо бууж эхлэв. Гэвч Пандугийн хүү бүх довтолгооныг няцаагаад өөрөө нумаа онилон харваж Ашваттхаманы гар дахь нумыг салам болгов. Энэ үер Калинг ба Ванг-гийн баатар эрчүүл аварга том заануудаар гүйлгэн Дронагийн хүүд туслаар амжин ирж Пандугийн удмын баатар эрийг шуурхайлан дайрав. Гэсэн ч Аржуна тэдний өмнөөс үүл мэт харанхуйлах үхлийн үй түмэн сум буулгаж тэдгээр баатар дайчдыг хиар цохин дайны талбараар нэгхүүр болгов. Тэр хооронд Ашваттхаман , түрүүчийнхээсээ бүр ч даамай урт,хүнд нум шүүрэн авч асар том арван сумыг Аржуна болон түүний тэрэгчин рүү онилон харважээ. Кришнагийн цус олгойдож өөрөө гуйвж байхад Аржуна хэд хэд шархдаад түр хөдөлгөөнгүй болоход Каурынхан тэр хоёр баатрын бодийг Ашваттхаман нэгэнт хөтлөв.гэж бодоод оодорч эхэлжээ. Гэвч Аржуна төдхөн сэхээ авч дайсны зүг

үерийн бороо шигсум дахин нүүлгэв. Ашваттхаман үхлийн тэр цохилтуудыг няцааж Пандугийнхны дайралтад тэсэн зогсож байсан боловч морьд нь олон суманд оногдоод их тэргийг тулалдааны газраас зайлан давхижээ. Хүч хүрээгүйгээс Ашваттахаман, Аржунатай халз тулаар дахиж эргэсэнгүй. Дунд бие Каурынхны цэрэг ухарч байхад тулалдааны хойт биед Пандугийнхан дийлдэж байжээ. Тэнд магадха нарын хаан Дандадхара, дайсны цэргийг сүйдлэн явган морьтой цэрэг, их тэргүүдийг олон зуугаар нь устган элдэж байжээ. Харахаас аймаар асар том заан дээр заларсан сайхь хаан дайсныг харван сөнөөж байхад заан нь их тэрэг, морьд хүмүүсийг дайран газарт шигдтэл няц дэвсэж, дайсны заануудыг дайран унагаж соёогоороо хүү татан алж байв. Дандадхарын зааны хөлийн дор их тэрэг, гархин хуягууд тар няр, эвдрэн хэмхэрч, түүний сүрлэг дайралтын ул мөрөөр цусан нэлий урсч байжээ. “Аржуна хараач ! гэж Кришна дуу алдаад Магадханы хаан тэрний номхоршгүй заан хоёртой сөөргөлцөх хүн ер алга! Чи тэр Дандадхараг ал, тэгэхгүй бол манай цэрэг их хохирол амсах нээ” гэв. Аржуна үүнийг сонсоод өөрийх их тэргийг ид тулалдаан болж буй хойт зүг нэн даруй залжээ. Тэнд их тэргүүд агт морьд заанууд холион бантан болтлоо хутгалдаад тулалдааны үймээн шуугиан улам нэмэгдэж байлдааны дун хэнгэрэг янчирын дуун нь зааны бахирах, морьдын янцгаах, цэргүүдийн хашгиралдах дуунд дарагдаж байлаа. Дандадхара, Пандугийн хүү рүү багц сум тавьж, үүнээс ч олон сумыг Кришна болон морьд руу нь харважээ. Гэвч Аржуна мэргэн харвалтаар түүний гараас нь нумыг алдуулж, тугийг нь унаган Дандадхараг хүрээлэн буй цэргүүдийг нь устгаж байлаа. Магадха нарын хаан улайран хашгирч, Аржуна онилон шагайгаад гурван сум дараалан тавихад Дандадхарын хоёр гар толгой гурав тасран унажээ. Тэгмэгцээ Аржуна дайсны зааны зүг олон зуун сум харвав. Аварга том заан орилон бархирч гуйвсаар амь тавин уналаа. Гэтэл лут гэгчийн том заан унасан магадха нарын хааны дүү Данда Аржунаг давшлан дайрав. Аржуна хурц сумаа мэргэн тавьж түүний толгойг ч хярган өнхрүүлэхэд Данда газар унаж цусаараа бялдахад жаргаж буй наранд үдшийн тэнгэрийн хаяа улайрах мэт харагдлаа. Аржуна цасан цагаан үүл шиг сайхан зааны нь бас бус олон зааны хамт харван алав. Тэгээд саяхан Пандугийнхныг алан давшиж байсан магадхагийн цэргүүд одоо ухаран зугтааж эхэлжээ. Өөр маш олон хүчирхэг зоригт баатар дайчид Кругийн ээрэм талд болсон энэ өдрийн тулалдаанд аржунагийн гарт амиа алджээ. Магадха нарын хүчийг Аржуна тийнхүү бут цохиж байсан яг тэр үеэр Курукшетрийн нөгөө нэг захад Каурынханы хүчийг малайн уулын нэг эзэн Пандья баатар гэгч хиар цохиж байжээ. Энэ хүн бол өөрийгөө дайны

талбар дээр Аржуна, Карна хоёртой мөр зэрэгцэх баатар эр гэж үзэж байжээ. Өөрийн хурдан их тэргээр мань баатар дайсны эгнээ рүү шуурга мэт нэвтрэн оржээ. Түүний хүчтэй түрэлтийг дийлэхгүй болсон нулинд, кхас, нишад олон Каурынхны бусад холбоотнууд ухарч эхэлжээ. Хэн ч түүнтэй мөчөөрхөж чадахгүй байлаа. Пандья морьтой, явган, их тэрэгтэй, заантай цэрэг эрсийг бут ниргэж замаа үхэгсдийн хүүрээр дүүргэж байв. Дайсныхаа цэргийг хайр найргүй устган сөнөөсөөр урагшаа улам улам давшин давхиж байгаа омог баатар Пандьягийн замд Дронагийн зоригт хүү гарч ирэхэд байдал өөр болсон юм. Ашваттахаман: “Сайн язгуурт хаан чи, тулалдаанд Индра бурхантай төстэй байна!” гэж дуу алдаад: “хүчирхэг арслан ой тайгын доторх буга согоог сүрэг сүргээр нь устгаж байгаа аятай чи морьт, явган цэргүүдийг хүйс тэмтэрч байна! Чиний их тэрэгний доор газар хүнгэнэж байна. Чи аянгат борооны хар үүл намрын тариаг устгах адил сүйдэлж байна! Энд чи л надтай үзэлцэж чадах дайсан байна, чамтай тулалдъя!” гэхэд “Тэгвэл тэгсүгэй!” гэж Пандья хариу өчив. Тэгээд Дронагийн хүү түүнд: “Цохиод” гэж хэлмэгцээ түүнийг галзуу мэтээр дайрч эхлэв. Ашваттахаман, есөн удаа хурц сум тавьсан боловч уулынхны удирдагч бүгдийг нь няцаагаад Ашваттахаман, Пандья рүү үерийн бороо шиг сум нүүлгэж эхлэв. Нум сум харвахдаа хамгийн чадамгай Ашваттахаман, өдрийн наймны нэгтэй тэнцэх хугацаанд найм найман шар хөллөдөг найман тийм тэргээр ачих тийм олон тооны сумаар дайсныг харважээ. Пандьягийн морьд Ашваттахаманы харвасан суманд нэвт харвуулан үхэж, дээрээ Малай улсын дүрсэн чимэгтэй туг нь их тэргэн дээрээс унаж, дайсны суманд хэлмэгдсэн их тэрэг нь олон жижиг хэсэг болон хэмхэрчээ. Гэсэн ч Дронагийн хүү тэр ханыг их тэргэн дээрээс нь унагамагц эд бад хийлгүй тулалдаанаа сунгахаар зорьжээ. Энэ үед тэндээс холгүй газар өнөөх ялгуусан Карна, Панду нарын заант цэргийг ухраан сүйдэлж байлаа. Ашваттахаман нэг лут том заан сул давхиж байхыг хараад мэргэн харвалтаараа түүнийг Пандьягийн зүг түүнийг калав. Авхаалжит Пандья, тэр хар хурдаараа гүйж явсан зааны нуруун дээр хадан хясааны нуруун орой руу дүүлэн гарч буй арслан мэт үсрэн мордож нүд эрмэхийн зуургүй анхныхаа цохилтоор хазаарлаж аваад дайсныхаа зүг эргэв. “Одоо чиний үхэл чинь ирсэн!” гэж сайхь хаан шатсан уур хилэндээ амьсгаа дээр гарсан байдалтай хашгирав. Гэвч тэр хаан, дайн байлдаанд сахиж байх боломжоо алдалгүй байж хүнд гэгчийн жад шидээд Ашваттахаманы толгой дээрх үнэ цэнэ ихт титмийг түмэн хэлтэрхий болтол нь салат болгон унагажээ. Ингэмэгц Ашваттахаманы ч уур хилэн бадарч дүрэмгүй хүний хөлд гишгүүлсэн сүрлэг могой шиг авирлав. Ашваттахаман тонгорог шиг хурц үзүүртэй хөнөөлт таван сумаараа



дайсны зааныг унагаж, гурван сумаараа Пандьягийн хоёр гар толгой тас харваад зургаан сумаараа түүний хүчирхэг зоригт зургаан шадар баатар эрийг сөнөөжээ. Уулынхны хааны толгой газар өнхрөн ойчихдоо алтан бугуйвч чимэгтэй хоёр гарынхаа хоорондуур харагдах уур хилэнт мэлмий нь яг хоёр одны хоорондуур харагдах сар шиг гялалзаж байлаа. Цэрэг, агт морь, зааныг олон зуугаар яв тас сэглэж, Рагшас нарт элбэг дэлбэг зоог бэлдэж өгсөн Пандья, Дронагийн хүүгийн суманд одоо л нэг номхрочоо болов. Талийгаачийн шарилыг үнсэн чандруу болтол шатаасан оршуулгын догшин дөлийг дээрээс нь ус асгаж баймааж нь намжаадаг бөлгөө.

## XXV

Аяа, Аржуна тулалдааны талбар дээр уулынхны хаан надад үзэгдэхээ болилоо! Харж байна уу, манай цэргийн ухарч байгааг! гэж Кришна хэлэв. Харвал Карна Пандугийнхны цэргийг шахах түрээд бүр Юдхитхирад аюул учруулж байгаа “Морьдоо ташуурдаад!3 гэж Аржуна, Кришнад хашгиран хэлээд ахдаа туслахаар яаравчлав. Их тулалдааны дуу чимээ улам ихэдсээр сум шунгинаж, нумын хөвч часхийж, их тэргүүд нижгэнэлдэж, заанууд орилолдож, цэргүүд хашгиралдаж шархадсан хүмүүс ёололдож байх бөгөөд тийм шуугианд бие бие лүүгээ тулалдаж буй баатрууд зүрх хөөрч эрт дээр үеэс хагарсан түнжингээ энэ тулааны талбар дээр дуусгал болгохын улайран хүснэ. Эрэлхэг зоригт нанчалууд ч Карнаг хүчирсэнгүй. Хамгийн тэргүүд эгнээнд байлдаж байсан панчалын хамгийн хүчирхэг хорин баатар Карнагийн гарт амь үрэгдэв. Карна дайсныхаа дотор дайран ороод өөрөөсөө хүч дутмаг дайчдыг баруун солгойгүй эргэлдэн хядаж байв. Энэ бол усан дээр нь Лянхув цэцэг ганхаж, хун шувууд хөвж байдаг тогтуун цөөрөмд сүргийн манлайд яваа зэрлэг заан туучин орсонтой адил амой. Цэргүүдийн бамбай, гархин хуягууд Карнагийн суманд хэмхрэн бутарч байх бөгөөд тэдний дотор Карнагийн ганц сумыг дааж амь гарах нэг ч хүн олдохгүй байна. тэрбээр, өөрийн мөр дээр таарсан Панчал, Сринжа, Пандугийнхныг хүйс тэмтрэх нь буга согоог арслан хядах лугаа адил ажээ. Пандугийн хөвгүүд үүнийг хараад өөрсдийнхөө амь насанд орохоор тулалдааны талбарын зүг зүгээс Карнаг дайрчээ. Тулалдааны нүд алдам их далайн өнцөг булан бүрт байлдааны сүх, шийдэм далайлдаж, цэргүүд бие биеэ сум жадаар сүлбэж, их тэргүүд их тэргүүдээ, заан заанаа, явган цэрэг явган цэргүүдээ, морьтой нь морьтойгоо зогсолтгүй сүйдэлж байлаа. Туг хиур хаадын нар борооны шүхрүүд, толгой гарууд хурц суманд тас огтлогдон хөсөр ойчно.энэ сүрт тулалдаанд бодио

хөтлүүлсэн хүмүүсийн нүүр царай нь гандсан цэцэг, хугарч гишгэлэгдсэн Лянхув шиг харагдана. Хүн, заан, агт морьдын сайхан бие цогцос нь шавар шавхай болсон хээнцэр хувцас шиг аягүй муухай болжээ. Карнад сүйдлүүлэн бас нөгөө талаасаа Млеччха нарын байлдааны заанд түрэгдэж байсан панчал нарт ихэр ах дүү Накула, Сахадева хоёр туслаар хүрч очиж амжлаа. Нөгөө догшин заанууд дайсан руу явж буй уул шиг дайрч байна. заанууд зарим хүмүүсийг соёогоороо нэвт сүлбэж заримыг нь дээшээ өргөөд газар хаяна. Тэр аварга араатны соёонд сүлбүүлэн шидэгдэж буй цэргүүдийг харахаас нүд хальтрам бөлгөө. Млеччхын хаан рүү Сахадева зоригтой дайрсан боловч Накула түүнийг удирдаж дайсны цэргийн жолоодогч болон түүний зааныг олон зуун хөнөөлт сумаар шүршжээ. Тэр хаан толгой үгүй болж заантайгаа газар ойчиход заанаар явахдаа гарамгай Млеччхагийн олон баатар эр Накулын эсрэг сүртэй дайралт хийв. Гэвч Панчал, Сомакчууд болон бусад Пандуугийнхан нь түүнд туслахаар ирж маш ширүүн тулалдаан болжээ. Сахадева найман зааныг дээр нь байсан хүмүүсийнх нь хамт алж, Накула бас олон заан устгажээ. Панчалуудын эзэн, шикхандын Драупадын хэдэн хүү тэдгээр лут заануудад үерийн бороо шиг сум буулгажээ. Тэгэхээр дайсны цэрэг ухран зугтав. Тэгээд Аржунын баатрууд Карна тийш довтолжээ. Духшасана, догшин Сахадевын замыг хаалаа. Энэ хоёрын улайран тулалдахыг их тэргэн дээрх цэргүүд хараад чанга чанга хашгиралдаж зэр зэвсэг, туг хиур дээш шидэж байлаа. Тэр хоёр хэн нь ч хэнийгээ дийлэхгүй их л уджээ. Духшасана мэргэн харваж Сахадевагийн гар дахь нумыг бут ниргэлээ. Тэгэхлээр нь Сахадева юлдээ сугалж аваад дайсан руугаа хүчтэй шиджээ. Тэр юлд Духшасаны гар дахь нум сумыг тас чавчаад газарт гүнзгий шидэх нь тэнгэрээс буух могой мэт. Сахадева өөр нэг нум тавив. Гэтэл Духшасана, тэр хөнөөлт сумыг өөрийнхөө юлдээр нислэг дунд нь хугаллаа. Дхритараштрийн хүү арслангийн архиран урхирах мэт газар даяар дуу хадуулан өөрийнхөө юлдийг дайсан тийш чулуудахад Сахадева түүний нь харваж газар дунд ойчуулав. Сахадева, орчлонг сүйдлэгч Шива бурхан мэт хөнөөлтэй, аймшигт сумаа өргөж барьсан нумандаа хөвчлөн татаж Духшасаны зүг шууд тавьжээ. Тэр сум, баатар эрийн гархин хуягийг нэвтлэн биеийг нь сүлбээд түүний их тэрэгний ар талд газар шаажээ. Духшасана ухаан алдсаныг хөтөч нь үзээд өөрөө үй түмэн суманд сүлбүүлсээр морьдоо эргүүлэн тулалдааны талбараас зайлан зугтав. Яг энэ үед Накула, дайсны цэргийг бут цохиод Карнатай уулзалдаж байлдав. Накула, Карна тийш инээмсэглэн харж: “Заналт чамайг бурхад над дээр одоо л нэг авчрав уу даа! Чи бол хамаг муу бүхний язгуур, Куру удмынхны хоорондын хямрал, мөхлийн шалтгаан! Өнөөдөр би чамайг алж үүргээ биелүүлээд зүрхийг

минь шатааж байсан зовлонгоос ангижрана” гэж их дуугаар хашгирав. Хөтчийн хүү үүний хариуд хаан бөгөөд дайчин эрийн амнаас гарах үгээр хариу болгохдоо: “Баатар эр чи дуулж бай! Би зоргийг чинь үзэхийг хүсч байна. Баатар хүмүүс гэдэг чинь сагсуу үг ярьж хүч, цаг хоёроо алдалгүйгээр байлдан тулалддаг юм шүү. Байдаг хүчээрээ л тулалд! Би чиний бардам занг номхотгоод өгье” гэлээ. Накула, Карна болон түүний уаачийг харван эхлэв. Карна түүнийг нь няцааж өөдөөс нь адилхан харваж байна. тэр хоёрын тулалдаан удаан үргэлжилжээ. Накула, хөтчийн хүүгийн гар дахь нумыг бут харван зэвсэггүй болгож аваад олон зуун сум нүүлгэхэд харж байсан бүгдээр түүний амжилтад гайхжээ. Гэтэл Карна түүний цохилтонд ер ажралгүй байж шинэ нум харваад урт бөгөөд хүнд алтан өдтэй таван сумаар харвав. Тэр сумууд сайхь баатар эрийн мөрөнд сүлбэн ороход мань баатар газар дээр алтан туяа цацруулагч нар лугаа төстэй болжээ. Гэтэл Накула, дайсныхаа зэвсгийг дахин бут ниргэв. Карна дахин нэг бүр ч бөх хатуу нум авч борооны үүл мэт нүүгэлтсэн сум харвахад Пандугийн хүүгийн толгой дээрх тэнгэр харанхуйлж байв. Накула хариу няцаагаад бас нүүгэлтсэн үүл мэт сэм нүүлгэхэд тэнгэрийг царцаа бүхэх шиг санагдана. Гэтэл хоёр баатар эр, тэр хөнөөлт сумын шуурган дотор орчлонг мөхөхөд, мандан гарч байгаа хоёр наран мэт байна. карнагийн тоо тоймгүй суманд сомакууд хүндээр хохирч байхад Каурынхны цэргүүд нь салхинд хөөгдөн үүл мэтээр сарнин зугтаж байлаа. Хоёр талын цэрэг тэр аюултай газраас хойш ухарцгаасан учир Карна, Накула хоёр хоёулахнаа үлдэн үзэлцэж байна. Төдхөн Карнагийн харвасан сумнууд Пандугийн хүүгийн хавийг бүрхэн харанхуйлжээ. Карна Накулын гар дахь зэвсгийг алдуулж, улаачийг нь их тэргэн дээрээс унагаж, мэргэн чиглүүлсэн дөрвөн сумаар дөрвөн морийг нь алаад Накулын их тэргийг жижиг жижиг хэсэг болон бутартал харваж, тугийг нь унагаж, юлд шийдмийг нь хэмхчээд зуугаад саран чимэгтэй бамбайг нь сэт сэт авчээ. Накула их тэрэгнээсээ үсрэн буухад байлдааны ганцхан л сүх түүнд үлдсэн байжээ. Гэтэл Пандугийн хүүг тэр сүхээ авч амжаагүй байтал Парнагийн сумууд тэр сүүлчийнх нь зэвсгийг бас алдуулжээ. Карна дайснаа зэвсэггүй болсныг үзээд бүр ч олон сум нүүлгэв. Гэхдээ түүнд их хор хүрэхгүйг хичээжээ. Тийнхүү тулалдаанд хүчирхэг баатар эрд ялагдсан Накула үлэмж их балмагдан гутарчээ. Карна инээлд алдан түүнийг морин тэргээрээ хөөж давхиутаа зугтаж байгаа Накулын хүзүүнд нумаа углав. “Дандугийн хүү, чиний хэлсэн үг чинь хоосон юм байж!” гэж Карна дуу алдаад тэр үгээ дахиад нэг хэлээч! Ай жаал минь үүнээс хойш өөртэйгөө тэнцүү юмтай хүч солигдож бай. Гэвч битгий ич. Гэртээ харьдаа, Мадрийн хүү чи. Аль эсхүл Кришна, Аржуна хоёрынхоо нөмөрт

оч! гэв. Ингэж тэр, урьд Кунтид өгсөн амаа санаж үхлийн саварт орсон Накулаг амьтай нь орхисон байна. Пандугийн сайхь хүү Юдхиштхирагийн их тэрэг рүү гүйн очиж түүн дээр авирч гараад ичсэндээ нүүр хийх газаргүй болж , хувин дотор орсон могой шиг амьсгаа давхцуулан байв. Карна ч яахав, панчалчуудыг улам хүчтэй дайрчээ. Сарны туяа шиг цагаан морьд хөллөсөн бөгөөд гоёмсог туг хиур намируулсан их тэргэн дээр суусан Каурынхны энэхүү удирдагч дайсны үй олон цэргийн дотор зүсэн оров. Нар нэгэнт их үд болсон боловч хөтчийн хүүгийн гар огтхон ч цуцаагүй бөгөөд тулалдааны талбар дээр маш их цус урсгалаа. Панчалчуудын олон баатар эрчүүл алагдаж бас олон нь дайны табараас үхэдхийн унаж зайуулагдаж байхад тэдний их тэргүүд хэмхрэн бутарч , туг хиур нь навтарга болтлоо салам урагдаж, агт морьд хөтчид нь үхэл байв. Дээрх хүмүүс нь үгүй болсон заанууд Карнагийн харвасан сумын дор ойн түймрээс зугтах адил сул харайлцгаана. Морьгүй болсон тэрэгнээсээ салсан баатар эрчүүд амь зулбан гарах гэж ум хумгүй гүйлдэж байна. Панчалчуудын цэрэг балмагдан ухрахад хөтчийн хүү ухрагсдыг элдэн хөөж морьтой, явган их тэрэгтэй, заантай хүмүүсийг устгахаар байжээ. Каурынхны хуарангийн бусад цэрэг ч Карнагийн хойноос дагалдан довтолгоонд уулгалан орж дайсныхаа цэргийг устгаж байлаа. Эрэлхэг зоригт Улука сүрт догшин Сатьякитай тулалдаж эхлэв. Энэ хоёр дайчин бие бие рүү жад шидэж нум харван, их чадамгай байлдаж байлаа. Улука дайсныхаа довтолгооныг няцааж хөтчийг нь морьтой нь алаад их тэргийг нь харвасаар яйран болгоход хүчирхэг Сатьяки аргагүй ухран зугтав. Харвасан сумнууд нь дайсны цэргийг бөөн бөөнөөр нь устгах тул сринжай , панчалчууд Улукаас зугтжээ. Номхотгошгүй бөгөөд тулалдаанд хайр найргүй Шакуни үерийн бороо мэт сумыг хатан зоригт Сутасома рүү нүүлгэв. Шакунийн харвасан суманд Сутасома их тэрэг олон мянган хэсэг болон бут үсэрч гар дахь нум хугарчээ. Сутасома их тэрэг ч үгүй харвах нум ч үгүй болсон атлаа дажгүй л дайсны суманд харвуулахдаа юлдээрээ тэр хөнөөлт цохилтуудыг няцааж байв. Дайсны харвасан сум Сутасомагийн юлдийг хоёр хэсэг болгон хугалахад л сайхь эр хугархайг нь дайсны өөдөөс шидчихээд тулалдааны талбарыг орхижээ. Хүчирхэг Крина тулалдагсдын дотор орж ирснээс дайсны сэтгэл зүрхэнд айдас төрүүлэв. Түүний их тэргийг Дхриштадьюмнагийн их тэргэнд их тэргэнд ойртон ирж буйг харсан хүмүүс Друпадагийн хүү одоо юу юугүй үхлээ гэж балмагдан итгэж байлаа. Пандугийнхны морьтой , явган цэргүүд түүнчлэн их тэрэгтэнгүүд хоорондоо : “ Энэ агуу их баатар эрийн уур хилэн бадарч, алагдсан Дронагийн өшөөг авах гэж шунаж байгаад сэжиг алга. Дхриштадьюмна түүний гараас гарах бол уу, яадаг бол?

Бид ер нь амь гардаг бол уу, үгүй бол уу? орчлонг сүйдлэгч Шива шиг хүн юм аа, гэлцэж байжээ. Крипийн мөндөр мэт буулгах сумнаас айчихсан Дхриштадьюмна биеэ хамгаалах гэж гараа өргөж чадахгүй хөдөлгөөнгүй зогсож байв. “ Друзадын хүү чамд аюул учраад байна шүү! Чи энэ баатар эрийн өмнөөс тэсэхгүй юм байна. Одоо хүртэл түүний сумнуудын нэг нь чамайг хөнөөхгүй байгаа нь гайхалтай. Би энэ аймшигт газраас тэргээ зайлууллаа шүү” гэж хөтөч нь Дхриштадьюмнад хэлэхэд Дхриштадьюмна нам дуугаар хариу өгсөн нь “ Сүнс минь балмагдаж , айснаас болоод үе мөч минь хөдлөхөө больжээ. Ай бурхан минь, бие дагжаад, үс босчээ. Хөтөч минь намайг энэ дайчин эрээс зайлуулж Аржунагийн байгаа газар аваачаач. Аржуна юм уу Бхимасенагийн ойр байвал нь би үхлээс аврагдах байна” гэв. Тэгээд Дхриштадьюмнагийн их тэрэг сүрт догшин Крипад элдэн хөөсөөр Бхимасенагийн зүг жийгүүлж байлаа. Критаварман, Шикхандинтай хатуу штрүүн тулалдаж бие биеэ тоогүй олон шархдуулаад цусандаа бялдагдсан байна. хоёулангийн хуяг дуулганд шаалттай сумнууд арсайж сарсайж цухуйгаад харахаас аймаар боловч цуцаж сулрахгүй улайран үзэлцсээр байтал Критаварман, Друпадагийн хүүгийн цээжинд айхавтар сүрхий цохилт өгөв. Шикхандин муурч унахад тугний иш модноос барьж аваад их тэрэгнээсээ арай ойчилгүй өнгөрөхөд хөтөч нь морьдоо бушуухан эргүүлэн залаад тулалдаанаасаа гаргаж, шархадсан дайчнаа үхлээс зайлуулав. Шикхандин тийнхүү дийлдэхэд Пандугийнхны цэрэг тал талаасаа устгагдсаар ихэд балмагдан талбараас зугтав. Энэ үед Дурйодхана, Юдхиштхиратай уулзжээ. Тэр хоёр яг л улангассан хоёр арслан шиг бие биеэ дайрахдаа хатуу хөвчит нумуудаараа үй олон сум харвах уул манан мэт харагдана. Дурйодхана өргөн хурц, үзүүртэй сумаар Юдхиштхирагийн хөтчийг харван намнав. Гэтэл Юдхишхира, Дурйодханагийн их тэргэнд хөллөсөн дөрвөн морийг дараа дараагаар харван алав. Дхриштараштрагийн хүү өөр нэг их тэргэнд шилжин очоод байлдахдаа Юдхиштрагийн цээж, хоёр мөр лүү сум шааж орхиход тэр баатар эрийн биенээс цус олгойдох нь эгээ л уулын усан хүрхрээ шиг байжээ. Гэвч Пандугийнхны ахмад нь болох тэр хүн хатуу цохилтод шантралгүй тэвчээртэй тулалдаж, хамаг хүчээ хуримтлуулан алмас эрдэнэ шиг хатуу, хурц үзүүртэй нэг сумыг дайсан руугаа харвав. Тэр сум Дурйодханаг хүндээр шархдуулахдаа биеэр нь нэвт гараад газар шаасан байна. Хамаг уур хилэн нь бадарсан Дурйодхана асар том шийдэм далайж ганц цохилтоор дайсагнал ба дайныг эцэс болгохоор Юдхиштхирагийн зүг шидэх гэв. Гэтэл Юдхиштхира түүнээс урьтаж цээж рүү нь жадаа сүлбэж амжжээ. Каурынхны эзэнтэн ухаан алдаад их тэргэн дээрээ өнхрөн унав.

Энэ агшинд Бхимасена өөрийнхөө тангаргийг санаж Юдхиштхирад хашгирсан нь: “ Хаантан минь цаадах чинь чамд алагдах ёсгүй билээ!” Тэгэхлээр Юдхиштхира түүнд үхлийн цохилт өгөхөөс татгалзав. Дурйодханагийн хөтөч ч энэ хооронд тэргээ эргүүлээд эзнийгээ дайсны сум хүрэхгүй газар аваачжээ.

Нар баруунаа хэвийж байх үед Карнагийн тэргүүлсэн Каурынхны цэрэг дайсны цэргийг шинэ хүчээр шууран дайрч ухраав. Бурхад, шулмасуудын хооронд болж буй мэт энэ аймшигт тулалдаанд чин зоригт дайчид нь байлдааны сүх, юлд, шийдэм жадаар заан ба их тэрэгнүүдийг устгаж байв. Алтан титэм, ээмгүүд нь гялтганасан олон зуун толгой газрыг гоёлын малгайгаар чимж, гол мөрөн мэт цус урсч байна. Заан, агт морьдын хүүр, нүүр нь хөшиж шарх нь ангайсан хүмүүсийн хүүрээр хучигдсан талбар нь орчлон сөнөх өдөр үхлийн бурхны эзэмшихүүн ямар байсны нэг адил харагдаж байлаа.

Чини овгийн чимэг болсон Сатьяки Кауравынхны энэ улайрсан дайралтын хамгийн түрүү эсрэгцэв. Карна, нарны туяа мэт гялалзах олон зуун сумаар Сатьякиг харвахад Сатьяки хариуд нь хорт могой шиг хөнөөлт олон зуу сумаар Карнаг харважээ. Энэ үед хүчит цэргийн манлайд явсан Дхриштадьюмна давшиж буй Кауравынхны замыг халхлан хааж түүний тугийн эргэн тойронд хатуу ширүүн тулалдаан болжээ. Байлдааны талбар дээр Аржунагийн их тэрэг газар донсолгон орчин тойрныг аянга ниргэх мэтээр нүрэглүүлнэ ггарч ирэхэд Карнагийн цэрэг ухаан алдатлаа айгаад эргээ дэлсэн хаялах далайн шуурганы долгион шиг эргээд зугтацгаав. Аржуна, сүрт нумаа дээр өргөж, их тэргэн дээрээ бүжих адил эргэлдсээр харавсан сумнууд нь гүйлдэж буй хүмүүсийн толгой дээрх тэнгэрийг халхлан үүл мэт нүүгэлтэн ниснэ. Аржуна дайсны байлдааны тэргүүд, заануудыг унасан хүмүүсийнх нь хамт, бас явган цэргүүдийг хиахтал нь устган үхлийн бурхан Яма мэтээр тулалдааны талбар дээгүүр Кришнагийн жолоодсон их тэргэн дээр зогсон давхиулж явна. Шархнаасаа сэхэж ирсэн Дурйодханы хөтөч, морьдыг устгаж, тугийг нь унагаагаад нумных нь хөвчийг тасалжээ. Тэгээд Аржуна, барааг харахаас сүрдмээр бөгөөд замдаа тохиолдох амьтай голтой бүхнийг хөнөөх тийм нэг сумыг Дурйодхана руу чиглүүлэн харвав. Хэрэв яг энэ үед Ашваттахаман түүнд туслаар ирж тэрхүү сумыг нисч яваа замд нь харваад долоон хэсэг болгоогүй бол Дхриштараштрагийн ахмад хүү зайлшгүй үхэх байсан ажээ.

Аржуна, Ашваттахаманыг шууран дайрахдаа морьдыг нь хөнөөж, гар дахь нумных нь хөвчийг тас харваж мөр дээрээ тааралдсан дайсны цэргийг хог хамах мэт

хядан Пандугийнхны цэргийг шахаж хөөж яваа Карнагийн байгаа газар муу давхиулжээ.

Карна, Сатьякийг орхиод Аржунын зүг эргэж нүд ирмэхийн зуурдгүй олон тооны сумаар Аржуна, Кришна хоёрыг дайрч эхлэв. Энэ хооронд түрүүчийн авсан цохилтоос сэхсэн Сатьяки, Карнагийн араас дайрч бас Пандугийнхны цэргийн олон хүчирхэг баатар эрчүүл Аржунаад туслаар иржээ. Шикхандин, Драупарын хүүхдүүд, Юдхиштхира хаан, Чекитана, ихэр ах дүү хоёр, Дхриштадьюмна нар матс, кайкей каруш, чедийн ангиуд болон тоолшгүй олон их тэрэг заан, морьт явган цэргүүд Карнаг тал бүрээс нь бүслэн янз бүрийн сум, жад, хануур жад, зээрэнцгүүдээр нүүлгэж эхэлжээ. Гэтэл Карна тэр хөнөөлт үерийг няцаан дайсны эсрэг довтлохдоо зэвсгийнхээ хүчээр тэднийг сүйтгэх нь усан шуурга замдаа тааралдсан моддыг дайран унагахын нэг адил байна. Уур хилэн нь шатсан Карна явган, морьтой, их тэрэгтэй заантай цэргүүдийг хүйс тэмтрэн устгахад нь Пандугийнхны цэргийн дарга нар түүний өмнөөс эсрэгцэн үзэлцэж чадалгүй мөр дээрээс нь зайлан зугтаж байлаа.

Карна, өөрийгөө тойрон бүсэлсэн дайсны бүслэлтээс мултран гарч байхад Аржуна Каурынхан луу давхар хүчтэйгээр шууран дайрч харавсан сумаараа тэднийг аянга ниргэх мэт устаж байв. Түүний гарт үхсэн дайчид, агт морьд заан олон болжээ. Нар, уулын цаагуур орж байх үеэр Кунтийн хүү Аржунайн ялгуусан довтолгоонд тэссэнгүй. Каурынхан маш их балмагдан ухарч байлаа. Үдшийн баруй бүрий, тулалдагсдын хөлөөр боссон тоос шороонд өөрийнхнийгөө дайснаас ялгахад бэрхтэй болжээ. Тулалдааны талбараас Каурынхныг зайлахад Пандугийнхан бас зайлж, хийсэн ялалтандаа бахдан Аржунайн агуу хүчирхийг ам амандаа магтан шагшсаар хуарандаа эргэн очиж шөнийхөө амралтыг өнгөөрөөхөөр майхан майхандаа тарцгаав. Харин цусанд бялдагдсан дайны талбар дээр аймаар муухай рагшас, хүний мах идэгчид болон хүүр идэгч амьтад сүрэг сүргээрээ иржээ. Каурынхны цэрэг шарханд сэглүүлж, хуяг дуулга нь эвдэрч хэмхэрсэн, үй олон морь, заан, их тэрэгнээсээ хагацсан учир гүн харамсал гунигтайгаар хуарандаа буцаж иржээ. Карна, санаа алдан гараа чанга атгаж Каурынхны эзэн хааныг уйтан хараад “ Аржуна, тулалдаанд чадамгай, их боломжтой тэвчээртэй хүн юм. бас Кришна, түүнд учрах болзошгүй аюулыг цаг тухайд нь сануулж бөгөөд байх юм. Өнөөдөр бид түүнийг дийлж барсангүй. Гэвч маргааш, тэрний юу сэддсэн бүрийг нь устгана даа, дэлхийн их эзэнтэн минь” гэхэд Дурйодхана.” Тэгэх болтугай гээд хаадаа тараахад бүгдээр майхан майхандаа очжээ.

## XXVI

Дараа эдрийн үүр тэмдгэрч байхад Карна, Дурйодхана хааны өмнө очиж “Эзэнтэн минь би өнөөдөр Пандугийн алдарт хүүтэй учран тулалдах болно. Одоо ч хүртэл бид хоёрын учран тулах гэхэд хувь тавилан саад хийж байлаа. Харин өнөөдөр би түүнийг алалгүйгээр дайны талбараас буцаж ирэхгүй. Бидний үйл хэрэг өлзийтэй болоход юу хэрэгтэйг хаантан минь сонс. Дайсны цохилтыг няцаах талаараа ч сум мэргэн харавхаараа ч, эрэлхэг зоригийн хувьд ч, авхаалж мэхийн хувьд ч Аржуна намайг гүйцэхгүй. Миний зэр зэвсэг тэрнийхээс доргүй. Вижая гэдэг миний нум бол эрт урьд цагт Индра, шулмасуудтай дайтахдаа хэрэглэж дийлсэн нум бөгөөд Аржунайн гандива гэдэг нумнаас хүчтэй билээ.

Пандугийн зоригт хүү надаас нэг л юмаар давуу байна. Над түүнтэй мөр зэрэгцэх хөтөч алга. Гэсэн ч би Аржунатай тулалдах болно. Ай халаг хаантан минь, хаадын хурлын чимэг болсон Шалья л морьдыг таньж мэдэх, их тэргийг жолоодох чадвар, гарынхаа хүчээр Кришнатай эн зэрэгцэх билээ. Хэрэв тэр миний хөтөч болох юм бол чи ялах нь тэр! Тэгсэн байхад бурхад ч, чөтгөрүүд ч тулалдаанд миний өмнөөс хүчин мөхөсдөж болно” гэжээ.

“ Карна минь, чиний хүсэл биелэх болно” гэж Дурйодхана хариу өчөөд мадр нарын эзэн тийш тэр даруй явлаа. Дурйодхана түүнд дөхөж очоод ихэд хүндэтгэн өгүүлсэн нь:

“ Хүчирхэг хаан, аймшиггүй зоригт баатар, тулалдаанд хосгүй дайчин Шалья минь! Бидний үйл өлзийтэй болоход чамайг хичээнгүйлэн гуйхын учир дэлхийн эзэн би, тэргүүнээ номхоноо гудайлганам. Миний хүслийг биелүүлэн үү. Аржунатай тулалдахад гагцхүү чи каранагийн хөтөч болж чадах хүн юм. Кунтийн сүр завхлант хүүг Кришна тулалдаанд хамгаалж буйн адил хатан зоригт Карнагийн хамгаалагч нь болох ажаамуу. Чамтай байсан цагт Карна дийлдэхгүй” гэлээ.

Шалья, Дурйодханы энэ үгийг сонсоод ихэд хилэгнэжээ. Хөмсгөө зангидан, гараар хүчтэй занган Дурйолханд хариу өчихдөө: “ Гандхарын хүү чи, намайг элэг барьж Карнаг надаас дээгүүр тавьж түүнд зулгуйдаж байна. Гэтэл би тэр хөтчийн хүүг тулалдаанд надтай мөр зэрэгцэх хүн гэж тооцохгүй. Аянгын сум шиг хүчирхэг миний гар, миний нумыг хар, салхи шиг хурдан морьд хөллөсөн миний их тэргийг хар! Би дайсныг ганц гараараа устгана. Энэ шийдмээрээ уулыг ч хоёр хуваачихна. Чи үүнийг мэдсээр байж намайг доод төрөлт хүний хөтөч бол гэж байна. Ингээд



кшатрий намайг өөртөө зарц байзал зохих хүний эрхэнд явах хүн гэж бодож байх шив дээ! Би ингэж доромжлуулсан болохоор дайтахыг ч болилоо. Эзэнтэн минь намайг улс гүрэндээ буцахыг соёрхоорой ” гэжээ.

Шалья ингэж хэлээд явах гэтэл Дурйодхана түүнийг тогтоож үлэмжийн их хүндэтгэлтэйгээр түүнд хандаж: “ Шалья минь, чиний хэлдэг үг зүйн хэрэг, эргэлзээ алга, карна ч тэр, хүч чадал, эрэлхэг зоригоороо чамаас давуугүй билээ. Гэвч би чамайг бүх баатруудынхаа дотроос шилж авахдаа зэр зэвсэгээ эзэмших талаар Карна Аржунагаас ямар шуу давуу байдаг бол агт морьдын таних ба хүч чадлаараа чи Крашнагаас мөн тэр зэргийн давуу гэж бодсон юм. Мадрын эзэн минь, агт морьдыг жолоодох уран чадвараараа чи ядав нарын хаанаас хоёр дахин илүү мэдэх билээ!” гэв.

“Тандхарын хүү чи намайг Кришнагаас дээгүүр тавьж байгаа хойно би сэтгэл тааламжтай боллоо. Чиний хүссэн ёсоор би Карнаг Аржунатай тулалдахад хөтөч нь больё. Гэхдээ би түүнд хэлэх гэсэн үгээ дуртай цагтаа хэлнэ гэдэг нэг болзол тавина” гэхэд Дурйодхана, Карна хоёр: “ Чингэх болтугай” гэв.

Өглөө болмогц Карна, Шалья хоёр, цагаан морь хөллөсөн, барсын арьсаар хулдсан байлдааныхаа их тэргэнд суужээ. Жагссан цэргийн урдуур нар үзсэн мэт гялалзсаар Карнаг гарч ирэхийг үзсэн Каурынхны цэргүүд чанга хашгиралдан баяр хүргэлээ. Бөмбөр нижигнэн, бүрээ дуугарч, дайчин уриа хашгиралдах шуугиан дэгдэж, цэргүүд ч байлдааны талбар дээр өөд их шуугиантайгаар газар доргим нүсэр алхаж хөдлөв.

“ Мадрын эзэнтэн минь, байлдааны газар руу бушуухан очъё. Явсхийж үзээч. Манай шилдэг дайчид үхэж барагдах нээ. Одоо миний тулалдах цаг болжээ. Хүчирхэг Аржунагийн эсрэг, Бхимасена Сатьякийн эсрэг надаас өөр хэн жолоодох юм бэ? Тэдэнтэй уулзан тулалдаад би нэг бол тэднийг хиар цохино, эсхүл Дронагийн гаргаж өгсөн замаар үхлийн бурхны оронд өөрөө одсугай. Өнөөдөр би Аржунатай заавал үзэлцэнэ. Үхлийн бурхан Яма тэргүүнтэй бурхад тэнгэрээс бууж ирээд түүнийг хаацайллаа ч гэсэн би тулалдаанаас зугтахгүй, түүнийг мэсээрээ хөнөөнө!” гэлээ.

“ Сагсуурахаа боль, Карна минь чи Аржунатай мөчөөрхөх гээд барахгүй. Виратын мал сүргийг таны дээрэмдэхэд тэр эр, чамайг, Бхишмаг, Дронаг, манай баатар эрчүүлийг хэрхэн дийлснийг санагтүн. Юунд чи тэр цагт түүнийг

хөнөөгөөгүй вэ? Хэрэв чи Аржунагаас зугтаж амь зулбахыг хүсэхгүй байгаа бол хөтчийн хүү чи түүнтэй тулалдмагцаа үхнэ гэдгээ мэд” гэжээ.

“ Тэгвэл тэгэг. Бидний тулалдах цаг ойртжээ. Хэрэв Аржуна намайг дийлбэл чиний үг хоосонгүй өнгөрөх болно. Урагшаа!” гэж Карна Шальяд хэлээд дайсны цэргийн өмнө гарч очин Пандугийнхны цэргүүдэд хандаж хашгирсан нь: “ Өнөөдөр над Аржунын их тэргийг зааж өгсөн хүнд би их шан өгнө шүү! Тийм хүнд би тэрэг дүүрэн эрдэнийн чулуу өгнө. Хэрэв үүнийг чамлавал нэмэрт нь зуун үнээ тосгон өгнө. Тулалдаанд Аржуныг над зааж өгсөн хүнд би зуун заан, түмэн шилдэг морь, Магадха газрын дуулах бүжиглэхдээ чадамгай зуун залуу эмэгчин боол бэлэглэнэ шүү. Бас Аржуна, Кришна хоёрыг байлдаж алсныхаа дараа тэр хоёрын эд агуурсыг бэлэглэнэ “ Карнагийн энэ үгийг сонсоод Каурав нарын цэрэг баярлалдан хашгирч байхад Шалья хорслонтойгоор инээгээд: “ Хөтчийн хүү чи эд агуурсаа дэмий бүү үр! Чи өнөөдөр Аржунагийн барааг харна, үүнд эргэлзэх юм алга соиорсондоо амлаж байгаа юм. Буян болох вий. Харин хүслээ биелэнэ гэж бүү найд. Чи хүзүүндээ хүнд чулуу зүүлттэй далайд ороод гатлахыг хүсч байна шүү дээ! Хоёр сүрхий арсланг нэг цөөвөр чоно дийлсэн гэж ер нь дуулдаагүй байх аа?” гэв.

“ Би ганцхүү хоёр гарынхаа хүчинд дулдайлан Аржунатай тулалдах юмаа. Анд нөхрийн царай гаргасан дайчин чи намайг айлгах гээ юу? Аржуна Кришна хоёрын хүч чадлыг би чамаас илүү мэднээ. Гэсэн ч Индра бурхан аянгын сумтайгаа одоо миний дэргэд ирээд ч миний шийдсэн санааг гуйвуулж чадахгүй” гэж Карна хэлэв.

“ Хэрэв их тэрэгний маань дугуй газарт шигдэж орхихгүй бол би өнөөдөр Аржунаг хөнөөнө, Тулалдаанд би Ямагаас өөрөөс нь ч айхгүй. Гагцхүү нэг өвгөн бярмань хараа л сэтгэлээс гарахгүй юм. Тэр тугалынх нь оронд мянган үнээ, зургаан зуун шар өгье гээд ч тус болохгүй юм. Тэр өвгөн даяанч намайг “ Онгон үнээний тугалыг алсны төлөөд, чамайг хөнөөх тулалдааны аюул нөмрөөд байх тэр мөчид их тэрэгний чинь дугуйнууд газарт шигдэг” гэж хараасан юм. Шалья чи дуугүй бай. Чи намайг айлгадаг нь биш. Карна, тулалдаанд айхыг мэддэггүй хүн шүү!” гэж бас хэлж байна.

Шалья зэвүүрхэн инээмсэглээд Аржуны хүч чадлыг магтаж, Каурынхны цэргийн жанжин зайлбаргүй үхнэ гэсээр байлаа. “ Тулалдаан хийх уран ухаан юу ч мэдэхгүй новшийн тэнэг минь гэж! Карна дуу алдаад чи айсандаа тэр үү, эсхүл над

үл мэдэгдэх ямар нээг шалтгаанаар чи Аржунаг магтаж байна! Хорон санаат чи анд нөхдөө дорд үзэн Пандугийн хүүд өлзий болох үг ярьж байна. Би чам шиг зуун юмыг алчихаж чадах л байна. Гэсэн ч чамайг тэгж байх цаг хараахан ирээгүй байгаа учраас л тэгэхгүй байгаа юм шүү” гэв.

Дурйодхана хаан, Карна, Шалья хоёрын үгийг сонсоод тэр хоёрын хэрүүлийг болиулар гэж яаравчлан ирж хөтчийн хүүг анд нөхрөө аргадах адил аргадаж хоёр гараа элгэндээ хичээлэнгүй барьсаар Шальягаас гуйлаа. Карна Дурйодханы үгэнд уур хилэнгээ барихад Шалья нүүрээ дайсан руу хандуулав. Карна инээвийлэн өөрийн хөтчид “ Урагшаа!” гэж хэлжээ.

Дурйодханы цэрэг Куругийн талд дахин тулалдахаар бэлэн болжээ. Баруун жигүүрт нь Крипа, Критаварман зогсож түүнээс баруун тийшхэнээ Шакуни, Улука хоёр байх бөгөөд тэдний хамт наранд гялтганах жад барьсан гандхарын аймшиггүй зорригт морьт цэргүүд, шөнийн буг чөтгөр хүний мах идэгч чөтгөр шиг харахаас аягүй бөгөөд зэрлэг, бөөн царцаа мэт туйлын олон уулынхны ангиуд байна. Зүүн жигүүрийг нь Дхритараштрын хүүхдүүдийн удирдсан самшаптакийн гурван түм дөрвөн мянган их тэрэг хамгаалж тэднээс зүүн тийшхэн камбож, скиф, явачууд зогссон байлаа.

Бүх цэргийн тэг дунд Карна их тэрэгтэйгээ зогсож, араас нь Духшасана, Дурйодхана, Ашваттахаман нар хүчирхэг цэргүүдээ дагуулан байрлажээ. “ Цагаан морьд хөллөсөн Аржунагийн их тэрэг манай цэргийг угтан хөдөлж байгааг хар. Зааж өг гэж гуйгаад байсан хүн чинь тэр дээ. Тэнгэрийг бүрхсэн тоосон их үүлийг харж байна уу? Газар дэлхий донсолгож байгаа их тэрэгнийх нь нижигнэх дууг сонсч байна уу? Муу яр зөгнөгч сүрэг махчин амьтад манай цэргээс баруун тийш хүрч ирээд ульж чихэнд чийртэй хашгиралдаж байгааг хараач, салхи өмнөөс маань сөрж, Каурынхны тугийг бөхийлгөлөө. Морьд чинь бүдэрч байна. Хувь тавиланд чинь муу ёр зөгнөж байна шүү” гэж Шалья Карнад өгүүлэв.

“ Карна минь, Кунтийн хүү, самшаптакуудын сүрэг үнээн дотор орсон арслан шиг дайрч байхыг харав уу! Их тэрэг нь тэдний цэргийн дотор ороод наран үүлийн цаагуур алга болох шиг далдарчихлаа. Агуу их дайчин эр одоо дайснаа устган сөнөөж агуу их цус урсгаж байна” гэж Шалья бас хэлжээ. Карнагийн уур хүрч, “ Самшаптакууд, шуургат далайн долгто шиг хөдлөн Аржунаг тал болгоноос нь дайрч байгааг харахгүй юу. Дайсандаа бүслэгдсэн тэр, тэнгист живж байгаа усчин шиг

нүдэнд харагдахгүй алга боллоо. Үхэл нь удахгүй ирнэ дээ” гэлээ. Аржуна Самшаптакуудтай тулалдан, зүг бүрээсээ дайрч буй цохилтыг няцааж, дайсны морьт цэрэг заануудыг, ер их тэргэндээ ойртож ирсэн бүхнийг хиартал цохиж байхад Карна, Дхриштадьюмнагийн толгойлон байсан панчал нарыг шууран дайрчээ. Олон мянган дунгийн дуу зүрхийг зүсэх шиг болж, хоёр этгээдийн бөмбөрийн нижигнэх чимээ нь морьдын янцгаах, заануудын урхирах, дайчдын уриа дуудлагуудтай холилдоно. Хоёр талын цэрэг хайр найргүй үхлийн тулалдаанд хутгалджээ.

Карна, дайсныхаа дайчин эрс, цэргүүдийг мянга түмээр нь устгаж, өөрийн замыг үхсэн хүний хүүрээр дүүргэн панчал, чедичүүдийн дундуур нэвтэрч гараад Юдхиштрихад дөхөж очив. Дравид, нишад нарын явган цэрэг Сатякийн удирдлагаар Карнаг дайрсан боловч нарны хүүг дийлж чадсангүй. Карнагийн цохилтонд сүйрч, бүтэн үлдсэн нэг нь ухран зугтжээ. Довтолж ирсэн бүхнийг Карна хиар цохиод дахин Юдхишьхираг дайрав. Гэвч Пандугийн хүүг сүрт догшин дайснаас хамгаалах зориг шийдэмгий агсан панчал, кейкай нарын цэргийн дарга нар хана мэт хаацайлан тулалджээ. Юдхиштира уур хилэн бадарч нүд гялалзуулан Карнад хашгиран хэлэхдээ: “ Хөтчийн хүү чи миний хэлэх үгийг сонс! Чи Дурйодханагийн үгэнд ороод дандаа бидний эсрэг байлдаж байна. Хамаг хүч, чадал, зоригоо гарга. Одоо би чиний тэр тулалдах шуналыг чинь тонилгоод өгье” гэж хэлээд алтадмал нумаараа үерийн бороо мэт үй олон сумыг Карнагийн өөдөөс нүүлгэв.

Юдхиштира чинээнд нь тултал хөвчилсөн нумаараа орчлонг сүйтгэгч Шива бурхны очир мэт хөнөөлтэй сумыг дайсныхаа өөдөөс харав. Тэр сум аянгын дуу шиг дуугарч нисэн явсаар Карнагийн зүүн сүвээ рүү нь шааж ороход Карна тэргэн дээрээ гуйвж тамир алдарсан гар нь нумаа унагав. Каурынхны цэргүүд үүнийг хараад харамсан гаслалдаж байхад Пандугийнхан оодрон баярлалдаж Юдхиштирагийн амжилтанд баяр хүргэж байлаа.

Гэвч Карна төлхөн ухаан орж үлэмж их хилэнтэйгээр дайснаа дахин дайран дотлов. Өөрийнхөө бурханлаг нум Вижагаараа хөнөөлт сумнуудыг нүүлгэж панчалынхааны хоёр хүү Чандрадев, Дандадхара болон замдаа саад болж Юдхиштира рүү нэвтрүүлэхгүй байсан бусад олон дайчдыг хядав. Пандугийнхны ахмадад туслаар өөр бусад хүчирхэг зоригтой баатар олноороо яаравчлан иржээ. Сатяки, Чекитана, Шикхандин, Драупадын хүүхдүүд, Накула, Сахадева, Бхимасена, Шишупала болон бусад олон баатар дайчин эрс Карна руу довтолж устгахыг улайцгаа байлаа.

Тэгэхлээр нь Карна тарни уншиж илбэтт багаж зэвсгээ хэрэглээд эргэн тойрноо нисдэг сумнуудаар дүүргэв. Тэдгээр нь ойн түймэр моддыг хөнөөхийн адил дайсныг хүйс тэмтэрч байлаа. Карна, мэргэнээр харваж Юдхишртхирагийн хуяг дуулгыг юу ч үгүй болтол сүйдэлж гар дахь нумыг нь бас алдуулав. Пандугийн хүү цусаа урсгасаар хүд жад дайсныхаа өмнөөс шидсэн боловч Карнагийн мэсэнд олон жижиг хэлтэрхий болон бтарч хөтөч нь алагдахад Юдхиштхира өөр нэг их тэргэн дээр шилжин суугаад нэгэнт зориг шантарсан Юдхиштхира ум хумгүй зугтав.

Гэтэл Карна хойноос нь хөөж очоод гараа сунгаж мөрөнд нь хүргэв. Гэтэл Шалья “ Түүнд бүү халд, тэгвэл бид үхлээ шүү” гэж хашгирав. Карна Кунтид өгсөн амаа санаж Юдхиштхираг тавьж явуулахдаа дооглон инээж “ Чи Крашригаас төрсөн байж тулалдааны талбар дээрээс амь зулбан зугтаадаг чинь юу билээ? Кунтийн хүү чи үүнээс хойш хатан зоригт дайчдад бүү ойртож бай. Тэдний өмнөөс хорон үг битгий хэлж бай. Саяных шигээ амиараа төлөхөд хүрнэ шүү! Хаантан минь хуарандаа буцаад оё доо, яахав. Чам шиг амьтдыг Карна алдаггүй шүү” гэв.

Хааныгаа байлдааны талбараас зугтааж байгааг хараад панчалчуудын олон цэрэг хүчирхэг Сатьяки, Драупадын хүүхдүүд Сахадевагийн хамт хойноос нь дагалджээ. Гэтэл Каурав нар Карнагийн удирдлагаар баярлалдан хашгирч зугтааж байгаа дайсныг элдэн хөөхдөө их хохирол учрулав. Бхимасена, Сатьяки, Дхриштадьюмна хоёрт хандаж хэлэхдээ: “ Та хоёул Юдхиштхира хааныг хамгаал. Саяхан тэр маань хөтчийн золигийн хүүгийн гарт арай л амь алдаагүй юм. Харин би одоо энэ гайг дараад өгье. Эсхүл би Карнаг энэ тулаанаар ална, эсхүл тэр намайг. Чин үнэн хэлж байгаа юм шүү” гэв. Тэгээд өөрийн цэргийг даруулан Карнаг маш догшноор дайрч эхлэв. Каурынхан удалгүй балмагдаж хөнөөлт хилэнт довтолгооноос амь зайлан зугтаалаа.

Өөрийнхөө цэргийг дийлдэж байгааг Карна хараад: “ Бхимасена хүчирхэг ч хүн, хатан зоригтой ч хүн, түүнийг хэн ч дийлэхгүй” гэж хэлээд – Би, Аржунагай л үхэх сэхэхээ үзэн тулалдах юмсан гэж аль язгуурын ганцхан хүсдэг юмсан гэж аль язгуурын ганцхан хүсдэг юмсан. Тэгэхийн тулд ч би Бхимасенатай халз тулалдъя. Хэрэв би түүнийг сумаараа хөнөөх буюу их тэргэн дээрээс нь унагачихвал Аржуна ахдаа туслахаар гарч ирнэ. Мадрын хаантан минь, их тэргээ явуулаарай гэлээ.

Шалья ч морьдондоо ташуурч өгч Бхимасеныг яаравчлан тосов. Хоёр их дайчин эр ч нижгэр тулалдаанд ширүүн үзэлцэж эхэллээ. Тэр хоёр бие биеэ их л

олон сумаар шархдуулжээ. Карна, Бхимасены гар дахь жадыг тэг дундуур нь хуга харваад хатгадаг олон арван сум буулгах нь ойд зэрлэг заан агнаж байгаа ангуучин шиг байлаа. Тэр сумнуудад хордсон Бхимасена уурандаа өөрт нэг нум шүүрэн аваад чулуун хясааг ч хага харваж дөнгөх тийм нэг сумыг хөвчиндөө хийгээд нумныхаа хөвчийг чихээ хүртэл татаж байгаад Карна руу харвав. Тэрхүү сум баатар эрин биеийг нэвт харван гарах нь аянгын гал уулыг нэвтрэн гарах луугаа адил байлаа. Карна гуйвж байснаа ухаан муурч их тэрэгнийхээ ирмэг дээр суугаад өгөв. Шалья ч морьдоо эргүүлэн Карнаг тээгээд явчлаа.

Карнагийн тийнхүү сүйд болж буйг харсан Дуройдхана шархадсан баатраа догшин аюулт Бхимасенаас хаацайлахын тулд нэн даруй Шрутавартан тэргүүтэй хорин дүүгээ нуур жад шидэн, нумаар харвасан Бхимасеныг зүг бүрээс нь дайрчээ. Гэтэл Пандугийн хүү ердөө ч амралгүйгээр дайсны довтолгооныг няцаагаад Каурынхны зүг өөрийнхөө хөнөөлт зэвсгийг чиглүүлжээ. Карнаг сэхэхээс өмнө дахин тулалдаад таван ах дүү нь Бхимасены гарт үрэгдэж бусад нь зутаагаад амь мулт гарчээ.

Карна, Бхимасеныг дахин дайрч хоёр баатарын хоорондын тулалдаан түрүүчийнхээсээ ч бүр ширүүн болов. Хоёул суманд олон удаа шархдаад унтарч намдашгүй догшин тулалдсаар байхдаа их уран чавдар, хүч чадлыг харуулж байлаа. Бхимасена аянгын дуу мэт том хашгираад үхлийн бурхны очир мэт асар том шийдмээ Карнагийн өдөөс шидэхэд Нарны хүү түүний нь няцаав. Карна харавсан сумуудаараа Бхимасенагийн тугийг нам унагаж, нумгүй болгоод, хөтчийн нь үхлийн оронд тонилгож, их тэргийг нь хэмхчихжээ. Гэтэл Бхимасена их тэргэн дээрээсээ үсрэн бууж явган байлдахдаа дайсны цэргийг шийдмээрээ сүйлдэж байна.

Карнагийн ялалт нь цэрэгтээ урам зориг оруулж түрүү зугтааж байсан нэг нь дахин эргэн байлдлаа. Газар дэлхийг доргиосон тулалдааны дуу чимээ хэмжээлшгүй их болж эгээ л тэнгис далайн шуурга шиг болов. Нар газар дээр хөөрсөн цагт тулалдаан урд урдхаасаа улам ширүүсэв. Хоёр их далай нэг нь нөгөөдөө усан хүрхрээ буулган, шуурган долгионууд нь холилдож буй мэт байлаа. Бузар олон их тэрэг, бөөн бөөн морьт цэрэг, тоо тоймгүй олон тооны заанууд тулалдааны түйвээнд мөргөлдөн хутгалдаж, борооны үүл шиг нүүгэлтэн үй олон сум, хануур жад тэргийг царцаа мэт харанхуйлж байна. Ус шиг урсах цус газрыг элбэг бялдана. Хөнөөлт суманд хэлмэгдсэн хүн, морьд, заан туладааны талбараар орох газраа олж ядан гүйлдэх буюу хөсөр унаж амь твихаар тэрчлэн тарчилж байна. Дайчид бие биеэ алж

цуцуалтгүй дайтахдаа өөрийн ба дайсныхаа нэр усыг чанга чанга дуудан зарлаж байна. Тулалдаанд учрахдаа тэд бие биеэ хараалын үгээр зүхэн загнаж эцэж цуцахыг мэдэхгүй тулалдана.

Курукшетрын дээгүүр үүл мэт тоос босч хамаг бүгдээрээ тулалдаанд холилдоод баатар эрчүүл бие биеэ аль хэдийнээ танихаа болиод галзуу мэтээр үзэлцэж байлаа. Хүн, морь, зааны хүүрээр боссон эрэг овооны дундуур цусан гол урсч, тас хяргуулсан толгойнууд усны замаг мэт хөвж байхад үс нь урсгал дагаад найгах нь голын замаг буюу хөвд шиг харагдана. Тэр цусан мөрөн, байлдагчдын сэтгэл зүрхэнэ айдас төрүүлэн үхлийн орон өөд урсч байхад тулалдааны талбарын эргэн тойронд хүүрээр амьдрагч араатан амьтад хөлхөлдөн, хон хэрээнүүд агаарт сүрэг сргээрээ нисэлдэн олз омгоо ажиглан харна.

Үй олон кшатра алагдсан тэр тулалдаан болж байхад Аржуна нумныхаа хөвчийг татах чимээ бусдаас гаргууд сонсогджээ. Аржуна дайсны цэргийн дотор дайран ороод самшаптак, кошал нарт асар их хохирол учруулж тэдний их тэргүүдийг онхолдуулан дайчин эрчүүлийг нь устгаж байлаа. Хатан зоригт Сушарман, Аржуны эсрэг гарч ирээд үй олон сум харваж сүхний ир шиг хурж нэг сумаар их тэргэн дээрх тугийг нь харавчихав. Тэгтэл Аржунын туг дээрх сармагчны дүрө гэнэт аймшигтай муухай орь дуу тавихад Карнагийн цэргүүд сандран балмагджээ.

Айж цочсондоо мөч нь татчихсан дайснууд руу Аржуна шууран дайраад үй олноор нь устгах нь Индра бурхан буг, чөтгөрүүдийг дайрахын адил бөлгөө. Санаагаар унаагүй байгсдын нэг нь болох Сушарман, өөрснийхөө цэргийг сүйрч байгааг хараад Пандугийн сүрт хүүгийн эсрэг халз тулаад гурван ч сумаараа хэнхдэг рүү нь онож харвав.

Аржуна тэсэхийн аргагүй өвдөж их тэрэгнийхээ ирмэг дээр унасхийн суув. “ Аржуна алдагдлаа!” гэсэн баярлан хашгиралдах дуун Каурынхны дотор гарч байлаа. Гэвч Пандугийн хүү сэхээ орж босоод тарни уншиж Индра бурхны илбэт мэсийг хэрэглэлээ. Юу юугүй мянга мянган сум нүүгэлтэж морьт явган цэрэг, заан, их тэргүүдийг устгаж эхлэв. Аржунагийн аймшигт мэсэнд хүйс тэмтрэгдэн буй самшаптакууд мянга түмээрээ үхэж байлаа. Гэвч тэд үхэх сэхэхээ үзнэ гэж нэгэн үзүүрт санаагаар тэвчээртэй тулалдаж байлаа.

Самшаптакууд алагдаж дүүрэх аюулд орсныг үзээд Крила, Критавагтан хоёр бас Каурынхны бусад дарга нар тэдэнд туслаар яаравчлан ирэв. Шикхандин,

зэвсгийнхээ цохилтыг Крипын өөдөөс хандуулж түүний давших замыг хааж эхлэв. Цэрэг дайны хэрэгт уран чадмаг болсон Крипа, дайсныхоо харвасан сумуудыг няцааж уур хилэн нь бадраад нүд ирмэхийн зуургүй түүний хөтчийг морьдных нь хамт үхтэл харваж, их тэргийг нь яйран болгов. Друпанын зоригт хүү их тэргэн дээрээсээ харайн бууж гартаа юлд бамбай барьсаар Крипагийн өөдөөс дайрсан боловч үй зайгүй нисэлдэн ирэх суманд хаагдан замынхаа дунд ирээд зогслоо. Дүүгийнхээ амь насны төлөө түгшин зовсон Дхриштадьюмна, Крипагийн нөгөө талаас шуурхайлан дайртал Крипаварман түүнд хориг тавьж халз тулалдах болгов. Бас Крипа руу дайрах гэж яравчлан явсан Юдхишхирагийн замд Ашваттахаман хөндөлдөн зогсож хаагаад Накула, Сахадева хоёрыг Дурйодхана, сринж, каруш, кейкай нарын цэргийн манлайд явсан Бхимасеныг Карна тус тус зогсоон байлджээ.

Энэ хооронд Крипа, Шикханданы зуун саран чимэгтэй хуягийг хараан урж тасчив. Хуяггүй болсон Шикхандин гартаа ганц юлд далайгаастай Крипыг дайрах нь улангассан амьтан үхлийн ам руу тэмүүлж буй мэт бөлгөө. Крипа түүнийгнам цохиж харахан амжаагүй байтал Читракетугин хүү Сукету гай гамшгийн хүрээлэнд орчхоод байсан Шикхандинд туслахаар яравчлан иржээ. Иймд Каурынхны хүчирхэг багш, Друпанын хүүг орхиод шинэ дайсантай нүүр учрав. Шикхандин ч ум хумгүй зугтаажээ. Ширүүн болсон энэ халз тулаанд Крипа, энэхүү хааны хүү Сукетуг гучин ширхэг хурц сумаар шархдуулжээ. Тэр сумнуудад шархадсан хаан хүү их тэргэн дээрээ унаад газар хөдлөхөд мод чичирдэг шиг дагжин чичирхийлж байлаа. Крипа, хутганы ир шиг хурц үзүүртэй сумаар Сукетугийн толгойг тас харвахад үнэт дуулгатайяа гялалзсаар газар унаж ш, их бие нь их тэрэгнийхээ ёроолд өнхрөн ойчжээ. Сукетугийн цэргүүд айн сүрдээд Крипагаас нүүр бууруулан зугтаажээ.

Энэ хооронд нум сум харвахдаа хэнийг ч урдаа гаргахгүй чадамгай Дронагийн хүү, Юдхишхирагийн зүг ерийн бороо адил үй олон сум харваж авай. Сатьяки, Драупанын таван хүү Юдхиштхирад туслаар ирээд зэр зэвсгээ бүгд Ашваттахаманы эсрэг чиглүүлсэн боловч тэдний хэн нь тэрхүү хатан зоригт дайчин эрийн хүч чадлыг дарах бүү хэл ганхуулж ч эс чадав. Ашваттахаман, засваргүй нүүгэлтэх үй олон гялалзах сум харваж тэнгэрийг бүдгэрүүлэхэд газар дээр өтгөн хар сүүдэр бууж байв. Тэр үүл мэт сумныхаа цаана Ашваттахаман өөрөө харагдахгүй болж байсан тул Сатьяки, Юдхиштхира, Сутасома болон Пандугийнхны бусад дайчид түүнийг харваж хөнөөх гэсэн нь талаар өнгөрч байжээ. Сутасомын гар дахь



нум, суманд харвуулж хоёр хэсэг болон унаж, Сатьякийн хөтөч алуулав. Жолоодох хүнгүй болсон морьд нь их тэргийг аваад талбар дээгүүр давхив. Ойд гарсан түймэр, хуурай өвс, сүрлийг хэрхэн шатаадаг вэ? Ашваттахаман сумнууд дайсны цэргийг яг тэр шиг устгана. Юдхиштхира уурандаа Дронагийн хүүд хандаж хашгирч хэлсэн нь: “ Ай, баатруудын доторх бар чи хэрэв намайг өнөөдөр хөнөөхийг хүсч буй бол чи нөхөрсөх, талархах гэдгийг нэг мөсөн үл мэдэгч хүн. Наманчилж, ариун судрыг уншина гэдэг чинь бярман хүний үүрэг байдаг юм. Кшатри хүн л тулалдаанд нум хөвчилбөөс зохих бөлгөө. Гэтэл чи бол бярман нэрнээс цаашгүй хүн. Ёс журмаа хамгийн их алдсан бярман чи, намайг хүч чадлыг чинь нуга дараад Каурынханд цохилт өгөхийг минь, гайгүй” гэв.

Дронагийн хүү инээмсэглэснээ Юдхиштхирад юу ч хэлсэнгүй, үг дуугүй байж байгаад хааныг дахин үерийн үүл мэт үй олон сумаар булж эхлэхэд Юдхиштхира ширүүн тулалдаанд тэвчин байж чадалгүй морьдоо эргүүлээд зайлан давхиулжээ. Талбарын нөгөө үзүүрт очиж тулалдаанд орсон боловч хүчирхэг Ашваттахамантай дахин учрахаас нэгэнт зайлсхийх болжээ. Карна Бхимасцнагийн дайралтыг няцаагаад панчалуудын цэрэг рүү дахин довтолжээ. Тэдний эгнээнд зүсэн ороод морьтой, явган цэргүүдийг устган, их тэрэг заанууд дээрээс дайсны цэргүүдийг унагаан олон мянгаар нь алав. Панчалын хамгийн дөмөг баатрууд түүнийг их тэргүүдээрээ бүслэн дарах гэж оролдсон нь бүтсэнгүй. Жиншу, Жиншукарман, Девапи, Читраюдха, Рочамана болон бусад олон хүн ялагдашгүй Карнагийн гарт амь алджээ. Түүний зам дээр тоо томшгүй олон цэрэг, агт морь, заануудын хүүр, эвдэрч хэмхэрсэн их тэргүүд хөглөрч байна. Карна, буга согооны сүрэг дотор орсон арслан мэтээр панчал, Сринж, чедийн цэргийн дотр туйлж байлаа. Арслангийн аманд өртсөн буга зайлбаргүй үхэж салдаг шиг, Карнагийн зам хаах гэсэн баатар эр бүхэн түүний гарт үхэж байлаа. Энэ хайр найргүй тулалдаанаас цорын ганц ч панчал хүн амьд гарахгүй нь ээ гэмээр болчихоод байлаа.

Энэ үед Аржуна Кришнад хандаж:

“ Васудевагийн хүү минь ээ! Би, Самшাপтак нарын хүчийг нэгэнт дарлаа. Дайснууд барснаас айсан марал гөрөөс аятай биднээс зугтааж байна. Энэ их тулалдаанд панчалын цэргүүд ч хүйс тэмтрүүлээ. Байлдааны зааны дүрс бүхий Карнагийн туг Юдхиштхирагийн цэргийн дотор байгааг олж харлаа. Манайхны хэн нь ч тэр дайсныг дийлж чадахгүй байна. Кришна минь Карна манай цэргийг хөнөөж байгаа

тэр газар тийш их тэргээ зал. Дайсны бусад баатар эрсийн хэнтэй ч байлдалгүйгээр би одоо ганц Карнатай туладахыг хүсч байна” гэв.

Тэгээд Аржуна өөрийн гялалзах их тэргэн дээрээ давриулан зам зуураасдайсны цэргийг устгахаар Карна руу довтолжээ. Дурйодхана, Самшаптак, камбожийн удирдагчид нь мянган их тэрэг, гурван зуун заан, нэг түм дөрвөн мянган морьт цэрэг, хорин түмэн явган цэргээр Кунтийн хүүг бүслэв. Аржуна орчлонг сүйтгэгч Шива бурхан шиг үлэмж их хилэгнэн самшаптакууд дээр үерийн бороо шиг үй түмэн сум буулгав. Түүний харвасан суманд нэвт сүлбүүлсэн толгой гараа тас хяргуулсан цэргүүд ундуй сундуй унаж, зэр зэвсгийнх нь цохиолтонд агт морьд аср том заанууд хэдэн зуугаараа хиарч байлаа. Нэг түмэн Самшаптак, хэдэн мянган камбож цэрэг түүнийгарт үрэгдэж, Камбожийн хаан Судакшин өөрөө байлдааны талбар дээр Аржунад цохиулан үхлээ олсон бөлгөө.

Курукшетрийн нэг өнцөгт тийнхүү Аржуна, Самшаптак нарын хүйс тэмтэрч байхад нөгөө нэг өнцөгт нь Карна, панчал нарыг хүйс тэмтэрч бас нэг газарт нь Бхимасена, Каурынхны цэргийг хиар цохин шахаж байжээ.

Панчалын цэргийг сөнөж дуусахаас аврах гэж Дхриштадьюмна маш олон шилдэг цэрэг дагуулсаар Карнаг уулгалан довтлов. Карна дайсны цэргийн дайралтыг, усны долгионд ажрахгүй байдаг хадан хясаа мэт гав ганцаараа өчүүхэн ч давхийлгүй угтав. Тэр тулалдаан маш ширүүн догшин болсон тул хажуугаас харсан хүний хуйхны үс зарсхийн босч байжээ. Карна, Пандугийнхны цэргүүдтэй тийнхүү тулалдахдаа хорт могой шиг хөнөөлт сумнуудаараа дайсныг шүршиж үхлийн оронд тонилогчдын тоог үлэмж их нэмэгдүүлсэн байна. Цусандаа бялдаж агсан Дххриштадьюмнад Сатьяки туслаар ирж Друпанын хүү рүү Карнагийн онилон тавьсан хөнөөлт цохилтыг сумаараа няцаав. Карна зэвсгийнхээ үзүүрийг Сатькийн эсрэг чиглүүлж байх тэр цагт эцгийнхээ нас барах өдөр өшөөг нь авахаар өгсөн тангарагаа биелүүлэхийн мун болж байсан Ашваттахаман, Дхриштадьюмнаг довтлон дайрав.

“ Зогс зогс, бярманыг алагч чи өнөөдөр надаас амь салахгүй!” гэж Ашваттахаман бачуу хашгирахад Дхриштадьюмнагийн таван сүнс зайлах дөхөв. Гэвч байлдаанд халдашгүй өөрийн чанарт найдан, Дронагийн хүүгийн довтолгооныг тэвчээртэй угтав. Ашваттахаманы харавсан сум Дхриштадьюмнагийн хөтөч морьдын нүд ирмэхийн зуурдгүй устгаад нумыг нь хуга, тугийг нь навс, их тэргийг

нь яйран байж очинов. Пандугийнхны эзэнтэн юлд, бамбай барин явгаар тулалдаанаа үргэлжлүүлэн байсан боловч Ашваттахаман, тэр зэвсгийг нь харван устгаад их тэргээрээ түүнийг жигд жийгүүлэх нь эгээ л гарьд шувуу тэнгэрээс газар руу халин нисэх мэт бөлгөө.

“ Ашваттахаман, Дхириштадьюмана рүү хуй салхи шиг хурдан дайрч байгааг нь хараач, Пандугийн хүүг алах нь дээ!” гэж Кришна, Аржунад хэд Друпадын хүүг үхлийн савраас аврагтун, Аржуна минь” гэв. Аржунагийн их тэрэг нисэх адил хурдалсаар очлоо. Кунтийн хүүгийн харавсан алтан өдөт сумнууд ч шоргоолжны үүр рүү шурган орж байгаа могой мэтээр Ашваттахаманы биед гүнзгий сүлбэн оров. Ашваттахаман, Дхириштадьюмнаг гүйцээгүй байсан боловч Аржунагийн эсрэг үзэлцэхээс аргагүй байжээ. Энэ хооронд хатан зоригт Сахадева хунтайжийг их тэргэндээ суулгаж аваад аюулгүй газар давхиулан одов. Аржуна, Ашваттахаманы суманд хэнхдэг мөрөөрөө шархадсан боловч жишим сумаар харвахад цаадах нь их тэргэнийхээ ирмэг дээр унаад ухаан алджээ. Хөтөч нь бушуухан морьдоо эргүүлээд дайны талбараас эзнээ авч зайлав.

Каурынхны цэрэг нэг талд Аржунад шахагдаж, нөгөө талынхан зоригт Бхимасенад шахагдан ухарч эхэлжээ. Ийм болмогц Карна чанга чанга уриа хашгиран цэргүүдийнхээ хийморийг сэргээж Пандугийнхны эсрэг тулалдаанд ороход бусад хүчирхэг баатар эрчүүл, түүний шадар хойноос нь дагалдан орлоо. Хоёр этгээдийн эрэлхэг дайчид тэр тулалдаанд уулзалдав. Шикхандин Карнатай, Дхириштадьюмна Духшасанатай, Юдхиштхира Читрасенатай, Сахадева Улукатай, Сатьяки тус тус байлдав. Аржуна, Бхимасена хоёр Дурйодхана тэргүүтэй Дхириштараширагийн хүүхдүүдийн эсрэг тулалджээ.

Бхишмаг ялагчийн жигүүрт суманд хорлогдож байсан хүчирхэг Карна, дайсныхаа морьд, хөтчийг догшноор устгаж, тугийг нь их тэргэн дээрээс нь унагав. Шикхандин, их тэргэн дээрээсээ үсрэн буугаад хануур жад шидсэн боловч түүнийг нь Карна нисэлт дунд нь харавчихлаа. Тэгээд Шикхандин нарны хүүгийн хөнөөлт сумнуудаас бултан зайлсаар ум хумгүй зугтан одов. Духшасана ухаан бодол зориг самбаатай тулалдаж панчал нарын удирдагчийг олон дахиж шархдуулан ухрахад хүргэв. Хэрцгий догшин арслан л тиймэрхүү шийдсэн дайралтаар зааныг замаасаа зайлуулдаг ажээ. Панчан нар хаан, их тэргээр дайран ирж удирдагчийгаа аврахаар яаравчлаад Духшасанын цохилтоос түүнийгээ хаацайлж амжив.

Энэ хооронд Сахадева, Улукаг бут цохиж ухруулахад тригартын цэргийн нөмөрт хоргодов. Сатъяки, Шакуний хөтөч ба морьдыг алаад нь хэмх хэмх харважээ. Шархадсан Шакуни Улукийн их тэргэнд гарч суухад эцгийгээ дайсны сумнаас авран шалавхан зайлав.

Дурйодхана, догшин хүчит Бхимасенын дайралтыг зогсоох гээд дэмий л мунгинана. Бхимасена, түүнийг морьд их тэрэгнээс нь гурван удаа хагацаахад Каурынхний эзэн хаан гурван удаа их тэрэг сольж тулалдаанаа үргэлжлүүлж байлаа. Духшасана, заантай их цэрэг дагуулан Дурйодханад туслаар ирсэн боловч Бхимасена заанууд руу агуу их догшноор дайрах нь Индра оурхан чөтгөрүүдийг дайрах лугаа адил байсан бөгөөд дайсны бузар олон цэргийг салхи үүлийг замхран хөөх адил сарниав.

Бхимассены харавсан сумнуудад шархадсан асар том заанууд уул өөрөө хөдөлж буй мэтээр ийш тийш эмх замбараагүй санд мэнд, онгойж харласан задгай шархнуудаа цус урсгасаар гүйлдэж дээрээ суусан хүмүүсийнхээ хамтаар хэдэн зуугаараа газар үхэдхийн ойчиж байв. Карна, Шикхандиныг ялаад Юдхиштхирагийн эсрэг эргэжээ. Нарны хүүгийн үерийн бороо адил суманд Юдхиштрагийн цэрэг эргэн зугтаав. Карнагийн харвасан сум дайсны цэрэг дээр тасралтгүй үер мэтээр бууж байсан бөгөөд сүүлчийн тавьсан сумных нь хошуу түрүүчийн сумныхаа өлөнд шүргэж байв. Тэр гялалзан нисэх урсгал нь ертөнцийг сөнөхөд орчлонг сүйлдэлж буй түймэр шиг харагдана. Пандугийнхны цэргийн дотор айж тэвдсэн, зовж тасалсан их дуун дэгдэв. Каурынхны хийморь нь Карнагийн сүр чадалд сэргээд ухарч буй дайсны араас шууран гарч байлаа.

Карна болоод Каурынхны эсрэг Юдхиштхира зэвсгээ далайж цэргээ хүйс тэмтрэгдэхээс хаацайлав. Түүний тавьсан сумууд давшиж буй дайсанд багагүй хохирол учруулах боловч улайрсан Карна, Юдхиштхирагийн их тэргэнд дөхөж ирээд түүний гар дахь нумыг хугалж гурван хурц сумаар цээж рүү нь харваж онов. Карнагийн хүнд шархдуулсан Пандугийнхны эзэн хаан их тэрэгнийхээ ирмэг дээр лагхийн суугаад ухрахыг хөтөндөө тушаалаа. Юдхиштхирагийн их тэрэг зайлан зугтаахад Каурынхан “Бариарай бариарай” гэж хашгиралдан араас нь туулаа. Кекай нарын цэргээс хоёр мянган шилдэг цэрэг тэдний замыг хааж хааныхаа ухралтыг аюулгүй болгожээ.

Гэтэл Карна, Кекайн цэргийн өмнөөс үерийн бороо мэт нүүлгэж гагц агшны дотор хэдэн зууг нь үхлийн оронд тонилгожээ. Накула, Сахадева хоёр, их ахынхаа амь насыг аврах гэж Карнагийн замыг тосов. Нарны хүү тэднийг сумаараа булж Юдхишхираг үлдэн хөөсөөр байна. Карна, Пандавын эзэн хаантны толгой дээрх үнэ ихт малгайг харван унагаж, дөрвөн сумаараа морьдыг нь намнаад аргагүй зогсоож авав. Дараа нь бас дөрвөн сум тавьж Накулагийн их тэргэнд хөллөөстэй дөрвөн морийг нь намналаа.

Хоёр ач дүү нь дайсны эрхэнд хоёул орсныг тэдний нагац ах Шалья харж дотроо зовсондоо Карнад: “Баатар эр чи, Аржунатай уёран тулалдах хүслээ мартжээ! Морьд чиньядарч, сум чинь барагдаж байна. Чи өөр дайснуудтай тулалдаж тамираа барчихаад Аржунын өмнө тэсэхгүй дээ! гэхэд Карна инээмсэглэснээ Шальягийн үгэнд оролгүйгээр Юдхишхирагийн зүг сум нүүлгэсээр байлаа. Гэтэл мадр нарын хаан: “Хүүе, хөтчийн хүү, хараач! Хүч ихт Бимасена манай цэргийг сарниачихад Дурйодханаг сүйд хийх гэж байна! Дхрихараштрын жавхлант хүүг их аюул нөмөрлөө. Хэрэв чи түүнийг алуулахыг дурлаагүй бол нэн даруй очиж тусла!” гэж хашгирав. Карна, энэ үгийг сонсч, тэр аймшигт тулалдаанд Бхимасена Дурйодханыг дийлж байгааг өөрөө хараад ихэр хоёрыг болон Юдхишхираг орхин, Дхритараштрагийн хүүд туслахаар цахилав. Накула, Сахадева хоёрт: “Та хоёр дайны талбар өөд бушуухан буцаж Бхимасенад тусла!” гэхэд ах, дүү хоёр түүний зарлигийг дагав.

Дайсныг хүчирхгээр сөнөөгч Бхимасена, Аржуна хоёрын цохилтонд Каурынхан тулалдаанд талбараас зугтан зайлав. Карна: “Зогсоод, зогсоод!” гэж хичнээн хашгиравч тус болсонгүй. Ялгуусан Пандугийнханд хөөгдөж буй цэргүүд нь энд тэндгүй зугтаасаар байлаа. “Карна минь хараач, чамайг энд байлаа ч тусгүй, манай цэргийн ухарч байгааг! Пандугийнханд хядагдаж байгаа манай цэргүү ганц чамд л горьдож байна, дайсныг залаагч минь! Ганц чамд бид горьдох байна” гэв.

Карна ч, Мадрын хааныг их тэргээ тулалдаанд оруул гэж зарлиг болгов. Карна, ид шидэт зэвсгээ тарнидаад үүл мэт нүүлгэх тоо тоймгүй хөнөөлт сумыг дайсан руу харавсан суманд газар доргиж, Пандугийнхны цэрэг нэлэнхүйдээ тэвдэж эхэлжээ. Талын дээгүүр айж бачимдсан хүмүүсийн орь дуу тархаж байгааорчлонг сөнөөхийн тулд амьд голтой бүхний орилох хашгирах чимээ мэт ажээ. Айсандаа ухаан алдах дөхсөн цэргүүд ухран зугтааж Аржунаг аюулаас аварч аль хэмээн залбиран гуйцгааж байлаа.

Аржуна, тэр их орь дуу чимээг сонсч, Карнагийн зэвсэг цэргүүдийн зүрхийг хэрхэн үхүүлж байгааг хараад Кришнад: “ Кришна минь, чи энэ баатрын урд хожид байгаагүй эрэлхэг гавьяаг харж байна уу? Орчлонг сүйтгэгчтэй адил тэр, гялалзах их тэргэн дээрээ морилоод над руу хилэнтэй харцаа чиглүүлэн талын дундуур давхиулж байна. Би ямар болтугай, үхэгдсэн үү, сэхэгдсэн үү, тулалдахад тэрнээс хэрхэнч ухрахгүй” гэв.

“ Карнатай тулалдахын урд чи Юдхиштхиратай уулзах хэрэгтэй. Түүнийг хөтчийн хүү даанч сүрхий шархдуулжээ. Ахынхаа сэтгэлийг засаад дараа нь Карнатай үзэлц алсугай!” гэж Кришна хариу хэлжээ. Аржуна, Юдхиштхираг олж үзэх гэж эргэн тойрон харсан боловч дайны талбар хаана ч Пандугийнхны эзэн хаан алга байлаа.

Тэгэхлээр нь Аржуна, Бхимасенад дөхж очоод: “ Хаан маань хаана байна?” гэх Бхимасена “ Хаан, тулалдааны талбарыг орхиж явсан. Бие нь Карнагийн суманд сүлбүүлэн сэглэгджээ. Одоо амьд уу, үхсэн үү, бүү мэд” гэлээ. “ Хуаран руу очоод ахын минь тухай мэдээд ир!” гэж Аржуна дуу алдахад Бхимасена татгалзаж. “ Тулалдаан болохын өмнө дайны талбарыг намайг орхилоо гэж баатрууд маань хэлэхгүй байг, Аржуна минь өөрөө яв. Би чамайг буцаж иртэл дайснуудтай чинь үзэлцэж байя” гэлээ.

Аржунагийн их тэргийг хуаранд ойртон ирж байхыг Юдхиштхира хараад Карна алагдсан байна гэж итгэн орон дээрээ өндийж суугаад Кришна, дүү хоёртоо баярлан талархаж: “ Та хоёул, Карнаг дийлэх мөртөө эсэн мэнд явна. Би тулалдаанд дийлдэж шившгээ тарьснаа бодохоос гутраад байж чадахгүй байлаа. Тэр ер нь үхлийн бурхантай адил хүн байсан юм.

Аржуна минь, чи түүнийг яаж байгаад алчихав, ярьж аль” гэв. “ Би Дронагийн хүү тулалдаад дийлсэн. Харин манай цэргийг устгаж буй Карнатай учрахын урьд чамтай уулзахыг би хүссэн юм. Намайг адислаж, ялалт хийг гэж ерөөгтүн” гэж Аржуна хэллээ.

Карна амьд байгаа гэдгийг Пандугийнхны эзэн хаан сонсоод ихэд уурсч : Миний цэрэг шившигтэйгээр ухарсан байхад, чи хөтчийн хүүтэй учрахаас зайлсхийн Бхимасеныг орхин наашаа иржээ. Чи чинь Карнатай халз тулаад алчихна гэж хичнээн ч удаа амлалаа. Бид ч чамд найдаад хичнээн ч залбирч байна!

Чамайг би Карнагаас хулчийгаад тулалдааны талбараас зугтаах юм гэж хэзээ ч бодоогүй. Дурйодхана биднийг дийлнэ гэж би хэзээ ч бодоогүй! Яая гэхэв, хэрэв чи айж байгаа бол Гандива-нумаа Кришнад өгөөд өөрөө хөтөч нь бол, эсхүл Карнагаас хулчийхгүй өөр хэн нэгэнд зэвсгээ өг!” гэв.

Аржуна, уурласан могой мэт амьсгаа давхцан юлдээ суга татаж гаргаж Юдхиштхирагийн толгой дээр далайж: “ Нумаа бусдад өг”над гэж хэлсэн хүний толгойг бас тас чавчих тангараг өргөсөн хүн” гэлээ. Кришна түүнийг ятгаж арайхийн уур хилэнг нь дарж, далайсан гарыг нь буулгав, “ Хаантан минь, намайг хулчгар гэж зэмлэх нь чи бишээ. Дайсны цэргийг хийр цохиж байгаа Бхимасена намайг зэмлэвэл зэмлэж болох л байсан . Харин байлдааны талбараас хоёр йожин газар байгаа чи ингэх ёсгүй. Чи аман дээрээ зоригтойгоос биш, ачир дээрээ үгүй шүү дээ. Тэгээд л чи намайг өөртэйгөө адил гэж бодох байх. Ер нь тоглоомны гайд ийм их уначисан хүний мэдэлд их гүрэн улсыг өгнө гэж олигтой юм болоо ч уу, үгүй ч үү, би мэдэхгүй байна. Хаантан минь, чи бол бидний хамаг гай зовлонгийн шалтгаан болсон хүн шүү. Чи л даалуу мөрийцөж тоглож хожигдоод, дүү нарынхаа гараар олж авсан хамаг юмыг алдсан шүү дээ. Чамаас болж энэ хөнөөлт дайн шатаад байна. Тэгээд бас бид чиний төлөө ялах ёстой болоод байгаа хэрэг. Ийм учраас чи биднийг хатуу үгээр бүү дайр, бидний уур хилэнг бүү хүргэ!” гэж Аржуна, Юдхиштхирад хэлэв. Аржуна ингэж хэлээд уйд дарагдан юлдээ хуйлаад нумаа газар шидчихэв. Түүний уур хилэн намдаж, хийсэн нүгэлдээ гэмшээд толгой унжуулан зогслоо. Тэгснээ хоёр гараа хавсраад Юдхиштхирад ойртон очиж хэлсэн нь “ Хаантан минь намайг өршөө, тайвширч үз. Би Бхишмасенад тулсан, хөтчийн хүүг алахын учир тулалдааны талбар өөд буцъя. Миний амь нас чиний л төлөө зориулагдана гэдгийг үнэн голоосоо би хэлье!” гэлээ. Юдхиштхира орноосоо өндийж босоод: “ Аржуна минь, би базаахгүй юм хийсэн хүн. Түүнээс болоод та нарт айхтар гай дайрсан юм! Миний толгойг тас огтло! Би бол хамгийн өөдгүй хүмүүсийн нэг өөрийнхөө овгийг хөнөөгч, залхуу, хулчгар амьтан! Би, бүр өнөөдөртөө зайлж бүх насаа ойд өнгөөрнө. Надгүйгээр аз жаргалтай амьдарцгаагаарай. Бхимасена хаан тань болог!

Ингэж доромжлуулчихаад миний амьд явах хэрэг ч юу билээ!” гэв. Тэгээд Юдхиштхира нэн даруй хуарангаас зайлахыг завдсан боловч Кришна түүнийг тогтоож Аржуныг уучлахыг гуйлаа. “Бид хоёрыг өршөөж үз. Өнөөдөр, чиний үхлийг нь хүсээд байгаа хүн чинь үхнэ гэж би чамд амлая. Өнөөдөр хөтчийн гайт хүүгийн цусанд газар дэлхий ханах болно!” гэж Кришна хэллээ. Кришнагийн ятгалаар ах дүү

хоёр эвдлэрчээ. Аржуна, Юдхиштхирагийн өмнө мэхийн суугаад ахынхаа хөлийг гараараа барьж, өршөөхийг дахин гуйлаа. Юдхиштхира, түүнийг босгож: “Аржуна минь, чи намайг ихэд хүндэллээ. Одоо яв, ялалт чинийх болно!” гэж хэлэв.

Энэ хооронд Бхимасена тоогүй олон дайсанд бүслүүлээд, зүг бүрээсээ дайрч байгаа Каурав нарыг няцаан амь нас хайрангүй тулалдаж байлаа. Шувуунууд өнчин ганц мод руу мөчир дээр нь сууж амрах санаатай бүгдээр тэмүүлж байгаа аятай Дурйодханы цэргүүд Бхимасена руу сум, жад нүүлгэсээр түүний зүг тал бүрээс нь зүтгэж байна.

“Вишока!” гэж Бхимасена хөтчөө дуудаад: - “миний их тэрэгний хавьцаа манай цэрэг ерөөс үзэгдэхээ болив. Миний эргэн тойрон дандаан дайснууд байна. Аржуна ч над туслахаар ирэхгүй байна. Ариун шударга Юдхиштхира амьд уу, үхсэн үү, мэдэх юм над адга, дотор минь их гонсгор байна!” гэхэд хөтөч нь – “Хараач! Дайсны их тэрэгнүүдийн туг хирууд далбилзаж байгааг олж үзэхгүй байна гэж үү? Тэдний их тэрэг, заан, морьтой, явган цэргүүд ундуй сундуй ухран бужигнаж байгааг олж харахгүй байна гэж үү? Сармагчны дүрстэй туг сэтгэл зүрхийг нь үхүүлсээр гарч ирлээ” гэв.

Аржуна, нүүгэлтсэн олон сумаараа тэнгэрийг харанхуйлсаар Бхимасеннад туслаар ирж байна. Каурынхны цэргийн хүчит баатар Крипа, Критаварман, Ашваттахаман болон бусад хүмүүс түүнийг зогсоох гэж оролдоод дэмий байлаа. Түүний зэр зэвсгэнд цохиулан хөтөч морь, их тэргүүдээсээ хагацсан тэд Аржунын мөр дээрээс зайлан ээлж дараагаараа зугтааж байв. Аржунын харавсан сумнууд үхэл авчрагч сүрэг шувууд мэтээр тэнгэрт нисч газрыг сүүдэрлээд курукшетрийг үхлийн бурхны эдлэнтэй адил болгож байлаа. Аржуна, дайсны цэргийг устгаж одоог хүртэл үзэгдээгүй үлэмжийн их цус урсгав.

“Дэлхий дээр тийт дайчин эр хараахан төрөөгүй юмаа. Түүний гар чичрэхийг мэдэхгүй, харваад алдана гэж байхгүй. Одоо удаж болохгүй боллоо. Түүний ер бишийн сүйтгэлийг харахаас зүрхэнд минь шар ус хурж байгаа ч гэсэн би түүнтэй үзэлцэнэ. Өнөөдөр бид хоёрын нэг маань үхлийн оронд тонилно. Мадрын хаантан минь, их тэргээ түүн тийш зал” гэж Карна, Аржунын баатарлаг гавьяаг хараад хэлжээ.

Аржуна, Бхимасеныг тэвдүүлж байсан дайснуудыг хөөн сарнийгаад уул овоо шиг болсон ххүр, эвдэрсэн их тэрэгнүүдийн дотуур арайхийн туучуулсаар түүнд дөхөж



очлоо. Юдхиштира амьд, биенээс нь сумнуудыг салгаж авсан байна гэдгийг Бхимасенад мэдэгдээд тулалдан байгаа хүмүүсийн дотор Карнаг хайсаар урагш тэмүүлэн явж байна. Харин Бхимасена өөрийн их тэрэгтэйгээ хойноос нь дагаж ар талыг нь хамгаалж явав. Дхриштараштрагийн алтан хуяг дуулгатай арван хүү Аржунын замыг хаах хэмээн довтлон ирэхэд Аржуна тэднийг нэвт нэвт харван бүгдийг үхлийн оронд тонилгож орхив. Самшаптакийн хүчирхэг ерэн баатарзүүн талаас их тэргээр давхилдан ирж довтолсон боловч Кунтийн хүү тэднийг зэр зэвсгээрэ хөтөч морьд юутай хүйтэй нь хүйс тэмтрэв. Кришна их тэргийг нь бараг зогсоолгүй давхиулсаар байна. Духшасена заан унасан мянга гурван зуун млеччи нарыг удирдан Аржуныг баруун талаас нь шууран дайрч сум, жадаа нүүлгэж эхлэв. Аржуна, тэдний өөдөөс эргэж зэвсгийнхээ хөнөөлт сумуудаар дайралтыг нь няцаагаад байхад Бхимасена дүүдээ туслаар ирээд Млеччи нарын цэргийг үлэмж ихээр усгав.

Энэ үед Карна, замдаа тааралдсан панчал нарын цэргийг шуурга адилаар дайран устгасаар Аржунад ойртон ирж байв.

Карна, замд нь хөндөлсөхийг оролдсон Дхриштадьюмна, Сатьяки хоёрын их тэргүүдийг бут ниргээд, Кекай нарын хааны хүү Вишоуг алж, гурван сумаар Кекай нарын удирдагч Угракарманугийн хоёр гар, тэргүүн гурвыг тас харван, Шикхандин, Сутасома хоёрыг хүндээр шархдуулав. Карнагийн гарт панчал, Кекүай нарын олон дайчин эр амь алдсан бөгөөд түүний хойноос их тэрэгтэйгээ дагаж явсан Дурйодхана, Крипа, Критаварман гурав ч дахин өгүүлэв.

Аржуна, Карнаг угтан тэмүүлж байх хооронд Бхимасена Пандугийнхны замд саад болж буй Млеччи нар болон тэдний заануудыг устгахаарбаылаа. Духшасана, түүн рүү аймшиггүйгээр дайрч нумаараа үй олон сум нүүлгэв. Бхимасена ч бугыг дайрч буй арслан мэтээр Дхритараштрагийн тугийг их тэргэн дэрээс нь харван сүлбэж, өөрийн нь толгойг үлэмж хүнд шархдуулав.

Духшасана, нэг гараараа жолоогоо шүүрэн барьж нөгөөгөөрөө Индра бурхны очир шиг дийлдэшгүй хүнд жад шидлээ. Тэр жад Бхимасены биеийг нэвт сүлбэн гарч газар шааж байхад Пандугийн хүү их тэрэгнийхээ суудлын ёроолд ухаан алдан ойчив. Гэвч ухаан ороод уур хилэн нь шатаж: “ Чи намайг шархдуулж хөнөөлөө. Одоо миний ээлж болсон өнөөдөр би андгайгаа биелүүлнэ. Чамайг юу ч аврахаасаа өнгөрсөн!” гэж хэлээд халз тулаанаа үргэлжлүүлэв. Духшасана, Бхимасенын бүх

сум, жадны дайралтыг няцаахад Пандугийн хилэгнэсэн хүү ер бишийн шийдэм тэргэн дээгүүрээ өргөж хамаг хүчээ тарган дайсан руугаа шидлээ. Духшасана тэр асар том мэсэнд толгойгоороо гэмтэж их тэргэн дээрээсээ тээр хол шидэгдэн унаж салгана таталдаж байлаа. Бхимасена, газар нэгэнт тарайн хэвтэж буй Духшасанагийн дэргэд очиж их тэргэн дээрээсээ үсрэн буугаад юлдээ хуйнаас нь гаргалаа. Тэгснээ Духшасананийн хоолой дээр гишгэж юлдээ цээж рүү нь шаагаад нэгэн сахилыг гүйцэтгэж биед нь наалдаж, үхлийн шархнаас нь годгодох цусыг ханатлаа уув. “Эхийн минь цагаан сүү ч, бал бурам ч дарс нанчид ч дайсны маань цуснаас амттай байсангүй!” гэж Бхимасена чанга хашгирав. Тэгээд үхсэн биеийг нь хараад инээд алдан: “Одоо би чамайг яах билээ? Үхэл л чамайг миний гараас мулталж авлаа.” гэж хэлжээ.

Дайсныхаа цусанд бялдсан Бхимасенаг харсан олон цэрэг учиргүй их айж зарим нь тамир алдарсан гараасаа зэвсгээ алдаж байхад зарим нь шурган ухаж байлаа. Цэргүүд айн сүрдсэндээ ба зэвүүрхсэндээ Бхимасенагийн байсан газраас зайлж бие биедээ “Энэ чинь хүн биш, лагшас болох нь эргэлзээ алга” гэлцэж байлаа.

Нишангиа тэргүүтэй Дхриштараштрагийн арван хүү, төрсөн дүүгийнхээ өсийг Бхимасенагаас авахыг шүд зуун хүсэхдээ түүнийг дайрч эхлэв. Гэтэл Аржуна, Бхимасенад туслахаар яаравчлан ирж алтан өдөт сумаараа арвууланг үхлийн оронд тонилгов. Хааны зоригт хөвгүүд тийнхүү амь алдмагц Каурынхны цэрэг Пандугийн хөвгүүдийн хүч чадлаас сүрдэн айгаад тулалдааны талбарыг орхин зугтаав. Дурйодхана, хатан зоригт Духшасанагийн амь алдсанд гаслан бүр унжийж хоцорчээ. Крипа болон бусад хаад тулалдааны талбарыг орхив. Тэдний уй гашуу нь уур хилэнгээс нь илүү болсон хэрэг ажээ.

Ганц Карна л тулалдааны газар үлдээд Аржунатай үхэх сэхэхийнхээ байлдаан хийхээр тэмүүлнэ. “Агуу их баатар эр, их тэргээ мадр нарын хаанаар жолоодуулсаар бидэнд дөхөн ирж байна. Панчалын цэргүүд түүний барааг хармагцаа уурссан арслангийн бараа харсан сүрэг буга шиг зугатааж байна. Пандугийн хүү минь одоо хамаг зориг хүчээ гарга. Хөтчийн хүүгийн эсрэг одоо чамаас өөр эсрэгцэн үзэх хүн үгүй. Индра бурхан Намучи чөтгөрийг яаж алсан, түүнийг чи тэгж ал, тэгэхдээ асар их болгоомжтой тулалд” гэж Кришна Аржунад хэллээ. Аржуна хариу өчихдөө: “Би түүнийг алья. Кришна минь мориндоо ташуур өг. Цаг нь болсон байна” гэв. Хоёр баатар эрийн их тэргүүд ч хоорондоо ойртож ирлээ.

Ээрэм их талын дунд тэр их агуу дайчин хоёр эрийг тэнгэрт гялалзах хоёр наран мэтэр гарч ирэхэд энд тулааныг үзсэн хаадын зүрх бахдах сэтгэлээр дүүрчээ. Хоёр талаас дайчин уриа чанга чангаар хашгирч бүрээ бөмбөг нижигнэж эхэллээ. Цэрэг бүхэн өөрийнхөө баатрын урам зоригийг хөгжөөхийг хүснэ. Хүч чадал зориг зүрхээрээ тэнцүү тэр хоёрын аль нь дийлэхийг хэн ч хэлж чадахгүй байлаа.

Хүмүүс, бурхад, чөтгөрүүд ер газар ба тэнгэрийн амьд амьтан бүхэн сэтгэл донсолжээ. Орчлон хоёр хэсэг хуваагдаж нэг хэсэг нь Аржунаг нөгөө хэсэг нь Карнаг дийлээсэй гэж хүсэж байна. Тэнгэрийн од гарагууд Карна ялаасай гэж байхад дэлхий, гол мөрөн, нуур, уулс, ой тайга, тал цайдам газрууд Аржуны талд оржээ. Дээд тивийн чөтгөрүүд болон бусад чөтгөр шулмасууд Карнагийн талд орж байхад доод тивийн Тагшака болон бусад аварга могойнууд Пандугийн хүүгийн талд оржээ. Карнагийн талд рагшас болон далайн мангасууд ороход Аржунын талд чоно, зэрлэг буга согоо, ой тайгын бусад амьтад оржээ. Түүний талд Индра тэргүүтэй бурхад байхад гагцхүү нарны бурхад Карнагийн талд байв. Вайши, шүдрэн, харцас, холимог омгууд Карнад ялалтыг ерөөж байхад бярман, Кшатри нар Аржунад ялалтыг ерөөж байлаа.

Бурхад, чөтгөр шулмас, сиддхи, ганхардва, апсар, рагшас, хүмүүс, адгуус амьтад, жигүүртэн шувууд, газар тэнгэр ер нь бүр орчлонгоороо Аржуна, Карна хоёрын тулалдааны гэрч болжээ. Амьгүй болсон бие цогцсоор хучигдаж, цусанд норсон ээрэм талын хоёр талаар урьд хожид үзэгдээгүй тэр, Каурынхан, пандугийнхны халз тулааныг ажиглан мянга түмээрээ багшралдан зогсжээ. Хоёр талаас үүл мэт нүүгэлтэх үй олон сум харвав. Тэр сумнуудад өдрийн гэрэл бүдгэрч, хоёр баатрын тулалдаж буй газраас хоёр этгээдийн цэрэг үхлийн тэр сумнуудад үрэгдэхээс зүрхшин зайлцгаав.

Аржунын харвасан сумууд Карнагийнхтай нислэг дундаа мөргөлдөх нь өрнө зүгийн салхи дорнынхтой мөргөлдөх лүгээ адил бөлгөө. Дурйодхана, Критаварман, Крипа гурав Карнад туслахаар ирэх боловч дэмий байлаа. Аржунын тавих сумнууд тасалдахгүй урсгал мэт асгаран буух тул тэд ухарчээ. Пандугийнхны баатрууд ч, Аржунагийн бусад нь Карнагийн харвах сумнаас зугтаан ухарч байлаа.

Энэ үед Аржунын толгой дээр тэнгэрээс цэцгэн бороо орж бурхдын айлтгал ерөөл бууж буйг харуулав. Хоёр талын цэргүүд чангаар хашгиралдав. Бүрээ хэнгэрэгийн дуу чимээ талаар дүүрч газар дэлхийг донсолгоно. Аржуна, Карна

хоёрын их тэргүүд хоорондоо ойртоход хоёр талаас нүүлгэх урсгал мэт сумнууд улам багшран өтгөрнө. Карна, Аржунын бүх цохилтыг няцаан Пандугийнхны цэрэг рүү устгагч сумуудаа онилон тавьсаар маш их гарз учруулж байна. Тэгэхэд нь Бхимасена уур хилэн бадарч тачьяадан хашгирч Аржунад хэлэхдээ: “Буянт хүний замыг орхисон, хөтчийн золигийн хүү чиний нүдэн дээр ийм олон баатрыг хядана гэсэн чинь юу гэсэн хэрэг вэ? Тэр чиний цохиолт бүхний чинь няцааж байна.

Пандугийн хүү чи, энэ тулалдаанд түүнийг хайрлаж яаж болох вэ? Хамаг хүч чадал, зориг зүрхээ гаргах цаг чинь болжээ. Үгүй бол дайсан чамайг дийллээ! гэжээ. Бас Кришна: “Хүч тэнхээ, оюун ухаан чинь алдраа юу эсхүл Карнагийн ард нуугдсан Каурынхан бүр оодрон баярлацгааж байна. Хамаг эрэлхэг зоригоо гаргаж хөтчийн хүүг устгах цаг чинь болжээ!” гэж Аржунад хэллээ.

Аржуна илбэт зэвсгээ шившин тарнидаад Карнагийн их тэргийн зүг орчлонг сүүлчийнх нь өдөр устгасан галт лав мэт үй түмэн сум, жад, хануур жад тасралтгүй шууран урсч эхлэв. Тэр үерийн бороо мэт буух аймшигт сумнуудад Карна огт ажралгүй харин ч арслан архирах адилаар дайчин үг хэлээд Аржуна, Кришна хоёрыг тус бүр гурван сумаар онож, их тэрэгнээс нь холоо байсан дайсныхаа олон баатруудыг оножээ.

Аржуна, Карна хоёрын халз тулааныг үзэх гэж Юдхиштхира хаан ч өөрөө алтан хуяг дуулгаа өмсчихөөд дайны талбар дээр дахин хүрч иржээ. Энэ үед Аржуна хүч ихт дайснаа дарах гэж хамаг хүчээ хөвчилтөл тэр хүчдэлээс нь болж Гандива нумных нь хөвч аянга мэт дуутайгаар тасарчихлаа.

Аржунын зүгээс ирж байсан урсгал мэт сум зогсох хооронд Карна Кришнаг олон хурц жадаар шархдуулж, дайсныхаа цэргийг маш их сүйтгэлээ. Карна, гурваг гайт сумаар Пандугийн хүүг онож, бас тийм таван сумаар хөтчийг нь онолоо. Нисэх могой шиг тэр найман сум Аржуна, Кришна хоёрын биеэр нэвт гараад Карнагийн саадагт буцаж очиж байв.

Гэвч Аржуна, нумныхаа хөвчийг хийж амжлаа. Карнагийн аймшигт сумнуудад хүнд шархадсан Кришнаг Аржуна хараад хилэн бадарч дайсныхаа зүг үхлийн, сум үер мэт дахин буулгав. Пандугийн хүүгийн мэсэнд шархадсан Карна цус савируулан тэвдээд, гагцхүү хамаг зориг зүрхээ шавхан дайчилсны үрээр тэргэн дээрээсээ эгээ л ойчсонгүй өнгөрлөө. Тэр хооронд нь Аржуна дайсны асар олон

баатрыг устгахад Каурынхан Карнаг дахин дайны талбар дээр ганцааранг орхиод зугтаав.

Хамаг газар нэлдээ Аржуна, Карна хоёр сумаар дүүрч ер хөл тавих газар үлдээгүй юм шиг санагдаж байлаа.

Тулалдааныг холоос ажиглаж байсан цэргүүдэд сумнаас өөр юм огт харагдахаа больжээ. Аржуна, Карна хоёрын ер бишийн зориг зүрх, цэрэг байлдааны уран чадамгийг хараад бурхад ч өөрснөө гайхаж байжээ.

“ Миний хүү Аржуна ялах нээ!” гэж тэнгэрийн эзэн Индра хэлэхэд “Миний хүү Карнаг ялна?” гэж нарны бурхан Сурья өчив. Бурхад Аржунад, шулмасууд Карнад ялалтыг ерөөж байв. Индра, хамгийн их бярманд хандаж: “ Эзэнтэн минь, шийдэж аль! Ялалтыг Пандугийнханд өгөхийг чамд мөргөн гуйя” гэлээ. Бярман хариуд нь: “Чингэх болтугай! Бурхад таалдаг Шударгаг үйлийн замаас хэзээ ч хазайлгүй явсан Аржуна дийлэг! Шулмасуудын хайртай Карна сөнөг!” гэжээ.

Бүх цохилтыг нь Аржуна няцаагаад байхлаар Карна, харахаас аймаар бөгөөд үхлийн хамгийн сүүлчийн тулалдаанд хадгалаад байсан тийм нэг сумаа саадгаасаа суга татан авав. Нумныхаа хөвчийг чихэндээ хүртэл татаж байгаад үхлийн бурхны элч шиг, хатгадаг могой шиг өнөөх сумаа зэхэж байна. Шалья сэтгэл тэвдэн Карнад хашгиран хэлэхдээ: “ өөр сум аваач, энэ сумаар чи Аржунаг алж чадахгүй!” гэлээ. Гэтэл уурласандаа болоод Карна мөчөөрхөж “Бай руу онилсон сум надад хоёр дахь удаагаа хэрэг болохгүй!” гэж хэлээд хөвчөө суллан тэр аймшигт сумаа Аржунагийн толгой руу илгээв. “Кунтийн хүү чи үхэх чинь энэ дээ!” гэж Карна хашгирч байна. Кришна агаарыг аянгын дуу мэт зүсэн шуугиж ирж яваа тэр сумыг хармагцаа хөлөөрөө дэвсэлж их тэргээ газарт тохойн чинээ шийтгэлээ. Аюумшигт сум, Аржунагийн толгой дээгүүр нисэн өнгөрөхдөө зэгсэн үнэт малгайг нь л авч хаяснаас биш, хатан зориг баатарт хор хүргэсэнгүй.

Аржуна, олон сумаараа Карнаг онож зовлонт гүн шарх олгожээ. Карна ч хариуд нь дийлдэшгүй мэсээрээ Аржунаг ганц биш удаа шархдуулж байв. Гэсэн ч Карнагийн сөнөх цаг ирж өнөөх золигийн бярманы хараалыг биелүүлэхийн учир их тэрэгнийх нь зүүн нэг дугуйг газар чангааж эхэлжээ. Дайсны мөндөр мэт буух сумны дор Карна бултан зайлж чадахгүй хөдөлгөөнгүй болжээ. Карна гүнзгий их уй гашууд дарагдав. “Насан туршдаа би шударга явахыг хичээсэн билээ. Алив тэр шударга ёс чинь? Яалаа гэж намайг ийм гай дайрав?” гэж Карна үглэж байна. Аржунын сумнууд

Карнагийн биед сүлбэн орж байвч Карна түүнд ажралгүй хувь заяагаа хилс боллоо гэж зүхэж байлаа. Гэвч дайсны хүчтэй цохилтоос аргагүй л хамгаалах хэрэгтэй болжээ. Карна мэсээ шившин тарнидаад Аржунын ирүүлж буй олон мянган сумыг чадамгай няцааж, өөрийнхөө харвасан сумаар Пандугийн хүүгийн нумны хөвчийг арван нэгэн удаа тасалжээ. Гэтэл түүний их тэргэний дугуйг газар залгисаар байлаа.

Карна, их тэргэн дээрээсээ бууж дугуйг хоёр гардан хүчээр өргөж суга татан гаргахыг оролдов. Гэтэл сайхан суга татаад ирэхэд нь л газар өөрөө дээшээ хөөрч түүнээс тас зууралдаад гаргахгүй байжээ. Уур хилэндээ уйлах нулимс нүднээсээ гаргасан Карна, Аржунад хандаж хэлсэн нь: “Хүүе, Кунтийн хүү, намайг тэргэнийхээ дугуйг татаж гаргатал түр хүлээ, хамгаалалтгүй хүн рүүгээ сум бүү харва. Аймхай амьтад л тэгдэг шүү дээ” гэлээ. Гэвч Кришна, Аржунад: “Түүнийг бүү хайрла! Түүний дахин хүч олж, чам руу довтлохоос нь өмнө цаг алдалгүйгээр цохь. Түүний болон нөхдийнх нь үйлдсэн бузар үйл гэмт хэргийг санагтүн!” гэлээ.

Аржуна, Кришнагийн хэлсэн бүгдийг санаад Карнаг улангассан мэтээр дайрч байлаа. Нарны хүү дугуйтайгаа ноцолдохыг болиод дайсныхаа эсрэг нүүр хандаж гал мэт гялалзах аймшигт нэгэн сумыг хөвчлөв. Тэр сумыг нумны хөвчнөөс гаран нисэхэд бурхад өөрснөө аймсан дуу алдаж, газар ч айсандаа донслов. Тэр сум, Аржунагийн цээжинд гүнзгий шааж ороход Аржунагийн хүч алдарсан гараас мэс нь уналаа. Пандугийн хүү ч ухаан алдлаа. Тэгээд Карна өнөөх гайт дугуйтай ноцолдохоор тонгойгоод хамаг хүчээ шавхан суга татахыг оролдовч болж өгсөнгүй заяа нь орхижээ. Тэр хооронд Аржуна ухаан оржээ. “Их тэргээ татаж гаргахаас нь өмнө толгойг нь тас ав!” гэж Кришна дуу алдав. Аржуна ч хутганы ир шиг хурц өргөн үзүүртэй сумаар харваж хатан зоригт Карнагийн их тэргэн дээрх тугийг унагав.

Дээрээ байлдааны зааны дүрс бүхий тэр туг бол дайсныхаа зүрх сэтгэлийг үхүүлж, Каурав нарын цэргийг зориг хүч, хийморийг нь сэргээх чадалтай бөлгөө. Аржуна, их тэргээрээ ойртож ирээд үхлийн бурханы очир шиг хөнөөлтэй бөгөөд бурхад шулмасуудын аль алиныг сөнөөж чадахуйц урд хожид үзэгдэггүй тийм сумаар газарт шигдсэн их тэргээрээ оролдон тонгойж байсан Карнагийн толгойг тэр үдшийн цаг тас хяргажээ.

Карна үхэтхийн унаж, шарх бүхнээс нь цус савирах нь бурханы очир хага дэлдүүлсэн улаан чулуут бэл бүр рүү аранзал улаан үерийн горхи жирэлзэн урсах

мэт харагдана. Түүний толгой хүчит их биенээсээ тун ч дурамжхан салан унах нь эд агуурс гялалзсан сүрлэг сайхан ордондоо эзэн нь хорогддог шиг байлаа. Карнагийн үхэхийг харж байсан бүхний нүдэнд ер бишийн юм үзэгдсэн бөлгөө. Талийгаач баатрын шарилаас нүд гялбам туяа цацран дээш хөөрч нарны туяа лугаа нийлжээ. Дурйодхана, бүх Пандугийнхныг өндөр дуугаар тулалдаандаа дуудан жигүүлэн орж иржээ. Дурйодхана, давшиж буй дайснууд замыг аймшиггүй хөнөөлт цохилтыг мөндөр мэт буулгаж байлаа. Дурйодхана тийнхүү дайсны бүх цэргийн эсрэг ганцаархнаа уур хилэн бадруулан тэмцэж дайсныг өдий төдий зуу, мянгаар нь устгаж өөрийнхөө цэргүүдэд: “Зугатаагаад ямар тус байнаа! Ээрэм талд уул ойд ч байх газар бидэнд олдохгүй. Өрөвдөх сэтгэлгүй дайсан та нарыг хаана ч байсан олно.

Пандугийнхны цэрэг тийм олонгүй. Баатар эрсүүд нь эцэж цуцсан байна. Бид ялах юм шүү! Цэрэг хүнийхээ үүргийг санацгаа. Тулалдаж байгаад зугатаах гэдэг чинь их зузаан нүгэл. Тулалдаанд үхнэ гэдэг бол тэнгэрт очих дээдийн жаргал!” гэж хашгирч байлаа. Гэсэн ч Каурынхны эрэлхэг дайчид энэ үед зугтаасаар дайсны хөнөөлт суманд сүлбүүлсээр бөгөөд Дурйодхана тэдний хойноос ухаан санаа нь балартан “эвий Карна минь! Эвий Карна минь!” хэмээн зай завсаргүй гасалж явна.

Шөнө болоход тулалдааны талбарт үлдсэн Карнагийн сарны гайхалтай сайхан туяа цацарсаар байлаа. Газрын гүнээс аймшигт дуу гарч, ширүүн салхи дэгдэж, долгиолж, уул нуруу доргин, газар дээр дөл бадруулсан сүүлт од бууж байлаа. Тэгснээ бүгд намжиж, нүдгүй хав харанхуй орчлонг хучжээ.

## XXVII

Тэр шөнийг Каурынхан ялгуусан Пандугийнхан хүрч үл очих бэлийн өндөр тэгш газар, Курукшетрийгээс өртөө орчим зайтай газар иржээ. Тэдний цэрэг хуарагнан цуглаад амрах болоход тулалдаанд хашир суусан Крипа байлдаанаас амьтай голтой үлдсэн цэргүүд шархадсан, ядарсан гутарсан эсэхийг багцаалж нэг хараад Дурйодханад хандаж: “Хаантан минь, кшатри нарт тулалдах замаас өөр дээр зам байхгүй. Гэвч Бхишма, Дрона, хүчит Карна, чиний хатан зоригт дүү нар талийгаач болсон болохоор бид одоо яах ёстойг сайн язгуурт хаантан минь над хэлж өгөөч! Чиний цэргүүдийг Аржуна, намрын үүлийг шуурган салхи хөөх шиг бут цохижээ. Цэрэг чинь далайн шуурганы эрхэнд орсон өмх хуучин их онгоц мэтээр Пандугийн ялагдашгүй хүүгийн өмнө дагжин чичирч байна. Одоо манай цэргийн

дотроос хэн нь Аржунын эсрэг үзэлцэж дөнгөх вэ? чиний цэргийг ч өөрийг чинь ч үхлийн аюул нөмөрчээ. Амь мултрахыг бодсон нь дээр. Хүчгүй болсон, хүн найрамдах аргаар л амь гарч болно. Хаантан минь, Пандугийнхтай найрамдах л одоо бидэнд байгаа ганц өлзийтэй зам мөн гэж би бодож байна. Юдхиштхира шударга, өрөвч сэтгэлтэй хүн. Хэрэв чи түүний ивээлд орвол чамайг хаан хэвээр үлдээж ч юун магад. Үүнийг өөрийнхөө хар амийн төлөө биш, харин бүгдийн төлөө л чамд хэлж байгаа юм шүү” гэхэд Дурйодхана хариуд нь “Крипа минь, тулалдаанд чи амь нас хайрлалгүй явж бидний төлөө чадах бүхнээ хийсэн. Чиний хэлж байгаа үг чинь анд нөхрийн ухаантай үг гэдгийг ч ыи мэдэж байна. Гэсэн ч би чиний зөвлөгөөнийг дагаж чадахгүй ээ, бярман минь. Кришна болоод Пандугийн хөвгүүд миний хийсэн нүглийг хэзээ ч өршөөхгүй. Өршөөлөө ч гээд, өргөн уудам улс орнуудыг эзэгнэн захирдаг би, нэг хаант улс гүрнийг дайснаудынхаа гараас өглөг болгон авах нүүр над яаж байх билээ. Хамаг хаадаас дээгүүр наран мэт гялалзаж явсан би ялгуусан Юдхиштхирагийн хойноос боолын гавтай явж элэг бариулан муугаа үзэх суух вэ? үгүй, баатар минь, одоо миний найрамдах цаг бишээ. Гагцхүү тулалдаанаар л би аврагдана. Газар дээр эд баялагаа орхичихоод дайнд амь насаа нэр төртэй өгсөн эрст бэлдсэн Индра бурхныд би очноо. Хэрэв би өөрийнхөө төрөл садан, анд нөхдийнхөө мөхлийн шалтгаан нь болчихсон хойноо хар амиа хаацайлах гэвэл, намайг хэн ч буруушаах нь түмэн зөв болно. Миний төлөө тулалдаж амь насаа өгсөн хатан зоригт нартаа би төлөх өртэй хүн” гэжээ.

Дурйодханагийн ингэж хэлэхийг сонссон кшатри нар бүгдээрээ чанга хашгиралдан сайшаажээ. Каурынхны цэргийн хийморь сэргэж ирлээ. Баатар эрчүүл нь Дурйодханад хандаж “ Хаантан минь , маргааш бид дайсантай тулалдана. Үхэх сэхэхийн тулаан хийхэд хэн биднийг жолоодохыг хаантан минь зарлиг болго!” гэцгээв.

Дурйодхана, Ашваттахаманы зөвлөснөөр Мадр нарын хааныг бүх цэргийн жанжин болгож зарлав. “Хаантан минь, би зөвшөөрнө! Би өөртөө байгаа бүхнээ амь насаа, улс, гүрнээ,эд баялгаа чамд өгнөө!” гэж Шалья өгүүлэв. Дурйодхана заншсан ёс дүрмийг дагаж Шалягийн толгойг рашаанаар цавдахад цэргүүд: “ Хаантан минь ялах болтугай! Урт наслах болтугай!” гэж хашгиралджээ.

Шөнө өнгөрөхөд Каурынхны сүүлчийн тулаанд орохор босчээ. Цэргүүд зэр зэвсгээ агсан жагсаад хатан зоригт шилдэг баатруудынхаа жолоодлогоор Курукшетрийн зүг аялав. Крипа, Критаварман, Ашваттахаман, Шалья болон бусад



амьд үлдсэн хаад Дурйодханаг хүрээлэн явахдаа гар нийлүүлэн байлдана. “ Хэн ганцаараа тулалдах буюу эсхүл үхлийн аюул учраад байхад нөхрөө орхисон хүний толгой дээгүүр нүгэл бууг!” гэлцэв.

Тийнхүү хоёр этгээдийн цэрэг тулалдааны талбар дээр нүүр нүүрээ харан зогслоо. Каурынхны цэргийн манлайд Шалья өөрийн мадр цэрэгтэйгээ зүүн жигүүрт нь Критаварман тригартчуудтайгаа, баруун жигүүрт Крипа, скиф, ява цэргийн хамт байна. Дурйодхана цэргийхээ тэг дунд Шальяагийн араас дагасан байх бөгөөд Каурыхны шилдэг цэргүүд нь түүнийг хамгаалж, ар талыг нь Ашваттахаман хаацайлжээ.

Пандугийнхан, гурван зам цэрэг болж хуваагдаад дайсны цэргийг шууран дайрчээ. Дхриштадьумна, Шикхандин хоёр мадрчуудыг, Юдхиштхира, Шальяг бушуухан дарж авахын тулд ганцааранг нь цэргээрээ дайрав. Аржуна Критавармантай, Бхимасена Крипатай тулалдав. Тийнхүү байлдааны арван найм дахь өдрийн өглөө хоёр этгээдийн олон мянган цэрэг хамгийн сүүлчийн тулалдаан хийх гэж Курукшетрад уулзалдсан нь энэ бөлгөө.

Явган ,морьтой их тэрэгтэй буюу заантай бузар олон цэрэг хэтрэмтгий их үймээнтэйгээр хэмхлэгдсэн их тэрэгнүүдээс унаж байхад, зарим нь тэдгээр улангассан амьтнаас амь зулбахын тулд байлдааны талбараар зугтаан харайлгаж явна. Их тэрэгтэй баатрууд зэр зэвсгээ чадамгай эзэмшиж заануудаар хаацайлан давшсан морьтой, явган цэргүүдийг устгаж байна. Олон нумчид их тэргэнд дээрх цэргүүдийг харван хүмүүсийг нь нөгөө ертөнцөд тонилгож байлаа. Дайсны их тэргүүдийг бүслээд зарим нь ганц ганцаараа зарим нь бөөн бөөнөөрөө тулалдаж байгаа нь бас олон заан зааныгаа,их тэргээ довтолж дээр нь суусан цэргүүд бие биеэ жад ,хануур жад сумаар хөнөөж байлаа.

Баатар дайчдын алхаа гишгээ, их тэргүүдийн нижигнээн, дайчдын уриалан хашгирах заануудын орилон урхирах, бүрээ, хэнгэргийн хангинан хүнгэнэхээс газар доргиж аянга ниргэх мэт цуурай гарч байлаа. Давшин довтолж байгаа Пандугийнхны замд Шалья, шуурга давалгааг хаагч хадан хясаа мэт хамгаалан зогслоо. Усны долгио хадан цохиог мөргөөд буцдаг шиг Пандугийнхны цэргүүд Шальяд тулж байлдсан хир нь зугтаан зайлж байлаа. Каурынхан ч үхэх сэхэхээ нэгэнт үзэхээр нэгэн үзүүрт сэтгэл гаргаж мадрчуудын эзэнг хүрээлэн нягтарчээ. Тийнхүү хатан зоригт баатруудын хооронд болж байгаа сүрт тулалдаан үхлийн оронд оронд

тонилогчдын тоог арвижуулах бөгөөд уг байлдаан нь бурхад, шулмасуудын хоорондох тулалдаан лугаа төстэй ажээ.

Дурйодханагийн манлайлсан цэрэг дайчин уриа хашгиралдан , зэр зэвсгээ яралзуулан хангинуулсаар дайсны цэрэг рүү ухасхийн дайрцгаалаа. Хун шувууд нуур руу тэмүүлж буй мэтээр Дурйодханагийн цэргүүд Пандугийнхны цэргийн дотор зүсэн оров. Тийнхүү хоёр талаасаа их л хөхүүн байдалтайгаар дайралцсан хатуу ширүүн тулалдаан хатан зоригт баатруудын хооронд болж байлаа. “ Цохь, дэлс, барь, хярга, алаад!” гэж энд тэндгүй хашгиралдна. Ганц ч цэрэг энэ сүрт тулалдаанд дайсандаа нуруугаа харуулахгүй байлаа.

Давшин дайрч буй дайснуудынхаа дотроос Дурйодхана, Чекитанаг онилон хэмхдэг рүү нь жад шаав. Чекитана тэр мэсэнд сүвлэгдсэн цусаа асгаруулсаар их тэргэн дотроо ойчоод үхэв. Түүний үхэхийг харсан Пандугийнхан Каурынхныг ухасхийн улайрч дайрна. Юдхиштхира, үүл мэт нүүгэлтэх олон сумыг Шалья тийш илгээж байна. Юдхиштхира Шальяагийн хоёх хажуугаас хамгаалан явж хатан зоригт баатар Чандрасена, Друмасена хоёрыг тогосын өдөн чимэгт олон сумаараа хөнөөв. Тэр хоёул, мадрчуудын хааны харсаар байтал алагдахад уур хилэн нь ихэд хөдөлсөн Шальяг, Юдхиштхира ба түүний цэрэг хүчтэй цохилт өгөв. Шальяагийн харвасан суманд шархдан Пандугийнхны эзэн хүч тамир алдсан учир их тэргээ тулалдааны талбараас гаргахыг хөтөчдөө зарлиг болгов.

Энэ үед Аржуна, ер бишийн хүчит мэсийнхээ хамаг хүч чадлаар Каурынхныг дахин дайрчээ. Дурйодханагийн цэргүүд мянга мянган суманд харвуулсан боловч ухрахгүй байжээ. Ашваттахаманын удирдсан цэргүүд, Аржунагийн их тэргийг тал бүрээс нь бүсэлж Кришна, тэр хоёрыг хануур жад, харвах сумаар шархдуулж байлаа. Хоёр талаас харвалдан сум нь зуны сүүлчийн аянгат үүлнээс орох бороо адил өтгөрч байна. Аржуна, Ашваттахаман хоёр улангассан мэт халз тулаан хийн бие биеэ хурц сэлмэн эврээрээ сүлбэн мөргөлдөх хоёр бух шиг бөгөөд хэн нь ч хэнийгээ дийлэхгүй их л удав. Аржуна, нумныхаа хөвчийг хамаг хүчээрээ татаж байгаад Дронагийн хүүгийн хөтөч ба морьдыг сүйдлэв. Гэсэн ч Ашваттахаман,хөдлөхгүй болсон ч тэргэн дээрээ зогсон тулалдсаар бөгөөд хурц хурц хурц үзүүр бүхий асар том шийдэм шүүрэн авч Аржуна руу шидэв. Аржуна тэр балтыг харван унагахад унах замд нь тааралдсан цэргүүд үхэтхийн унаж байлаа.

Яг энэ үед панчалчуудын цэргийн хүчит жанжин Суратха, Ашваттахаманыг өөр талаас нь дайрав. Уур хилэнт Ашваттахаман, хөмсөг зангидан, үхлийн гайт очир шиг нэг жадыг Суратха руу шидлээ. Жад панчалын зүрхээр орон нэвт сүлбээд газар шаах нь Индрагийн очир тэнгэрээс шумбан орж ирэх шиг. Ашваттахаман , Суратхагийн их тэргэн дээр яаравчлан гараад Аржунатай тулалдаанаа үргэлжлүүлэв. Тэр хооронд Юдхиштхира шархнаасаа сэхэж тулалдааны талбарт буцаж очоод Шальяг дахин ухасхийн дайрахад Бхимасена, Сахадева болон Пандугийнхны бусад сүлбэж шааж байгаа мэтээр мадрчуудын хаан давшиж ирэгч дайснуудыг сумаараа сүлбэж, хүн тахилгын өрөөнд бөөн арц баглаа баглаагаар хаяхын адил хүчирхэг Шалья газрыг хүүрээр цацаж байлаа. Сайхь хаан, Юдхиштхира, Бхимасена хоёрын алтадмал хуяг дуулгыг салам болгоод хоёр баатрыг мөр цээжээр нь шархдуулжээ. Крипа, Шальяд туслахаар ирж, хоёул нийлэн Юдхиштхирагийн зүг сум нүүлгэсээр түүний хөтөч ба морьдыг нь алав. Гэтэл Бхимасена, Сахадева хоёр Шальягийн хөтөч морьдийг хөнөөж өөрийг нь ч сүрхий шархдуулав. Шалья их тэргэн дээрээсээ харайн буугаад илд, бамбайгаа сэгсэрсээр Юдхиштхира луу ухасхийн дайрав. Түүнийг Бхимасена, сахадева, Сатьки болон Пандугийнхны бусад баатрууд олон зуун сум харван дайрахад Шалья огт ажрахгүйгээр арслан буга хуу дайрах мэт Юдхиштхира рүү зүтгэлж байв. Бхимасенын харвасан сум мадрчуудын хааны түмэн одоор чимсэн бамбайг салам болгож, юдхиштхира өөрөө алт, эрдэнэсийн чулуун чимэгтэй жадаа шүүрэн авч шившин тарнидаж” Жигшүүрт чи одоо үхэх чинь энэ!” гэж хашгираад байдаг чадлаараа чулуудав. Тэр жад, мадрчуудын эзэн хааны цээжээр сүлбэн биеийг нь усан дотуур туулах адил тийм хялбархан нэвтэлж газарт гүнзгий шааж оржээ. Шальягийн ам, хамар, чих,нүднээс цус олгойдож, хоёр гараа тэлэн дайсныхаа зүг харан ойчжээ. Тэрбээр газрыг шуналтай тэврэн элгэн дээр нь дараад сэршгүй бөх нойроор унтчихсан юм шиг байлаа.

Шальяг алагдахтай зэрэг Каурынхны цэрэг жанжингүй болж сандраад цэцгээ алдсан сүрэг гөрөөс арслангаас зайлан зугтаах мэтээр ухарч эхэлжээ. Дурйодхана өөрсдийн дийлж буйдаа оодорсон дайснуудынхаа дайралтыг няцаасаар байлаа. Аржуна , Юдхиштхира, Сатьяки болон Пандугийнхны бусад баатрууд нийлээд, хориглон байлдаж байгаа Каурынхныг хамаг хүчээрээ шууран дайраг Дурйодханагийн ухарч байсан цэргүүд нь хааныхаа эрэлхэг зоригтойг үзээд хийморь нь сэргэж ус түрэхийн үе дэх далайн хүрхрээ шиг үлэмж шуугиантайгаар эргэн ирж байлаа.

Энэ тулалдаанд хатан зоригт Шакуни, Юдхиштхира руу хүмүүсийн зүрх дэлсээр сүртэй хашгиран дайраад дөрвөн морийг алав. Сахадева, Юдхиштхираг их тэргэн дээрээ суулгаж аваад ширүүн тулалдааны талбараас зайлав. Энэ хооронд Улука, Накулагийн довтолгооныг няцааж, Критаварман Сатьякитай, Дурйодхана Дхриштадьюмнатай, Крипат Драупадын таван хүүтэй тус тус тулалдаж байлаа. Байлдагсдын дээгүүр тоос манан өтгөн үүл мэт болон босч тэднийг хараа нэвтрэмгүй хөшгөөр хучиж байлаа. Морьдын туурай, их тэрэгний дугуй, давхилдаж буй зааны хөл, явган цэргийн хөлөөр боссон тоос салхинд туугдан бүх талбайг манцуйдан бүрхжээ. Цэргүүдийн нүдэнд нар ч бүдгэрч байлаа. Харин газрыг цус бялдан норгоход тэр их тоос суужээ. Тэр үед хоорондоо байлдаж байгаа морьт, явган цэрэг, заан, их тэрэгнүүдийн бараа нүднээ дахин харагдлаа.

Аржуна, Кришнагийн жолоодсон их тэргэн дээр, дайсны эгнээ дунд ой шугуй руу орох адил нэвтрэв. Тэр аймшигт ой шугуйн мод нь их тэрэгтэй цэргүүд, мөчир нахиа нь нум, илд өргөс нь жадууд юм. Аржунын харвасан сум Каурынхан дээр намрын бороо шиг бууж байв. Пандугийн ялгуусан тэр хүү, ойд гарсан түймэр мод, бутыг шатаан устгах адилаар явсан замаараа үхэл тарьсаар дайсны цэргийн дотор шумбан оржээ.

Дурйодханагийн харвасан сумнуудад хүнд шархадсан Дхиштадьюмна, дайсан руугаа үүл мэт нүүгэлтсэн үй түмэн сум илгээсээр тэвчээртэй тулалдаж байв. Дхиштадьюмна, Дурйодханагийн дөрвөн морийг алж, хөтчийнх нь толгойг тонилгожээ. Дхиштадьюмнад Дхиштхираштрагийн хүү дийлдэн их тэргээ орхиж эзэнгүй нэг морин дээр мордоод дайсны сумнаас бултан давхиад явчлаа.

Дхиштхирагийн зуун хүүхдээс амьд үлдсэн арван нэгэн хүү (дурйодхана бол арван хоёр дахь хүү нь байсан юм) ойн дотор анчид зэрлэг зааныг дайрч байгаа юм шиг Бхимасена руу ухасхийн дайрцгаажээ. Пандугийн хүчирхэг хүүгийн уур хилэн бадарч тэдний эсрэг байлдаанд хамгийн түрүүнд Шрунтантаг үхтэл харвав. Бас нэг сумаараа Жаятсенаг хөнөөв. Найтра, Рави, Бхуривала гурав Бхимасенаг устгах гэж дэмий зүтгэж байж харин өөрснөө кинкушийн цэцэглэн буй мод түлээчний сүхэнд огтлуулах мэтээр суманд харвагдан үхжээ. Арван нэгэн эрэлхэг зоригт иэр баатрууд нэг нэгээрээ алагдсаар байгаад бүгдээрээ тийнхүү Бхимасенагийн гарт алагдахад цэргүүд нь ухран зугатаажээ.

Аржуна, Бхимасена, Сахадева гуравт цөм цохиулсан Дурйодханагийн цэргүүд ч сандран зугтааж эхлэв. Чин зоригт Сушарман, Аржунын дайралтыг тогтоох гэж оролдоод барсангүй. Пандугийн хүү зуун сум тавьж түүний их тэргийг яйран болгоод үхлийн гайт очир шиг сумаар өөрийн нь зүрхийг нэвт сүлбэв. Сушарманы үхсэний дараа Каурынхны цэрэг нүд хальтармаар хядагдаж дайны талбараас ундуй сундуй балмагдан зугатаацгааж байлаа.

Шакуни, Сахадева рүү ухасхийн дайрч байхад түүний хүү Улука, Бхимасенагийн замыг хааж байлаа. Хоёр талаас тавьсан сумууд үүл мэт нүүгэлтэж нислэг дундаа маш аймаар дуутай мөргөлдөн өдрийн гэрлийг бүдгэрүүлэн байв. Сахадева, Шакунийн гар дахь Пандугийн хүүгийн толгойг хүчтэй шархдуулав. Ухаан муужирсан Сахадева их тэрэгнийхээ ёроолд унав. Гэвч Бхимасена тэр даруй туслахаар хүрэлцэн ирж зэр зэвсгийнхээ бүх хүчээр дайраад Шакунийг цэргийнх нь хамт ухраав.

Гэтэл Улука эцэгтээ туслахаар ухасхийлээ. Одоо тэр хоёул Бхимасенагийн дайралтыг няцааж эхлэв. Тэр хооронд Сахадева ухаан ороод тулалдаанд дахин оржээ. Өргөн хутганы ир шиг хурц үзүүртэй сумаар Улакагийн толгойг тас авч, Шакунийг харваж олон шархдуулав. Шакуни, хүүгийнхээ алагдсанд сэтгэл донсолж , нумаа алдаад, Сахадева руу илд шийдмээ шидсэн боловч цаадах нь зам зуур няцаажээ.

Гандхарчууд хаанаа дийлдээд зэвсэггүй болчихсон байхыг хараад зугтааж эхлэв. Шакуни ч тэдний хойноос дагав. Сахадева алтан чимэгт их тэргээрээ түүний араас элдэн хөөж харвахдаа олон шархдуулж : “ Жигшүүрт новш минь, зогсоод тулалдаач! Даалуугаар тоглож байсан үеийг сана, чи биднийг яаж элэг барьж дооглож байлаа! Одоо би чамайг ална” гэж хашгирав. Сахадевагийн сумнуудад нэвт нэвт харвуулсан шакуни гартаа жадтайгаар дайсан руугаа эргээд улайран дайрчээ. Гэтэл Сахадева, хурц өргөн үзүүртэй, алтадмал сумаа нумныхаа хөвчнөөс тавихад тэр сум Гандхарын хааны толгойг тас авав. Толгойгүй болсон Шакунийн бие цус олгойдуулсаар газар унахад цэргүүд нь айн балмагдаж ялгуусан дайсандаа элдэн хөөгдөв.

Газар донсолж уул ус, ой мод, доргин газрын гүн дороос хүнгэнэн нижигнэх битүү дуу сонсогдов: Нарны хоёр талаар тэнгэрийн чулуунууд унаж зүг бүхнээс

салхи хөдлөхөд халуун хумх туссан юм шиг чичрэн дагжих заануудын нүднээс нулимс гоожжээ.

Дурйодхана хөнөөгдөлгүй амьд үлдэн цөөн цэргийг цуглуулан аваад дайсны бүсэн дотор хамаг хүчээ шавхан тулалдсаар байлаа. Каурынхнаас үлдсэн тэр багахан цэргийн тал бүрээс Пандугийнхан тэмүүлэн дайрчээ. Зүг бүрээсээ суманд харвуулж байгаа Каурынхны дайчид нэг нэгээрээ алагдан Дурйодханагийн цэрэг цөөрсөөр байв. Аймшигт тулалдаанд олон шархдан сэглэгдэн ядарч туйлдсан Дхритараштрагийн хүү эргэн тойрон харж үзвэл гагцхүү ялж оодорсон дайсны цэргүүд л байхын үзэв. Арван нэгэн акшаухининг Дурйодхана, Курукшетрад авчирсан юм, гэтэл одоо тулалдааны талбар дээр ганцаараа хүч тамир барагдан цус нөжиндөө холилдон зогсож байв. Тэгээд Дурйодхана ч зугтаалаа.

Тэр үед Пандугийнхны цэргээс хоёх, мянгат морьт цэрэг, нэг түмэн явган цэрэг үлдсэн байжээ. Гэтэл Каурынхны цэрэг бүгд дайны талбарт хүүрээ тавьсан бөгөөд энд тэнд үлдээд эсэргүүцэл тавьж байсан цөөхөн цэргийг нь Дхриштадьюмна, Аржуна болон ялсан их цэргийг бусад баатрууд хүйс тэмтрэн дуусгаж байжээ. Дурйодхана, мориноосоо ч салаад харуй бүрүйн дунд гартаа ганц шийдэм бариастай гав ганцаараа гүйж явна. Сайхь эр Курукшетрагаас зүүн тийш нэг өртөө хирийн газар Двайпаяна нуурын эрэг дээр зэгсэн дотор дайснаас нуугджээ.

Эцсэн морьд хөллөөстэй, тулалдаанд сэг болсон нэг их тэргээр гурван баатар эр Каурав нарын хуаранд нар шингэсэн хойно хүрэлцэн ирсэн нь ялагдсан тухай мэдээ авчирсан ажээ. Тэд нар бол Дурйодханийн цэргээс хамгийн сүүлд амьд мэнд үлдсэн Ашваттахаман, Крипа, Критаварман гурав байлаа. Хуаран даяар зовлонт дуу шуу хадав. Амь үрэгдсэн хунтайж нарын хатад цурхиран уйлалдаж толгойтой үсээ зулгаана. Хуаранг хамгаалахаар үлдсэн цэргүүд уй гашууд автагдан нум нулимс болцгооно. Хааны бэлэвсэрсэн охидууд санд мэнд юм хүмээ бэлтгүүлж шивэгчид ба амь сахигчдаа дагуулан Хастинапур өөд хөдлөв. Эл хуль болсон хуаранд өнөөх гурван баатар л хоцорчээ.

Гэтэл Пандугийнхан тулалдааны талбар дотуур Дурйодханаг эрж эрж олоогүй боловч хуарандаа бөөн баяр болон буцаж очоод өөрснийхөө ялсан тухай мэдээг зарлах буухиа элчийг зүг бүрт илгээжээ.

## XXVIII

Ядарч туйлдсан, цус нөжиндөө холилдон Дурйодхана нуурын зэгсэн дотор хоргодож байхыг нь хэдэн анчид үзээд ялагчдын хуаранд очиж Пандугийнханд энэ тухайгаа мэдээлжээ.

Пандугийнхан тэр анчидад өгөөмөр шан хүртээгээд өөрснөө олон цэрэг дагуулан Двайпаяна нуурыг чиглэн явав.

Тэнд очвол, Каурынхны эзэн хаантан амь зулбахаар усан дотор орчихсон байжээ. Юдхиштхира инээмсэглэж “ Чи яах гэж хар амиа бодон энэ нууран дотор нуугдана вэ? чи бол өдий олон хатан зоригт баатруудын үхэл ,овгийнхны үхлийн шалтгаан болсон хүн дээ! Аль вэ? чиний өнөөх бардам зан чинь Дурйодхана? Хүмүүс чамайг эрэлхэг эрэлхэг гэж дэмий хоосон сагсуурч байжээ. Гэвч ирээд бидэнтэй тулалд!” гэж хашгирав.

“Би хар амиа хамгаалах гэж байлдааны талбараас зугтаасан юм бишээ. Их тэрэг минь эвдэгдэж, морьд минь алагдаад хамаг дайчдаа тулалдаанд алдаад би ганцаараа үлдсэн билээ. Амиа аврах гэсэн ч юм биш, айсандаа ч биш харин жаахан амрах гэж би энд нуугдсан юм. Намайг жаахан амраа, өөрсдөө ч амарцгаа, тэгсний дараа би гарч та нартай байлджья!” гэж Дурйодхана хэлэхэд Юдхиштхира: “Бид бүгдээрээ амарсан одоо чи ирээд байлд. Хэрэв чи биднийг дийлбэл чи улсын хаан бол” гэв. Дурйодхана хэлсэн нь: “Дүү нараа бодож би засгийн төлөө тэмцэж байсан юм. Тэд маань тулалдаанд үхлээ. Тэд нар байхгүй болохоор болсон Юдхиштхира минь, би чамайг дийлэх байлаа ч гэсэн над улс гүрний хаан байх хэрэг алга! Хамгийн хатан зоригт баатруудаасаа хагацсан улс гүрэндээ чи л хаанчил, харин би бугын арьсан дээл өмсөөд ой шугуйд даяанч болон холдож өгье. Тэнд л би амьдралаа дуусгая” гэлээ.

Юдхиштхира ёжтой инээмсэглэж “ Чи уй гашуудаа дарагдан ухаан санаа муудан тэр усан дотроо дэмийрч байна! Өршөөх байх гэж бүү горил. Чи одоо нэгэнт эзэн биш болчихоод байж, над улс гүрэн бэлэглэнэ гэж балайрах чинь юу вэ? би чамтай тулалдаж дийлж авч байж л хаанчлах болно. Чиний амь нас миний гараас мултрахгүй Дурйодхана чи гараад ир, гарч ирээд тулалдсугай!” гэв.

Дурйодхана гүнээ шүүрс алдаж: “сэг болтлоо шархдаж туйлдан зэвсэггүй болсон ганц би та нартай яаж нэг зэрэг тулалдах вэ? Чадахгүй, би та нартай тулалдахдаа аймшиггүй байсан шүү дээ. Одоо харин та нар шударга уужуу сэтгэл гарга. Би та нартай тулалдъя, тэгэхдээ ганц ганцаарантай чинь үзэлцье! Тэгвэл ч би

та нараас амь үрэгдсэг ах дүүс, анд нөхдийнхөө хариуг лавна даа” гэв. “Мундаг хүн шүү, Дурйодхана чи. Одоо чи нээрэн кшатрий хүн шиг ярьж байна. Зэвсгээ сонгож ав, бидний нэгэнтэй маань үзэлц. Хэрэв чи дийлбэл дахиад хаан болоорой гэж би амлачихья!” гэж Юдхиштхира хариу болгов.

“Хэрэв чи над ийм өрөвч сэтгэл бэлэглэж байгаа бол хатан зоригт Юдхиштхира минь би шийдэм барьж байлдя. Та нарын хэн чинь надтай үзэлцэж чадна гэж бодвол явгаар ганц шийдмээр тулалд л даа. Тэгвэл зэвсэг маань ч тэнцүү болно шүү дээ” гэж Дурйодхана хэллээ. Тэгээд Дурйодхана хэнийг ч дагуулдаггүй юм шүү. Хаантан минь та тэгж зөвшөөрөхөө яарлаа даа. Бхимасена л одоо түүнтэй тулалдвал болох болов уу даа. Энэ зэвсгийг эзэмших ур чадвараараа Дурйодханад хүрэхгүй ч гэсэн хүчээр давуу даа. Гэлээ ч Дхритараштрагийн хүү давуу шүү. Яах гэж түүнд ингэж ам алдав аа. Дайсандаа ингэж өрөвч сэтгэл гаргадаг чинь таарахгүй шүү дээ. Түүнийг үгээ мхэлж дуусахад тэнгэрээс цэцгэн бороо орж Дурйодханагийн яруу алдрыг магтсан апсар нарын дуулалдах сонстжээ. Пандав ах дүү нар ба Кришна тэргүүн гудайлгасаар, Дхритараштрагийн үхэж буй хүүг ганцааранг орхиж холдов.

Тэд явсаар Каурынхны хуаранд очвол хэн ч байхгүй байлаа. Пандугийнхан алт, сувд, эрдэнэсийн маш их олз олж аваад бүх цэргийнхээ хамт хуаран лугаа чиглэв. Өөрснөө ядарсандаа болоод Огхавати голын дэргэд хоноглов. Тэдний хамт ганц Сатьяаки үлджээ. Харин Юдхиштхира “Бүх хүүхдээ алдсан золгүй хаан хатангийн сэтгэлийг зас” гээд Кришнаг Хастинапур лүү илгээжээ.

Энэ завсар Дурйодханагийн дийлдсэн тухайг Ашваттахаман, Крипа, Критаварман гурван баатар сонсоод хурдан их тэргүүдээрээ түүн лүү яаравчлан явжээ. Тэдний хүрч очиход Дхритараштрагийн хүү усан шуурганд орвонгоороо оглорон унасан мундаг том шал мод шиг хөглөрөн цусандаа хөвж байжээ. Цөөвөр чоно мэтийн шөнийн олон муухай зэвүүн амьтад эргэн тойрон сүрэглэн байгаа нь хааны ширээний хажуу хавиар өглөг горьдсон зусарч хаалгачид шиг үзэгдэнэ.

Уй гашууд дарагдсан тэр гурван баатар их тэрэгнээсээ буугаад Дурйодханад ойртон очив. Ашваттахаман нүд дүүрэн нулимстай гүнээ санаа алдаад “эзэнтэн минь, цулгуй газар шороо тоосонд булуулаад хэвтэхийг чинь би үзэх тавилантай бол хүмүүсийн ертөнцөд байнгын юм гэж үнэхээр байдаггүй юм байна. Бүх дэлхий эзэн байсан чи одоо бүгдэд Хаягдаад эн зэлүүд газрын мухарт хэвтэж байна. Хамгийг чадагч Ямын замыг мэднэ гэдэг үнэхээр хэцүүеэ” гэлээ. Гэтэл уйлж байгаа



Ашваттахаман ба түүний хамт хоёр нөхөрт Духойдхана хэдэхдээ: “Амьд амьтан бүхэнд үхэл ирдэг юм. Над өлзий болжээ. Ямын гай гамшиг намайг дийлэх байлаа. Гэвч би тулалдаанд ороод үхлээс хэзээ ч зугтааж яваагүй. Над өлзий болжээ. Тулалдаанд та гурав үхэлгүй эсэн мэнд гарсныг чинь би үзлээ. Миний тухай битгий уй гашуу болцгоо. Хэрэв ариун судар үнэн байдаг юм бол би тэнгэрт гараад мөнхийн төр барина” гэжээ. Дронагийн хүү уй гашуу, уур хилэнд нэрвэгдэн гараа атгаж, уйлснаасаа болж сөөнгөтсөн хоолойгоор хаандаа хандаж “Чамайг жигшүүрт аргаар мэхэлж луйвраар аллаа, Дурйодхана минь, миний хэлэх үгийг сонсч бай. Би өнөөдөр л Панчал нарыг бүгдийг нь Кришнагийн нүдний өмнө үхлийн оронд тонилгоно гэж чин үнэнийг барьж өөрөөр нь итгэх итгэл, ариун нэр төрөөр нь тангараглая. Чамд тангараглая, хаантан минь” гэжээ.

## XXIX

Ашваттахаман, Крипа, Критаварман гурав өмнө зүг чиглэн явжээ. Каурынхны хуарангийн ойролцоо гарахад ялгуусан дайснуудын шуугилдах дуу чимээ сонсогдохлоор тэд мөшгөн хөөж магадгүй хэмээн айгаад зүг буруулан өтгөн ой тайгад орж явчив. Харанхуй болохоос өмнө тэр гурав ой дотуур хэвтрэн явахдаа түмэн мөчиртэй аварга том баньян мод олж үзэв. Тэр бол ой тайгын моддын дотроос хамгийн том нь юм. Тулалдаанд олсон шарх сорвиндоо шаналж ядарч зүдэрсэн сайхь гурван баатар эр тэргээ буулгаж үдшийнхээ мөргөлийг үйлдээд өнөөх том баньян модныхоо нөмөрт амрахаар тухлав. Шөнө болж, мянга түмэн одорд харанхуй тэнгэрт гялалзан гарч ирлээ. Зүг бүрээс харанхуйд тэнүүчлэн яваа шөнийн амьтдын аягүй муухай дуу, улих чимээ сонсоно. Дээд зэргийн бандан орон дээр заларч байвал таарах Крипа, Критаварман хоёр баатар ядарч туйлдсандаа цулгай газар сунаж хэвтэнгээ дугжирчээ. Гэтэл уй гашууд дарагдан, өс хонзонгоо аваасай гэсэн хүсэлдээ биелүүлж байгаа Ашваттахаманы нойр хулжаад унтаж чадахгүй байна. Модныхоо дор суугаад эргэн тойрныхоо ойг хэсүүлэн харж байвал тэдний хоргодож байгаа баньян модны мөчрүүдэд шөнө хоноглохоор үүрлэсэн олон мянган хон хэрээ суунхан байхыг Ашваттахаман олж үзжээ. Тэдгээр шувуу түүний хажууханд суугад унтаж байгаа ажээ. Тэгтэл нүд ногоон, бие хар, хошуу урт, савар урт хурц, харахаас аймар нэг ууль харагджээ. Тэр шувуу баньян модонд чимээгүй нисч ирэн мөчир дээр нь суугаад, унтаж байгаа хон хэрээнүүдийг хурц савраараа толгой жигүүрий нь тасчин, биеийг нь хүү татан ганц ганцаар нь алж эхлэв. Модны доорх газар үхсэн шувуудаар хучигдав.

Ашваттахаман, уулийг ажиглан гүн бодолд автагдлаа: “Ууль, над дайн хийх хичээл зааж байна. Ашваттахаман чиний тангаргыг биелүүлэх цаг иржээ. Намайг дуртай бүхэн нь зэмлэг, хамаагүй. Шударга Пандуугийнхан алхам бүрдээ шударга биш, ой гутам юм үйлдэж явна шүү дээ. Хүмүүс гэдэг чинь амжилтанд хүргэх үйл ажлыг л таашаадаг юм байна” гэж Ашваттахаман өөртөө хэлжээ. Тэгээд, аймшигт нэгэн шийд гаргаад Дронагийн хүү, Крипа, Критаварман хоёрыг сэргээж сая сэдсэн санаагаа мэдэгдэв.

“Чин зоригт баатар Дурйодханаг элэг барин даапалсан дайсны нүдний өмнө ов мэхээр алж, Бхимасена, түүни толгойг гишгэн өшиглөж байсан. Бид, өнөөдөр тэдний баяр хөөр болон хашгиралдахыг нь сонссон. Гэвч би тэднийг майхандаа унтаж бахй хооронд нь өглөө болохоос өмнө бүгдийг нь хүйс тэмтрээд өшөөгөө авъя” гэж Ашваттахаман хэлэв.

Ийм үгийг Ашваттахаманаас сонсоод Крипа, Критаварман хоёрын айдас хүрч давхийв. Крипа түр дуугүй байснаа:

Дронагийн хүү минь, өшөөгөө авах гэсэн эрмэлзлэлийг чинь сйашаалтай байна. Чамайг болиулах гээд бүтэхгүй гэдгийг би мэдэж байна. Бид хоёул чамд хүчин туслалцъя. Тэгэхдээ өглөө, гэгээн цагаан өдрийн цагаар шүү. Маргааш гурвуулаа дайсныг дайръя, яруу цуут баатар минь! Маргааш дайсантайгаа сэргэг хүчтэй байлдахын тулд одоо унтаж амар” гэхэд Ашваттахаман: “Миний зүрхэнд уур хилэн, уй гашуу хоёр бялхаж байгаа цагт миний нойр яаж хүрэх вэ? Тулалдаанд амь үрэгдсэн эцгийнхээ, Дурйодханагийн болон бусад чин зоригт баатар дайчдынхаа хариуг аваагүй байж, Дхриштадъяюмна амьд явж байгаа цагт, түүнийг би тулалдаж алаагүй байж миний нойр яаж хүрэх вэ? Дайснуудаа нойрон дунд нь устгасан цагт л сая би амар унтана” гэлээ. “Дараа гэмших юм хийх хээрггүй, хүү минь” гэж Крипа дуу алдаад Панчалчууд одоо дуулгаа тайчиж зэр зэвсгээ буулгачихаад шөнийн тайванд итгэн нойрсоцгоож буй. Зүүд нойрын дунд, зэвсэггүй байгаа хүн рүү гар далайсан хүн ёроол хязгааргүй тамд унана, түүнд аврагдах ямар ч горьдлого байхгүй” гэв.

Нагац минь, чиний хэлж байгаа чинь үнэн, гэсэн ч би тангараг тавчихсан болохоор андгайлснаа биелүүлэхээс нааш би амар заяа үзэж чадахгүй ээ. Пандуугийнхан, шударга чин үнэн ёсны гүүрийг аль хэдийнээ түэмн хэлтэрхий болтол эвдсэн улс. Миний цуг хэрхэн алагдсаныг, Бхишма, Карна, Бхуршравас,

Дурйодхана хэрхэн алагдсаныг санаж үз. Хоёр гуяа хугалуулаад хөсөр суун хэвтэж чин сайн язгуурт хааны орь дуу тавж байсныг санахаас элэг минь эмтэрч байна! Миний энэ шийдсэн санаанаас намайг буцаах хүн энэ дэлхий дээр байхгүй” гэж Ашваттахаман хариу өчив.

Ашваттахаман, ингэж хэлээд морьдоо хөллөж ах тэргэн дээрээ гарч суугаад дайсны хуарангийн зүг явлаа. “Ашваттахаман минь, чи юу хийх гэж санаад байна даа? Хүлээ, бид хоёр маргааш чамайг дагая, итгэж үз бидэндээ! гэж Крипа, Критаварман хоёр хойноос нь хашгирлаа. Гнвч хариу дуугарсангүй болохоор, хоёул юмаа санд мэнд зэхэж аваад Ашваттахаманы хойноос явжээ. Тэд явсаар дуг нойрондоо дугжирч байгаа панчалчуудын байранд хүрч, хаалганых нь гадаа зогсов. Пандуугийнхны хуарангийн хаалганы дэргэд Крипа, Критаварман хоёр юу ч хийхээс буцахгүй шинжтэй байгаа Ашваттахаман үзээд тэр хоёрт: “Би энэ унтаа байгаа хуаран дотор яг үхлийн бурхан Яма шиг орьё. Та хоёр ч үүгээрээ ганц ч хүнийг амьд гаргахгүй байх гэж би найдаж байна” гэж шивнэн хэлжээ. Ашваттахаман, Шива бурханд мөргөөд Юдхиштхирагийн их хуаранд чив чимээгүй ороод явчлаа. Түүний зүүн баруун хоёр гарыг нь дагалдан үл үзэгдэх олон амьтан хойноос нь оржээ. Ашваттахаман, Дхирштадьюмнагийн майхныг түүний тавсан тэмдгээр нь таньж түүн тийш чиглэв. Тулалдаанд ядарч зүдэрсэн Панчалчууд газар зэрэгцэн сунаж хэвтээд бөх унтацгааж байна. Дронагийн хүү, нөгөө майхандаа ороод хааны хүү торго, дэвсэж анхилмал үнэрт цэцгээр хучигдсан хээнцэр гоё орон дээрээ бөх гэгчийн дугжирч байхыг олж харав. Агваттахаман, Дхриштадьюманг өшиглөн сэрээв. Хунтайж сэргэ харвал өмнө нь Дронагийн хүү зогсож байв. Орноосоо босох гэмэгц нь Ашваттахаман толгойтой үснээс нь шүүрэн барьж аваад газар унагаж цээжин дээр нь гишгээд дарчихлаа. Хунтайж тийчлэн тэлчилж Ашваттахаманыг хумсаараа маажин самардаж дөнгөж дуулдахтай үгүйтэйгээр “Ай, Дронагийн хүү чи намайг мэсээр ал. Тэгээд би тэнгэрт чинь үнэн явдалтын төр барья” гэжээ. Ашваттахаман түүнийг багалзуурдахад тэр хүн үг хэлж чадахаа больж, багалзуур нь зөвхөн хэржигнэж байв. Овгийгоо бузарласан новш минь, багш нараа алдаг хүнд хойт насандаа барих хаан төр олддоггүй юм. Над мэсээр алагдах тийм заяагүй хүн шүү чи гэж Ашваттахаман хэлээд дайсныхаа цээжин дээр хөлөөрөө аймшигтай дэвсэлж гарав. Ингэж Дхриштадьюмнагийн хашгирахад хатад манаач нар нь сэрсэн боловч алагчийг шөнийн хий үзэгдэл чөтгөр гэж айсандаа тэд, байсан байрнаассаа хөдөлж ч чадсангүй. Ашваттахаманыг майхнаас гараад явсан хойно л тэд

гашуудалтайгаар орь дуу тавжээ. Энэ дуу чимээнээр сэрсэн олон баатар эр, хуяг дуулгаа өмсчихөөд Дхириштадкюмнагийн майхан руу яаравчлан явцгаажээ. “Рагшас, хунтайжыг алчихаад хуарангаар хэсч явна!” гэж айж сандарсан бүсгүйчүүл хашгиралдаж байв. Тэр хооронд нь Ашваттаханамн, Уттамаужасы майханд орж түүнийг орон дээрээ унтаж байхыг үзжээ. Ашваттахаман, түүний хоолой дээр гишгэж байгаад илдээ гаргаж ирэн тахилгад өргөх амьтныг төхөөрч байгаа юм шиг Уттамаужасыг алав. Тэгээд мань эр цааш нь майхан майхан дамжин орсоор олон дайчдыг унтаагаар нь алжээ. Тэргүүнээсээ хөлөө хүртэл цусанд будсан тэр хүн цагийн элч, үхэлтэй өөртэй нь адил болсон байв. Алагдаж байгаа хүмүүсийн орь дуу тавихад сэрсэн цэргүүд түүнийг харснаа энэ чинь зүүдэнд үзэгддэг өнөөх рагшас байна гэж бодон айхдаа нүдээ аниад түүний сэлмэнд ямар ч арчаагүй хядагдаж байв.

Шикхандин, Драупадын таван хүү, бусад баатар эрс нойрноосоо сэргэж Ашваттахаманы руу ухасхийн дайрав. Гэтэл Дронагийн хүү мянган саран чимэгтэй бамбайгаараа тэдний мэсийн дайралтыг няцааж дайснуудаа догшноор устгасаар байв.

Драупадын хүүхдүүд түүний гарт цувран амь алдсаар байв. Сутамоса, Ашваттахаман руу жад шидээд сэлмээ далайн дайрсан боловч Дронагийн хүү өрөөсөн гарыг нь тас огтлоод гэдэс рүү нь үхлийн цохилт буулгав. Шикхандин түүнд ойртон очиж толгойг нь сумаар шархдуулсан боловч Ашваттахаман сэлмээрээ хүчтэй чавчиж Драупадын хүүг хоёр хуваагаад орхив. Ашваттахаман, заримынх нь толгойг тас чавчиж заримынх нь хэнхдэг цээж гэдэс гүзээ рүү нь сүлбэж, олон зуун цэргийг хэсэг бусаг болгон хэрчиж Панчал матс нарыг тэр шөнө маш их хядсан байна. Сэг болсон хүний хүүр газрыг хучжээ. Хуаран даяар айдас хүргэсэн хашгираан гарахад сэрээд айж ухаан сүнс нь зайлж балмагдсан цэргүүд: “Энэ юу вэ? Хэн бэ? Юу болов оо? Хэн хашгирч байна аа?” гэлцэн дуу алдаж байгаад биеэ хамгаалж амжилгүйгээр Ашваттахаманы сэлмэнд хөнөөгдөж байлаа.

Хүн бүхэн айж сандран тэвджээ. Зарим нь айснаасаа болоод хөдөлж ч чадахгүй зогсоно зарим нь сэрмэгцээ гэнэтийн гайд дайрагдан тэвдээд харанхуйн дунд бие биеэ ч мэсээр хөнөөж байлаа. Агт морьд, заанууд уяагаа алдуулж хуарангийн дотуур ийш тийш сандран давхилдахдаа хүмүүсийг дайрч алж байжээ. Олон баатар эрчүүл зугтаан зайлж амь гарахыг завдтал тэднийг хаалган дээр очмогц нь Крипа, Критаварман хоёр хайр найргүй устгаж байлаа. Тэгж байгаад мань хоёр адаг сүүлд нь хуарангийг нь гурван талаас гал тавьжээ. Галын гэрэлд Ашваттахаман

яг л үхлийн бурхан шиг дүвчигнэн дайсныг устгах бөгөөд Пандугийнхны олон мянган цэрэг алагдаж эсэргүүцэх чадалгүй болж байв. Газраар нэг цус урсана. Зарим хүн хөсөр унажээ. Зарим нь зугтааж, зарим нь нуугдахыг оролдож зарим нь амиа хамгаалан тулалдаж, бас нэг хэсэг нь ухаан самуураад бие биеэ хөнөөж бүгдээрээ тэр шөнийн хядлаганд үхжээ.

Амь тавьж буй хүмүүс орь дуу тавин ойр хавийг дөжрөөх нь аандаа намдаж эхлээд шөнө дунд болохын алдад дахин нам гүм болжээ. Дронагийн хүү, Пандугийнхны их цэргийг бүгдийг нь үхлийн бурхан- Ямын оронд тонилгожээ. Амьд, үхсэн хүний мах иддэг чөтгөр шуламс, хүүрээр хооллогч шөнийн амьтад тэр шөнө цусандаа бялдсан тэр үхэгсдийн их хуарангаар дүүрч их хөлл болжээ. Ашваттахамна, Крипа, Критаварман гурав өглөө болохоос өмөн нас барж байгаа Дурйодханагийн буй Двайпаяна нуурын зүг явав. Тэнд хүрч очиход Каурынхны эзэн хагриугүй амь тавих болчихоод дөнгөж амьсгаатай байжээ. Мань гурван баатар эх тэрэгнүүд дээрээсээ харайн бууж, амь тавин ядаж таталдаж байгаа Дурйодханаг хүрээлэв. Ашваттахаман хааныхаа духны цусыг гараараа арчин, нүд дүүрэн нулимс гүйлэгнүүлэн: “Кришна, Аржуна хоёр бузар нүгэл үйлдсэн дээ! Чамайг дайснууд чинь луйврын аргаар алсан, чамгүйгээр бид хаанааас аз жаргал олж амар тайван сууж чадах вэ? Бид гурав энэ дэлхий дээгүүр уй гашуу болон тэнэх болно. Харин чи, тулалдаанд амь үрэгдэн тэнгэрт заларсан хатан зоригт эрсийн очсон тэр тэнгэрт заларна. Тэнд очиж багшдаа баяр мэнд хүргээд, Дхриштадъямнаг алагдсан гэж хэлээрэй чамаас өмнө тэнгэрт заларч очсон Карна, Бхуришравас болон бусад чин зоригт баатруудыг тэвэрч таалаарай” гэв. Тэгээд Дурйодханагийн нэгэнт мэдээгүй болсон биед хандан Ашватахаман хэлсэн нь: “Дурйодхана хэрэв гол чинь арай тасраагүй бол чиний чихэнд чимэгтэй хэдэн үг над байна, дуулж бай. Пандугийнхны цэргээс долоохон хүн үлдсэн, манайхаас ч бид гурав л үлджээ. Панчалчууд, матс нар, Драупадын хэдэн хүү бүгд алагдсан шүү. Үйлдсэн муу үйлийнх нь хариу тэднийг хөнөөсөн юм. Өнөөх ах дүү тав, Кришна, Сатьяки долоо амь зулбаж гарсан., эгсэн ч одоо Пандугийнххан хүүхдүүдгүй болсон. Шөнө би, Пандугийнхны хуаранд очиж унтаагаар нь бүгдийг хүйс тэмтэрчихсэн!” гэв.

Ийм үг сонсч зүрх нь сэргэж баярласан Дурйодхана ухаан орж: “Бхишма, Карна хоёрын аль нь ч хийж чадаагүй юмыг чи бүтээжээ. Одоо би өөрийгөө бурхдын хаан Индратай адил гэж бодож байна. Та гурав аз жаргалтайм амьдарч, үйлс чинь бүтэж, цэцэглэн мандах болтугай. Тэнгэрт дахин уулзалдана, бид” гэжээ.

Тэгээд Каурав нарын эзэн таг дуугүй болов. Түүний сүнс тэнгэрт залраад бие нь л газар дээр үлджээ.

Шөнийн алаан хядаанаас амь мултарч гарсан ганц хүн-Дхриташтадьюмнагийн хөтөч үүр цүүрээр Огхаватын эрэг хүрч Пдхиштхирагийн өмнө сөхрөөд түүний цэрэг сөнөсөн тухай мэдээ айлдав. “Аяа, хаантан минь, Драупадын хэдэн хүү, матс нарын хааны хүүү нар хуарандаа унтаагаараа бүгд алашгдлаа. Аяа, хаантан минь, чулуун зүрхт Критаварман, Готамын хүү Крипа, бузар явдалт Ашватттахаман гурав чиний бүх цэргийг ургьд шөнө устгачихлаа. Цэрэг чинь сүхээр чавчсан мод шиг мсүйдлээ. Критаварман зугтааж байгаа бусад хүнийг хядаж байх хооронд би арай чамай амь мултран гарч ирлээ” гэжээ.

Энэ аймшигт мэдээг сонсоод Юдхиштхира унах дөхөв. Сатьяки, түүнийг ухасхийн барьж тогтооход, Бхимасена, Аржуна хоёр урагш гарч ирээд гарнаас нь барьж авав. “Эвий хөөрхий, бид, дайснаа ялсан мөртөө ялагдчихдаг. Байна гэж Юдхиштхира дуу алдаад цэрэг маань хязгааргүй их далайг гаталсан аянчид, өөрсдийнхөө муугаар алмайрч байж жижигхэн голд живж үхсэнтэй адил юм болжээ. Аяа, хүүхэд ах, дүүгээ үхлээ гэж дуулаад ДДраупади юу болох бол!” Гэв. Тэгээд Наулад хандаж : “Чи яваад тэр золгүй хатныг нааш аваад ир !” гэлээ. Өөрөө бусдын хамтаар шөнийн хядлага болсон газар өөд явжээ. Харахаас нүд халтирмаар тэр золигийн газар Юдхиштхира хүрч очоод толгойгоо тас чавчуулсан, биеэ хэрчүүлж хэсэглүүлээд, цусандаа бялдагдсан садан садан төрөл сайн нөхдийнхөө хүүрийг үзжээ. Хаан, түүний дагалдан явагчид, тэр аймшигт үзэгдлийг хараад тэссэнгүй айж харууссандаа ухаан алдан унацгаав. Тэр хооронд НАкула, Упаплавьягаас Драупади хатны хамт ирлээ. Хатан, сөнөсөн хуаранг үзмэгжээ давхийн цочиж ухаан алдаад ширүүн салхинд унах чинар мод адил газар савж очив. Бхимасена түүнийг өргөн босгож сэтгэлийг нь засах сэргээх үг хэлж байв. “Дронагийн нүгэлт хүү, баатар эрсийг унтаа дээр нь хядлаа гэснийг дуулсан цагаас хойш бие минь галд шатах шиг болоод байна. Пандугийнхан минь, хэрэв та нарт тэрний үйлдсэн бузар булай хэригийн үр лайг өөрт нь амсуулахгүй, тэр заналт амьтныг хань шадруудынх нь хатм амийг нь хөнөөхгүй бол би энд үлдээд юу ч идэлгүй байж үхлээ хүлээх болно” гэж Драупади асгартал уйлан хэллээ. “Хатантан минь, бүү уй гашуу бол. Биний хэдэн хүү, дүү нар, дайчин эрийн ёсоор үхлийг угтжээ. Харин Дронагийн хүү алс холын ой тайгад нуугдан алаг болсон учир түүний амь нас чиний мэдлээс гарчээ. Драупад аа! гэж Юдхиштхира хариу хэлэхэд Драупади Бхимасенад хандаж: “Кшатри хүний

үүргийг сана! Виратын нийслэлд намайг элдэн хөөж байгсдыг чи тэр үед яаж шүү цааш нь харууллаа, тэрэн шигээ тэр тулалдаанд дийлддэггүй заналт Ашваттахамыг цааш нь харуул! Тэгвэл л миний уй гашуу тайлагдана гэлээ.

Тэгээд, хүчирхэг Бхисамена, Накулаар хөтчөө болгож их алтан тэргэндээ суугаад Дронагийн хүүгийн их тэрэгнийх нь мөрөөр Ашватахаманыг элдэн хөөж эхлэв. Тэр үед Хастинапурээс буцаж ирээд байсан Пандугийн бусад хүү, Кришна нар түүний хойноос бас явав.

### XXX

Тэр хооронд Дхритаршта нас барсан зуун хүүхдээ харамсан гашуудан мөчрөө огтлуулсан мод шиг болчихоод Хастинапурт сууж байжээ. “Уй гашуугаа март, эзэнтэн минь. Чиний хүүгийн удирдсан олон мянган хаад, чин зоригт дайчин эрс тулалдаанд нас барлаа. Ариун сударт заасныг загаж тэднийгээ нутаглуулах ёс гүйцэтгэвэл зохино!” гэж Санжая түүнийг ятгана.

“Би нэгэнт ах дүүс, анд нөхөд, садан төрөлгүй болсон учир одоо над амьд явах ямар хэрэг байна. Над одоо үр хүүхэд, улс гүрэн, харах хараа аль ч алга. Урьд нэг насандаа би нэг их нүгэл үйлдсэн маань эргэлзээгшй боллоо. Тэгээд л одоо бурханд намайг хэмжээ хязгааргүй аймшигт гаслангаар залхаан шийтгэж байгаа хэрэг. Газар дээр надаас илүү золгүй хүн хаана байх вэ? Би, ой тайгад явж, тэнд бүх насаа ганц бие даяанч болж өнгөрөөе” гэв.

Оршуулах ёслолын тухай иСанжая түүнд дахин сануулахад уй гашууд нэг автагдсан сайхь хаан муурч унав. Санжая, Видура хоёр түүнийг арайхийн сэхээж, хаан хүн өөрийн хүлээсэн үүргээ мартаж болохгүй гэж итгүүлэв. Тэгээд Дхритараштра их тэргээ хөөлө гэж зарлиг болжээ. “Гандхари, Кунти, бусад хатад, хааны охидыг аюваад ир. Тулалдааны талбарт очих цаг болжээ” гэж Видурад хээлв.

Гандхари Кунти хоёр, түүнчлэн бусад хааны хатад Дхритараштрагийн дуудсанаар хүрч иржээ. Тэд, уулзаж мэнд усаа мэдэлцээд л чанаг чанга цурхирана уйлалдаж, ордыг гашуудал харууслын дуугаар дүүргэв. Уйлалдаж байгаа золгүй тэр бүсгүйчүүлийг Видура их тэрэгнүүдэд суулгахад, хаан өөрөө, тэр хатад, охидыг дагуулсаар Хастинапураас гарч явлаа. Одоо хүртэл нүд хужирлаж ч болдоггүй алдсан цоохор марлууд агуй дотроосоо гарах адил тэд ордонгоосоо гарч иржээ..

байсан бөгөөд нэгэнт бэлэвсэрсэн хааны хатдыг эгэл түмний нүдэнд ил гараад ирэхэд бүх хот даяар чангаар уйлалдаан шуугиан дэгджээ. Үс гээгээ кадалж, гоёл чимгээ орхиж, уй шгашуу болон царай алдаж нүднээс гарсан амьтад, эгээ л цэгцээ алдсан цоохор марлууд агуй дотроосоо гарах адил тэд ордонгоосоо гарч иржээ.

Их тэрэгнүүддээ орж суугаад Курукшетрэг зорин яваа хаан, чин шударга хатдыг хотынхон олноороо дагалдан явжээ.

Дхритараштраг өртөө газар ч холдоогүй байтал Крипа, Критаварман, Ашваттахаман гурав ядарч зүдэрсэн, тоос шороонд дарагдсан амьтад хандаж, нулимсаа барьж ядан хэлсэн нь: “Аяа, эзэн минь, чиний хүү агуу их гавьяа анд шадруудынхаа хамт Индрагийн оронд одсон, бүх цэргээс бид гурав л хамт үлдсэн Крипа, Гандхарид хандаж: “Чиний хэдэн хүү, эрэлхгээр тулалдаж байгаад бузар олон дайсныг устган нас барсан. Тэд мөнхийн жаргалыг олж, одоо үхэлгүй мөнх бурхалын дунд биегүй ертөнцөд буй нь эргэлзээгүй ээ. Тэдний хэн нь ч тулалдахдаа дайсанд ар шилээ харуулаагүй ээ. Хүүхдүүдийнхээ төлөө шаналж бүү зовогтун! Хатантан минь, тэдний дайсан илүү жаргал эдлээгүй. Чиний хүү Дурйодханыг Бхимасена луйврын аргаар алсныг бид мэдээд Ашваттахаман мтэргүүлэн бид гурав, Пандугийнхны бүх цэргийг хуарандаа унтаа байх хооронд нь довтолж очоод бүгдийг устгачихсан. Панчалчууд бүгдээрээ, Драупадын ах дүү нар, хүүхдүүд цөмөөрөнг алсан. Одоо бид, Пандугийнхны элдэн хөөж өшөөө авахаас нь нуугдах гэж гарч явнам. Иймд, хатантан минь, биднийг саадгүй замдаа орохыг соёрхоно уу. Аяа, хаантан чи ч өөрцгүй соёрх! гэлээ. Тэгээд сайхь гурван баатар Дхритараштра, Гандхари хоёртой салах ёс гүйцэтгэн морьдондоо ташуур өгч, цааш Ганга мөрний эрэг зүглэн явлаа.

Тэнд очоод гурван тийш салж Крипа Хастинапур өөд, Криташарман умар зүгт орших өөрийн улс гүрэн рүү, Ашваттахаман өмнө зүгийн балар ойд орших ариун даяанч Вьясагийн байр өөд тус тус явжээ.

Курукшетрийн ээрэм атлын өөд очоод Юдхиштра, Пандугийн хүүхдүүд, Кришна, Сатьяки, бас тэднийг дагалдан яваа Драпауди болон Пандугийнхны талын хаадын хатадтай тааралджээ. Юдхиштра ёсыг дагаж Дхритараштрагийн хөлд сөхрөн мэднчилэв. Өвгөн хаан мэндийн хариуд маш дурамжхан байлаа. Хүүхдүүдээ алсан хүмүүсийг үзэх ямар олиг байх мвэ. Их мэргэн ухаант Кришна л Дхритараштра,



Гандхари хоёрыг Пандугийн хөвгүүдтэй арай чамай эвлэрүүлжээ. Гагцхүү бүх хүүхдээ бас алдсан Драупадын уй гашуу хөгшигн хаьтны уур хилэнг намжаажээ.

Тэгээд бүгдээрээ байлдаан болсон гаүзар өөд хөдөлжээ. Мянга мянган үхдэл хүүрээр цацагдаж, гол булаг мэт урссан цусанд нэвчсэн бөгөөд цөөвөр, нохой, чонууд сүрэг сүргээрээ язганах тэр ээрэм тал тэдний хараанд өртөв. Тэр бүх аймшгийн дунд харахаас айдас хүрэм буг чөтгөрүүд, хүүр идэгчид тэнэж байна. Хааныг дагалдсан ариун шударга хатад Курукшетрад хүрч ирээд харвал тэдний эрцүүл, үр хүүхэд, ах дүүс нь амьсгалгүй сунан хэвтэж буг чөтгөр чоно, цөөвөр элээ хэрээнд зулгаалгаж байна. Шива бурхны тоглоом шиг, тэр аймшигт тал газрыг үзсэн хатад, хааны охидудуд гашуудалтайгаар дуу алдан хашгиралдаж үнэ ихт их тэргүүд дээрээсээ бууцгаана. Хэлж баршгүй харамсал гашуудалд автсан тэдний дотроо олон нь мууран унаж байхад зарим нь тэр аймшигт тал даяар зүрх ширдхийн хашгиран уйлалдаж, нас барсан эр нөхөр, үр хүүхдээ айн ийш тийш самгардан гүйнэ.

“аяа, Васудевын хүү чи энэ үс гэзгээ сэгсийлгэж, булбарай зөөлөн гараараа толгой түрүү, хэнхдэг цээжээ балбан уй гашуудал болон хашгиралдаж ийш тийш гүйлдэж байгаа зовлонт хүмүүсийг хараач” гэж Гандхари, өөрийгөө тэр гаслант аялалд дагаж яваа Кришнад хандаж хэлэв. Үр хүүхдээсээ үүрд хагацсан эхчүүл, эр нөхрөө алдсан эхнэрүүд баатар эрсийн шарилаар хучигдсан этр аймшигт ээрэм талаар тэнэж яваа хэрэг. Их их гавьяа байгуулсан жанжид, хаад тийнхүү Курукшетрийн талд мөнхийн нойроор унтаж байгаа хэрэг. Тэд, агар зандангаар хулдсан торгон бүтээлэгтэй орон дээрээ биш, харин шороо тоос, цус нөж болсон цулгай газар дээр унтаж буй хэрэг. Тэд, агар зандангаар хулдсан торгон бүтээлэгтэй орон дээрээ биш, харинн шороо тоос, цус нөж болосн цулгай газар дээр угнтаж буй хэрэг. Тэдний чихэнд яруу алдарт үйлийг нь матган джжлах дуучид, туульчдын хоолой чимэг болж байгаа биш, харин цөөвөр чононуудын ой гутам улилт, хэрээнүүдийн гуаглах дуу хадна. Зарим нь яг нойрсох мэт сунан хэвтэх бөгөөд тэдний сайхан биеийг муухай амьтад зулгаана. Зарим нь амраг хайрт эхнэрээ тээврч байгаа мэтээр сэлэм, илд гарт атгаастай амьд юм шиг банья. Бүсгүйчүүл энд тэндгүй хөглөрөх жад, нум, их тэрэгнүүдийн эвдэрхий хэмхэрхийд бүдчин ээрэм талаар тэнэвч байлдаанд ба араатан амьтан, махчин шувуунд сэглэгдсэн хүүрүүдийн дотроос өөрсдийнхөө ойр дотны хүмүүсийг олж танихгүй явна. Тас чавчигдсан толгой, гарыг их биед нь авчирч тавьж үзэхэд хэзээний л биш байх учир гашуудаж зовсондоо өөрийн эрхгүй дуу алдаж:

“Тэр минь биш байна”, Тэрнийх мний биш байна” гээд улам ч гашуудалтайяа уйлалдаж байна.

Гандхари ч Дурйодхангийн аладгсан газар очиж, түүнийг цусандаа холилдон гулдлайн хэвтэхийг үзээд, усан шуурганд ховрон ойчих мод мэтээр мууран унажээ. Тэр авгай ухаан ороод уйлан сөхөрч хааны үхсэн биеийг тэврэн: “Эвий хөөрхий, хүү минь!” эвий хөөрхий минь” гэж дуу алдаж банйа. Түүний нүднээс асгарах нулимс, алагчдийн биеийг угаажээ.

“Тоо тоймгүй их цэргийн жанжин хүн амиа алдаад одоо гав ганцаар хөдөө хэвтэж байх! Ивээл ээлийг нь олж авах гэж өрөөлдөгч хаадаар хүрээлүүлж нэгэн цаг явсан энэ хүн, одоо, чоно, цөөвөр чоноор хүрээлүүлэх гэж дээ. Одоо үзэсгэлэнтэй охидын дэвүүр биш, харин цусанд ховдог элээний жигүүр л нүүрийг нь дэвж байх шив дээ. Бхимасенад хөнөөгдөөд арсланд алагдсан тэр заан шиг мболж улс гүрэн, амь нас хосулангаас хагацжээ. Аяа, Кришна над амьд явахын эхрэг алга. Талийгаач болсон баатруудаа, уйлан гашуудаж байгаа энэ хөөрхий золгүй бүсгүйчүүдийг харахд нүд хүүгийг үхлээс ч илүү зовлонтой байна. Тэднийг харахаас зүрх минь дэлбэрчих гээд байгна. Хааны орд харшийн дэнж дэвсэг дээр л гишгэж байсан эрдэнийн чимэгтэй тэдний хөл одоо болоход цусанд нэвчиж норсон газраар туучиж явна. Уй гашуудаа шаналж туйлдсан хатад, эр нөхөр, үр хүүхдийнхээ хүүрнүүдээс махчин араатан, шувуунуудыг арайхийн үргээж байна. Тэдний тунамал сайхан нүүр царай нь төөнөм халуун наранд гандаж хатсан лянхуа цэцэг шиг болжээ. Тэд уйлж унжсандаа бүр сульдаад газар хэвтэх буюу хүүр,, эвдэрхий хэмхэрхийн доогуур бүдчиж явахдаа зүрх шимшрэм өрөвдөлтэй гаслаж гинших нь сүрэг тогоруу дуугаралдахтай адил ажээ. Аяа, Кришна минь, энэ ээрэм талыг хараач! Олон зуун сарын чимэгтэй бамбай, туг, нар мэт гялалзах алтан хуяг дуулга, малгай, газраар энд тэндгүй хөглөрч тахилгын мянга түмэн түүдэг гал мэт гялалзана. Догшин Бхисамена алаад цусыг нь сорж байсан Духшасана, тэнд мөнхийн нйороор унтаж хараглана. Хаадын хурал дээр миний үгийг ойшоолгүй Драупади, Пандугийн хүүхдүүдийг элдвээр элэг барьж, Драупадийг үстэж байж ийм айхтар залхаал үзжээ. Тэнд бас миний нэг хүү Виеарна, Бхимасенад хөнөөгдөөд алагдсан заанудын дунд, намрынэ тэнэргийн сар хар үүлэн дунд орчихсон юм шиг харагдана. Залуухан эхнэр нь түүнийхээ шарилаас улайрсан цөөвөр чонуудыг үргээн хөөж дийлэхгүй байна. Олон арван жад, нуманд нэвт нэвт харвуулсан байх боловч амьд ахуйнх шигээ бас л үзэсгэлэнтэй харагдана, тэр! Аяа, Еришна минь, тэнд бас Аржунын хатан зоригт хүү

Абхиманью хэмхэрч үйрсэн хуяг дуулга, зэр зэвсгийн дунд гулдайж байна. Абхиманьюгийн золгүй гэргий Уттара, түүний нэгэнт амьсгаа хураасан биеийг зөөлхөн зөөлхөн илж чангаар гиншин үглэж гашуудан байна. Алтан хуягийг нь тайлж цусандаа бялдсан биеийг нь ншд салнгахгүй ширтэж байна!”.

“хань минь ээ- гэж хөөрхөн Уттара дуу алдаж, чин зоригт Абхиманьюгийн биен дээр халуун нулимсаа асгаруулан байж чи минь өдрийнхөө ажилд ядраад унтах адил нойрсжээ. Эдий, чи минь яагаад хариу дуугарахгүй байна? Би чамайгаа гомдоож яваа юу? Надтайгаа яагаад ярьдаггүй юм бэү” гэнэ. Уттара, түүний цээжин дээр толгойгоо тавин Абхиманьюд амьд хүнтэй ярьж байгаа юм шиг: “Аржунын хүү, хүчирхэг Кришнагийнэ зээ хүү чамайг байлдаанд яагаад алсан байдаг билээ? Пандуугийнхан панчал нарын харсаар байтал амийг чинь хөнөөсөн тэр хатуу сэтгэлт яргачмд яасан гутамшигтай вэ? Чамайг алуулчихсан эцэг чинь яаж амьд явж ч чадна вэ? Чи минь нэгэт өнгөрсөн хойно эцэг чинь дайснаа слаад ч яадаг юм, нохой долоо! Би мөн ч золгүй хүн ээ! Үхэж чаддагсан бол үхээд чамтайгаа тэнд гэрт уулзах юмсан. Миний сайхан хань минь тэнд чиний сайханд унаж гүйлдэх тэнгэрийн дагинас чамтай уулзана. Тэдний энхрийлэл хайрыг амсахдаа намайгаа хааяа санаж байгаарай!. Эзэн хаан Виратынхаа алагдсанд гашуудан, нулимс асгаруулцгааж байсан матс нарын гэргийчүүл уйлж унжсаар байгаа Уттараг үхсэн нөхрийнх нь биенээс арайхийн салгацгаав. Дронад хөнөөгдсөн Матс нарын хаан хөөсөр хэвтэх бөгөөд тзүүний дээгүүр сүрэг хон хэрээ баяртай гуаглан эргэлдэнэ. “Аяа, Кришна минь, өнөөх хүчирхэг Карна цувандаа бяалдаж гулдайн ойчсоныг нь хараач. Байлдаанд сөнөөгч гал шиг дийлддэггүй энэ хүн одоо нэг унтарчээ. Тэнд Аржунад алагдсан бардам зантай Жаятрахта цөөвөр чоно, хон хэрээний хоол болоод хэвтэж байна. Эхнэр нь түүнийхээ чавчигдсан толгойг олох гээд дэмий л бэдэрч байна. Тэнд бас Карнагийн хөтөч болж тулалдаанд ороод Пандугийнхны ялалтын төлөө хүчирхэг баатар эрийн чин зоригийг мохоох гэж оролдож байсан Шалья Юдхитхирад алагдаад одоомахчин шувууд түүний хэлийг суга татан идчихжээ. Бхишма сумуудаар дэвсгэр болгоод үхсэн хэвтэнэ. Дайснч зэр зэвсгэнд олон удаа сүлбүүлж үхсэн Дрона хуяг дуулгатайгаа гулдайж, түүний гэргий, шавь нар гүнээ гашуудацгааж байгаа. Харагдана. Аяа, Кришна минь, Каурынхны овог мөхжээ, бас Пандугийнхны овог ч бараг хүйс тэмтрэгджээ! Ийм юманд хүргэсэн чи ч бас муугаа үзтүгэй. Чи энэ ах дүүс бие биенээ хядах байлдааныг зогсоож болох байсан, гэсэн ч

чи тэгсэнгүй. Миний үр хүүхэд, миний ах дүү нар үхэж үрэглсэн шиг чиний овог ч сөнөтүгэй” гэж Гандхари хэлэв.

Юдхиштхира зарц нар ба лам нартаа зарлиг болгосон нь :”Ганц хүнийг орхилгүйгээр бүх үхсэн хүмүүсийг оршуулах ёслол гүйцэтгэ” гэжээ. Тэгээд зарц нар нь Видурагийн хяналтанд явж зандан мод, агар тахил үйлдэх тос, арц, торго дурдан хувцас хунар, түүдэг гал асаах хуурай мод авчирч, их тэрэг зэр зэвсэгний эвдэрхий хэмхэрхий цуглуулж энэ бүгдээрээ оршуулгын асар том түүдэг гал асаажээ. Лам нар гүрэм ном уншиж, ариун сударт заасан дагуу ёс горим гүйцэтгэв. Тэр оршуулгын гал шөнөжин Курукшетрийн ээрэм талд асах нь хав харанхуй тэнгэрт үзэгдэх од шиг байжээ. Лам нарын мөргөл унших, номын дуу дуулах, бүсгүйчүүдийн гиншин орилолдох дуун тэнгэрт хүрч басйан ажгуу.

### XXXI

Курукшетрад болсон их тулалдаанаас хойш олон жил өнгөрчээ. Өвгөн Дхритараштра, Гандхари, Кунти хамт ой тайганаа зайлан одож даяанчдын дунд амьдарч байгаад ойн нэг удаагийн түймэрт нас барцгаажээ. Өвгөн Видура ч нас барсан бөгөөд харин Санжая Гималай руу яваад үүрд алга болжээ. Тулалдаанаас хойш гучин зургаан жилийн дараа Кришна үхжээ. Түүнийг ой дотор явж байхад нь анчид, буга гэж андуураад харвачихжээ. Кришнагийн овгийнхонд Гандхарын хараал хүрсэн ужчир хоородноо байлдсаар байгаад сөнөсөн ажээ.

КУРУКШЕТРИ ЙН ТАЛД БОЛОСН БАЙЛДААНД, ХАМАГ АНД НӨХӨД, САДАН ТӨРЛӨӨ ҮХҮҮЛСЭНДЭЭ Юдхишхира сэтгэлийн зовлон гашуудалд нэрвэгдэн удаан жил шаналжээ. Юдхишхира алах гэж хүсээд хүссэндээ хүрсэн Карна түүний төрсөн дүү байсныг мэдээд түүний зүрхэнд зүү шивэх шиг болосн бөлгөө. Энэ нууцыг Кунти авгай ой тайгад явахыннхаа өмнөхөн түүнд тайлж өгчээ. Гэсэн ч Юдхишхира дүү нарынхаа хамтаар олон жил аз жаргалтай хаанчлан захирч Ашвамедха хэмээх гагцхүү дэлхийн эзнийхийдэ, мориор тахих их тахилыг үйлджээ. Харин нас барсныхаа дараа Пандугийн хүү, Драупади бүгдээр тэнгэрт зарарчээ.

“Драупади, өшөө аваарай гээд байсан өнөөх Ашваттахаман яасан бү?” гээд Жанамежая асуулаа. Вайшампаяна ингэж хариу өчив.: тулалдаан болж өнгөрснөөс хойхон нь Пандугийнхан Дронагийн тэр хүүг балар шугуйн дотор ариун Вьясын байранд байх зуур дээр нь яг буужээ. Өш хонзонгоо авах гэж хор шар нь

хөлдөлсөн Пандугийн хүүхдүүдийг Ашваттахаман үзмэгцээ Пандугийн овгийг хүйс тэмтэрнэ гэж өөрөө тарнидсан зэвсэг барьж авч бас зэвсгээрээ үхлийн цохилт буулгахад бэлдээд байсан Арцунаг хөнөөхийг завдав. Гэтэл арижйн явдалт мэрэг даяанч тэр хоёрын хоорондуур орж алалдах тулаанд нь саад хийж Пандугийнхан ба Ашваттахаманыг эвлэрэх тийш хандуулжээ.

Аржуна, нумаа хураав. Харин Дронагийн хүүгийг ид шид шидэт зэвсэг нь аймшигт хаалаар тарнигдсан басйан учир Аржунагийн хажуугаар өнгөрөн Ахиманьягийн залхуу гэргий Уттараг хөнөж, түүни йумайд байсан төрөөгүй хүүхдийг үхүүлжээ. Энэ нүгэлт үйл, бас шөнө хийсэн их хядлага хоёрын төлөө Кришна, Ашваттахаманыг хараажээ. Кришнагийн хааарлаар Ашваттахасан одоог хүртэл орох байх газаргүй тэнүүчилж явдаг болсон гэнэ.

